

СОЁЛЫН ЖИМЭЭР СОЁЛ СУДЛАЛЫН ТӨВ

ЭРДЭМ

ШИНЖИЛГЭЭ

СОЁЛЫН ЖИМЭЭР

ᠰᠣᠶ᠋ᠣᠯᠢᠨ
ᠵᠢᠮᠡᠭᠦᠷ



ᠰᠣᠶ᠋ᠣᠯᠢᠨ
ᠵᠢᠮᠡᠭᠦᠷ

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia

СОЁЛЫН ЖИМЭЭР

СОЁЛ СУДЛАЛЫН ТӨВ

*

*

БОТЬ. II

Редакцын зөвлөл:

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	(Монгол)
Доктор (Ph.D)	Н.Мягмар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	(Герман)
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Б.Болд	(Япон)
Доктор (Ph.D)	Залгаабаяр	(БНХАУ)

Ботийг эрхэлсэн: Э.Итгэл

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia

THE CULTURAL WAY

CENTER FOR CULTURAL STUDIES

*

*

Volume. II

Editorial board:

Doctor (Sc.D)	Badamdorj. D	(Mongolia)
Doctor (Ph.D)	Chuluunbaatar. L	(Mongolia)
Doctor (Ph.D)	Myagmar. N	(Mongolia)
Doctor (Ph.D)	Qurčabaatar. L	(Germany)
Doctor (Ph.D)	Qasbaatar. L	(China)
Doctor (Ph.D)	Bold. B	(Japan)
Doctor (Ph.D)	Zalgaabayar	(China)

Edited by: Itgel. E

ISSN: 2791-1446

© *Sodon Soyod Publishing, Mongolia*

ГАРЧИГ

УЯНГА. <i>Монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь судалгааны тухай товч өгүүлэх нь.....</i>	<i>1</i>
ЧАН ХУАНЬ ХУАНЬ. <i>Шинэ эриний монгол хэлний уран зохиол дахь энэтхэг уран зохиолын орчуулга тархалтын байдал.....</i>	<i>10</i>
ХАСБААТАР. <i>Л. Чулуунбаатарын шүлэг дэх “хүүхдийн ертөнц”</i>	<i>23</i>
КАНЬ ХАЙ ИН. <i>Эх дэлхийн уянгын эрэлчний сэтгэлийн дуун.....</i>	<i>44</i>
ХАСХҮҮ. <i>Шинэ зууны монгол улсын романд тусгагдсан далд мэдрэхүйн шинэсийн тухай өгүүлэх нь.....</i>	<i>65</i>
ТЭРГЭЛ. <i>Дундад улсын одоо үеийн утга зохиолын монгол орчуулгын судалгааны тойм.....</i>	<i>81</i>
СҮМЭН. <i>Шинэ цаг үеийн шашин шүтлэг итгэл бишрэлийн тухай шинэжих нь.....</i>	<i>98</i>
Ү.МӨНХДАГВА. <i>Торгуудын их нүүдэлд оролцсон Хошууд аймаг.....</i>	<i>105</i>
Т.БАТБЯМБА, Г.АРИУН-ОНОН, С.МӨНХСАЙХАН. <i>Монгол улсын Үндсэн хуулиудын үгийн сангийн давтамжийг харьцуулсан нь.....</i>	<i>118</i>
ЖЯН ЮАНЬ, И ВЭЙ ЧИ. <i>Хара Хүлэгү ба Хара Огул хэмээх нэрийн тухай товч өгүүлэх нь.....</i>	<i>130</i>
НОМИН, ХАЙ ЛИ. <i>Монгол үндэстний онцлогт эмт хоолыг нээн ашиглах тулгам чанарын тухай өгүүлэх нь.....</i>	<i>137</i>

УЙГУРЖИН МОНГОЛ

МЭДЭЭЛЭЛ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

CONTENT

UYANGA. On the Study of Modern Mongolian Literature in China
(1991- 2000 years Research on this problem)

CHANG HUAN HUAN. Translation and introduction of Indian
literature in Mongolian literature in the new era

QASBAᠶATUR. “Children’s wold” in L.Chuluunbaatar’s poem

KAN HAI YING. The importance of the study of the history of
Mongolian literature (1976—2013)

HASHUU. Telling about the secretary symptoms of the
new century in Mongolia’s novel

TERGEL. Overview of modern Mongolian literature
translation studies

SU MAN. An analysis of the religions in new age

MUNKHDAGVA. U. Khosud who took part in the
great migration of Torgud

BATBYAMBA. T, ... Comparing word frequency of the
constitutions of Mongolia

JIANG YUAN, YI WEI QI. Talking about Qara Hülegü and
Qara Oghul

NOMIN, HAI LI. Talking about medicinal diet in Mongolian

MONGOLIAN SCRIPT

NEWS

INTRODUCTION OF EDITORIAL



**МОНГОЛ УЛСЫН ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛЫН ДУНДАД УЛС ДАХЬ
СУДАЛГААНЫ ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ**

Уянга *

ХУРААНГУЙ

Монгол улсын орчин үеийн уран зохиолыг дундад улсад уйгуржин монгол үсэгт хөрвүүлэн нийтлэхийг дагалдан монгол улсын орчин үеийн туужсын судалгаа ч дундад улсад өрнөж эхлэв. 1991-2000 оны хооронд, монгол улсын орчин үеийн туужсын зохиол нь дундад улсад уран дүрийн тухай судалгаа, илэрхийлэх арга байдлын тухай судалгаа, утга сэдвийн тухай судалгаа зэрэг утга зохиолын уламжлалт судалгааны арга хэлбэрээр голлон судлагдаж байсан мөртөө басхүү харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын шинэ хандлагаас шинжлэгдэж байсан нь анхаарууштай юм. Энэ нь монгол утга зохиолын судалгааны арга хэлбэрийг тэлэн үргэлжлүүлснээр барахгүй монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь сонгодог үзлийг ахиулав.

Түлхүүр үгс: Монгол улс, Дундад улс, туужсын судалгаа

Дундад улсад монгол улсын орчин үеийн уран зохиолыг ХХ зууны 50-аад оноос эхлэн уйгуржин монгол үсэгт хөрвүүлэн орчуулж байжээ. Энэхүү хөрвүүлэн орчуулах явцад дундад улсад монгол улсын орчин үеийн уран зохиолын судалгааны ажил өрнөж эхэлжээ. 1991-2000 оны хооронд монгол улсын орчин үеийн уран зохиолын судалгаа дундад улсад шинэ нэгэн хөгжлийн шатандаа орсон байна. Тус хугацаанд дундад улсад монгол улсын орчин үеийн уран зохиолын түүх, монгол улсын орчин үеийн зохиолч жич зохиол бүтээлийн тусгай судалгааны өгүүллийг хэвлэн нийтлэв. Доор дундад улсад 1991-2000 оны хоорондох монгол улсын орчин үеийн туужсыг хэрхэн судлан шинжилж байсан тухай нарийвчлан шинжлэе.

* 2019 оны Дундад улсын хэл утга зохиолын докторант (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль).



Нэг. Харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын хандлага дахь судалгаа

Харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиол нь тусгай нэгэн шинжилгээний салбар болсны хувьд уран зохиол судлаачдын дотно хүрээлэлд багтсаар ирэв. Дундад улсын монгол уран зохиол судлаачид ч тус судалгааны аргыг хэрэглэж монгол улсын орчин үеийн уран зохиолыг судалж байжээ.

Харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын шинжилгээний чухал нэгэн судалгааны арга бол зэрэгцүүлсэн судлал болно. Зэрэгцүүлсэн судлал нь гол сэдэвлэхүүн, хэлбэр, үйл явдал, хүн, хэл хэллэгийн онцлог, урлагийн онцлог ба бусад хэлбэрийн судалгаа байж болох мөртөө бас зохиогчийн зохиол бүтээл, утга зохиолын төрөл жанр, үзэл санаа урсгал бүлэг зэргийн харьцуулсан судалгаа байж болно¹. Үүнээс харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын судалгааны хүрээ хэмжээ өргөн дэлгэр байх нь тодорхой байна. Хасартанийн “Дөлгөөн Дон, Тунгалаг тамир роман дахь Аксания ба Долгорын дүрийг харьцуулах нь” хэмээх өгүүлэлд дүрүүдийг харьцуулан судлахаар дамжин, тус хоёр дүр бол тухайн үеийн чөлөөт хайр дурлал ба жаргалант амьдралыг хайгч дүр болох бөгөөд хоёул ялагдагч болно гэж хураангуйлан дүгнэж, романтик хэлбэрийн амьдралыг өнгөрөөж байсан Аксаниягийн дүр ба эр нөхөр, үр хүүхэддээ хайртай Долгорын дүрийн адил бус талыг нарийвчлан ажиглаж, Долгорын дүр бол Аксаниягийн хуулбар дүр биш, харин өөрийн гэсэн онцлогтой өвөрмөц дүр болох юм гэсэн үзлийг дэвшүүлжээ.

Үүнээс гадна Лү Шюнь-ий Эх нутаг ба Д.Нацагдоржийн Хуучин хүү зохиолыг харьцуулсан судалсан өгүүлэл “Лү Шюнь ба Д.Нацагдоржийн зохиол бүтээлийн харьцуулал”² буй. Тус өгүүлэлд Эх нутагт тусгагдсан ард түмнийг сэхээрүүлэн гэгээрүүлэх, харийн түрэмгийг хөөн зайлуулах, харгис феодалын бурангуй ёсыг устгаж шинэ нийгмийг цогцлоон байгуулах үзэл санаа ба Хуучин хүү бүтээл дэх феодалын зан авир, хуучны ёс дүрмийг илчлэн феодалын хамгаалагч ба хуучнаа сэргээх үзлийг буруушаан, хувьсгалын туршлага сургамжийг

¹ 杨乃乔:《比较文学概论》(第三版), 北京大学出版社, 2006年5月, 186页。

² Мөнхдэлгэр. “Лү Шюнь ба Д.Нацагдоржийн зарим зохиол бүтээлийн харьцуулал”, ЗҮМҮБТМСЭШС 1992 №4, т 37



дүгнэн ард түмнийг дуудан сэрээхийг зорьсон үзэл санааг харьцуулан судлав.

Харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын судалгааны арга бол монгол утга зохиолын хөгжлийн улбааг шинжилсэн шинэ хэлбэрийн судалгааны арга болно. Дээр өгүүлснээр харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын зэрэгцүүлсэн судлалын аргыг голлон хэрэглэж, монгол туужис ба бусад үндэстний туужсын харьцаа холбоог шинжлэн, монгол туужсын хөгжлийн дотоод жам хуулийг илэрхийлэх оролдлого хийжээ. Харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын судалгаа нь монгол туужсын судалгааны хөгжилд зохих нөлөө үзүүлэв.

Хоёр. Уран дүрийн тухай судалгаа

Уран дүр бол туужсын зохиолын дутагдаж болшгүй чухал элемент болно. “Монголчууд эрт үед зохиолын баатрыг тэргүүлэгч хэмээн нэрлэж, үлгэр туужсын тухай алдаг оног өгүүлэлцэн ярилцаж байснаа XIX зуунд нэлээд системтэй туужсын онол бүрэлджээ. Ингээд зохиолын хүнийг үнэлж шүүмжлэх нь туужсын судлалын гол өгүүлэгдэхүүний хувиар хожмын үе хүртэл уламжилсан мөртөө XX зууны сүүлчийн хагаст улам эрчимжин чангарч уран дүрд агуулагдсан соёл түүхэн агуулгад тайлбар хийсэн зүйл ихээр төрөн гарсан байна”³. Монгол улсын орчин үеийн туужсын дундад улс дахь судалгаа нь мөн л уран дүрд суурьлан нэлээд олон судалгааны өгүүлэлд дурьдагджээ.

Тунгалаг тамир бол Ч.Лодойдамбын төлөөлөх чанартай бүтээл мөн. Тус романы тухай судалгаа 1991-2000 оны хооронд дундад улсад нэлээд эрчтэй өрнөж байсан мөртөө уран дүрийн судалгаагаар голлон шинжлэгдэж байв. Тус романд бүх анги давхарга нийгмийн хүчийг төлөөлсөн дүрийг бүтээсэн бөгөөд эдгээр дүр нь түүхэн үнэнд суурьлан буй болсон юм. Даруй Төмөрийн дүрийг бүтээхэд Ч.Лодойдамба аавынхаа учралд түшиглэн бичсэнийг “Лодойдамбын тухай дурсамж”⁴-д “Лодойн аав Архангайд жин тээн явж байгаад цэцэг өвчин тусаж их удаан хэвтсэнд нутгийн хүмүүс эргэж тойрон эдгэрүүлсэн юм гэнэ, мөн Лодой цахиур Төмөрийг Архангайд өвчилснийг бичиж байхдаа аавынхаа

³ Дорнотэнгэр. “Шүүмжлэлийн чадавхи – Өвөр монголчуудын утга зохиол судлалын тухай нэг зүйлийн шинжилгээ”, ӨМАХХ 2002

⁴ Ч.Долгорсүрэн. “Лодойдамбын тухай дурсамж”, Шилийн гол 2000 №3, т 79



өвчилж байсныг ярьж байхыг би их тод санаж байна” гэж тэмдэглэжээ. “Тунгалаг тамир дахь Төмөрийн дүр”⁵ гэх өгүүлэлд Төмөрийн дүрийг “эр зоригтой, хээгүй зантай, арга мэх олонтой, хүч чадал ихтэй, бие бялдар болоод өнгө зүс сайн, мах цустай, хайр сэтгэлтэй, амьд дүр болгон зураг болтол дүрсэлжээ” гэж хураангуйлан өгүүлэв. “Тунгалаг тамир роман дахь сайн эрийн дүрийн үзэл ухамсрын бүтэц”⁶ гэх өгүүлэлд тус роман дахь Төмөр, Түгжил, Хонгор, Бадарч зэрэг хүмүүс бол тогтсон түүхт нөхцөл, тогтсон ангийн суурь дээр цогцлогдсон хувь хувийн өвөрмөц онцлог бүхий дүрүүд, эдгээр дүрүүдийн үзэл ухамсрын бүтцийг нийгмийн үзэл ухамсар, атаа хорслын үзэл ухамсар, сайн эрийг бишрэн бахархах үзэл ухамсартай хэмээн эш татан нотлов.

Дундад улсын уншигчид, судлаачдын дунд Д.Нацагдоржийн Хуучин хүү нь нэлээд нөлөөтэй. “Хуучин хүүгийн таталган зургаас дүрийг задлах нь” гэх өгүүлэлд хуучин хүүгийн дүрийг “ухаан сэргэлэн, номхон шударга, ажилч хөдөлмөрч боловч зүүн хошууны захад хүрсэнгүй баруун мөрний тэртээ гарсангүй гурав дөрвөн өртөөнд эргэн тойрон явсаар дорой ноомой, хоосон балай дүр болж хоцорчээ”⁷ хэмээн хуучин хүүгийн аж ахуй, оюун ухааны талд балай хоосон байдлыг илчлэн, ирээдүйн хүмүүс заавал үүнээс сургамж авах чухалтай гэх санаагаа илтгэжээ. Хуучин хүүгээс гадна бас Шувуун саарал, Хөдөө талын үзэсгэлэн, Харанхуй хад зэрэг өгүүллэгийн монгол морьны дүрийг “Д.Нацагдоржийн өгүүллэг дэх монгол морьны дүр дүрслэлийн тухай өчүүхэн тэмдэглэл”⁸ гэх өгүүлэлд судлан шинжлэв.

Б.Дариймаагийн өгүүллэг “Хос мөнгөн бугуйвч”-ийн тухйа шинжилсэн “Хос мөнгөн бугуйвч дахь Балдан өвгөний дүр”⁹ гэх өгүүлэлд Балдангийн дүрийг хашир тохь бодлоготой, цаг үргэлж үр хүүхдийн төлөө сэтгэлээ чилээж байдаг, хүүхдийн сэтгэлийг хөндөх үг яриа, үйл ажиллагаанд гомддог боловч амархан уучилдаг, нүүрэн дээр нь сурган шүүмжилдэг, ачлалгүй хүүхэддээ хар санадаггүй дандаа биеэ

⁵ Насандалай. “Тунгалаг тамир дахь Төмөрийн дүр”, МХУЗ 1998 №2, т 76

⁶ Фу Лянь. “Тунгалаг тамир роман дахь сайн эрийн дүрийн үзэл ухамсрын бүтэц”, Алтан түлхүүр 1994 №1, т 73

⁷ Ван Гүйжэнь. “Хуучин хүүгийн таталган зургаас дүрийг задлах нь”, Торгон жолоо 1995 №5, т 73

⁸ Чүлтэм. “Д.Нацагдоржийн өгүүллэг дэх монгол морьны тухай дүрслэлийн тухай өүүчхэн тэмдэглэл”, ЗҮМҮБТМСЭШС 1993 №1, т 15

⁹ Вү Бэймэй. “Хос мөнгөн бугуйвч дахь Балдан өвгөний дүр”, Торгон жолоо 1997 №1, т 13



буруутгадаг зан араншин ба уран нарийн хянамгай зантай гүтгэлэг цуурхлыг ойшоодоггүй, өрөвч зөөлөн сэтгэлтэй, эд ашигт шунахайрдаггүй зэрэг талаас хураангуйлав.

1991-2000 оны хооронд дундад улсад, монгол улсын орчин үеийн туужсын судлал нь уран дүрийн судалгаагаар онцлогдож байсныг мэдэж болно. Эдгээр туужсын уран дүрийн судалгаанд зөвхөн хүний дүрийг шинжилсэн бус амьтны дүр дүрслэлд мөн анхаарлаа хандуулсан нь анхаарууштай. Тус судалгаа нь өнөөдрийн туужсын судалгааны суурь болж өгчээ.

Гурав. Илэрхийлэх арга байдлын тухай судалгаа

Уран зохиолд гоо сайхан бол түгээмэл оршиж байдаг. Гэтэл үүнийг мэдрэн таашааж, урлагийн гоо сайхан болгон мэдрэн төрхжүүлэх нь зохион бүтээлтийн урлагийн мэргэжил болно. Монгол улсын орчин үеийн туужсын судалгаанд бүх хэлбэрийн урлагийн илэрхийлэх арга байдлыг тохьтой сайхан хэрэглэсэн байна. Үүний дотор хам сэрлийн аргыг элбэг хэрэглэжээ. “Утга зохиол урлагийн онол судлалд өгүүлэх хам сэрэл нь голдуу зохиогч ба урлаачаас иймэрхүү адил бус сэрлийн харилцан нэвтрэлцэх сэтгэлийн хөдөлгөөнд түшиглэн өөрийн дотоод сэтгэлгээ эсвэл гадаад ертөнцийн хэрэг бодис, үзэгдлийг илэрхийлэх нэг зүйлийн урлагийн арга барилыг заана. Үүнийг ихэнхдээ урлагийн хам сэрэл гэж хэлэх буюу сэрлийн шилжилт, сэрлийн нэвтрэлцэл”¹⁰ хэмээнэ. Дундад улсын монгол уран зохиол судлаачдаас тус судалгааны аргыг монгол улсын туужсын судалгаанд оновчтой сайхан хэрэглэсэн байна. “Хөдөө талын үзэсгэлэн дэх гоо сайхны тохиолдол”¹¹ гэх өгүүлэлд өнгө будгийн ялгарлаар гоо сайхны шууд сэрлийг хөндсөн, далд ухамсрын хөндийрлөөр гоо сайхны далд сэрлийг өдсөн, сонсох сэрлийн хослуулалт ба дуу чимээний тодруулалт жич хором зуурын тусгалаас үлдсэн оюуны догдлолын харамсалтай хэмээн зохиолд илэрсэн хам сэрлийг шинжилжээ.

¹⁰ Сараана. “20 дугаар зууны монгол туужсын аргын судлал”, ӨМАХХ 2005, т 161

¹¹ Батнасан. “Хөдөө талын үзэсгэлэн дэх гоо сайхны тохиолдол”, Торгон жолоо 1998 №7, т 11



Сэтгэлийн гүн дэх нууцыг уудлан бичсэн байна. “Нийгэм, ёс суртахуун, ахуй амьдрал – С.Эрдэнийн зохиолын тухай”¹² хэмээх өгүүлэлд, түүний зохиолын утга сэдвийн сонголтын талаар хайр дурлал ба эхийн хайрыг бичихдээ хүний амьдралын гадаад дүрслэлд зогсонгуйрсан бус, харин сэтгэлийн гүн дэх нууц, хүмүүсийн үл анхаарах зүйлийг уудлан бичиж, нийгмийн асуудал ба ёс суртахууны асуудлыг гүнзгий судлан, ахуй амьдралын утга агуулгыг эрэлхийлэхээр оролдсоныг задлан өгүүлэв. Уран зохиолчдоос зохиолдоо сэтгэлийнхээ гүний нууц зүйлийг дэлгэн бичих нь уран зохиолчдын амьдралыг ажиглах гярхай харцын тусгал байж, тэдний урлах сэтгэхүйг шууд илэрхийлж байдаг.

Дүрслэлийн аргыг оновчтой хэрэглэсэн байна. Нарийн зүйлсийн дүрслэлээс зохиолын үйл явдлын хөгжлийн байдлыг ойлгож чадна. Тунгалаг тамир романд нүдний тухай дүрслэл үлэмжхэн илэрсэн учраас шүүмжлэгчдийн төлөөлөл болох “Тунгалаг тамир роман дахь нүдний дүрслэл”¹³ гэсэн өгүүлэлд, 200 гаруй борогжуу оновчтой, идлэг, дүрслэг дүрслэлийг эмхлэн цэгцлэхээр дамжин, хожмын судлаачдын зохион бичихэд хавсралт лавлах болгохыг зорьжээ. “Хос мөнгөн бугуйвч дахь байгалийн орчин ахуйн дүрслэл болон уран нарийн шагламж сийлбэрлэл”¹⁴ гэх өгүүлэлд, Балдан өвгөний дотоод сэтгэлийн зураглалыг байгалийн орчин ахуйн дүрслэлтэй нягт холбон задалж шинжлэв. Үүнтэй адилаар “Хоньчин Найдангийн зарим онцлогийн тухай” хэмээх өгүүлэлд, зохиолын үйл явдал, байгалийн өнгө үзэмж ба хэл хэллэгийн онцлогийн тухай шинжлэн, “Туужын байгалийн өнгө үзэмжийн зураглал нь зохиолын баатрын зан чанарыг хөгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлжээ” хэмээв.

“Би хэзээд мартаггүй туужийн илэрхийлэх арга байдлын тухай шүүлт”¹⁵ гэх өгүүлэлд зохиолч Мягмарын гадаад дотоод хүүрнэлийг уялдуулсан шинж, дүрээр дамжин амьдралын өнгө онцлогийг

¹² Ван Вэйхөн. “Нийгэм, ёс суртахуун, ахуй амьдрал – С.Эрдэнийн зохиолын тухай”, Алтан түлхүүр 1995 №4, т 42

¹³ Туяа. “Тунгалаг тамир роман дахь нүдний дүрслэл”, Торгон жолоо 1993 №3, т 28

¹⁴ Батнасан. “Хос мөнгөн бугуйвч дахь байгалийн орчин ахуйн дүрслэл болон уран нарийн шагламж сийлбэрлэл”, Торгон жолоо 1997 №4, т 17

¹⁵ Хасчимэг. “Би хэзээд мартаггүй туужийн илэрхийлэх арга байдлын тухай шүүлт”, ЗҮМҮБТМСЭШС 1999 №2, т 36



илэрхийлэх ба зохиолын баатрын хэл хэллэгийн өвөрмөц чанар ба түүх хийгээд эдүгээч давхаргад эргэцсэн “бодлын урсгал”-ын арга зэрэг олон бичлэг илэрхийллийн арга байдлыг шинжлэхээр дамжин түүний зохиол бүтээлд тусгагдсан хүний амьдралыг харуулсан гүн ухаанч шинж ба хүмүүнлэг шинжийг мөрдөн илчлэв.

Дөрөв. Утга сэдвийн тухай судалгаа

Монгол улсын орчин үеийн уран зохиолд сургаал шинжит тууж нэлээд олон харагдана. Тодруулбал, Хос мөнгөн бугуйвч, Багана, Үүлэн чөлөөний нар, Аюуш зэрэг олон бүтээл буй. Эдгээр туужсын зохиолын сургаал шинжийг тодруулахаар дундад улсын монгол уран зохиол судлаачид судалгааны өгүүлэл тууригдсан байна. “Монгол улсын гурван өгүүллэгийн сургаал шинж”¹⁶ гэх өгүүлэлд, Хос мөнгөн бугуйвч, Багана, Үүлэн чөлөөний нар зэрэг гурван өгүүллэгт үндэслэн эх эцэг ахмад настнаа хүндэлж явах, улс орондоо хэрэгтэй хүн болохын чухал чанарыг задлан өгүүлэв. “Ёстой монгол хүн – Аюуш гэдэг туужийг уншаад”¹⁷ хэмээх өгүүлэлд Аюушийн бусдын төлөө амь насаа зориулсан баатарлаг зориг санааг магтан дуулахын хамт түүнийг хожмын хүмүүсийн үлгэр дууриал гэж сайшаан үнэлэв.

ДҮГНЭЛТ

1991-2000 оны хооронд дундад улсад монгол улсын орчин үеийн тууж нь харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын хандлага дахь судалгаа, уран дүрийн тухай судалгаа, илэрхийлэх арга байдлын тухай судалгаа ба утга сэдвийн тухай судалгаанд суурьлан судлагдаж байжээ. Судалгааны арга байдлын хувьд, харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын судалгааны арга нь утга зохиолын шинэ хэлбэрийн судалгааны арга болж, бусад хэлбэрийн судалгаа нь утга зохиолын уламжлалт судалгааны арга болно. Өгүүлэл шүүмжлэгчдийн хувьд, ихэнх нь дунд сургуулийн багш нар, өнгөрсөн үеийн хэл бичгийн хичээлийн сурах бичигт сонгогдсон монгол улсын орчин үеийн уран зохиолыг шүүмжлэн үнэлсэн байдаг. Энэ нь монгол утга зохиолын

¹⁶ Бао Лүншань. “Монгол улсын гурван өгүүллэгийн сургаал шинж”, Монгол хэл бичиг 1994 №9, т 15

¹⁷ Бао Цэнгэлт. “Ёстой монгол хүн – Аюуш гэдэг туужийг уншаад”, Торгон жолоо 1994 №3, т 63



судалгааны цар хэмжээг тэлэн өргөжүүлснээр барахгүй монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь сонгодог үзлийг ахиулав.

НОМ ЗҮЙ

1. 杨乃乔: 《比较文学概论》(第三版), 北京大学出版社, 2006 年
2. Дорнотэнгэр. “Шүүмжлэлийн чадавхи – Өвөр монголчуудын утга зохиол судлалын тухай нэг зүйлийн шинжилгээ”, ӨМАХХ 2002 он
3. Мөнхдэлгэр. “Лү Шюнь ба Д.Нацагдоржийн зарим зохиол бүтээлийн харьцуулал”, ЗҮМҮБТМСЭШС 1992 №4,
4. Ч.Долгорсүрэн. “Лодойдамбын тухай дурсамж”, Шилийн гол 2000 №3
5. Насандалай. “Тунгалаг тамир дахь Төмөрийн дүр”, МХУЗ 1998 №2
6. Фу Лянь. “Тунгалаг тамир роман дахь сайн эрийн дүрийн үзэл ухамсрын бүтэц”, Алтан түлхүүр 1994 №1
7. Ван Гүйжэнь. “Хуучин хүүгийн таталган зургаас дүрийг задлах нь”, Торгон жолоо 1995 №5, т 73
8. Чүлтэм. “Д.Нацагдоржийн өгүүллэг дэх монгол морьны тухай дүрслэлийн тухай өүүчхэн тэмдэглэл”, ЗҮМҮБТМСЭШС 1993 №1
9. Вү Бэймэй. “Хос мөнгөн бугуйвч дахь Балдан өвгөний дүр”, Торгон жолоо 1997 №1
10. Сараана. “20 дугаар зууны монгол туужсын аргын судлал”, ӨМАХХ 2005
11. Батнасан. “Хөдөө талын үзэсгэлэн дэх гоо сайхны тохиолдол”, Торгон жолоо 1998 №7
12. Ван Вэйхөн. “Нийгэм, ёс суртахуун, ахуй амьдрал – С.Эрдэнийн зохиолын тухай”, Алтан түлхүүр 1995 №4
13. Туяа. “Тунгалаг тамир роман дахь нүдний дүрслэл”, Торгон жолоо 1993 №3
14. Батнасан. “Хос мөнгөн бугуйвч дахь байгалийн орчин ахуйн дүрслэл болон уран нарийн шагламж сийлбэрлэл”, Торгон жолоо 1997 №4
15. Хасчимэг. “Би хэзээд мартаггүй туужийн илэрхийлэх арга байдлын тухай шүүлт”, ЗҮМҮБТМСЭШС 1999 №2
16. Бао Лүншань. “Монгол улсын гурван өгүүллэгийн сургаал шинж”, Монгол хэл бичиг 1994 №9
17. Бао Цэнгэлт. “Ёстой монгол хүн – Аюуш гэдэг туужийг уншаад”, Торгон жолоо 1994 №3



ABSTRACT

With the publication of modern Mongolian literature translated into Uyghur Mongolian in China, the study of modern Mongolian novels has flourished in China. It is worth noting that during 1991-2000, Mongolian modern novels in China were not only mainly studied by traditional literary research methods such as image research, expression technique research and subject matter research, but also investigated from a new perspective of comparative literature and world literature. This not only expands the ways and means of Mongolian literature research, but also promotes the choice of modern Mongolian literature in China.

Keywords: *Mongolia, China, research on this problem*

**ШИНЭ ЭРИНИЙ МОНГОЛ ХЭЛНИЙ УРАНЗОХИОЛ ДАХЬ ЭНЭТХЭГ УРАН
ЗОХИОЛЫН ОРЧУУЛГА ТАРХАЛТЫН БАЙДАЛ****Чан Хуаньхуань *****ХУРААНГУЙ**

Дэлхийн эртний боловсон гүрний нэг хэмээгдсэн энэтхэг нь гүн нууц шашны өнгө төрхтэй соёлтой юм. Үүн лүгээ холбогдсон утга зохиол нь маш их хөгжилд хүрч, дэлхий дахинаа өвөрмөц байр суурьтай байдаг. Шинэ эринд, өөрчлөлт нээлтийн чөлөөтэй орчин нь гадаадын шилдэг соёлыг дамжуулан тараахад төд нөхцлийг ханган, ийнхүү ар үзэгдэл дор монгол үндэстний уран зохиол дахь энэтхэг уран зохиолын орчуулга, танилцуулгын тоо хэмжээ нь олширч эхэлсэн байна.

Түлхүүр үгс: Шинэ эрин, Энэтхэг уран зохиол, орчуулга, тархалт

Энэтхэг бол дэлхийн эртний боловсон улсын нэг болох бөгөөд энэтхэгийн эртний утга зохиол бол дэлхийн утга зохиолын түүхэнд хамгийн бүрэн төгс, хамгийн баялаг утга зохиолын эрдэнэсийн сангийн нэг нь мөн¹⁸. Монгол энэтхэгийн соёлын харилцаа нь шашны харилцаанд үндэслэсэн шинжтэй. Монголчууд аль эртнээс энэтхэгийн шашны ном зохиолыг орчуулахын хамт, “Зохист аялгууны толь” зэрэг онол өгүүлэхүйг дамжуулж, ойр орчин үеэс нааш Тагоре зэрэг уран бүтээлчдийн шүлэг зохиолыг орчуулан танилцуулж эхэлжээ.

Шинэ эрин –ээс нааш, өөрчлөлт нээлтийн чөлөөтэй орчин нь гадаадын шилдэг зохиолыг дамжуулан тархаахад төд нөхцлийг ханган өгчээ. Энэхүү ар үзэгдэл дор, монгол үндэстний уран зохиол дахь энэтхэг уран зохиолын орчуулга танилцуулгын тоо хэмжээ нь ч олширсон байна. Гэвч өнөө үед хүртэл, энэтхэг уран зохиолын шинэ эриний монгол үндэстний уран зохиол дахь орчуулга жич судалгааны байдлыг дан ганц

* 常欢欢, 2021 оны Харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын магистрант (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль).

Phone: 18847167063, Mail: 1426896082@qq.com

¹⁸ Чандмань, Баясгалан. “Гадаадын утга зохиолын түүх”, II боть, ӨМАХХ 1990, т 52



зохиолчийн жишээнд үзүүлсэн цөөн хэдэн судалгаа байхаас гадна, бүх талаар системтэй судалгаа хараахан гараагүй байна.

Нэг. Шинэ эриний монгол үндэстний уран зохиол дахь энэтхэг уран зохиолын орчуулгын байдал

1978 – 2015 он болтол, монгол түүвэр сэтгүүлд нийт 36 энэтхэг зохиолчийн 87 зохиол бүтээл нийтлэгдэн тархжээ. Үүний дотор 8 давхцлын зохиолтой байж, эдгээрийг гаргавал нийт 79 зохиол болно. Орчуулагдсан зохиол бүтээлийн тоо (давхцлын зохиолыг багтаахгүй) жич үүн лүгээ харгалзсан зохиолчийг хүснэгтээр илтгэлвэл доорх мэт:

Зохиолч	Зохиолын тоо	Зохиолч	Зохиолын тоо
Премчанд	6	Санкир Шайлендра	1
Гү. Нажияафали	1	Жайнендра	1
Амарагат	1	Тагоре	30
Валлатахул	2	Ананд	2
Бахай Вир Шин	1	Банким	2
Манулал Шарма Шил	1	Тевворе	1
Мохамиди Ир Бал	1	Сумадава	2
Бана	1	Галидаса	2
Сенапат	1	Бавапут	1
Бибүтипүшан	1	Прасад	1
Б.Тачарияа	2	Рушкин Бонд	1
Баса	1	Пүттект	1
Ширихарса	1	Б.Саханай	1
Сарат	2	Цо.Ёсёопел	1
Чандар	2	С.Томогайду	1
Дандин	1	Апита Кума	1
Маник	3	Ашок Чакраварт	1
Яшпал	1	Машибу Шинхе	1

Бодит тоо баримтаас үзвэл, шинэ эринд, энэтхэгийн Тагоре-ийн зохиол бүтээл хамгийн олон орчуулагдан тархагдсан байдаг. Бодитой зохиолчийн зохиол бүтээлээс гадна, шинэ эриний монгол түүвэр сэтгүүлд энэтхэгийн ардын аман зохиол бас өргөн тархсан байна. Үүнд мэргэдийн үлгэр, ёгт үлгэр, хүүхдийн үлгэр зэрэг төрөл зүйлийг багтаагаад нийт 25 үлгэрийн зохиол орчуулагдан нийтлэгджээ. Уран зохиолын текстийн орчуулгаас гадна, зохиолч жич зохиол бүтээлийн



танилцуулгын орчуулга нийт 6 байдаг. Хураангуйлбал, шинэ эриний монгол түүвэр, сэтгүүлд энэтхэг уран зохиолтой хамаатай орчуулгын зохиол нийт 118 байна. Шинэ эринд, энэтхэг уран зохиол нь монгол ном сэтгүүлд сонгогдон нийтлэгдсэнээс гадна, тусгай номоор хэвлэгдэн тархсан ч буй. Жишээлбэл, энэтхэгийн алдарт зохиолч Галидасийн “Үүлэн зардас” (уянгын найраглал), Гүршин Рэмдэн-ий “Шижим нь тасарсан цаасан шувуу” (роман), Премчандын “Нэг атга буудай” (роман), Чандарын “Би үхэж болохгүй” (роман), “Тагоре-ийн шүлгийн сонгомол”, “Тагоре-ийн задгай шүлгүүд” гэх зэргээр орчуулагдсан байна.

1. Түүвэрт сонгогдсон энэтхэг уран зохиолын орчуулгын байдал

Шинэ эриний монгол ном түүвэрт “Гадаадын хүүхдийн өгүүллэгүүд”, “Гадаадын өгүүллэгүүд”, “Ази Африкийн орны яруу найраг”, “Гадаадын уран зохиолын танилцуулга”, “Шүлгийн далайн шүр сувд”, “Гадаадын уран зохиолын агуулгын тойм”, “Дэлхийн уянгын шүлгийн сонгомол”, “Гадаадын шилмэл өгүүллэгүүд”, “Дотоод гадаадын мэргэдийн үлгэр”, “Дэлхийн алдарт хүүхдийн домгууд”, “Гадаад улсын аман үлгэр”, “Дэлхийн шагналт зохиолууд”, “Нобелын шагналтнуудын өгүүллэгүүд” зэрэг түүврүүд гадаадын утга зохиолыг сонгон орчуулж, нийт 89 энэтхэг зохиол бүтээл нийтлэгджээ. Энэ нь шинэ эриний энэтхэг уран зохиолын орчуулгын бүх тооны хагасаас илүүг эзэлж, эдгээр түүвэр нь энэтхэг уран зохиолын орчуулгын гол талбар болсон байна.

1980 онд ӨМАХХ –оос хэвлүүлсэн “Гадаадын хүүхдийн өгүүллэгүүд” гэх номд Чойралжавын монголчилсон “Гал цохих” гэх Премчандын хүүхдийн өгүүллэгийг нийтэлжээ. 1981 онд ӨМАХХ –оос хэвлүүлсэн “Гадаадын өгүүллэгүүд” гэх номд Цогтын орчуулсан Гү.Нажияафали-ийн “Баярын цэцэгт цагариг” ба Амарагатын “Ташуур хорхой” зэрэг хоёр өгүүллэгийг нийтэлсэн байдаг. 1983 онд ӨМСХХ –оос хэвлүүлсэн “Ази Африкийн орны яруу найраг”-т Валлатахулын “Энэтхэгийн дуу”, “Галт тэргэнд” гэх хоёр шүлэг, Бахай Вир Шин –ийн “Гоёлт”, Манулал Шарма Шил-ийн “Хүний дуу”, Мохамиди Ир Бал-ийн “Орчлон чамд шөнө заяасан гэхэд”, Санкир Шайлендра-ийн “Эх орон” зэрэг 6 шүлгийг кирилл үсгээс буулган нийтэлжээ. 1983 онд ӨМСХХ –оос хэвлүүлсэн “Гадаадын уран зохиолын танилцуулга” (дээд, доод) гэх бүтээлд Даянга-аас 10 энэтхэг уран зохиолыг хятад хэлнээс монгол



хэлэнд орчуулжээ. Тус түүвэрт Жайнендра-ийн “Тушаалаасаа огцров”, Тагоре-ийн “Живсэн онгоц”, Анандын “Харьцаж болшгүй эгэлчүүд”, Банкимын “Анандаз сүм” ба “Хорт могой”, Премчандын “Гудан”, Тегворе-ийн “Гвора” зэрэг тууж, “Фед” гэх шүлгийн түүвэр ба Сумадава-ийн “Үлгэрийн далай”-н танилцуулга жич “Упгуша болон дөрвөн өнгийн чөтгөр”, “Эрэгтэй эмэгтэйн аль нь нэн муу буй” гэх хоёр үлгэрийн зохиолыг сонгон орчуулжээ.

1986 онд ӨМСХХ –оос хэвлүүлсэн “Шүлгийн далайн шүр сувд” гэх гадаад шүлгийн түүвэрт Л.Одсэр, Нямаагийн орчуулсан Тагоре-ийн “Цэцэг чамдаа”, “Дахиад саллаа”, “Ширвэгдэл”, “Өр өвдөл”, “Энхрий хайрт хонгор минь”, “Амрагийн минь бэлэг” зэрэг 6 шүлгийг нийтэлжээ. 1987 онд хэвлэгдсэн “Гадаадын ардын аман зохиолын түүвэр”-т “В раман шашинтан”, “Цөөвөр ба Мавадын үлгэр”, “Залуу эрийн хүслэн”, “Зоос хүүлэгч шийтгэгдэв” зэрэг 4 энэтхэгийн ардын үлгэрийг Ариун, Буяндэлгэр нар хятад хэлнээс орчуулжээ.

1986, 87, 89 онд ӨМСХХ –оос хэвлүүлсэн “Гадаадын уран зохиолын агуулгын тойм” гэх 2 боть түүвэрт нийт 26 энэтхэг зохиол бүтээл орчуулагдан нийтлэгджээ. Үүнд 19 роман, 7 жүжгийн зохол багтана. 1 дүгээр боть (1986 он)-д Жайнендра-ийн “Огцролт”, Банкимын “Анандаз сүм” ба “Хорт могой”, Тагоре-ийн “Онгоц живсэн нь”, “Гора”, Премчандын “Гудан” зэрэг роман сонгогдов. 2 дугаар боть (1987 он)-д Бана-ийн “Кдамбари”, Анандын “Хар хүчний хүмүүс”, Сенапатын “Зургаан му тариа”, Бибүтипүшан-ийн “Аян замын дуулал”, Б.Тачария-ийн “Өлсгөлөн” зэрэг роман ба Тагоре-ийн “Улаан Доржмядаг”, Баса-ийн “Зүүднээс цочсон үлгэр”, Ширхарса-ийн “Луугийн баяр” зэрэг жүжгийн зохиол сонгогдов. 3 дугаар боть (1989 он)-д Премчандын “Энэрэнгүй ёст хүрээлэн”, Саратын “Хэв заншлыг эвдсэн хүн”, “Сриканта”, Чандарын “Ялагдал”, Дандины “Хааны арван хөвгүүний аяллын тэмдэглэл”, Маникийн “Пидма мөрний онгоцчин”, Яшпалын “Улсаас урвагч”, Б.Тачария-ийн “Барс унасан хүн” зэрэг роман ба Галидасын “Малавика ба Нимидра хаан”, “Сакунтла”, Бавапотын “Малат Мадава хоёр”, Прасадын “Сканда Гипта ван” зэрэг жүжгийн зохиол сонгогджээ. Эдгээрээс гадна тус түүвэрт “Жатака ном” (ёгт үлгэрийн түүвэр)-ын товч танилцуулга жич “Хөх тээлэй төрөл”, “Ведаду-ийн төрөл”, “Самж вангийн төрөл” зэрэг гурван ёгт үлгэр нь сонгогдон



орчуулагдаж, “Вед” (шүлгийн түүвэр), Сумадава-ийн “Үлгэрийн далай” (үлгэрийн түүвэр) ба Тагоре-ийн “Гитанжали” (шүлгийн түүвэр)-ийн тухай танилцуулгын орчуулга байдаг.

1990 онд ӨМАХХ –оос хэвлүүлсэн “Дэлхийн уянгын шүлгийн сонгомол”-д Тагоре-ийн “Хүүхдийн ертөнц”, “Баярын хөгжим хангиналаа”, “Тийм л юм шиг”, “Жанге”, “Хөвөө хаяагийн түүвэр”-ийн 18 дугаар шүлэг зэрэг зургаан шүлгийг сонгон нийтэлжээ. 1993 онд ӨМСХХ –оос хэвлүүлсэн “Гадаадын шилмэл өгүүллэгүүд” гэх номд Бао Юй Ин-ий монголчилсон Тагоре-ийн “Суба”, Г.Чойравжаагийн монголчилсон Машибу Синхе-ийн “Хар аав болон цагаан аав”, Н.Өлзийбатын монголчилсон Рушкин Бондын “Тэргэн дээр учирсан хүүхэн” зэрэг зохиолыг нийтэлжээ. 1993 онд Үндэстний хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн “Дотоод гадаадын мэргэдийн үлгэр” хэмээх бүтээлд “Гурван онгоц”, “Шатрын хөлөг дээрх буудайн мөхлөг”, “Хацраа алгадуулсан нь”, “Бирба хийгээд улсын ван”, “Арга түмэн лан”, “Ван зурхайч хоёр”, “Эмгэн ээж хулгайч барьсан нь”, “Ургаа модоор гэрчлүүлсэн нь”, “Догшин барс хүнээс айна”, “Гудамж цэвэрлэгч бүсгүй ба зулчин”, “Нэг аяга үнээний сүү”, “Үгэн дотор үгтэй”, “Хариулахад хүчир дөрвөн асуулт”, “Тэргүүлэгч сайд сонгосон нь” зэрэг 14 мэргэдийн үлгэрийг сонгон нийтэлсэн байна.

2001 онд ӨМАХХ –оос хэвлүүлсэн “Дэлхийн алдарт хүүхдийн домгууд” гэх үргэлжилсэн зурагт дэвтэрт Чандарын “Тонгоруу ургасан мод” гэдэг романыг сонгон орчуулжээ. 2011 онд ӨМСХХ –оос хэвлүүлсэн “Гадаад улсын аман үлгэр” гэх аман үлгэрийн түүвэрт “Гурван худалдаачин муурын гурван хөлийг худалдаж авсан нь”, “Машларупия-ийн нэхмэлчин”, “Ван хийгээд түүний тэргүүлэгч сайд” зэрэг гурван аман үлгэрийг эрдэмтэн Оюун орчуулав. 2012 онд ӨМСХХ –оос хэвлүүлсэн “Дэлхийн шагналт зохиолууд” хэмээх бүтээлд Рушкин Бондын “Тэргэн дээр учирсан хүүхэн” гэх романыг Н.Өлзийбат орчуулжээ. 2017 онд ӨМАХХ –оос хэвлүүлсэн “Нобелын шагналтнуудын өгүүллэгүүд”-д Тагоре-ийн Кавукабабу эргэж ирсэн нь” гэх романыг Журамт кирилл үсгээс буулгав. Шинэ эриний монгол ном түүвэрт сонгогдсон энэтхэгийн зохиол бүтээл нь шүлэг, ардын аман зохиол, тууж, жүжгийн зохиол зэрэг олон хэлбэр төрлийг хамарч, 18



шүлэг, 30 аман зохиол, 34 туужийн зохиол, 7 жүжгийн зохиол орчуулагджээ.

2. Сэтгүүл дээр нийтлэгдсэн энэтхэг уран зохиолын орчуулгын байдал

Шинэ эринд, энэтхэг уран зохиол нь монгол хэлний ном түүвэрт сонгогдон орчуулагдсанаар үл барам, “Дэлхийн утга зохиол”, “Жиримийн уран зохиол”, “Хун галуу”, “Цоморлиг” гэх сэтгүүлд ч тархалтаа олжээ. Эдгээр сэтгүүлд нийт 23 энэтхэг уран зохиол нийтлэгдэж, 18 зохиол нь “Дэлхийн утга зохиол” сэтгүүлд тархаж, тус сэтгүүл орчуулгын бүтээлийн гол талбар болов.

1979-1989 он			
Зохиолч	Зохиол бүтээл	Орчуулагч	Нийтэлсэн хугацаа
Премчанд	Тосгоны худаг	Монь	1980.1
Тагоре	Капүл хүн	Нямноров	1980.2
Тагоре	Суба	Бао Юй Ин	1980.2
Тагоре	Сүүдэр	Үхэрчин	1982.1
Машибу Шинхе	Хар ба цагаан аав	Г.Чойравжаа	1982.2
Тагоре	Ирибали	Чимэгмаа	1982.3
Маник	Хулгайч	М.Хишигжаргал	1983.3

1979-1989 он			
Зохиолч	Зохиол бүтээл	Орчуулагч	Нийтэлсэн хугацаа
Тагоре	Мохемоеэ	Гочоо	1983.4
Маник	Жиутбакупул	Вү Юэ	1984.1
Рушкин Бонд	Тэргэн дээр учирсан хүүхэн	Н.Өлзийбат	1986.1
1990-1999 он			
Зохиолч	Зохиол бүтээл	Орчуулагч	Нийтэлсэн хугацаа
Пүттект	Галзуу нохой	Батболд	1991.3
Б.Саханай	Ноёноо будаалсан нь	Тодорхой бус	1992.3
Тагоре	Оронцог	Мандарваа	1993.3
Цо.Ёсёопел	Шинэ танил ах	Тодорхой бус	1994.6



2000-2015 он			
Зохиолч	Зохиол бүтээл	Орчуулагч	Нийтэлсэн хугацаа
С.Томогайду	Чандар	Тодорхой бус	2000.2
Тагоре	Кавукабабу эргэж ирсэн нь	Тодорхой бус	2004.4
Апита, Күмэ	Хэвлий дэх охины гуйлт	Аюурзана	2006.5
Ашок Чакраварт	Хайр бишрэл хүлээсэн хаан – Чингис хаан	Тодорхой бус	2007.4

“Дэлхийн утга зохиол” сэтгүүл дэх орчуулгын байдал

Дэлхийн утга зохиол сэтгүүл 1979 оноос эхлэн, тус ондоо нэг л хугацаа хэвлэгдэж, 1980 оноос эхлэн улирлын сэтгүүлийн хэлбэрээр жил болгон дөрвөн хугацаа хэвлэгдэн, 1999 оноос дахин хос сарын сэтгүүлийн хэлбэрт шилжин өнөө хүртэл хэвлэгдсэн байна. 1979-2015 он хүртэл тус сэтгүүлд нийт 18 энэтхэг зохиол нийтлэгджээ. Үүнд Ашок Чакравартын “Хайр бишрэл хүлээсэн хаан – Чингис хаан” гэх 1 шүлгээс гадна бусад 17 нь бүр өгүүллэгийн зохиол болно. Хүснэгтээс үзэхэд, 80-аад он (1979-1989)-д 10 зохиол, 90-ээд он (1990-1999)-д 4 зохиол, 2000-2015 онд 4 зохиол нийтлэгдсэн байна. Үүнээс шинэ эриний монгол уран зохиол дахь энэтхэг уран зохиолын орчуулга нь 80-аад оны үеэр нэг хэмжээний өрнөлтөө олж, 90-ээд оноос хойш бууралтын шатанд орсныг ажиглаж болохоор байна.

“Жиримийн уран зохиол”, “Хун галуу”, “Цоморлиг” сэтгүүл дэх орчуулгын байдал

Дэлхийн утга зохиол сэтгүүлээс гадна, шинэ эриний Жиримийн уран зохиол, Хун галуу, Цоморлиг зэрэг уран зохиолын сэтгүүлд бас өдий төдий энэтхэг уран зохиол орчуулагдан тархжээ. 1978-2015 он болтол Жиримийн уран зохиолын 1984 оны 6 дугаар хугацаанд Тагоре-ийн “Огоорол” гэх өгүүллэгийг нийтлэв. Цоморлиг сэтгүүлд Сарангийн орчуулсан Премчандын “Шалунта хатан” гэх өгүүллэгийг 1981 оны 3 дугаар хугацаанд нийтэлжээ. Хун галуу сэтгүүлд Дондовын орчуулсан “Ариун хайр хийслээ” гэх дууг 1980 оны 1 дүгээр хугацаанд нийтэлжээ. Зулдайн орчуулсан Тагоре-ийн “Тэр бүл”, “Хүүхдийн ёсон”, “Анхааралд үгүй хээ засал” зэрэг шүлгийг 1985 оны 1 дүгээр хугацаанд нийтэлжээ.



1985 оны 2 дугаар хугацаанд Зулдайн орчуулсан Тагоре-ийн “Нойр хулгайлагч”, “Эхлэлт”, “Хүүхдийн ертөнц” зэрэг шүлгийг нийтэлжээ. 1988 оны 6 дугаар хугацаанд, Төгсбаярын орчуулсан “Гайсер хаан” гэх аман үлгэрийг нийтэлсэн байна. Дэлхийн утга зохиол, Жиримийн уран зохиол, Хун галуу, Цоморлиг зэрэг сэтгүүл дэх энэтхэг уран зохиолын орчуулгаас үзвэл, тууж зохиол зонхилох хэсгийг эзэлж, нийт 19 нийтлэгдэн, шүлэг дэд байранд орж, нийт 8 нийтлэгдсэн байна.

3. Тусгай номоор хэвлэгдсэн энэтхэг уран зохиол

Энэтхэг уран зохиол нь монгол түүвэр, сэтгүүл зэрэгт сонгогдон орчуулагдсанаас гадна, тусгай ном болж хэвлэгдсэн ч буй. Шинэ эринд, Галидасын “Үүлэн зардас” (уянгын найраглал), Гүршин Рэмдэн-ий “Шижим нь тасарсан цаасан шувуу” (роман), Премчандын “Нэг атга буудай” (роман), Чандарын “Би үхэж болохгүй” (роман), “Тагоре-ийн шүлгийн сонгомол”, “Тагоре-ийн задгай шүлгүүд” зэрэг зохиол бүтээл хэвлэгдэн гарчээ. Галидаса бол эртний энэтхэгийн дэлхийн нөлөө бүхий шалгарсан шүлэгч бөгөөд жүжгийн зохиолч байж, 1000 гаруй жилийн турш, түүний зохиол бүтээл нь энэтхэгийн утга зохиолын оргил хэмээн нийтлэгдсээр иржээ¹⁹. Үүлэн зардас бол түүний хамгийн алдартай уянгын найраглал байж, 1981 оны 5 сард, Монгол улсын Б.Ринчений орчуулгаар Бээжингийн үндэстний хэвлэлийн хорооноос хэвлэгдэн гарчээ. Гүршин Рэмдэн бол энэтхэгийн алдарт эмэгтэй зохиолч, түүний “Шижим нь тасарсан цаасан шувуу” гэх өгүүллэг нь 1982 оны 10 сард, Сүег нарын орчуулгаар ӨМСХХ –оос хэвлэгдэж, 2018 оны 6 сарын 1-нд 2 дугаар хэвлэл нь хэвлэгдэн тархав. Премчанд бол энэтхэгийн орчин үеийн утга зохиолын үндсийг тавигчийн нэг мөн. Түүний өгүүллэгийн зохиол “Нэг атга буудай” нь 1985 оны 8 сард, Норовсүрэнгийн орчуулгаар Үндэстний хэвлэлийн хорооноос хэвлэгдэн тархав. Энэтхэгийн тусгаар тогтносны дараах шалгарсан зохиолч Чандарын “Би үхэж болохгүй” гэх бүтээл нь 1985 оны 8 сард Үндэстний хэвлэлийн хорооноос хэвлэгдэв. Нобелын шагналт зохиолч Тагоре-ийн хятад орчуулгын задгай шүлгийн түүвэр “Тагоре-ийн шүлгийн сонгомол”-ыг 1984 оны 11 сард, Н.Сундуй монгол хэлэнд орчуулж, ӨМСХХ –оос хэвлүүлэн тархаажээ. 1985 оны 10 сард, “Тагоре-ийн задгай шүлгүүд” гэх

¹⁹ Галт. “Гадаадын уран зохиолын түүх”, II боть, ӨМСХХ 1994, т 85



түүврийг Нулмасаран, М.Асар нар хятад хэлнээс монгол хэлэнд орчуулж, ӨМАХХ –оос хэвлүүлэв. “Тагоре-ийн шүлгийн сонгомол”-д Тагоре-ийн “Цэцэрлэгч болсон түүвэр” ба “Болжмор одсон түүвэр” гэх хоёр шүлгийн түүврээс сонгогдсон шүлгүүд байж, “Тагоре-ийн задгай шүлгүүд”-д нь “Шинэ сарны түүвэр”, “Гитанжали”, “Үр жимс” зэрэг түүврийн шүлгүүд нь сонгогдон оржээ.

Хоёр. Энэтхэг уран зохиолын шинэ эриний монгол үндэстний уран зохиол дахь тархалтын түүхэн улбаа

1. Харь зуучаар хүрсэн байдал

Төрөл зүйл	Хятад зууч	Кирилл зууч	Бүх тоо
Тоо норм			
Тоо хэмжээ	110	7	118
100-ны харьцал	94%	6%	100%

Орчуулгад эш болсон зохиолыг нь үндэслэж орчуулгыг шууд орчуулга, дам орчуулга гэж хоёр төрөлд хуваадаг. Шууд орчуулга гэдэг нь нэг төрлийн хэлний зохиолыг бусад хэлний дамжилтгүйгээр өөр нэг хэл дээр орчуулан илтгэхийг заана, дам орчуулга гэдэг нь нэг хэлний зохиолд бусад хэлээр дамжуулан өөр нэг төрлийн хэл дээр орчуулахыг хэлдэг²⁰. Шинэ эриний монгол үндэстний уран зохиол дахь энэтхэг уран зохиол үндсэндээ бүр дам орчуулгаар дамжин тархаагдаж, голдуу хятад хэлнээс орчуулсан ба кирилл үсгээс буулгасан байдалтай байна. Бодит тоо баримтаар илтгэвэл доорх мэт:

Хятад хэлний зуучаар дамжин тархсан нь

Бодит тоо баримтаас үзвэл, шинэ эриний монгол үндэстний уран зохиол дахь энэтхэг уран зохиолын хятад зуучийг дамжсан бүтээл бүх орчуулгын зохиол бүтээлийн 94.4%-г эзэлсэн байна. Дундад улсын монгол үндэстэн урт хугацаанд хятад үндэстэнтэй холилдон суурьшиж, хятад үндэстний соёлын нөлөөг шууд буюу дам байдлаар хүртсээр иржээ. Шинэ дундад улс байгуулагдсанаас нааш өвөр монгол оронд хос хэлний сурган хүмүүжлийн төрийн бодлогыг явуулж, хятад хэлийг суралцаж, тус хэлэнд мэргэшихэд төд болсон байна. 1947 онд, урт хугацаа

²⁰ “Орчуулгын ухааны суурь”. ӨМАХХ 1989, т 13



колончлолын хал там амсаж байсан энэтхэг улс тусгаар тогтнож, үндэстний чөлөөлөлтийг дагалдан нийгмийн үзэл ухамсрын хэлбэр бүхий уран зохиол нь ч өрнөлтийн байдалд оржээ. 50-аад оны үед, Дундад улсын Бээжингийн зохиолчдын хэвлэлийн хороо, Ардын соёлын хэвлэлийн хороо, Шанхайн шинэ утга урлагийн хорооноос “Ази Африкийн уран зохиол” гэх тусгай бүлэг гаргаж, энэтхэг уран зохиолыг их хэмжээгээр орчуулан нийтэлж байжээ²¹. Эдгээр ашигтай нөхцөл нь энэтхэг уран зохиолын монгол үндэстэнд уран зохиолын тархалтад төд замыг ханган өгчээ.

Кирилл бичгийн зуучаар дамжин тархсан нь

Шинэ эринд, энэтхэг уран зохиол нь хятад хэлийг монгол хэлэнд орчуулагдсанаар үл барам, кирилл бичгийг ч дамжин өвөр монголчуудад соёлын хүртээл болж байжээ. Газарзүйн байрлалаас үзвэл, ар, өвөр монгол хил нийлэн суурьшиж, урт хугацаанд соёлын солилцоо хийсээр ирсэн юм. Ар, өвөр монголын адилавар амьдрал, хэл хэлэхүйн орчин жич соёлын суурь нь өвөр монголын монголчуудад монгол улсын утга зохиолыг амархан хүлээн авах боломжийг олгосон байдаг.

2. Тархалтын онцлог

Нэгд, Сонгодог зохиолчийн бүтээл олон тархжээ. Шинэ эриний монгол үндэстний уран зохиолд энэтхэгийн төлөөлөх чанартай Тагоре, Премчанд зэрэг зохиолчийн бүтээл олон орчуулагдан тархсан байна. Тагоре бол энэтхэгийн ойрх орчин үеийн утга зохиолын суурийг тавьсан зохиолч бөгөөд Ази тивийн анхны нобелын шагналт зохиолч мөн. Тэрээр 60 гаруй жилийн зохион бүтээлтийн хугацаандаа хоёр мянга шахам зохиол бүтээл туурвиж, элбэг баялаг уран зохиолын эд эрдэнэсийг үлдээсэн юм. Шинэ эриний монгол түүвэрт, түүний “Цэцэг чамдаа” (1986 он), “Дахиад салаа” (1986 он), “Ширвэгдэл” (1986 он), “Өр өвдөл” (1986 он), “Энхрий хайрт хонгор минь” (1986 он), “Амрагийн минь бэлэг” (1986 он), “Хүүхдийн ертөнц”, “Баярын хөгжим хангиналаа” (1990 он), “Тийм л юм шиг” (1990 он), “Жанге” (1990 он), “Хөвөө хаяагийн түүвэр”-ийн 18 дугаар шүлэг (1990 он), “Гэр бүл” (1980 он), “Хүүхдийн ёсон” (1980 он), “Анхааралд үгүй хээ засал” (1980 он), “Нойр хулгайлагч”

²¹ 黎跃进：天津师范大学，“新中国印度文学思潮流派译介与研究的考察”，外语与翻译，1992年第9期，50至52页。



(1985 он), “Эхлэлт” (1985 он), “Хүүхдийн ертөнц” (1985 он) зэрэг шүлгүүд, “Онгоц живсэн нь” (1986 он), “Гора” (1986 он), “Суба” (1993 он), “Капүл хүн” (1980 он), “Сүүдэр” (1982 он), “Ирибали” (1982 он), “Мохемоез” (1983 он), “Оронцог” (1993 он), “Огоорол” (1984 он), “Кавукабабу эргэж ирсэн нь” (2004 он) зэрэг туужууд монгол хэлэнд орчуулагдан тархав. Үүнээс гадна, “Тагоре-ийн шүлгийн сонгомол” (1984 он), “Тагоре-ийн задгай шүлгүүд” (1985 он) зэрэг задгай шүлгүүдийн сонгомол дэвтэр хэвлэгджээ.

Премчанд бол энэтхэгийн утга зохиолын түүхэн дэх шалгарсан зохиолч бөгөөд орчин үеийн утга зохиолын үндэслэгчдийн нэг мөн²². Шинэ эриний монгол хэлний түүвэрт, түүний “Гал цохих” 1980, “Тудан” 1986, “Энэрэнгүй ёст хүрээлэн” 1989, “Тосгоны худаг” 1980, “Шалунта хатан” 1981 зэрэг туужийн бүтээл нь орчуулагдан тархсан байна.

Тагоре, Премчандаас гадна, Чандар, Ананд, Маник зэрэг энэтхэгийн алдарт зохиолчдын зохиол бүтээл олон нийтлэгджээ. Эдгээр хүмүүсийн зохиол бүтээл энэтхэг цаашлан дэлхийн утга зохиолд ч эрхэм нандин өвийг үлдээж өгсөн байна.

Хоёрт, Утга сэдвийн талаар феодал ёс, колончлолыг эсэргүүцсэн зохиол бүтээл олон тархжээ. Энэтхэгийн ойрх үеийн түүх бол тухайн ард түмний английн колончлолыг эсэргүүцсэн үндэстний чөлөөлөлтийн тэмцлийн түүх болно²³. Иймээс ойрх үеийн утга зохиолын агуулгын олонх нь бодит ахуйд чиглэж, үндэстний хувь заяанд холбогдсон онц чухал нийгмийн гол сэдвийг бичсэн байна. Үүний дотор колончлолыг эсэргүүцэх, феодалыг эсэргүүцэх агуулгын уялдаа нь энэтхэг уран зохиолыг ахуйч үзлийн замд хөтөлж, ойрх үеийн утга зохиолын гол онцлогийг бүрэлдүүлжээ. Тагоре, Сарат, Премчанд зэрэг энэтхэгийн төлөөлөх зохиолчид нь 19 дүгээр зууны дунд үеийн энэтхэг үндэстний чөлөөлөлтийн хөдөлгөөний өрнөлт дундаас тодрон гарсан юм. Тагоре-ийн “Мохемоез” гэх өгүүллэгт, Ганган хүүхэн Мохемоез-ийн харамсалт нэг насаар дамжуулан, бусдаар эзэн мэдүүлсэн феодалын ургийн дүрэм, овог ялгалын дүрэм зэргийг илчлэн буруушаан, феодалыг эсэргүүцсэн эрс чанга байдлыг илэрхийлсэн байдаг. “Гора” гэх романд Тагоре-аас 19

²² Галт. “Гадаадын уран зохиолын түүх”, II боть, ӨМСХХ 1994, т 458

²³ Чандмань, Баясгалан. “Гадаадын утга зохиолын түүх”, II боть, ӨМАХХ 1990, т 282



дүгээр зууны 70, 80-аад оны үеийн колончлол доорх энэтхэгийн нийгмийн зөрчил, будлиант байдлыг үнэн бодитоор дэлгэн үзүүлж, колончлол ба феодалыг эсэргүүцэн, үндэстний ухамсрыг сэргээх гэсэн үзлээ илтгэсэн байна. Саратын “Сриканта” хэмээх романд Сриканта ба дуучин хүүхэн Ражияалкашми хоёрын хайрын түүхээр дамжуулан, 20 дугаар зууны эхэн үеийн ард түмний ялзармал феодал, колончлогчдын ноёрхол доорх гаслант амьдралыг дэлгэн үзүүлж, нийгмийн эмзэг талыг шүүмжилсэн юм. Премчандын “Гудан”, “Энэрэнгүй ёст хүрээлэн”-д феодал нийгэм дэх эгэл доорд ард түмний харуусалт амьдралыг зураглахаар дамжин феодал нийгмийн гэм архагийг илчилсэн байна. Үүнээс гадна, Тагоре-ийн “Капүл хүн”, “Живсэн онгоц”, Премчандын “Нэг атга буудай”, Анандын “Харьцаж болшгүй эгэлчүүд”, “Хар хүчний хүмүүс” зэрэг өгүүллэгт бүр нийгмийн байр сууринд эгэл ардын зовлонг амьдрал, азгүй учралыг бичихээр дамжин феодал нийгмийн дүрмийн гажуу буруу, колончлолын харгис хэрцгий байдлыг дэлгэн үзүүлжээ.

Гуравт, Ардын аман зохиолын тархалт нь энэтхэг уран зохиолын эртний элбэг нөөцийг харуулна. Аль эрт НТӨ 3000 жилийн үеэр энэтхэг орон нэлээд өндөр соёлыг бүтээсэн байна²⁴. Энэтхэгийн эртний хоёр том дууль “Рамаяана”, “Махабарата” ба “Үлгэрийн далай”, “Панчатандара” зэрэг аман зохиолын цоморлиг нь энэтхэг уран зохиолын өв хөрөнгө бөгөөд дэлхийн уран зохиолын эд эрдэнэс мөн. Шинэ эриний монгол хэл дэх энэтхэгийн уран зохиолын орчуулгын тоо дэд байранд ордог. Энэтхэгийн аман зохиолын орчуулга нь монгол хэлний уран зохиолд шинэ энерги болж, харьцуулсан утга зохиолын судалгааны цар хүрээг өргөтгөсөн байна.

Дөрөвт, Шинэ эриний монгол хэл дэх энэтхэгийн уран зохиол нь голдуу хятад хэлийг дамжин тархсан онцлогтой. 118 орчуулгын бүтээлийн 111 нь бүр хятад хэлээр дамжин монгол хэлэнд тархжээ. Энэтхэг бол олон үндэстнээс бүрэлдсэн улс, бенгал хэл, энэтхэг хэл, үрт хэл зэрэг үндэстний онцлог бүхий орон нутгийн хэлээр бичигдсэн зохиол бүтээл зэргээс бүрэлдсэн байна²⁵. Орчуулга нь нэг зүйлийн үг хэл, соёлын харилцааны арга болсны хувьд, орчуулгын ажил нь

²⁴ Галт. “Гадаадын уран зохиолын түүх”, II боть, ӨМСХХ 1994, т 52

²⁵ Галт. “Гадаадын уран зохиолын түүх”, II боть, ӨМСХХ 1994, т 302



орчуулагчийн орчуулах гэж байгаа зохиол бүтээлийн ар дахь үндэстнийх нь соёлыг гүйцэд ойлгон, үндэстнийх нь үг хэл үсэг бичигт нь нэвтрэхийг шаарддаг. Хятад үндэстний дотор энэтхэгийн үндэстний хэлэнд нэвтэрсэн хүн голдуу Жөн Жэньдуо (郑振铎 zheng zhen duo), Хуан Баошөн (黄宝生 huan bao sheng), Ни Пэйгөн (倪培耕 ni pei geng) зэрэг байж, Дэлхийн утга зохиол сэтгүүлийн эш хэвлэл болох хятад сэтгүүл “世界文学 shi jie wen xue” (Дундад улсын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн, уг нэр нь “译文 yi wen” болно) дэх энэтхэгийн уран зохиолыг эдгээр хүмүүс орчуулсан байна.

Шинэ эриний монгол хэлний уран зохиол дахь энэтхэг уран зохиолын орчуулга нь хэдийгээр голдуу хятад хэлийг дамжин монгол хэлний уран зохиолд тархсан ч тэр нь орчуулах явцдаа үндэстэнчилж, монгол уран зохиолын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон байна. Иймээс гадаадын уран зохиолын орчуулга бол тасралтгүй өөрийн үндэстний утга зохиол ба баялагжуулж, үндэстний соёлоо хөгжүүлж байгаа явдал мөн.

Тайлбар: Явцуу утгаар шинэ эриний уран зохиол гэдэг нь 1978-1992 оны хоорондох уран зохиолыг заана. Дэлгэрэнгүй утгаар шинэ эриний уран зохиол гэдэг нь шинэ эрин-1978-1992, хожуу шинэ эрин-1993-2000 жич шинэ зуун 2001 оноос эдүгээ хүртэл уран зохиолыг нийтэд нь багтаадаг. Тус өгүүлэлд өгүүлэн бүхий шинэ эриний монгол уран зохиол гэдэг нь цаг хугацааны хувьд 1978-2015 оны хоорондох өвөр монголын монгол үндэстний уран зохиолыг нэрлэсэн байна.

ӨМАХХ – Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

ӨМСХХ – Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо

ABSTRACT

As one of the ancient civilizations in the world, India has a mysterious religious culture, and the Indian literature connected with it has also been developed accordingly. In the new era, the environment of China's reform and opening up has created favorable conditions for the dissemination of foreign excellent culture. Under this background, the translation and introduction of Indian literature in Mongolian literature is gradually increasing.

Keywords: *New age, Indian literature, translation, distribution*

**Л.ЧУЛУУНБААТАРЫН ШҮЛЭГ ДЭХ “ХҮҮХДИЙН ЕРТӨНЦ” *****Л.Хасбаатар *, Хуар*****ХУРААНГУЙ**

Л.Чулуунбаатарын хүүхдийн шүлэг нь хүүхдийн хөгжим дуу шиг цовоо цолгин, алиа дэгжин цаг үе, хүүхэд насны гэнэ цайлган бодол сэтгэл, үйл учралыг үлгэрийн кино дэлгэцийн шинжээр илэрхийлэн зурагласан мөр бадгууд, хүүхэд үеийн байдал шинж бол нэгэн хүсэл мөрөөдлийн, зүүд зэрэглээн цаг үе тул тэдний ой бодлыг юугаар илэрхийлж болох тухай сонин сэтгэмж бүхий шүлэг найргууд байдгийг тодорхойлон гаргахыг зорив.

Түлхүүр үгс: Хүүхэд нас, хүсэл, мөрөөдөл, одоо

Шүлгийн ертөнцийг хүмүүс янз бүрээр тайлбарлана. Нэг бол шүлгийг залуу хүмүүсийн нүдээр харж бичиж байж ертөнц дэлхийн тухай төөрч ухаарсан сонин сонин учрал тохиол илэрдэг гэх юм, нэг бол бүр настай хүний томоожсон байдлаар энэ уяхан замбуулингийн улиран хувьсах мянга түмэн үзэгдэл юмсыг туулж өнгөрсөн ухаалаг туршлага суусан бодлоор тунгаан сургасан захисан мөр бадгуудыг тэрлэдэг гэх юм. Эсвэл бүх хүүхдийн нүдээр ертөнцийг сонирхон шохоорхсон алиа бодлоох бичих ёстой гэх юм.

Тийм ээ, бидний үед хүүхдийн шүлэг их хомсдож байна. Цөөн хэдэн шүлэгчид энэ сэдвээр тууштай хөндөн бичиж байгаа боловч ер нь хүүхдийн шүлгийн уг санаанаас гажууд байх зүйл дандаа ажиглагдана. Юу тэр вэ? гэвэл хүүхдийн шүлэг бол хүүхдийн сэтгэл бодлын илрэл, сонирхол, гайхал байх хэрэгтэй. Тэдний эмзэгхэн бодол, тэдний хэл хэллэг, тэдний эрэл хайгуул, тэдний зугаа цэнгэлийн оюун бодол байх учиртай. Тийм биш бол хийсвэр хуурай, аргалж цааргалсан хүчээр

* Тус өгүүлэл нь 2016-2021 оны Дундад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Суурь Мөнгөний Нийгэмлэгийн Судалгааны Төслийн хүрээнд бичигджээ.

* Доктор, профессор (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургуулийн багш).

* 2020 оны утга зохиолын магистрант (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль).



шахсан, хоосон сургаал захиас буюу нэг том томорсон тоочилтууд болчихдог байна.

Нэг. Хүүхэд бол хөгжим мөн

Хүүхдийн бодол эх адаггүй, замбараагүй бас гэнэн гэдгийг “Ишиг” шүлэгт:

Дээгүүр нь үсэрвэл

Яадаг юм байна

Доогуур нь шургавал

Яадаг юм байна

Дэлхий гэдэг

Ийм л үү

Тэгээд үсрэхэд

Эвтэй л байна

Үсрээд л байя

Үсрээд л байя

Үгүй байж

Өлсөж байна

Мөөм ер нь

Яагаа вэ

Май ! май !

*Май ! май !*²⁶ гэж маш энгийн агаад хөгжилтэй зурагласан байх юм. Энэ бол хүүхэд насны гэнэн багын дүрслэл. Тэдэнд бодох зүйл гэж үгүй, тоглоод үсрээд л байх юм. Тэдэнд зовж тооцоолох төсөв төлөвлөгөө гэж үгүй, цаг зав болгоныг тоглож наадаж өнгөрөх нь нэг ёсны жаргал цэнгэл мөн. Тэгээд бах таваа ханатал тоглож дуусвал

²⁶ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 171



өлссөнөө мэдэрч байна. Ээж ээ! хаана байна! би өлсөж байна! гэх л амар хялбар зураглал. Энэ бол зөвхөн хүүхэд насанд л байдаг гэнэн цайлган, эрх чөлөөт амьдрал билээ. Харин бид түүнд ямар нэгэн чимэг зүүлт хийх буюу одоо яаж энэ дэлхийг танья! гэж ухаан санаа гаргаж эхлэх л юм бол энэ шүлэг тэр чигээрээ балрах нь ээ! амьдралын дунд эрх тэгш бус, хүмүүсийн дээрэм тонуулын шинжтэй үйл хийж буйг тугалын нүдээр харуулж, мэргэн заалдлага хийлгэсэн энэ шүлэгт:

Элдэв амьтан байх гэж
Ээж надад хэлээ билээ
Илүүхэн чагнаж яваасай гэж
Итгэж бас захиа билээ
Хачин хачин байна
Харин тэр
Хоёр хөлтэй юмаа
Нэн ч аймар хачин байна
Нэг л бишийг дөтнөх юм
Нээрэн ухаан нь олдож өгөхгүй
Явган оцойж суух юм
Яасан ч муухай үзэгдэх юм
Өөдөөс нь би ингэвэл
Өөрийн чих маань ч дэлдийчихлээ
Үмбүү ээжийг минь сааж байна
Өдөрт намайг өлсгөж байна
Элдэв юм байх гэж



Ээж надад хэлээ билээ²⁷ Үүнээс үзэхэд, энэ бол нүүдэлчин малчны энгийн амьдралын нэгэн зураглал харагдаж байвч энэ дотор эрх тэгш бус үзэгдэл, хүүхдийн эрх чөлөөнд халдаж байгаа маш зүй бус үйлдэл явагдаж байна. Олон мянган жилийн турш хар тэргүүт хүн өөрийн амьдралынхаа нөөц бололцоог хангахын тулд бусдын ашиг сонирхол, амь амьдралын чухал зүйл болох “сүү”-г нь булаан авч энэ дэлхийн эв найрсаг, энх амгалан амьдралыг эвдэн сүйтгэж, тайван бус амьдралыг үүсгэдэг байна.

Энэ нь эх байгалийн юм бүхэн зохицонгуй, найрсаг, бүх юмс замаараа, хөдөлгөөний шалтгаангүйгээр, алгуурхнаар үл мэдэгдэм өсөж хөгжиж, хувирч өөрчлөгдөх жам хуульд эрс эвдлэл хийж буй. Хүн байсан газар шунал дагалдаж л байдаг, өөр бусдын ашиг сонирхолд зайлшгүй халдлага хийж байх гэдэг зүй бусыг тэд гаргаж байна.

Энэ шүлэг маш товч харсан үзсэнээ шууд тоочиж “тугал”-ын бодлоор хэлүүлжээ. Хүмүүсийн аль болох, болохгүй үйл лайг бидний ойлголтоор тоочиж шүүмжлэх юм бол, шүлэг биш шүүмжлэн өгүүлсэн зохиол болж улигаа барах байлгүй. Харин хүүхдийн гэнэн өсвөр бодлоор тугалын энэхүү заалдлага хийж байгаа нь маш оновчтой арга барил болж чадсан байна. Юу үнэн бэ? хүүхдийн үзэл бүх үнэнийг тэр чигээр нь хэлж гаргадаг хамаг учир буй!

Найрагч хүүхдийн шүлгийг маш гүн сэтгэж бичдэг нь ажиглагдана. Хүй их хорвоо дэлхийн үе дамжин үргэлжлэх үйлийн үрийн тухай, өнгөрсөн үеэ залгамжилж хойч шинэ үе нь бүрддэг тухай, мөн дэлхий дахины амь ахуйн үүсэл хөгжлийн мөн чанарыг маш эвлэг илтгэсэн нэгэн шүлэг буй.

Цорвоо

Цор

Цор

Цорвоо

²⁷ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 172



Хор

Хор

Хорвоо

Цорвоо наашаа

Гүйлдэнэ

Цорвоо (цэн) шиг ээ

Харагдана

Хорвоо түүнийг

Тэжээнэ

Хурмаст тэнгэр

Цэлмэнэ

Нэг

Цорвоо

Нэгэн

Хорвоо

Нэгэн

Хорвоо

Нийтийн

Цорвоо

Цор

Цор

Хор

Хор

Хорвоо



Дээрхээс ажиглавал, хүүхдийн хэл зүгшрүүлэх шүлэг ч юм шиг, эсвэл хүүхдийн дуу ч юм шиг, бүхийл шүлэг төгсгөлдөө ганц нэг давхар цэг л хэрэглэсэн байх юм. Ерөнхийдөө нэг үг нэг мөр шүлэг, эсвэл хоёр үг нэг мөр шүлэг болж нийт 245 мөр дотор эхэн буюу төгсгөлийн 6 мөр нь бас давхцаж байна. Энд ямар нэгэн хүүрнэл тоочилт гэж алга, ямар нэгэн тайлбар ч байхгүй. Зүгээр л нэг горхины усны хоржигноон шиг хор хор! цор цор! гээд дуусгаж байх юм. Гэхдээ энэ богино шүлгийн дотор саяын дээр өгүүлсэн санаа ахуй бүрэн илэрч буй. Энэ бол бидний эрхэмлэн дээдэлдэг байгаль эхийн энгийн жам ёс, тасралтгүй үргэлжлэн залгамжлагддаг шинэ хуучны үе уламжлал бөгөөд энэ нь ямар ч гаднын нөлөөгүй, тайван жигд амьдралын зураглал болж байх юм. Ер нь ертөнц дэлхий дээр байгаа юмыг тэр чигээр нь зураглаж, энгийн бус аргаар илтгэж байгаа гэдэг бахархан таалдаг гоо сайхны хүртээмж бөгөөд уншиж суугаа хүн түүнийг ямар л бол ямар байдлаар нь ухаарч ойлгох нь шүлэг сонирхлын нэгэн зол жаргал болов уу хэмээн үзэж байна.

Миний анзаарснаар сүүлийн үед хүүхдийн шүлгийн уралдаанд шүлэгч Л.Чулуунбаатарын олон шүлгүүд сонгогдон уншигдаж байх бөгөөд саяхан болсон шүлгийн тэмцээнд ч гэсэн хаа сайгүй харагдаж байсан! Юу үнэн бэ? хүүхдийн сэтгэл, хүүхдийн сонирхлыг татаж чадсан шүлэг үнэн !

Хоёр. Хүүхэд бол хүүхэлдэй жүжиг

Хүүхдийн сонирхол даанч олон байдаг, тэр нь энэ бүхэл бүтэн амьдралтай танилцахын тусад олон арвин зүйлийг сонирхон шохоорхдог бөгөөд тэр чинээгээр хүйтэн хатуу хорвоог танин мэдэж ойлголцдог, тиймийн учир ямар ч юмс үзэгдэл нь тэдэнд цоо шинэ юмс байж, өөрийн сэрэхүй мэдрэхүй таван эрхтнээрээ хүрэлцэн байж сая ойлгож мэдэх учиртай. Яг ийм шинжээс нь үзэхэд, тэд бол хүүхэлдэйн киног сонирхогчид билээ. Мөн дэлхий дээр ээжийн сургаал хүмүүжлээс дараа нь тэд тоглоом шоглоомын ертөнц хүүхэлдэйн киноноос зарим зүйлүүдийг ухаарч харааны соёлын хичээлд шилжин ордог ч гэж хэлж болох юм. Энэ талаар шүлэгчээс маш энгийн, хошин шинж бүхий мөр бадгийг зохиож тэдэнд зарим зүйлийг үзүүлсэн байдаг.

Эрдэнэ шии

Баруун айлын



Бавуу гуай

Бага л инээгээд

Байхгүй болчихсон

Зүүн гацааны

Жугнай, хөөрхий

Өглөө байсан!

Өнөө байхгүй!

Урд энгэрийн

Уран цэцэг

Ухаангүй

Инээчихлээ

Удалгүй

Өвөрлүүлчихлээ

Хойд хонгилын

Ховдог жамц

Ходоодны өвчтэй

Инээх ч үгүй

Эцэх ч үгүй

Одоо л над дээр

Орогнох болсон

Инээх юмсан

Эзэн минь тэгээд

Ирэх л юм

Эрдэнэ шиш



Налж түрэм

Эрдэнэ шиш

*Инээж үхнэ!*²⁸

Энэ шүлэг намрын ургац эрдэнэ шишийг хурааж байгаа байдлыг зураглажээ. Манай зарим нөхдийн шүлэглэдэг араг – шаргал намар болж комбайн машин ирж, тэргүүний шинжлэх ухаанч аргаар яаж ийж эрдэнэ шишийг хадаж хамж, тээрэмдэж салгаж, хайрцаглан ууталж баян тансаг намрын хураалтаа авч байгаа! хэмээн тоочсонгүй. Зөвхөн монгол айлын дөрвөн хөршийнхний дүр зургаар жүжиглүүлэн тоглуулж намрын ургац хураалгаад дуусчээ.

Бүх шүлэг 26 мөр, маш амархан хүүрнэлээр бичжээ. Энд хүүхдүүдэд монгол айлын Бавуу, Жугнай, уран цэцэн Г.Жамцын нэрсийг хэлж өгч буй, монгол нутгийн айл, гацаа, энгэр, хонгилын нэрүүдийг нарийн ялгаж таниулж байна. Хамгийн гол нь эдгээр инээд алга болсон зүйл хааш явсныг яриагүй. Хаа явсан бэ? хөмөргөнд оржээ. Нөөц бэлтгэлд хураагджээ гэж нэг нэгээр тоочоогүй.

Харин “налж түрээд”, “инээж үхнэ” гэдэг нэг ёсыг ярьж өгчээ. Энэ бол өнгөн талаас харахад тийм гунигтай үлгэр биш, инээж л байна, үгүй болж л байна! тэгээд хүүхдүүдэд бол тоглоом шоглоом шиг л үзэгдээд өнгөрч байна. Үүний цаана юу нууц өгүүлсэн бэ гэвэл, манай энэ манан цэнхэр орчлонд хүн гэх амьтан зовохын төлөө төрж жаргахын төлөө үхэж байна гэсэн санаа, эсвэл хүн гэдэг амьтан үхэж байж сая бусаддаа хүмүүс байсан гэдгийг таниулдаг ёс учрыг хэлжээ.

Ингэж хүүхдийн шүлэг бичих нь тэдэнд тэдэнд ямар нэгэн хэмжээний дараас болохгүй мөртлөө өнгөн талаасаа их хошин энгийн жүжиглэг шинжийг агуулж, танин мэдэхийн талыг нь тэлж өгч байгаа нь амжилттай болжээ.

Амь ахуйн асуудал бол дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа маш чухал нэгэн сэдэв болно. Үүнийг уран зохиолчид, дэлхийн улс гүрэн болгоны өөрийн байдалд тусган тус тусдаа маш их сэтгэл тавин бичиж

²⁸ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 176-177



буй. Ази тив буюу дундад улсын хөрс шороон дээр энэ асуудал одоогоор ихэд чухал анхааралд өртөж буй. Цаг эриний хөгжил ба шинжлэх ухааны асар хурдан хөгжил нь хүн амьтны оршин амьдрах орчин тойронд сөрөг талын нөлөөг ихээр үүсгэж байна.

Эх байгалийн эд баялагийг нээн ашиглах, цаг агаарын хэт дулаарал, цөлжих, элсэн шуурганы дэгдэлт, далайн хар салхи цунами гамшиг зэрэг нь бүгд хүний үйлдвэрлэлийн үр нөлөөнөөс шалтгаалж том хямралд учраад байна. 20 дугаар зууны 50, 60-аад онд Өвөр Монголын Ордос хотын Үүшин жоугийн Муу-Ус элсэн цөлийг ногооруулах асуудлаар Боролдой хэмээх бүсгүй бүх гацаагаа дайчилж элсний том нүүдлийг бургас тарин зогсоосон бөгөөд бусад цөлжсөн газруудад их хэмжээгээр бургасыг янз бүрийн аргаар тарьж бойжуулснаас бүх улсын үлгэр жишээ хөдөлмөрчнөөр үнэлэгдэж, улс даяар Үүшин жоу-аас суралцах хөдөлгөөн өрнүүлж, нөр их шуугиан дэгдээж, нэг үес ёстой л нэгэн журмын шилдэг хөдөлмөрчин жишээч болж байсан түүхтэй билээ.

Шүлэгч Л.Чулуунбаатар энэхүү үйл ажиллагаанаас сэдэл авсан болов уу! тэрбээр хүүхдүүдэд “Бургас” хэмээх нэгэн шүлэг бичжээ.

Бургас бургас

Найгаж байна

Бутын намаа

Ногоорч байна

Мөчир салаагаараа

Даллаж байна

Мөнх хаврыг

Урьж байна

Уран шувууг

Урьж байна

Ус голыг

Урсгаж байна



... Удын ногоон

Жижиг навчийг

Уруулдаа үлээж

Дуугаргана би

Усны шувууг

Дууриагаад

Урьдын дуугаа

Хангинуулна би

Бургас бургас

Найгаж байна

Бутын намаа

Ногоорч байна

Сайхан ногоон

Мөчрөөс нь

Салгаж баглан

Авах юм

Сайр элсний

Оройд би

Сая бумаар

Тарих юм²⁹

Энэ богино шүлэгт амь ахуйн тухай маш тод томруун ойлгуулан хүүрнэжээ. Бургас ногоорхоор нь хавар болдог, ус голыг урсган уран шувууг залдаг, усны шувуудын дуунаас урьдын дууг би дуулж сурна, тэгээд сайхан ногоон мөчрүүдийг салгаж аваад сайр элстэй бүх газарт

²⁹ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 178-179



сая бумаар нь тарьж амь ахуйн мөнхийн нов ногоон ертөнцийг бүтээн байгуулж байна.

Хүүрнэл шүлгийн тоочилт нь зөвхөн байгаа зүйлийг байгаагаар нь зураглаад түүнийгээ цааш нь үргэлжлэн тарина л гэсэн байна. Энд ямар нэгэн ёс учир яриагүй, зүгээр л хүүхдийн бодлоор ногоон ертөнцөө улам л хайрлаж, улам л ихийг ногооруулна гэсэн санаа байна.

Үнэндээ энэ бол манай дэлхийн маш эмзэг сэдэв мөртлөө хүүхэд багачуудыг хөдөлмөрт урьж ногоон ертөнцийн гоо сайхныг бүтээн байгуулалцаж байгаа хүүхэдэйн кино төлөвтэй зураглал юм.

Ер нь хүүхэд бол хүүхэд шүү! түүнд ёс ярих, сургаал айлдах байдлаар шүлэглэх юм бол хоосон номлол төдий болох юм. Харин тэднийг уриалан дуудаж өдөөн хөтлөлцүүлж нийгэм нийтийн хөдөлмөрт оролцуулах нь маг чухал! гэх мэт түүний “Хонь”, “Намаа”, “Ямаан толгойн учир”, “Зараа”, “Тэмээ” гэхчилэн адгуус амьтны нүдээр хүний ертөнцийн тухай үзсэн бодсон хажуугийн зураглал нь хүүхдүүдэд танин мэдэх ойлголтыг улам бодит ялгам харуулсан зүйлтэй олон шүлгүүд байдаг.

Гурав. Хүүхэд бол хүслэн билээ

Хүүхэд нас бол хүсэл мөрөөдлийн эрин билээ. Үг хэлэнд орж, хөл дээрээ тогтон алхаж эхэлсэн хүүхэд олон юмыг сонирхон шинжиж, олон юмыг дуурайж дэрвэн янз бүрийн үйлдэл хийж үймүүлдэг. Яг энэ л цагаас эхлэн тэд галуу шувуу, тахиа цорвоог дуурайн өөрийнхөө эрэл хайгуулыг эхлүүлнэ. Нэг л их гайхсан, сонирхсон, юм болгоныг анзааран мэлэрч байснаа ээж аавын туслалцаатайгаар танин мэдэхийн ертөнцөд дэвэрцэглэн орно.

Шүлэгчийн “Мөр” гэсэн нэгэн шүлэгт:

Мөр

Мөр

Мөр

Энэ юуны

Мөр вэ?



Эрвэй хүүхдийн

Мөр байна!

... Эгээ л миний

Мөр байна!

... Энэ юуны

Мөр вэ?

Их хүний

Мөр байна!

Энэ юуны

Мөр вэ?

Эгээ л монгол

*Мөр байна!*³⁰

Энэ мөрийн зорилго бол нярай бага хүүхэд мөр мөшгөөд гүйж буй зураг харагдана. Тэр дундаа хүүхдийн, миний, том хүн, нийт монголын мөр олж харах мөрдлөгө байсан ажээ. Энэ мөрийн явцад, эзгүй хол явах, энхэл донхол зам, эвгүй бол унаж эндэх, эх орон нь ээж гэдэг шиг нь түшиж авах, ингээд энэ мөр эрхэст гартлаа хол явах мөр хэмээн товч зуржээ.

Шүлэгчээс хүүхдийн мөр хайж явснаас эрхэс тэнгэрт түүнийг мацуулан гаргасан байна. Ер нь Л.Чулуунбаатарын хүүхдийн шүлэг дэх ертөнц нь ихэнхдээ гараг од, эрхэс тэнгэрийн орон зай олон дахин илэрнэ! бас нэгэн шүлэгт:

Од оо, од

Миний нүд ч од

Чи ч гэсэн од

³⁰ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 162-163



Би газрын нүд

Чи тэнгэрийн нүд

Тэгэхээрээ –

Чи бид хоёул

Нэг нь нэгээ

Санаж байдаг

Нэг нь нэгээ

Манаж байдаг

Од оо! од

Миний нүд ч од

Чи ч гэсэн од³¹

Газар тэнгэрийн хоорондоос одтой өөрийгөө холбочихоод нэг нэгийгээ санаж манаж шөнө нь од тэнгэртээ нүд болон гэрэлтэж, өдөр нь хүүхэд “би тэгэхээр нь манхайхгүйгээр/ бичгээ бариад чамайг орломой” гэж гэнэн цайлганаар үзэж байна.

Мөн нэгэн “Од”-доо:

Од оо

Од!

Орой дээр минь бэлччихдэг

Онгон цавьдар

Од!

Би ер нь чамайг

Бэрх юмаар бодлоо шүү

³¹ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 182



Бодох бодохдоо дүрийг чинь

Бүр ч хэцүү гайхлаа гээд цааш нь одтой маш олон зүйлийг хөөрөлдсөн байх юм. Харамсалтай нь одо түүнд ерөөс хариу өгөхгүй учир гомдож, гуниглаж бүр сүүлд нь агсарч загнах хэмжээнд хүрч байна. Өөрийгөө өмч малтайгаа танилцуулсан, юу хийдэг, юу сурдгаа хэлсэн, тэгж байхад юу ч хариулахгүй өөдөөс гөлийгөөд байх юм. Би сургуульдаа явж бичиг үздэг, чи тэгэхэд ер нь сургуульд бичиг мичиг үздэг юм уу? үгүй юм уу? хэчнээн олон асуултын хариуг өгөхгүй болохоор нь “од оо ер нь таны тэнд, очих цаг минь болж! очих очихдоо чамд би олон ч юм заана!” хэмээн шүлэг ч төгсөж хүүхэд ч учраа хэлээд дуусаж буй. Эдгээр үйл явдал бол хүүхдийн гэнэн тархинд байдаг л үзэгдэл, гэхдээ түүнийг хэрхэн уран яруу шүлгийн айзамд оруулж ирэх вэ гэдэг бол шүлэгчийн урлах ур дүйд түшиглэнэ. Шүлэгчийн сэрэлд гараг эрхэс бол бүр өөрийн гэр өрх мэт санагдаж түүгээр чөлөөтэй зугаалан явдаг бол түүний бийр доорх тэнгэр нь бүр монголын тэнгэр ч болж харагдана.

Орчлонгийн олон гарагт

Ондоо ер нь байгаагүй

Тэнгэр гэдэг монгол нэртэй

Цэнхэр хөх тэнгэр минь ...

Миний аав

Айхавтар хүн

Мэдэхгүй юм

Байдаггүй

...

Аавын бичсэн тэнгэр

Алган дээр минь зэрэглэв

Алгаа дэлгээд шинжвэл

Жаргах наран шиг улайв



Үдэш би гэрээс гараад

Өндөр тэнгэрээ ширтвэл

Одод, сараа тойроод

Үлгэр сонсож суух юм

За! тэгээд би ч

Одныхоо нэг нь болж

Онгод тэнгэрийн үгийг

Олзуурхаж сайхан чагналаа ...

Орчлонгийн олон гарагт

Ондоо ер нь байгаагүй

Тэнгэр гэдэг монгол нэртэй

Цэнхэр хөх тэнгэр минь ...³²

Энэ шүлэгт бяцхан хүүхэд газар дэлхийгээс тэнгэрийн оддыг гайхах биш, бүр эрхэс тэнгэрийн мандалд ододтой цуг тэнгэрийн үлгэрийг сонсон сууж байна! энэ хүсэл мөрөөдөл үнэн дүр зураг болон үзэгдэж байна. хүүхдийн энэхүү гэгээн цайлган хүсэл мөрөөдөл бол бүр эчнээ холыг бодож энэ их аугаа том эрхэс гараг болгон нэг том гэр бүлийнхэн гэсэн шүлэгчийн аугаа багтаамжийг харуулж байна. Үнэхээр уншин суухад дотор долгисон эрхсийг багтаам уужим амьсгалж байна.

Шүлэг маань ардын дунд өргөн дэлгэрсэн нэгэн сайхан шүлэг байдаг аа! тэр нь дуучин Лхасүрэнгийн хүүгийн ойд зориулан бичсэн “Хүүхэд” гэсэн шүлэг юм. Энэ шүлгийг хүүхдийн шүлэгийн уран уншлага, шүлгийн уралдаануудад олон удаа уншигдаж бүр шагнал авч буйг нь миний бие шүүгчийн хувиар хянаж явахдаа таарч байв.

Юу сайхан?

Хүүхэд сайхан

³² Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 189-191



Алаг бөмбөгөө чулуудвал

Аав нь энд тосох сон

Ахиад хүү минь сарвайхдаа

*Алтан бөмбөрцөг аваарай*³³

Энэ бол нэгэн киноны бичлэг мөн, мөн л нэгэн хормын үзэгдэл төдий зураг мөн, эндээс л бид эцэг үрийн залгамж гэдэг хэр үнэ цэнэтэй гэдгийг ойлгоно. Басхүү залгамж үеийн хүүхдүүдэд хэр зэргийн үүрэг ачаалал очиж байна гэдгийг ч ухаарах ёстой юм.

Миний бие олон өгүүлийнхээ дотор шүлэгч Л.Чулуунбаатар бол өнөөгийн монгол шүлэгт дуу хөгжмийг оруулж ирсэн том төлөөлөгч хэмээн дурдаж өнгөрсөн билээ. Гэхдээ түүний шүлгүүдэд дүр төрхийг маш тод томруунаар оруулж ирсэн байна. Дээр өгүүлсэн жишээ шүлэг бас бус маш олон хүүхдийн шүлгүүдэд тус тусдаа бие даасан алиа дэгжин хүүхдийн дүр зураг маш олон буй. Энэ бол түүний байнга ярих дуртай “хайрын дөлөөс, биеэ ол! шүлгийн дүрд, хайраа оруул!”³⁴ гэдэг шүлгийн санаа болой! үнэн бодитой дүр зураг байж сая шүлэг нь амьд хөдөлгөөн болж, хүмүүсийг зөвхөн хараан сэрлээр бус, тэмтрэх сонсох сэрлийн хүртээмжийг ч хөгжөөж чаддаг үйлдэл нь энд байж байна.

Л.Чулуунбаатар хэдийгээр таван жилийн хугацаанд энэхүү олон шүлэг найргуудаа бүтээгээд биднээс холдсон билээ! түүний олон шүлгүүдийг аван уншаад ойлгохгүй, ахин дахин уншаад ч олон арван жил уншаад шүлгийн мөн чанарт нь нэвтэрнэ гэдэг хэцүү үйл юм! тэрбээр энэ олон шүлэг найргаа олон өдөр хоног бясалгаж байсан байхаа! гэхдээ нэг бичээд эхлэх юм бол маш хурдан бичиж дуусгадаг, миний мэдэж байхаар хүүхдийн шүлэг дэх тэдгээр амьтнаар сэдэвлэсэн шүлгүүдийг бараг хоёр гурван шөнийн дотор бичиж дуусгасан юм. Тэгэхээр шүлэг бясалгах ба шүлгийг түрж гаргах бол хоёр тусдаа явдал бөгөөд нэгэнт онгод буусан үедээ шүлэгч маань маш ихээр догдолж бүр чичирч дагжаад шүлгүүдээ тэрлэн бичдэг байсан.

³³ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 157

³⁴ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 198



Хүүхдийн шүлгээс хамгийн илүү тархаж оюутан залуусын амны уншлага болсон шүлэг нь яахын аргагүй “Монгол ээжийн хүү” юм. Энэ шүлэг олон газар орны их дээд, тусгай мэргэжлийн сургуулиудын уран тод уншлага буюу шүлгийн тэмцээний тайзыг чимж байсан бөгөөд миний бие ч бараг гуч гаруй жил энэхүү шүлгийг уншиж явсан түүхтэй, энэ бол шүлэгчийн монгол улсын яруу найраг онцгойлон Д.Нацагдоржийн “Алс газар сурахаар явагч” шүлгийн санаанаас сэдэл авч бичиж гаргасан гайхалтай мөр бадгууд болно.

Үүл мөрлөөд ханайн зогсох

Богд уулын баян энгэрт

Хийл исгэрүүлээд сунган одох

Булган голын ноён эрхинд

Нас минь бойтогтойгоо

Наадахын баханд дүүрч байлаа

Найз минь надтайгаа

Наадмын морийг сундалж байлаа

Үүрийг угтаад цацран цавчих

Цолмон одны алсын тохионд

Сөрийг хийсгээд сэнгэнэн үлээх

Торгон талын цэнгэг салхинд

Морь минь эмээлтэйгээ

Морьдын аянд бэлхэн байлаа

Мөөм минь монгол сүүгээ

Мордуулахын аманд өргөж байлаа

...

Монгол ээжийн хүүхэд бид



Мянга мянгаараа нэг л хүн шүү

Монгол нутгийн өглөөл бол

*Түм түмээрээ манийх шүү!*³⁵ гэдэг сонгодог мөр бадгаа ингэж шуун босгож билээ.

Монгол ээжийн хүү шүлгийнх нь нэрээр манай Солонгод гэр бүлийн сурлагын тэтгэлэгийн мөнгөний шагналыг ахан дүү Л.Хурцбаатарын санаачлагаар 1996 оноос эхлэн Өвөр Монголын бүх аймгийн хот хошуу сум шатны сургуулийн эмзэг давхаргын, сурах хүсэл эрмэлзлэлтэй хүүхдүүдэд зориулан мөнгө, эд юмс, ном судрын дэмжлэгийг явуулж эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл монгол улсын Улаанбаатайн их сургууль, Оюунлаг дунд сургуулиудаар явуулсан бүх нийгэм нийтийн урлаг кино медиа, зохиол бүтээлийн том хэлбэрийн шагналуудыг ч зохион байгуулж амжилттай явагдуулж байна.

Шүлэгч Л.Чулуунбаатарын тус хүний болон гэр бүлийнхэн тухайн үед маш ядуу тарчиг амьдралтай, өнчин өрөөсөн өссөн боловч бидний хожим үеийнхэн дахиж тийм амьдралаар даарч хөрж, өлсөж ундаасан, соёлын балай болж болохгүй гэсэн санаагаар энэхүү үйл ажиллагаагаа хорин хэдэн жил явуулсан нь нийт олны таашаалыг халуунаар хүлээсэн юм.

Үүнд хамгийн гол нь шүлэгчийн санааг ирээдүй хойчдоо үнэн зөвөөр ойлгуулан тэдний гэрэл гэгээтэй сайн сайхан ертөнцийг бүтээн байгуулалцаарай гэсэн санааг давхар илэрхийлж байгаа юм.

Шүлэгчийн минь гэгээн сүнс амар амгалан байх болтугай хэмээн эндээс өчин өчсүгэй!

³⁵ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 1



НОМ ЗҮЙ

(1) Өгүүлэл

1. Хуан Жинь. “Орчин үеийн монгол шүлгийн судлал”, докторын зэрэг хамгаалах өгүүлэл.
2. Хүүзаяа. “Монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь нөлөө судлал (1980-1990)”, ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
3. Дүүтуул. “Өвөр Монголын уран зохиол дахь Р.Чойном үзэгдэл”, магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
4. Жан Рүншя. “Монгол улсын орчин үеийн утга зохиолын дундад улс дахь нөлөө судлал (1946-1979), ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2011

(2) Ном

1. С.Энхбаяр. “Утга зохиолын онол”, УБ., 2011
2. Эрдэнэхад. “Органик зохицонгуй туурвихуй ухаан”, ӨМСХХХ, 2001
3. С.Урсгал. “Монгол шүлэг зүйн түүхэн түүхэн тогтолцоо”, ӨМСХХХ, 2000
4. Баяуд Оюунбилэг. “Шинэ эриний монгол шүлгийн гоо зүй”, ӨМСХХХ, 2007
5. “Д.Нацагдорж”, ӨМАХХ, 1981
6. Н.Өлзийбат, Б.Осор, Лигдэн. “Өнөр цэцгийн 50 жил”, ӨМСХХХ, 2005
7. Буяндэгжрэх. “Монгол ард улсын утга зохиолын тойм”, ӨМСХХХ, 1988
8. Г.Буянбат. “Н.Сайнцогтын ойлбор”, ӨМАХХ, 1986
9. Б.Буянхишиг. “Ерэн есөн хар ямаа”, ӨМБХХХ, 2006
10. Б.Бүрэнбэх. “Зөн мэдрэхүй шүлэг зүй”, ӨМАХХ, 2001
11. Б.Бүрэнбэх. “Уянгын эрэлчний тэмдэглэл”, ӨМАХХ, 2001
12. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I (Ойн дугараа), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
13. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть II (Зүүдэн цагаан туулиан), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
14. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть III (Хан сасарын үүл), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
15. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть IV (Зүүдэнд минь хоноосой), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014



16. Солонгод Л.Хасбаатар. “Р.Чойном, Л.Чулуунбаатар”, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2015
17. Л.Хасбаатар. “Р.Чойном судлал жич түүний шүлгүүд”, ӨМСХХХ, 1996
18. Л.Хасбаатар. “Цагийн жаварт бөхөөгүй зул”, УБ., 2009
19. П.Хорлоо, С.Лувсанвандан, Д.Мөнх, Д.Цэнд. “Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх”, I, ӨМАХХ, 1985
20. П.Хорлоо, С.Лувсанвандан, Д.Мөнх, Д.Цэнд. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл”, ӨМСХХХ, 2004
21. Хайрхан. “Монгол шүлгийн эдүгээч хувьсалтын судлал”, ӨМАХХ, 2014
22. Хайрхан. “Өнөөгийн монгол шүлгийн ерөнхий судлал”, ӨМСХХХ, 2010
23. Хангай. “Дундад улсын орчин үеийн уран зохиолын түүх”, ӨМИСХХ, 2000
24. Ван Мандаа. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, ӨМСХХХ, 2000
25. Т.Сайнбаяр. “Дундад улсын монгол үндэстний өнөөгийн утга зохиолын түүх”, ӨМСХХХ, 2003
26. Н.Сайшаалт. “Монгол шүлгийн айзмын судлал”, ӨМАХХ, 1981
27. Сүег. “Утга уянгын тольт”, ӨМАХХ, 1998
28. Ш.Сүрэнжав. “Сүмтэй бударын чулуу”, УБ., 1989
29. О.Дашбалбар. “Хүн ертөнц”, боть I, Өвөр Монголын соёлын дуу хөгжим дүрс шингээлтийн хэвлэлийн хороо, 2019
30. О.Дашбалбар. “Хүн ертөнц”, боть II, Өвөр Монголын соёлын дуу хөгжим дүрс шингээлтийн хэвлэлийн хороо, 2019
31. Х.Дамбийжалсан. “Өвгөн хайлсны шуугиан”, ӨМАХХ, 2003
32. Дорнотэнгэр. “Орон нутгийн түүх, иргэний хараас, соёлын уламжлал”, ӨМАХХ, 2015
33. Л.Чулуунбаатар. “Ойн дугараа”, ӨМАХХ, 2000
34. “Р.Чойномын амьдрал уран бүтээл”, Чойномын мэдэлсний 70 жилийг ойг тэмдэглэх эрдэм шинжилгээний хурлын бүтээл, УБ., 2006
35. М.Жалфунгаа. “Үр өнөөгийн монгол уран зохиолын түүхэн найруулал”, ӨМСХХХ, 1987
36. Хайрхан. “Шүлгийн ухааны тайламж”, ӨМИСХХ, 2020
37. С.Баянжаргал. “Монгол хөгжимдхүйн бүрэн бичиг”, ӨМАХХ, 2017
38. С.Баянжаргал. “Монгол язгуур урлаг – хөгжимдхүй дууны 365 нэрс”, ӨМАХХ, 2017
39. Ц.Цолмон. “Их тамучийн тэнгэр”, ӨМАХХ



40. Ц.Цолмон. “Орчлонтой яригч дорнодахины яруу найрагч”, Чэнь Ганлун, С.Урсгал. “Д.Нацагдоржийн сонгодог тайламж”, ҮнХХ, 2009

41. 王宁: 《管或乐法基础教程》, 高等教育出版社, 2008 年

(3) Сонин сэтгүүл

1. Алтангадас. “Монгол ардын аман зохиол хорь гучаад оны монгол улсын шинэ шүлгийг нөлөөлсөн нь”, БХҮИСЭШС, 1993 №3

2. Ч.Эрдэнэбаяр. “Монголын орчин үеийн эх орон сэдэвт яруу найргийн хөгжлийн товч”, ӨМИСЭШС, 2000 №1

3. Б.Энхтүвшин. “Их Нацагдорж – 20 дугаар зууны монголын соён гэгээрүүлэгч, их зохиолч”, Дундад улсын монгол судлал, 2007 №4

4. Ц.Хасбаатар. “Монгол улсын шүүмж судлалын өнөөгийн байдал”, ӨМИСЭШС, 2000 №4

5. С.Хас-Өлзий. “Б.Лхагвасүрэнгийн шүлгийн нууцлал – үйлт уран дүр”, Алтан түлхүүр, 1994 №1

6. Лагсагмаа. “Дундад улс дахь монгол улсын орчин үеийн уран зохиолын судалгаа”, ДУМС, 2008 №5

7. Кань Хай Ин. “Диваажингийн элчийн зөн мэдрэхүй”, ӨМИСЭШС, 2020 №1

8. Ц.Дамдинсүрэн. “Монголын уран зохиолын товч өгүүлэл”, Монгол түүх хэл бичиг, 1958 №6

9. Т.Дэлгэрсан. “Халхын уудам нутгийн гайхамшигт зураг – миний нутаг – Д.Нацагдоржийн Миний нутаг гэх шүлгийг дахин сонирхоод”, Монгол судлал, 2009 №1

(4) Цахим сүлжээ

1. 百度文库: 交响乐乐器介绍一图文详解》

<https://wenku.baidu.com/view/2dc72fbf9fc3d5bbfd0a79563>



ЭХ ДЭЛХИЙН УЯНГЫН ЭРЭЛЧНИЙ СЭТГЭЛИЙН ДУУН

(Ай Чин ба Нулмасарангийн уран бүтээлийн жишээн дээр) *

Кань Хай Ин *

ХУРААНГУЙ

Ай Чин бол Дундад улсын шинэ үеийн шүлгийн давцан дээрх дагуулагч, их шүлэгч бөгөөд ард олондоо “Шүлгийн дэвжээний манлайлагч” гэж үнэлэгддэг бол харин Нулмасарангийн шүлгүүд ориглуун сүрлэг ба үнэн сэтгэлийн дуудлагаар баялаг байж, тухайн цаг үеийн урмаар хүмүүсийн оюуныг тэтгэсээр иржээ. Эдгээр зохиолчид нь монгол шүлгийн давцанд өөрийн содон бүтээлээ нэмэрлэж, шүлгийн өвөрмөц хэв маягаараа бусдаас онцгойрон ялгарсан билээ. Тус өгүүлэлд дээрх хоёр зохиолчийн уран бүтээлүүдэд харьцуулалт хийхэд нар сар, гэрэл гэгээ, навчис зэрэг дүрслэлээр эх хүн, эх газрын зураглал, цаг үеийн уриалга талаас уран бүтээлээ тууривахыг эрэлхийлдэг байжээ.

Түлхүүр үгс: Ай Чин, Нулмасаран, шүлэг найраг, нар сар, гэрэл гэгээ, навчис, эх хүн, эх газар, цаг үе

Улс төрийн итгэл үнэмшилтэй ба шүлэг дуу бичлэгт шүлэг найруулагч бол хувь хүний баяр баясал, аз жаргал, зовлон зүдгүүр зэргийг цаг үеийн ороо бусгаатай нягт уялдуулж, ил тодорхой цаг үеийн уриалал ба ард түмний дуу хоолойг илэрхийлж, өөрийн нийгмийн бодит ахуйн үнэн бодитой дүр төрөхийг илтгэсэн нь Ай Чин-ий ахуйч үзлийн дууллын үндсэн хөг аяс болсон байна. Бодит ахуйн ганцаардал нь шүлэг урлагийн үзэл сэтгэлгээ бодгаль чанарын үндсэн элемент мөн. Ай Чин бол орчин үеийн дундад улсын эдүгээч үзлийн арга барил, романтик

* Тус сэдэв нь Улсын нийгмийн шинжлэх ухааны төлөвжүүлэлтийн судалгааны “Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын түүх судлал”-ын нэг хэсэг болно. Зөвшөөрсөн дугаар: 15XZW046

* Доктор, профессор (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургуулийн багш).
kanhaiying@126.com



үзлийн оргилуун сэтгэлгээ хийгээд ахуйч үзлийн ухагдахууныг амжилттай нэгтгэсэн шүлэгч, орчин үеийн шинэ шүлгийн ертөнцийг хөгжүүлэгч мөн³⁶. Шүлгийн мөн чанар бол үзэл сэтгэлгээнд буй. Шинэ эриний монгол шүлэг нь голдуу нэгдлэг чанар, үүдэн бүтээлч чанар, зохицмол чанар, олон талт чанар зэрэг онцлогоороо 20 дугаар зууны 50-70-аад шүлэг дуунаас ялгагдах болжээ³⁷. Нулмасарангийн шүлэг хурц ирмүүн уянгалаг шинжээрээ онцгойрч байв. Өнөөгийн монгол уянгын шүлэгт Бүрэнбэхийн дараа бас нэгэн гайхамшигийг бүтээсэн нь бараг Нулмасаран гэх өгүүлэмж буй. “Хатан гол ба залуу нас”-аас эхэлсэн уянгаллын халамжил нь “Гал хонгорын дуулал”, “Үндэс гүн сурвалж урт”, “Чингисийн сүлдний өмнө” зэрэг шүлэгт тулгуурлан “Навчинд өргөх дуу”-аар оргилыг цогцлоожээ. Сэтгэлийн бардамнал, төсөөллийн бардамнал, хэлний бардамнал бол Нулмасарангийн уран бүтээлийн гурван тулах цэг болно. Нулмасарангийн шүлэг бүтээлийг хэл хөтөлж, сэтгэлгээ түлхлэн, төсөөлөл жигүүрлүүлжээ³⁸.

Нэг. Нар, сар, гэрэл гэгээ, навчис санаа дүрслэл

Нулмасаран урлагийн арга барилын талаар монгол үндэстний уламжлалт соёлын нөлөөг хүртсэн зохиолч. Илтгэх арга барилын талаар том талбарыг бүтээдэг нь баатарлаг туулийн онцлогийг хадгалаагүй гэж хэлэхийн аргагүй. Үндэстний санаа сэтгэлгээ, соёл түүхийн талаар тэр маш анхаарч байсан нь түүний шүлгүүдэд илэрнэ. Эдгээр нь үндэстний хувь заяаны тухай хариуцлагатай байдлаар уянгалж байхтай салшгүй холбоотой юм. Гэхдээ тэр үндэстний цог жавхааг уянгалуулдаг. Эдгээрээ илэрхийлэх үеийн шинжилгээгээ цул сонгож, байршуулах тал нь бусадтай адилгүй, гол зүйлээ нэгэн бодит юм дээрээс эхлүүлж, өөрийн сэтгэлгээгээ уянгалуулна. Цул шүлгийн онол нь бэлгэдэл зүйн уран зохиолын гоо зүйг хүндэтгэж, шүлэг дууны гоо зүйн хүслийг илтгэж байдаг. Бэлгэдэхүй үзэл Ай Чин-ий дур сонирхлыг хамгийн их татсан нь шүлэг дууны илэрхийлсэн бодгаль цогцын эрх чөлөөт гоо сайхан болно³⁹. Шүлэг дууны үнэн сэтгэлгээ, санаа дүр, хэлбэрийн гоо сайхан гурвын

³⁶ 乔以钢总编：《现代中国文学（1898-1949）》，南开大学出版社，2009年，第207页。

³⁷ 满全著：《碎片与体系》，远方出版社，2018年，第175页。

³⁸ Хайрхан：“Монгол шүлгийн эдүгээч хувьсалын судлал”，ӨМАХХ，2014 т 165.

³⁹ 张菲菲：《象征主义视角下的艾青诗歌研究》，西安外国语大学硕士学位论文，2014年，第55页。



нэгдэл юм. Ай Чин-ий өмнөх хугацааны шүлэг дууны үхлийн ухамсарт, шинэ амь насны хүсэл эрмэлзэл, гэрэл гэгээний тасралтгүй үйл ажиллагаа илэрч байдаг⁴⁰.

Агуулгын талаар гансралын, хилэгнэлийн, сүр далайцтай хэв маяг нь Ай Чин-ий шүлгийн хамгийн үндсэн илэрхий онцлог болсон байна. Гэрэл гэгээн хүсэл эрмэлзэл, амь насны баяр бахдал ба хүн төрөлхтний дахин төрөх итгэлийг илэрхийлсэн “Нар”, “Үүр” зэрэг шүлэг буй. Эх орны хүнд зовуурь хийгээд уй гашуудлын гансралын уянгалаар ард түмний эсэргүүцлийн зориг санаа, тэмцлийн оргилом магтаал бол Ай Чин-ий японы түрэмгийллийг эсэргүүцэх дайны үеийн шүлэг бүтээлийн онцлог ба үндсэн хөг аяс болно⁴¹. Түүний хурц чанга гүн зузаан улсаа хайрлах сэтгэл санаа ба эх орны бэрх зовуурь, эх газрын зовнилын сүр сүлдтэй ойртож байдаг. Шүлэгчийн зовнил нь даруй ард түмний зовнил, шүлэгчийн уй гашуу бол даруй ард түмний уй гашуудал, шүлэгчийн амин сүнсний гүнээс ундрах дуу бол ард түмний дуу болно⁴².

Энэ нь хүсэл эрмэлзэл, гэрэл гэгээ, ялалтын гэрлийг авч ирдэг. Нар бол хүслийн бэлгэдэл, амь насны зөн мэдрэхүй, гал халуун нар нь халуун дулаан, хүнд нүсэр газар шороо нь эх орны хайрыг дам тусгаж, дун цагаан цас нь тахимдуу хөвгүүний чин үнэнч сэтгэлийг бэлгэдэж байдаг⁴³. Ай Чин-ий “Нар”, “Галт бамбай”, “Нар өөд” гэх шүлэгт шүлэгчийн хэв заншил дахь тогтмол гүн бодлогошрол хийгээд оргилом халуун сэтгэлийн уялдаа холбоо, сэтгэлгээн дэх гүн гүнзгий гансралын, залуу насны баяр бахдалын онцгой уялдаа буй⁴⁴. Цаг үеийн онцлогийг харуулж, ард түмний үзэл сэтгэлгээг илтгэсэн шүлэг болжээ. “Нарны үг” шүлэгт баяр бахдал ба гоо сайхан бялхаж, хүний сэтгэлийг хөдөлгөм дуу өнгө нь яг сайхан цэвэр тунгалаг хаврын салхи мэт бидний сэтгэлийн хөвчийг догдлуулж, дотоод сэтгэлийн хамгийн гоо сайхан, хамгийн

⁴⁰ 张菲菲: 《象征主义视角下的艾青诗歌研究》, 西安外国语大学硕士学位论文, 2014年, 第12页。

⁴¹ 晓雪: 《生活的牧歌-论艾青的诗》, 云南人民出版社, 2014年, 第13页。

⁴² 晓雪: 《生活的牧歌-论艾青的诗》, 云南人民出版社, 2014年, 第15页。

⁴³ 张菲菲: 《象征主义视角下的艾青诗歌研究》, 西安外国语大学硕士学位论文, 2014年, 第31页。

⁴⁴ 晓雪: 《生活的牧歌-论艾青的诗》, 云南人民出版社, 2014年, 第19页。



эрхэм дээд сэтгэлийг уриалж байдаг. Шүлэгч нар болж, нар нь шүлэг болоод, нар ба шүлэгч хоёр харилцан уусаж нэгдсэн байна⁴⁵.

“Үүрд дүрэлзэн ноцох нар”-ны цацруулж байгаа гэрэл бол даруй үнэн ёсны гэрэл, шинжлэх ухааны гэрэл, хүмүүсийн үзэл санаа ба хүслийн гэрэл болно. Тэр гэрлийн магтаал, гэрлийн тэмцэл, гэрлийн өнгөрсөн, одоо ба ирээдүйн зураглалаар дамжуулж хүн төрөлхтний боловсон түүхээс аваад гэрэл гэгээ ба түнэр харанхуй, шинжлэх ухаан ба мухар сүсэг, оюун ухаан ба балай мунхаг, бусдач үзэл ба сэтгэлч үзэл, урагшлалт ба ухралт, хувьсгал ба эсэргүүцлийн үхэж сэхэхийн тэмцэл, хүмүүсийн өмнөх нь хойнохоо ялгах түүхийн жам ёс хийгээд бусдач үнэн ёсыг илрүүлж байдаг⁴⁶.

“Нар” гэх шүлэгт:

“Балар эртний онгод булинаас

Түнэр харанхуй цаг үеэс

Хүн төрөлхтний үхлийн урсгалын тагтнаас

Гүн нойрссон уул хайрханыг цочоон хэлмэгдүүлж

Хэрэв гал хүрд элсэн довцог дээгүүр эргэцвэл

Нар миний өөдөөс бөмбөрөн ирмүй ...” гэж амьдчиллыг хэрэглэж, нарыг бичиглэсэн байна.

“Наранд” гэх шүлэгт: “Хэрэв чи үгүй бол, нар аа/ аливаа амь нас аль харанхуйн дотор мөлхөж/ жигүүр байсан ч, зөвхөн багваахай шиг/ өнө үүрдийн харанхуй дунд дүүлэх болно/ би чамайг хайрлах нь хүмүүс тэдний эхийгээ хайрлах шиг/ чи гэрлээрээ миний үзэл хийгээд/ намайг халуун сэтгэлээр амьдруулж, хүслэнгийн төлөө шаналж/ миний амь насыг үхэл аваачих хүртэл”, “Өнөөдөр/ нар миний өчигдөр нулимс урсаж өнгөрсөн нүүрийг үнсэж/ хүний орчлонгийн муу муухайд дургүйцсэн нүдийг үнсэж/ үнэн ёсны төлөө хоолой сөөнгөрсөн дуу бүхий уруулыг үнсэж/ миний өтлөхөөс өмнө буурай болсон/ бөгтийсөн нурууг үнсэж/ өнөөдөр/ би олж сонсов/ нар наранд ярьсан нь” <Над руу

⁴⁵ 晓雪: 《生活的牧歌-论艾青的诗》, 云南人民出版社, 2014年, 第47页。

⁴⁶ 晓雪: 《生活的牧歌-论艾青的诗》, 云南人民出版社, 2014年, 第96页。



ирээрэй> Өнөөдрөөс эхэлж/ чи баяртай байвал таарна .../”, “Нар өөд” гэх шүлэгт шүлэгчийн “би”, шүлэгчийн ил тодорхой бодгаль чанар хийгээд бодгаль чанаржлын сэтгэлгээг илэрхийлж, цаг үеийн үзэл сэтгэлгээ ба хүсэл эрмэлзлийг дамжуулсан байна. “Нар өөд” нь сэхээтний байлдах зориг санаа гэж үнэлэгдсэн байна. Ай Чин-ий “Үүр”-ийн тухай сонирхол нь дотоод сэтгэлийн нэг зүйлийн мэдрэхүй, мөн ч өнгө будгийн нэг зүйлийн дур сонирхол болно. 1942 онд шүлэгч хурц гярхай харцаар хүмүүст хүслийн туяаг дамжуулж, оргилом халуун сэтгэлээр “үүрийн мэдэгдэл”-ийг туурвисан байна.

“Чиний хүрч ирэхийн төлөө/ би уул бэл дээр зогсохыг хүсэж/ тарианы тэндээс буцан ирэх залуу хүүхнийг/ угтах шиг/ чиний өөдөөс хоёр гараа дэлгэнэ ... учир нь чи/ цэвэр ариун инээмсэглэл буй/ бас намайг согтууруулдаг хээр талын цэлмэг амьсгал буй/ ... / аливаа бүхэн нам сэлүү/ бүгчим бороон дуслыг харж, цонхны өмнөө эргэлзэж/ би үхэл, дайныг холбон бодож олов/ бас хүний ертөнцийн аливаа зол бусыг ... /” (Үүр), “Бор ногоон ойр шугуй хийгээд бор/ ногоон ой шугуйн хооронд/ хөх хуйша уул бэлээс хөх/ хуйша уул бэл хүртэл/ номин ногоон хээр тал/ номин ногоон хээр тал, номин/ ногоон хээр талд - / шинэ соргог сүү шиг утаа урсана .../ аа, үүрийн гэгээ цагаан хувцсаа өмсөх үес/ хээр тал тариа ногоо/ хичнээн шинэ соргог аж ! .../” (Үүрийн гэгээ цагаан хувцсаа өмсөхөд), “Чамд харьяалагдах нь/ гэрэл хийгээд харанхуйн солбицолд/ харанхуй тогтуун зайлж/ гэгээн өдөр хөөж гүйцсэн цаг мөчид/ бүлэг од нэгэнт нуугдав/ чи мөн л тэндээ зогсож/ нар мандахыг хүсэж буй/” (Үүрийн цолмон) гэж шүлэгч Ай Чин-ээс хуучин нийгэм сүйрч, шинэ нийгмийн үүрийн гэгээ хүрч ирэхийг хүсэн бахархсан сэтгэлээ илтгэжээ.

“Амь нас бол үүрдийн хүч гаргадаг машин/ хэзээд зогсолгүй урагшладаг хүрд/ хүний амьдрал бол/ нэг зүйлийн өөрийгөө бүлгэм нийтэд зориулах чармайлга/ хувь хүн хийгээд бүх цогцын нэг зүйлийн тохируулал олох чармайлга/ ... / бид ховор нандин амь насаа/ амь насаа яасан ч үрж болохгүй/” (Галт бамбай)-д шүлэгч биеч сэтгэлийн уянгалал ба дүр бүтээлт нь дээд дэсийн авьяас билгийн нэгдэл байж, хүний дүр нь дүрслэг бөгөөд бодгаль чанараараа шүлэгчийн биеч уянгаллыг илрүүлж, шүлэгчийн биеч уянгаллаас хүмүүсийн дүр нь нэн баялаг, нэн өнгө ялгаран солонгорч байдаг. Эдгээр шүлэг нь ард түмний тэмцлийн сүр жавхлантай үзэгдэл хийгээд шүлэгчийн галт бамбайн магтаал, нарны тухай



гал халуун үзэл сэтгэлгээтэй байж биднийг догдлуулж зоригжуулж байдаг.

“Шатсан тал”-д:

“Жижигхэн нэг ширхэг чүдэнз

Шинэ нэгэн ахуйг нээв ...

Тийм их гал аа

Шатсан тал галын далай болов !

Галын сор бүжиглэж, эргэлдэж

Гал есөн давхар үүлний цаана гарав !

Од мичид хагас тал нь гэрэлтэй байж болохгүй

Дууг зөвхөн нэг л хэсгийг нь дуулж болохгүй ...” хэмээн зүйрлэлийг хэрэглэж, эрх чөлөөг хүсэн уриалсан сэтгэлгээтэй нүүр тулж буй.

“Тэр бол хөөрхөн/ галын зан чанартай/ усны гадар дүрстэй/ .../ түүнийг ус гэж үзэж болохгүй/ чиний зовнил шархлалыг эдгээж болно/ тэр бол гал дээр асгасан тос/” (Архи), “Сацрах гэрэл шиг дүрс үгүй/ сэрчигнэх салхи шиг тогтворгүй/ ерөөс тэр бол чиний хооронд/ ямагт зай завсартай байсан аж/” (Хүсэл эрмэлзэл), “Баясан хөөрч хязгааргүй зовон шаналах нь/ бүр нүдээр дамждаг/ хорсол өшөө хэнхдэг цээжинд дүрэлзэж/ нүднээс галын оч бадарна/” (Нүдний тухай), “Урьхан хаврын салхи энд үл хөөрөөд/ уран хараацай нисээд энд ирнэм .../ асга хаднаас унахаас үл эмээвээс/ алаг нүднээ гялбаа сацралыг чинь үл үзнэм/” (Цасан лянхуа) Ай Чин Нулмасаран хоёр шүлэгчийн шүлэгт дэнгийн гэрэл цасан лянхуа зэрэг санаа дүрийн тухай бичсэн мөр бадгууд ч буй.

Нулмасарангийн “Галтай цогтой залуу насаа/ бид зүгээр өнгөрүүлэхгүй/ гавьяа зүтгэлээр дүүрэн бялхуулж/ түүний эрийг гайхуулна/” (Залуу нас), “Хээнцэр ариун цэцэг навч нь бахархалтай ч/ хээр талаас бүхнийг яаж түүнэ дээ?/ хараанд орсон хэдэн бутыг нь чимэглээд/ хаврын өнгийг хуудсан завсар хадгалму!” (Шилийн голын шижир долгио), “Өмсөж чимэхийн сайхнаар/ өнгө зүсээ гайхуулсан бол/ өвдөг тойрон халиурах/ өвс навчинд хослохгүй буй/ эрх нялхраад зангүй/



хөдөөгийн түмэн цэцэг ээ/ элдэв сонин аашгүй/ монголын гоо охид оо/” (Хөдөөгийн түмэн цэцгүүд) гэж шүлэгч өнгөрсөн үеийн тэр бүхнээ эргэцүүлэхдээ түүнийгээ дурлал янагтайгаа холбон шүлэглэж, янаг дурлалынх нь гэрч болж явах байсан онгон уулын сараа магтан дуулсан байна.

“Онгон уулын сар”-д: “Тэр үеэс л мөнгөн сар/ тэнгэрийн биш, манайхны болж/ тэжээж өсгөсөн алтан шороотой минь/ дэлгэсэн биш, төрсөн болжээ/ .../ цайран гялалзах нуур голоос/ царцан тогтсон туяа ойж/ бүрэг бараг цэцэг навчинд/ бүжиглэж хөдөлсөн гэрэл цоохорлоно/ .../ цэцэггүй өвлийн талд/ цас чинь наддаа цэцэг юм/ гэгээгүй шөнийн огторгуйд/ сар чинь наддаа нар юм/ сар – миний нутгийн бараа/ бараа нь намайг хэзээд баясгана/ онгон – миний хайрын цогц/ цогц нь даянд мөнх сүндэрлэнэ/ гэж шүлэгчийн хий хүслийн бүрэлбаа болсон онгон сар доорх хөдөө нутгаа тун хавтай зураглажээ. Шүлэгч өнгөрсний бодит ахуй ба өнөөдрийн зүүд хүслээ шүлэглэж, бодитой ахуй ба зүүдэн дунд зорчиж байлаа.

“Дэн хийгээд Нар”-д:

“Сондор хэлхээ замын дэн

Сувд ээмэг гэрийн дэн

Гэрэлт нарны нөхвөр болж

Гэгээн өдрийг үргэлжлүүлж байна

...

Хоног өдрийг хоёул ээлжилж

Хорвоогийн харанхуйг хоёул үлдэж

Хоолой нийлүүлсэн хоршооны аясаар

<Гэрлийн магтаал>-аа дуулдаг юм аа!

Навчинд өргөх дуу ба гэрлийн магтаал хоёр шүлэгт бүр навч, гэрэл хоёр дүр буй. Гэрлийн магтаал дахь гэрэл нь үнэн ёс, ардчилал, хувьсгал, шинжлэх ухааны төлөөлөл болж, харанхуй бүрэнхий цаг үед ашиг харагч, хувинцар буруу этгээдийн гарт гинжлэгдэн хүлээслэгдэж



байсан бол Нулмасарангийн шүлэгт ногоон навч нь хөдөлмөрчин ард түмний төлөөлөл болж, тэнгэрээс буусан хувилгаан хүлэгт гинжлэгдэж, хар зудын улаан дайсанд цохиулж, халуун нарны гал шилээвэрт шархдаж, эрэн цоохор болж, үр жимс нь унаж, өчүүхэн салааг л үлдээжээ. Гэрлийн магтаал нь нарны өөдөөс нэн баялаг агуулахуунтай, нэн гүнзгий агуулга ба аугаа их хураангуйллын хүчтэй, урлагийн талаар нэн нарийн бөгөөд бүрэн төгөлдөр болжээ. Гэрэл, гэрэл гэгээ, гэрлийн оч зэрэг нь дэлхий ертөнц, түмэн бодис хийгээд хүн төрөлхтний салж болшгүй зүйл болно. Энэ нь мөн ч хүмүүст эхийн хэвлийгээсээ гарч ирэх үеэс үйл ажиллагааны зүйлс болно⁴⁷. Гэрлийн магтаалд өргөн уудам урлагийн ертөнцийг дэлгэж, хүний сэтгэлийг донсолгом үзэл санааны хүчийг хангажээ. Мөн гэрлийн магтаалд хязгааргүй эн ертөнцийн баялаг ба түг түмэн хүн төрөлхтний түүхийн нийтийн үзэгдэл ба амьдралын зураг дүрс, шүлэгчийн хэдэн арван жилийн цаг үеийн амьдрал хийгээд хөгжил хувиралын тухай онцгой сэтгэгдэл ба гүн гүнзгий бодолхийллийг илрүүлж, хүн төрөлхтний хүсэл ба хүслийн магтаал, түүхийн хөгжлийг ахиулах хүч хийгээд оюун ухааны магтаал, шинжлэх ухаан ба урагшлалт, хувьсгал хийгээд үнэн ёс, гэрэл гэгээ ба ирээдүйн магтаал буй⁴⁸.

Шүлэг нь хүн төрөлхтний гоо сэнхрэлийн ухамсрын бүтээгдэхүүн болсны хувьд, түүхийн хувьсалтад өөрийн мөн чанарын онцлог, уянгаллыг тодлох болно. Гоо сэнхрэлийн үзэл ухамсар бол гоо сэнхрэлийн сэтгэгдэл хийгээд гоо сэнхрэлийн хүсэл хоёр давхаргын хувьсангүй нэгдэл мөн⁴⁹. Гэрлийн магтаалд: “Дэлхий ертөнц гэрэл үгүй бол/ хүрхрэн урсах мөрөн голыг олж харахгүй/ мянган газар үргэлжилсэн ой шугуйг олж харахгүй/ догдлох дуртай их далайг олж харахгүй/ .../ дэлхий ертөнц гэрэл гэгээгүй бол/ хүмүүс хос нүдээ алдсантай адил/ пуудалчин баримжаа цэг үгүй тэй адил/ замын хажууд хорт могой байхыг мэдэхгүй/ өмнө талд оноол нүх байхыг мэдэхгүй/ гэж гэрлийн чухал чанарыг шүлэглэжээ. “Гэрлийн бидэнд оюун ухааныг ивээж/ гэрэл бидэнд уран таамаглалыг ивээж/ гэрэл бидэнд оргилом сэтгэлийг ивээж/

⁴⁷ 晓雪: 《生活的牧歌-论艾青的诗》, 云南人民出版社, 2014年, 第95页。

⁴⁸ 晓雪: 《生活的牧歌-论艾青的诗》, 云南人民出版社, 2014年, 第96页。

⁴⁹ 曹万生著: 《中国现代新诗学流变史》, 人民出版社, 2015年, 第259页。



гэрэл бидэнд өнө мөнх дүрийг бүтээдэг/ гэрлийн байгаллаг гоо сайхныг үзүүлсэн байна.

Урлагийн хувьсангуй үзлийг баримталж, түүний ухаанаар хэм айзам ба сул чөлөөлт, төвлөрүүлэл хийгээд дэлгэрүүлэл, бодичлол ба хийсвэрлэл, далд багтаамж ба ил саруул зэргийн харьцаа холбоог зүй зохистой шийдвэрлэж, эв дүйтэй хэрэглэж чадах нь туйлын чухал юм. “Бум түмэн навч мөчир жирвэлзэн ганхаж/ булбарай зөөлөн гараа чамд хурайлахад/ голион царгиа дуу авалцаж/ ноосны нургиа цуурай үүсгэж/ саргай яргуй улам залуу үзэгдэж/ саран хөхөөн дуун улам тунгалаг болж/ .../ сүмбэр хайрханы цаст оргилоор намиран давсан/ сүлд тугийн минь доорх тэдгээр навчис/ ширүүн мөрний давлагаат цэнгэлээр халин өнгөрсөн/ цест армийн минь завин дээрх навчис/ тэсрэх аянгын ганц очийг биедээ золгуулж/ тэнэгэр талын түймрийг ноцоосон тэдгээр навчис/ тэмдэгрэх үүрийн зурвас гэгээг шүүдэртээ тусгаж/ тэргэл нарны мандлыг мэдээлсэн тэдгээр навчис/” шүлэгт далд багтаамжтай хийгээд ил саруулыг хамгийн сайхан уялдуулж хэрэглэсэн шүлэг болно. Бэлгэдлийн аргаар бичигдсэн болохоор далд багтаамжтай мөртөө бас утгын хандлага нь тодорхой шүлэг болно. Тус шүлэгт сайн сайхан зол жаргалт шинэ амьдралыг тэмцэн авч ирэхийн төлөө өөрийн амь биеэ харамгүй үрэгдүүлсэн тэдгээр навчис – түг түмэн хувьсгалт баатарчуудын ач гавьяаг магтан дуулсан байна⁵⁰. Навчинд өргөх дуунд навчаар эгэл жирийн ард түмнийг бэлгэдэж үзүүлсэн төдий биш, харин шүлгийн мөр бадагтаа хүртэл голдуу дүр төрхөөр хийсвэр санааг бодитой болгон илтгэсэн байна. Нулмасаран навчаар хөдөлмөрчин ард түмнийг бэлгэдэн, навчны хэв чанар, навчны түүх, навчны талхигдал, навчны амилал – хөдөлмөрчин ард түмнээ магтан дуулж, соёлын их хувьсгалд тарчлал, шаналал амссан ард түмнийг өрөвдөн, тэдний сэтгэлийн дууг уянгалуулан, хилэн хорслыг хашхиран, маргаашийн төлөө зүтгэх ард түмний төлөө зүтгэх зориггоо илтгэжээ. Нийгэм түүхийн ач холбогдол бүхий том сэдвийг сонгож, цаг эриний зүрхний лугшааг сонордуулж, ард олны бодлын үгийг зоригтой хэлдэг. Уянга сэтгэлгээний үйл давлагаа, уран дүрийн амьдлаг дүрсээр санаагаа илтгэдэг.

⁵⁰ Дархан. “Нулмасарангийн шүлгийн сонгомолыг уншаад”, МХУЗ, 1987 №2, т 27



“Навч соёог зөөлөн гэж битгий бас/ найлзуур биед нь алмаз хатуу яс шөрмөстэй юм/ намиран буусан өгөөмөр хур ганцхан ундалмагц/ нэвшрэн дарсан хад чулууг ч ив өргөдөг юм/ .../ нарны гэрлийн үр хөвгүүд ээ, үр хөвгүүд ээ/ надад бас гал жигүүрээ хөвчилж өгчээ/ найраг шүлгийн минь өд өрөвлөг зөөлөн боловч/ харанхуйг дайрах таны тэмцэлд хүч нэмэг !/ аливаа бүхний сурвалж болсон гэрлийн өгөөмөрч, ашиг харахгүй байдлыг ид хүчтэй тусгажээ. “Хур атрыг арчуурын алхаагаар өн оруулж/ хурц наранд хөлсөө асгалсан тариачин аав минь/ хурга тугалыг уургийн хувингаар сүрэг болгож/ хур салхинд нүүрээ борлуулсан малчин ээж минь/ хүчний манжиргаар балай харанхуйг хэмхчин няцалж/ хөгжлийн харшийг гагнан босгосон ажилчин ах минь/ оюуны дураар орчлонгийн гайхамшгийг тодруулан дэлгэж/ урьдын зүүдийг үнэнд ойртуулсан эрдэмтэн багш минь!” хэмээн байгаллаг навчисын сайхан, хүний эрхэм дээд зан чанарыг зураглажээ. Нулмасаран бол улс төрчийн байдлаар нийгэм байгалийг шинжиж, уянгалаг аястай дүр төрхөөр гол илтгэх арга барилаа болгосон өвөрмөц хэв маягтай шүлэгч болох юм. Тэр ер нь санаа сэтгэлгээгээ цулгүй хийсвэрээр илтгэхээс зайлсхийж, аль болох шинэ сэвүүн, амьд дүрслэг, бодит байр суурьтай уянгалуулан илтгэхийг эрхэмлэсэн байдаг. “Түгшүүрийг ялсан 10 сарын наран доорх/ түмэн улаан буман ногооныг та үзээч дээ/ төвшрөлийг авч ирсэн шинэ эриний босгыг бүрхсэн/ төлжин дэлгэрэгч өнгө үзэмж нь юутай эрхэмсэг!/ .../ найман зүг дөрвөн зовхист илчээ цацруулсаар/ нарны гэрлийн үр хөвгүүд гялалзан айсуй/ найрал яруу цэл ногоон дуугаа аялсаар/ навч цэцгийн эгч дүү нар мяралзан айсуй!” Нулмасарангийн шүлгийн цог сүлд нь тэр гачигдлаар эхэлсэн шүлгээ хилэн хорсол, хүмүүнчлэлээр төгсгөв. Түүний ихэнх шүлэг нь үндэстний хувь заяа, улс ирээдүйн тухай санаа тавьсан байна.

Хоёр. Эх хүн, эх газрын зураглал

Хүний зураглал нь Ай Чин-ий шүлэг дууны амьгүй бодисын будаггүй зураг илэрхийлэл дундах чухал зүйл болно. Түүний “Да Яньхө – миний хөхүүл эх” гэх эрхэм дээд утга агуулга бүхий эхийн зориг санааны хүч нь хүмүүсийг гэрэл гэгээ рүү хөтлөн дагуулж байдаг. Ай Чин шашин суртахууны өнгө будаг өтгөн шүлэг дууллаар хүн чанарын цайлган хийгээд харанхуй, хүн чанарын авралаар дамжин хүмүүсийн амь насны үнэ цэнийн эрхэм дээд ба дорой буурай гэх эсрэг онолыг илчилж,



амь насны эрхэм дээд ба хүний нэр хүнд зэрэг хүмүүнлэг үзлийн сэдвийг сүвэгчилж, Ай Чин эх гэх дүрээр гэгээвч болгон, шүлэг дуундаа хүмүүнлэг үзлийн үзэл санааг нэмэрлэжээ. Шүлэг дэх эх хүний дүрийн цөм нь эхийн нууц хүч чадал болно. Төрж өсөх, дахин төрөх зэрэг амь насны үзэл ухамсар ба идэвхтэй уужим амь насны үзлийг шингээж, шүлэгч эх гэх их хайрын хүчээр дайн дажин дуусгах, үүрийн гэгээ хүрч ирэхийг хүсэмжлэн барласан байна⁵¹. “Хөх” нь эх, эх нутаг, гэр бүлийн гүн зузаан мөрөөдлийн сэтгэлийг тусгажээ. “Хөх” гэх энэхүү санаа дүр нь мэдрэлийн чадварын өнгө будагтай байж, зохиогчийн тухайн үеийн ганцаардмал муужралын сэтгэлгээний туршлагыг зурагласан байна. “Да Яньхө – миний хөхүүл эх” бол тун цөөн эхийн дүрийн зураглалт шүлэг болно, шүлэгт нэн дотоод чанарын илрүүллийг чухалчилж байдаг. Ай Чин тэдгээр хүчир зовуурт он жилүүдэд энгийн бөгөөд аугаа их эхийн дүрийг бүтээж, шүлэг дэх эхийн дүр нь нялх хүүхдийн тухай халамжлал ба өхөөрдөл тусгагдаж, уншигчдад хязгаарлашгүй догдлолыг өгдөг.

Да Яньхө зохих хэмжээнд нутаг усны хайр сэтгэл ба түшиглэл, эх нутгийн хүмүүнчлэл, эх газрын хүмүүнчлэлийг харуулж байдаг. Шүлэгчийн эх орон ба ард түмний гүн зузаан хайр халамжлал нь шүлэг дууны хүнд нүсэр гансралын сэтгэлгээний суурь болно. Эх орон хийгээд ард түмний хүн нүсэр чин үнэнч хайр сэтгэл нь шүлэгчийн хүмүүст дайны ялалтын итгэлийг уриалж, нэг талаар тухайн үеийн харанхуй нийгэм, ард түмний хүнд зовлон, эсэргүүцлийн зориг санааг дуудаж, зөвхөн ингэвэл сая дундад улсын гэрэл гэгээг олж чадна гэж үзжээ. Да Яньхө бол Ай Чин-ий нэг зүйлийн зовнилт хайр, түүний гансрал нь түүний амьдарч байсан амьдралын цаг үеэс гаралтай. Да Яньхө нэг зүйлийн бэлгэдэл болж, нэгэн аугаа их эх хүн, дундад улсын түг түмэн ажилч энгийн хөдөлмөрчин түмний бэлгэдэл болсон байна. Да Яньхө бол нэгэн эхийн хайрын бэлгэдэл, тэр ажилч энгийн, түгээмэл хайр, цуцашгүй, эрэлхэг баатарлаг, “үнэн, нинжин, гоо” бүрдсэн эхийн чанарын тусгал мөн⁵². “Да Яньхө – миний хөхүүл эх” нь шүлэгчийн өмнөх хугацааны хүмүүнлэг үзлийн үзэл санааг гүйцэд илэрхийлж, шүлэгчийн ядуу зүдүү хөдөлмөрчин эмэгтэй Да Яньхө-ийн гунигт амьдралын зүрх зүсэм гашуудлыг илэрхийлж, түүний дүрээр дамжуулж,

⁵¹ 陈剑雨《二战时期中日诗歌母亲形象比较-以左翼诗歌为例》，重庆师范大学硕士学位论文，2018年，第25页。

⁵² 周迎：《母性崇拜：解读艾青诗歌的一个视角》，西南大学硕士学位论文，2009年，第5页。



хагас феодал хагас колонийн дундад улсын хөдөө тосгоны уруудал хоосрол, үгүйрэл доройтол ба хязгааргүй зовлонгийн илэрхийлэл болжээ.

Эмэгтэйчүүдийн хувь цогцын гунигт жүжиг бол тухайн цаг үеийн нэгэн гол мотив болно. Өрөвдлийн цаана Ай Чин-ий эмэгтэйчүүдийн дарлагдаж байгааг хайхрахгүй буюу хүч гаргах чадалгүй байгааг илэрхийлж буй. Эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүдийг хүндэтгэхийн аргагүй, гунигт жүжиг нь тасралтгүй үүсэж, эмэгтэйчүүдийн оршихуйн үнэ цэнэ нь оршихгүй болдог. Эмэгтэйчүүд тэдний шүлэг бүтээлд эхнээсээ дуустал нам дуугүй байж, өөрийн хүчир зовлонгоо уудлахын аргагүй, нийгмийн тухай эсэргүүцэл нь үг дуугүй эсэргүүцэл болсон байна⁵³. Ай Чин эхийн хүчир зовлонгийн тухай зураглалд, эхийн цуцашгүй амилалын эрч зоригийн тухай магтаал, Лү Шюнь шиг “минчүүрсэн үзэгч нар”-ын хилэгнэл ч буй. Түүний хүсэж бүтээсэн нь үнэн бодит оршсон эхийн ертөнц харин хүслэнгийн бус эхийн домог биш юм⁵⁴. Хүчир зовлон ба тэлчлэл нь шүлгийн гол үзэл санаа болсон байна. Биеэ үрэгдүүлэх маягийн гунигт жүжгийн үзэл санаа бол Ай Чин-ий шүлэг дууны чимэг болно. Бодит ахуй хичнээн харанхуй, олон зүйлийн гэр бүлийн дарамтыг эдэлж байсан ч Да Яньхө баясангуй амьдралын үзлийг баримталж байдаг. Ай Чин-ий зүрхэнд сийлэгдсэн Да Яньхө-ийн үнэн, түүний эгэл гадаад төрхийн дотор хадгалагдаж байгаа худал үгүй эхийн хайр болно. Ай Чин их бичиглэлийн “эх”-ийн үнэн, нинжин, гоо эхийн чанарыг илчилснээр барахгүй, түүний шүлэг зүйн хүслэн үнэн, нинжин, гоо гурвын нэгдэл нь хүн төрөлхтний хамтын эрч зоригийн гурван зүйлийн илрэл, шүлэг нь эрхбиш тэдний хоорондох хамгийн сайхан харьцаа болсон байна⁵⁵.

“Өрлөг эх – Да Яньхө минь” шүлэгт:

“ ...

Да Янь хө, амьдрахын төлөө

Хөхний сүүгээ ширгэтэл урсгасны дараа

⁵³ 陈董: 《艾青与惠特曼诗歌比较研究》, 西安外国语大学硕士学位论文, 2013年, 第29页。

⁵⁴ 周迎: 《母性崇拜: 解读艾青诗歌的一个视角》, 西南大学硕士学位论文, 2009年, 第7页。

⁵⁵ 周迎: 《母性崇拜: 解读艾青诗歌的一个视角》, 西南大学硕士学位论文, 2009年, 第16页。



Тэр минь намайг тэвэрч байсан хоёр гараараа хөдөлмөр хийдэг

Тэр минь инээмсэглэсээр бидний хувцсыг угаана

*Тэр минь инээмсэглэсээр ногооны сагсыг бариад тосгон захын
мөс зайрмагтсан цөөрөмд хүрдэг*

Тэр минь инээмсэглэсээр мөсөн хэмхдэг бутарсан лууван хэрчдэг

*Тэр минь инээмсэглэсээр гараараа гахайн тэжээлийн агыг
малтдаг*

*Тэр минь инээмсэглэсээр мах чанаж байгаа зуухны галыг
тэвхэрддэг*

*Тэр минь инээмсэглэсээр дугуй саваа өргөөд талбайд очиж шар
буурцаг болон буудай дэлгэж ээдэг*

...

Да Яньхө өнөөдөр, таны хөхүүлж өсгөсөн хүү чинь гянданд

Танд магтаал шүлэг бичиж

Шар шороон доорх таны бор улаан сүнсэнд өргөж

Намайг тэвэрч байсан сунаж сарвайсан гарт чинь өргөж

Намайг таалж байсан уруулд чинь өргөж

Гөлтгөнөсөн хар эелдэг зөөлөн царайд чинь өргөж

Намайг мөөм идүүлж тэжээсэн хөхөнд чинь өргөж

Үр хүүхдэд чинь, ах дүү нартаа өргөж

Өнөр их дэлхийн аливаад

Да Яньхө-тэй адилхан миний өрлөг, эхтэйгээ таны үрсэд өргөж

*Намайг яг төрсөн үртэйгээ адилхан хайрладаг Да Яньхө-дөө
өргөнө ...” Жу Гуанчянь-ий үзэхээр шүлгийн айзам бол тус бие нь үзэл
сэтгэлгээний нэгэн чухал хэсэг мөн⁵⁶ гэжээ. “Да Яньхө – миний хөхүүл*

⁵⁶ 曹万生著：《中国现代新诗学流变史》，人民出版社，2015年，第258页。



эх” шүлгийн хамгийн чухал онцлог – өөрийнхөө сэтгэлгээгээр уншигчийн баяр баясал урам сэтгэлийг урамшуулж байдаг. “Тэнгэр дээр/ нарыг олж харахгүй/ ганц сүрэглэж байгаа хунгийн сүрэг/ хэлмэгдэн цочисон хунгийн сүрэг/ хар өдөн жигүүрээ тавьж/ тэдний тайван бус хийгээд гуниг гашуудлаа дуудна/ энэ эзгүй орон зайнаас зугтаана/ номин ногоон өвч бүрхсэн өмнө оронд/ зугтаан очно .../” (Умард зүг) шүлэг нь умард орны хүчир бэрх ба түүний эх газар шиг өргөн уудам элбэг баялагийг зураглаж, Ай Чин-ий нэг зүйлийн аугаа их үзэл санааны долгисол хүртэж, ганц хүрдэт зүтгүүр тэрэг, шар элсэн шуурга, илжиг, тэмээ, гуйранч эдгээр бүхэн нь бидний үндэстний урт удаан түүх хийгээд хүнд нүсэр чээжлэхүйтэй харьцаа холбоотой байдаг. Умард орон нь Ай Чин-ийг нэн нүсэр хүнд үнэн бодитой болгожээ⁵⁷.

“Хавар аа/ Лун хуа-ийн туурийн цэцэг дэлгэрлээ/ тэдгээр шөнийн хооронд дэлгэрлээ/ тэдгээр цусан толбот шөнийн хооронд/ тэдгээр шөнийн одон гэрэлгүй/ тэдгээр шөнө салхи дэгдэж байв/ тэдгээр шөнө бэлэвсэн бүсгүйн мэгшихийг сонсоно/” (Хавар), Ай Чин цусан толбот шөнө, цустай мөр зэрэг ороо бусгаа цаг үеийн хүмүүсийн хүчир зовлон зол бус хувь заяа, уярал гансрал, өрөвдлийг бичиглэсэн бол Нулмасарангийн “Навчинд өргөх дуу”-нд: “Булан тохой өндөр нам газар бүхнээс/ бут бургас өвс цэцэг ургамал бүхнээс/ бум түмэн навч мөчир жирвэлзэн ганхаж/ булбарай зөөлөн гараа чамд хурайлахад/ .../ ийм л сайхан тийм л сонихонд нь манай монголчууд/ эх дэлхийгээ навчит дэлхий гэсэн ч бололтой/ эмээл түрүү хорго авдар эдлэл бүхэндээ/ сийлбэр нарийн навчин хээ урласан ч бололтой/ .../ наадах дэлхийн сая түмэн жирийн хөдөлмөрчдийн/ нарны зүг шөнөөс мордсон цустай мөрөөс/ намрын зүг өвлөөс гарсан хөлстэй мөрөөс/ навчны зам хэрхэн суналзахыг үзээч та: / илч гэгээг бидэнд өгсөн нүүрсэн дээр ч/ им тамгаа дурайтал дарсан навчин хуараас/ ирсэн замынх нь хол ойрыг шинжиж болно/ ивээл хайрынх нь их багыг хэмжиж чадна/” гэж шинэ амилал, шинэ амьдралыг хүсэн бахдаж, магтан дуулсан байна.

“Хөдөө тал” шүлэгт: “Хүнийг согтоом хөвсийн хөөрч/ хүмүүсийг согтоом цэл ногоором/ хөвсийн хөөрөх нь гацуурын шугуй/ цэл ногоорох нь талын зүлэг/ хөөрхөн хүүхэн хайр бахдалыг татаж/ хонин сүрэг хайр

⁵⁷ 晓雪：《生活的牧歌-论艾青的诗》，云南人民出版社，2014年，第21页。



бахдалыг татнам/ хүлэг морь минь ч энд хоргодон эргэцэж/ хүсэл сэтгэлээ энэхүү газар үлдээнэм/” гэж хүсэл сэтгэлээ хөдөө нутагтай холбон шүлэглэсэн байна.

“Дахин амилсан эх газар” шүлэгт:

“Учир нь, бидний өнгөрсөнд үхсэн эх газар

Гэгээн цэлмэг огторгуй доор

Нэгэнт дахин амилав!

...

Хүчир зовлон нэгэнт чээжилвэр болов

Түүний халуун өвөрт

Дахин эргэлдэн оршиж байгаа нь

Байлдагчийн цус мөн”

“Хөдөө тал”, “Дахин амилсан эх газар”, “Умард зүг”, “Дундадын эх газарт цас шуурав” зэрэг шүлгүүд нь өөрийн сэтгэлээсээ үүсгэсэн цаг үеийн үзэл санаатай нэвтрэлцүүлсний илрэл мөн. Улсаа хайрлах үзэл бол Ай Чин-ий шүлэг дууны хэзээд магтан дуулдаг гол хөг аяс, гол сэдэв болно. Эх орны хайр сэтгэлээ уянгалуулах бол Ай Чин-ий улсаа хайрлах үзлийн шүлэг дууны гол агуулга болно. Түүний улсаа хайрлах шүлэг дуу нь бас ард түмний хайр, дундад улсын доод давхаргын хөдөлмөрчин ард түмний хувь заяаг анхаарч байдаг. Шүлэг дууны гол сэдэв хийгээд үндэстний мандаж мөхөхтэй нягт харьцаатай байдаг. Түүний нүдэнд “үргэлж нулимс цэлэлзэж байдаг” гэдэг нь шүлэгчийн сэтгэл дэх зовнил ба хязгааргүй хорслыг илрүүлж, эх орны тухай хязгааргүй хайр, дурсгал, түрэмгийлэгчид эх орныг талхидаж, ард түмний мөлжил дарлал амсаж байгааг хараад шүлэгчийн дотоод сэтгэл дэх нэн чанга хүчтэй зовнилыг буй болгосон байна. Ай Чин-ий эх газрын шүлэгчин хэмээгдэх шүлэг “Энэ нутагтаа би хайртай”-д: “Шулганан жиргэх шувуухай болжмор/ болсон бол би/ шүнгэнэх шаргиа хоолойгоороо/ ингэж нэг уянгалахсан/ догшин салхи ширүүн бороонд/ талст мэт энэ нутгийн шороо/ тугтам оргилох гуниг зовлонг/ өнөд цалгилуулсан мөрөн гол/ зогсошгүй үлээн исгэрэх/ хилэн хорслын салхи хийгээд/ зузаан хөвчийн завсраас айсуй/



өглөөний туяаг/ уянгалж – эцэс мөртөө/ үхэж мордохдоо/ өд сөдөө ч үлдээлгүйгээр/ энэ хөрснөө булнам!” гэж шүлэгч эх газар, үндэстэн ястандаа хайртай сэтгэлээ илтгэжээ.

Нулмасарангийн “Навч барьсан өнгөт хаврын оёдолчин/ навтар савтар дээл хувцсыг нь соливч/ намаа холбосон одон эмжээртэй зээл ээ/ найман зүгийн салхийг урин зуралзана” (Бахархалтай Хөх хот минь), “Уургаа чирээд малдаа гарах үес/ ургах нарыг давлагаан дээгүүр угтдагсан/ уналгаа ергүүлээд гэртээ суух үес/ унах сарыг шуугиан дундуур үддэгсэн ...!” (Далайн хөвөөнөөс түүж ирсэн шүлгүүд – давлагаан шуугиан хоёр), “Баарины аялалаас – улаан тоос ногоон униар”-т: “Манарах тоос эргээд л бүү үзэгдээсэй/ манай амьдралд хайр дурлал хэрэгтэй шүү!/ мандах нарны улбар гэрлийг гялалзуулаад/ малын бэлчээрт номин униар нутагшиг!/ мөнгөн сарны цагаан туяаг нөмрөөд/ мөчир навчтай зөөлөн униар үнсэлцэг!/ хэмээх Нулмасарангийн шүлэгт эрх тэгш ардчилал, эрх чөлөөт үзэл санаа ба урван тэрслэх үзэл санаа нь органик нэгдэж, өөрийн шүлгийн гоо сайхны үзэл санаан хамгийн дээд илрэл болгодог. Гагцхүү эрх тэгш, ардчилал ба эрх чөлөө нь сая гэрэл гэгээ хийгээд гэрэл илчээр нартай адилтгаж болдог. Үнэн үг хэлэх бол ер нь Ай Чин-ий баримталдаг урлагийн зарчим юм. Шүлэг дуугаар өөрийн үзэл сэтгэлгээгээ илтгэх нь шүлэгчдийн ур авьяас мөн. Навчин өргөх дуунд: “Мөрийг нь мөшгөж дууг нь чагнаад явах тутам/ нар ойр, гэрэл ойр, хавар ойр оо!/ дууг нь бахарч, мөрийг нь гишгээд аялах тутам/ нутаг сайхан, ус сайхан, хүн сайхан аа!” Нулмасарангийн шүлэг нь зүүд ба бодит ахуйн хоорондох зорчигч “би”-ийн дүрийг болж харах нь дамжиггүй. “Сэтгэл бөмбөрөх гурван сарын хонгор салхи чинь/ сэргэлэн навчны дэгдлээд ирсэн жороо сайвар шүү/ сэжүүр хаданд тал нь хүрмэгц зэрэглээн мяралзаж/ сэрүүн булагт туурай нь тусмагц долгион босно/ найр хөгжөөнт зургаан сарын амилалын шуугиан чинь/ навч ногоонд бодогдож гарсан уянга дуулал шүү/ намааны үзүүрээс голион царгиа дуу авалцаж/ намгийн хөвөөнөөс ноосны нургиа цуурай үүснэ!” гэж гэрлийн хүлээслэгдэл ба навчны талхигдал, гэрлийн чөлөөлөгдөл ба навчны дахин амилал, хувь биеийн хүсэл эрмэлзэл тусгагдаж буй. Түүний зүүд нь хүүхэд насны үеийнхээ өчигдрийн тухай дурсал мөрөөдөл, эх нутгийнхаа энхрий хайранд татагдан хоргодох үеийн сэтгэл бялхаж байдаг. Түүний шүлгүүдэд сарны гэрэл, нохойн дуу, горхины чимээ, хот руугаа эргэх сүрэг, үдшийн жиргээ, үүрийн жавар туйлын үнэнч



сэтгэлийн хайр мөрөөдлөөр бялхаж байдаг билээ. Шүлэгч төрсөн нутгийнхаа тэр бүхнийг миний өмч, эрхэм алдар, үхэл мөхөл ба юугаар ч солихгүй гэсэн хайр сэтгэлээ илтгэжээ⁵⁸.

Гурав. Цаг үеийн уриа дуу

Ай Чин уужим хараагаар цаг үетэй зохицох үед, өөр би-ийн үзэл ухамсар ба цаг үеийн үзэл ухамсрыг баримталж, ухуулах чадавх хийгээд урлагийн онцгой чанарын нэгдлийг баримталжээ. Цаг үет чанарын зарчим бол бодит ахуйн халамжлалын үзэл санаа ба өөр би-ийн гоо зүйн хэлбэршил нь Ай Чин-ийг ухамсартайгаар “эгэл даруу” шүлэг дууны гоо зүйн хэв маягийг сонгуулжээ. “Алдагдсан он сар”-д: “Зарим нь хүйтэмсэг жижигхэн тосон дэнгийн доор/ гэвэл цаас шиг авч болохгүй/ нэн аяга усыг газарт асгах шиг/ ширж хадсаны дараа/ жаахан сүүдрийг ч олж харахгүй/” гэж гээгдэн орхигдсон, үрэгдэж талагдсан он сарын төлөө харууссан сэтгэл байх бөгөөд “Аль жил аль сарыг мэдэхгүй/ намжуун тогтуун атлант далайгаас/ нэгэн ширхэг унтаахай лянхуа дэгдэн ирэв .../ венец сувд шүрээс ч гялалзам/ тэр бол их далайн хатны манлай титэм/ венец баярын өдрийн орой буй/ түмэн айлын дэнгийн гэрлийн тонгоруу сүүдэр/ усанд хөвж буй/” (Венецийн оройн хөгжим) гэж гадаадад суралцаж байх үеийн амьдралаа зурагласан байна.

“Нүүрсний яриа” шүлэгт:

“Аварга гүрвэл ой шугуйг эзэрхсэн цагаас

Чи нэгэнт гүн шаналал хорслын дунд үхэв

Үхэл ? биш, би мөн амьдрах буй

Газрын гадаргуу анх чичирхийлсэн цагаас

Надад гал өгөгч надад гал өгөгч!” нүүрс бол эртний дундад улсын бэлгэдэл болсон зүйл юм. “Нүүрсний яриа”, “Дахин амилсан эх газар”-ын хөгжил нь шүлэгт шүлэгч гансралаас бүрмөсөн хагацсан баясангуй үзэл сэтгэлгээ хийгээд үндэстний омогшилт сэтгэлгээ бялхаж байдаг⁵⁹.

⁵⁸ С.Баяр: “Нулмасарангийн шүлгийн ертөнц”, Алтан түлхүүр, 1989.5-6 т 37

⁵⁹ 李怡著: 《中国现代新文学与古典诗歌传统》，中国人民大学出版社，2015年，第249页。



“Дундадын эх газарт цас шуурав”:

“Дундадын эх газарт цас шуурав

Хахир хүйтэн дундад улсыг битүүмжлэв

Дундад улс

Миний дэнгийн гэрэлгүй шөнө

Туурвисан сулхан шүлгүүд

Чамд өчүүхэн төдий ч дулаан өгөх билүү?”

Японыг эсэргүүцэх дайны үед, Ай Чин-ий шүлэг түүний нарийн будлиантай сэтгэлийг эзэмдэх ба шийдвэрлэх чадвар, хос хосоор харилцан зөрчилдөж хамтран орших шүлгийн сэтгэлгээ ба шүлгийн ид шид нь эх газрын эгэл даруу бөгөөд гунигтай, тариачны тэнэг мунхаг ба мужаад, байлдагчийн элэй халай эрхэм дээд жич хүний үхэл хийгээд дахин төрөх зэрэг зүйлс түүний бийр доор зураглагджээ⁶⁰. “Би богино саравчин доор зогсож/ сэтгэл төвлөрүүлэн зэрлэг уул довцог хийгээд/ өндөр хол уудам огторгуйг харж/ удтал сэтгэл дотор ямар нэгэн гайхамшгийг мэдэрсэн шиг/ би гэрэл цацарсан юмыг олж харан/ тэр яг нар шиг миний сэтгэлийг зоригжуулна/ тэнгэрийн хязгаарт хүнд нүсэр нүргэлэх дуутай/ догшин салхи ширүүн бороо галзуу хохирол шиг/ давлагаан долгион наашлана/” (Цаг үе) хэмээн цаг төрийн тайван бус, ер бусын байдлыг шүлэглэжээ.

Гэрлийн магтаалд дундадын үндэстний түүхийн эргэлтийн явц дунд, онцгой түүхийн агуулагдахуун ба ил тодорхой цаг үеийн онцлогийг ивээсэн байна. Тэр нь хурц чанга урлагийн нөлөөлөх хүч ба маш том үзэл санааны хүчтэй байдаг. Гэрлийн магтаалд шүлэгч 20, 30-аад оны үеийн бие махбод ба үзэл санаа нь хүчир зовуурь амсаж, чөлөөлөгдсөн шүлэгч сүг сүнсний гүн дэх эрх тэгш, ардчилал ба эрх чөлөө нь хувь хүний чухал чанарыг таньж, тэр нь зарим анги давхаргын онцгой эрх тэгш биш, нэн ч бүх хүн төрөлхтний төрөлхийн мэдлэг боловсны илрэл болсон байна⁶¹. Гэрлийн өнгөрсөн, одоо, ирээдүйг

⁶⁰ 李怡著：《中国现代新文学与古典诗歌传统》，中国人民大学出版社，2015年，第250页。

⁶¹ 贺孝恩：《艾青「诗论」美学思想研究》，西南大学硕士学位论文，2010年，第9页。



дүрслэн гэрлийг магтан дуулахын зэргээр гэрлийн хүсэл хөөцөлдлөөр хүн төрөлхтний хөгжлийн түүхийг эргэцүүлэн бодолхийлж, гэрэл гэгээ харгис харанхуйг ялдаг – гэрэл гэгээтэй хамт урагшилж, гэрэл гэгээг магтан дуулах зориг санаагаа илтгэжээ.

Нулмасарангийн “Нийгэм журамдаа нараа дагасан цэцэг гэвэл/ нийтийн төлөө цэцгийг ундаалсан хур шиг/ мөр нь хүрсэн ариун хөрс нэг бүрт/ мишээлт цэцэг тэдний араас дэлгэрнэ/” (Болд байлдагч, аугаа байлдагч), “Арван сарын улаан навч аа/ асга ирмэгийн ногоон нарс аа/ аруухан үзэмжээрээ тэднийг даллаж/ аяны зүдрэлийг нь тайлж байна уу?/” (Хайн шинжлэгчдийн дуулал), “Намрын хяруу санчигт нь буусан/ настай хуурчийн амьдралын замд/ нартай наргүй хоёр хэсэг/ наана цаана нь ялгарч байдаг/ настай насгүй хоёр заяа/ намын шугамтай холбогдож байдаг/” (Үндэс гүн сурвалж урт), “Цас нөмөрсөн нарс майлс нь одоо/ цагаан лянхуа усанд ганхахаас эснүүн ээ/ бороонд угаагдсан сарлаг хуар нь өнөө/ булбарай мандарваа пянзанд дэлгэрэхээс сэрмүүн ээ/” (Хатан гол ба залуу нас), “Эрдэнэ чулууны тунгалаг хөх өнгөтэй/ эх улсынхаа цэлгэр огторгуйг харахад/ эрхэс цэцгийн анхилам сайхан үнэртэй/ энхжил өөдлөлийн цэвэр агаарыг амьсгалахад/ өвчүү цээж минь тал шиг тэнийн саруулжиж/ эрх жаргал минь далай шиг гүн санагддагсан/” (Бараан үүлний сарнилт) зэрэг шүлгүүдэд тухайн үед ихэнх шүлэгч зохиолчид эдгээр алс хэтийн ач холбогдолт түүхт явдлыг хангалттай сайхан тусган харуулж амжаагүй байхад Нулмасаран үүнийг цаг тухайд нь өөрийн уран бүтээлдээ урлагаар тусгаж, цаг эриний зүрхний лугшааг уншигчдад хүчтэй сонордуулсан байна.

ТӨГСГӨЛ

Шүлгийн гоо сайхан нь шүлгийн сэтгэлгээний гоо сайхан, санаа дүрийн гоо сайхан, хэлний гоо сайхан, шүлгийн хэлбэрийн гоо сайхан зэрэг талаар илэрдэг. Бодгаль чанарын эрх чөлөө нь Ай Чин-ий шүлгийн гоо сайхан сэдвийн мөн чанарын цөм болсон байна⁶². Ганцаардал нь Ай Чин-ий үндсэн үзэл сэтгэлгээ болсон байна. Урлагчийн биеч үзэл сэтгэлгээгээ зохиол бүтээлдээ уусгасан бүтээл бол сая жинхэнэ амь настай байдаг. Ай Чин хялбар эгэл урлагийн хэв маягийг хөөцөлддөг. Хүмүүнлэг үзэл бол түүний шүлэг дууны гол илрэл болно. Энэ нь цаг

⁶² 张菲菲：《象征主义视角下的艾青诗歌研究》，西安外国语大学硕士学位论文，2014年，第54页。



үеийн хувьсалыг дагалдан хувирч, улс ба үндэстний хувь заяатай нягт харьцаатай байдаг⁶³. Ай Чин-ий шүлэг нь хэлний гоо сайхан, найрууллын гоо сайхан, эрх чөлөөт шүлгийн бүрэн төгөлдөр гоо сайхны нэгдэл мөн. Дүрслэг сэтгэхүй бол Ай Чин-ий шүлэг дууны зохион бүтээлтийн үед дэлхий ертөнцийг танин мэдрэх үндсэн арга хэлбэр мөн, дүрслэг сэтгэхүйн чухалчлал нь түүнийг зохион туурвилын явц дунд мэдрэхүй хийгээд үзлийн маягийн уран бүтээлийг хүндэтгэх болгосон байна⁶⁴. Буцан ирсэн ахмад нэг үеийнхний бүх цогцот чанарын уянгалал бол нийгэм түүхийн бүх цогцот эзэмдэл болно. Тэд нар заалдлагаар гол сэдэв болгож, шүлэг дуу нь эгэл, дан цулгуй, төвлөрсөн, ил саруул онцлогтой байдаг⁶⁵. Цаг үеийн тэнүүлчний сэтгэц бол Ай Чин-ий зохиол бүтээлийн бодгаль чанарын нэг зүйлийн илрэл, гансралын сэтгэлгээ бол түүний нэг насны зохиол бүтээлтийн бодгаль чанарт нөлөөлж байв. “Үнэн, нинжин, гоо”-ийн нэгдэл бол түүний шүлгийн гоо зүйн системийн цөм болно. Түүний шилдэг чанар хийгээд онцгой чанар нь цаг үеэс хэтийдэн давах чанар дээр илрэлээ олдог. Ай чин-ий шүлэг дуу дахь хүн төрөлхтний чанарын гол сэдэв бол түүний тухай судлалын ахилтгүй байхын үндсэн шалтгаан болно⁶⁶.

Яруу найраг бол амь насны нэг зүйлийн орших хэлбэр, аливаа бүхнийг хэтийдэн давсан оюун сүнсний аруухан болор тоочил мөн. Шүлгийн үзэл сэтгэлгээний ертөнц бол сэтгэлгээний элемент, шүлэгчийн үзэл сэтгэлгээ нь шүлэг бүтээл дэх дахин илрүүлэл, даруй шүлэг дуунд уусгасан үзэл сэтгэлгээний элемент болно. Шүлэг дууны үзэл сэтгэлгээний ертөнц бол шүлэгчийн үзэл сэтгэлгээ эсвэл дотоод сэтгэлгээ нь гадагшлалаар дамжин гоо мэдрэхүйн өнгө будаг бүхий урлагийн ертөнц мөн, даруй шүлэг дуу дахь үзэл сэтгэлгээний ор мөр, мөр сүүдэр ба мэдээлэл болно. Байгаллаг үзэл хийгээд ахуйч үзлийн шүлэг дуунд бусдач бодит оршихуй нь урлагийн ертөнцтэй тэнцүү буюу бага байж, урлагийн ертөнц нь бусдач бодит оршихуйтай тэнцүү буюу арай их байдаг. Учир нь урлагийн ертөнцөд шүлэгчийн биеч элемент

⁶³ 贺孝恩: 《艾青「诗论」美学思想研究》, 西南大学硕士学位论文, 2010年, 第11页。

⁶⁴ 陈萱: 《艾青与惠特曼诗歌比较研究》, 西安外国语大学硕士学位论文, 2013年, 第31页。

⁶⁵ 李忍: 《「朦胧诗论争」中的代际裂痕问题研究》, 湖南科技大学硕士学位论文, 2011年, 第32页。

⁶⁶ 叶槽: 《诗歌艺术宝藏的发现与开掘》, 《扬州师院学报》, 1995年第3期, 第30页。



агуулагддаг⁶⁷. Нулмасарангийн шүлгийн биеч шинж нь нэн чанга байдаг. Биеч уянгалал нь бусдач дүр үзэмжээ шүүрэн авч хэлний удирдамж доор санааны аяар тэврэн халхалдаг байна. Иймээс Нулмасарангийн шүлэгт үзэмж, дүрийн төсөөлөл туйлын баялаг байдаг ч нягтрал их, үсрэлт түргэн, солигдол хурднаас болоод хүний сэтгэлд зориг болж үлдэх нь тоотой. Мөн чанарыг нь үзвэл түүний шүлэг бол сонорын сэрэлд үйлчилдэг уншлагын шүлэг, уянгалаг шинж, айзамлаг шинжээр товойж бүрэн бүтэн урлагийн ахуй цогцлоохыг төдий л анхаардаггүй. Хэлний бардамнал ба уянгаллын томсгол нь түүний нэн их амжилтад харшилсан байна. Нулмасарангийн шүлэгт уянгалахуй үзлийн дутагдал тод илэрчээ⁶⁸. Нулмасаран бол улс төрчийн гэгдэх сэтгэлгээтэй шүлэгч юм. Шүлэгч маань монгол шүлгийн талбарт өөрийн содон бүтээлээ нэмэрлэж, шүлгийн өвөрмөц хэв маягаараа олноор ялгарч байв. Тэр өөрийн шүлгээ ард олны дуу хоолой болгохыг зорьдог болохоор ихэнхдээ бүр том сэдвийг сонгож, цаг эриний зориг санааг тусган, нийгэм нийтийн хувь заяа, ард олны бодлын үгийг зоригтой хэлдгээрээ бусдаас ялгарч, өөрийн сүрлэг урлагийн хэв маягаа тодруулсан байдаг. Түүний омголон ааш, уярам сэтгэлгээ, багтаамжтай гүн санаа, дүрслэг чанартай шүлэг нь уншигчдын оюуны шим тэжээл болж байна.

ABSTRACT

Ai Qing is the leader and great poet of China's new poets, and is known as "the leader in the poetic world". Nulmasarang's poems are bold and heroic, full of sincerity, and inspire people's spirit with the spirit of the times. The poet has contributed his masterpiece to the Mongolian poetic world and marches to the beat of a different drum. The two poets made the same exploration on the creation of images of sun, moon, light and leaves; the depiction of mother and earth and the call of the times.

Keywords: *Mongolian literature; translated literature; the importance of historical research; research*

⁶⁷ 满全著：《碎片与体系》，远方出版社，2018年，第204页。

⁶⁸ Хайрхан: “Монгол шүлгийн эдүгээч хувьсалын судлал”, ӨМАХХ 2014, т 166.



**ШИНЭ ЗУУНЫ МОНГОЛ УЛСЫН РОМАНД ТУСГАГДСАН ДАЛД
МЭДРЭХҮЙН ШИНЖИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ**

*Г.АЮУРЗАНЫН “БӨӨГИЙН ДОМОГ”, “ЦАГААН ХАР УЛААН”, “АРВАН ЗҮҮДНИЙ ӨР” ГУРВАН
РОМАНААР ЖИШЭЭЛЭХ НЬ*

Хасхүү *

ХУРААНГУЙ

Монгол улсад өнгөрсөн зууны 90-ээд оноос эхлэн улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын өргөн хүрээнд шинэ өөрчлөлт гарч, үзэл ухамсрын чухал илрэл болсон уран зохиол ч энэхүү өөрчлөлтийн нөлөөг хүртэн шинэлэг санаа бүхий бүтээлүүд зулай зулайгаа гишгэн буй болжээ. Үүнд төлөөлөх чанартай зохиол бүтээл, зохиолчийг дурдвал юун түрүүнд залуу зохиолч, орчуулагч, яруу найрагч Гүн овогт Аюурзана жич түүний зохиол бүтээл байж таарна. Аюурзанын үргэлжилсэн үгийн зохиол нийгэм, улс төрийн хувирлаас болсон хүмүүсийн оюун санаа, сэтгэлгээний хувирлыг тусган харуулахаар дамжуулж, нийгэм, соёл, хүний гурвалсан харьцаа жич энэхүү харьцааг буй болгож байгаа далдын шинжийг илтгэн гаргасан байна. Тус өгүүлэлд энэхүү далдын шинжийг гурван хэсэгт хуваан задлах болно.

Түлхүүр үгс: Далдын хүч, хамтлагийн ухамсаргүй, Г.Аюурзана

Хүн төрөлхтний нийгэм шинэ зуунд дэвшин ороод хорин жил болжээ. Энэхүү хорин жилийг уран зохиол олон талаас нь тусган харуулж, нийгэм, хүн, урлаг соёлын уялдаа хөгжлийг түлхэн ахиулж байна. Монгол улсын шинэ уран зохиол нь мөн шинэ зууны 20 жилийн учрал тохиолдол, хөгжил хувирлыг тусган харуулж, шинэ үеийн залуу зохиолчид уран бүтээлийн тавцанд ур ухаанаа сойж байхын нэг нь Гүн овогт Аюурзана болно. Монгол улс өнгөрсөн зууны 90-ээд оноос эхлэн зах зээлийн эдийн засагт шилжиж, нийгмийн өргөн хүрээнд хувирал өөрчлөлт буй болсны нэг нь уран зохиол урлаг соёлын хүрээн дэх хувиралт байв. Монголын орчин үеийн уран зохиол нь өнгөрсөн зууны

* Доктор, ӨМИС-ийн Монгол улсыг судлах хүрээлэнгийн лектор.
Phone: 15910634424, EMail: hasihu112233@163.com



60-аад оны шижир алтан үеийг өнгөрөөн 90-ээд оны урлаг, утга сэдэв чөлөөтэй болсон эрин цагийг угтан авч ирж, үүнийхээ суурь дээр шинэ зууны шинэ ухамсар, сэтгэгдэл бүхий бүтээл урлаг соёлын тавцанд нэлээд олон буй болжээ. “90-ээд оноос хойш ямар нэгэн үзэл сурталгүй цэвэр уран зохиолын төлөө гэж хэлж ярьцгаах болсон ба энэ замналаар утга зохиолыг хөгжүүлэхийг хэн хүнгүй оролдох болсон. Үүнээс өмнөх үеийг нийтэд нь намын үзэл сурталд хамруулан харлуулах үйл ажиллагаа ч идэвхтэй явж байна”.⁶⁹ Ямар нэгэн үзэл сурталгүй, цэвэр уран зохиолын төлөө зохион бүтээх болсон нь шинэ зууны монгол уран зохиолд урлаг, уран сайхныг уг хэв янзаар нь илэрхийлэх боломжийг буй болгож өгчээ.

Урлаг, уран сайхныг тэр янзаар нь илэрхийлэхэд зохиогчийн сэтгэц, зохиогчийн үндэстний хамтлагийн ухамсаргүй гэх зэргийн элемент чухал нөлөө үзүүлэхтэй зэрэгцэн, хүн зүй, нийгэм зүй болон уран зохиолын хоорондох харьцаа холбоо дам байдлаар тусгагдаж байна. Аюурзана шинэ үеийн сэхээтний хандлагаар зах зээлийн эдийн засагт шилжсэн монгол улсын нийгэм, хүн зоны оюун сэтгэлгээний хувирал өөрчлөлтийг тунгаан харж, хувирал ихтэй орчинд хэрхэн өөрийн уламжлалаа залгамжлан шинэ хувиралттай зохицуулахыг бодолхийлж зохиол бүтээлээ туурвиж байв.

Нэг. Соёл, үзэл ухамсрын хувирлаас шинэ үеийн ухамсрыг хайх нь

Уран зохиол нь хүн, нийгмийн тусгал байдгийн учир хүний амьдрал, нийгэм хоёртой салшгүй харьцаа холбоотой юм. “Уран зохиол үнэндээ нийгмийн ар үзэгдэл, нийгмийн хувьсгал болон хөгжил зэрэг талын элементээр тогтоогдох буюу эдгээрт түшиглэнэ. Уран зохиол ямар ч байсан зохиогчийн нийгэм, зохиол бүтээл тус биеийн нийгмийн агуулга хийгээд уран зохиолоос нийгэмд өгөх нөлөө гэх гурван зүйлээс салж чадахгүй”⁷⁰. Уран зохиол болон нийгэм, зохиогчийн хоорондын нягт харилцааг судлаачид улам гүнзгийрүүлэн нарийвчлан судалсаар ирэв. ХХ зууны дунд, сүүл үеэр буй болсон “уран зохиол хүн зүй” хэмээх шинэ ухагдахуун нь чухам ийм судалгааны үр бүтээл болж байна. Уран

⁶⁹ Э.Батжавхлан нар. “ХХ зууны монголын уран зохиол”, УБ., 2017 т 484

⁷⁰ (美) 勒内韦勒克, 奥斯汀沃伦著, 刘象愚, 邢培明, 陈圣生, 李哲明译 文学理论[M], 浙江人民出版社, 2017年2月, 85页, 111页 (载《文学于精神史德文季刊》, 第2期, 1933年, 497页)。



зохиол шүүмжлэгчдийн уран зохиол хүн зүй судлалын гол илрэл нь домог болон ёслолын хэлбэрээр суурь судалгаа болгосон уран зохиол судлалын “уг төрөхийн шүүмжлэхүй Archetypal Criticism”-ийн бүлэг болно. Канадын алдарт уран зохиол шүүмжлэгч Фрэй (Northrop Frye) утга урлагийн ухааны хүрээнд анх удаа уран зохиол хүн зүйн судлал хэмээх ухагдахууныг дурдан гаргасан хүн болохын хувьд шүүмжлэлийн шинжлэх ухаанч чанартай болох эсэх нь соёлын үзэгдлийн дотоод бүтцийн дүрэмжсэн ойлголтын түвшнээр тогтоогдоно хэмээн өгүүлжээ. “Өнгөрсөн үеийн уран зохиолын онолд уран зохиолын стилль/*төрөл, хэлбэр*/-ийн хуваариар гол судалгаа болгож, уран зохиолын дотоод бүтцийн тухай ойлгогдохуун дутмаг, ганц нэг бүтээл болон уран зохиолын бүхэл цогцын харьцааг олтгойлж/*мөчид хуумгай хандах*/ байжээ. Эдгээр нь *уг төрөхийн шүүмжлэхүйн* бүлгийн залруулах хэрэгтэй зүйл болж байв”⁷¹. Үүнээс уран зохиолын дотоод бүтэц, нэн ялангуяа зохиол бүтээлд тусгагдаж байгаа соёлын үзэгдэл нь тухайн бүтээлийг задлан шинжлэх, зохиолчийн дотоод сэтгэлгээ, зохиолын далд санааг хайхад чухал нөлөө үзүүлж байгааг мэдэж болно.

XX зууны 90-ээд оны монголын нийгмийн хувьсгал нь улс төр нийгмийн том хувирал өөрчлөлтөөсөө соёлын хувирал хөгжил болж улирсан байдаг. Төлөвлөгөөт аж ахуйгаар суурь болгосон аж ахуйн бүтэц дэглэм нь энэхүү хэлбэртээ тохирсон нийгэм соёлын системийг буй болгож байсан бол зах зээлийн эдийн засагт суурилсан нийгэм соёлын орчин нь бүх зүйлийг нээлттэй болгон, хүний үзэл ухамсар ч өрнийн өргөн хүрээнд шинэ хачин зүйлийг хүлээн авч суралцах болсон байна. Шинэ зуунд гарсан үргэлжилсэн үгийн зохиол нь яг ийм нийгэм түүхийн хувирлын нөлөөнд буй болж, уламжлалт соёлыг хайн эрэлхийлэх, уламжлалт залгамжлалын зориг санаа бүхий агуулгатай болжээ. Соёлын хувирал өөрчлөлтийн цаг үеийн монголын уран зохиолыг судлан шинжлэхэд уран зохиол хүн зүйн судлалын аргыг ашиглаж, уран зохиол, урлаг, хүний хоорондох гурамсан харьцааны хувирал хөгжлийг хайж илэрхийлэх хэрэгтэй. “1990-ээд оны хүүрнэл зохиолын гол онцлог нь сэдэв чөлөөтэй болсонтой шууд холбоотойгоор түүх, нийгэм, хүний тухай амьдралын олон талт асуудлыг бүхлээр нь дүрслэх боломжтой

⁷¹叶舒宪, 文学与人类学[M], 陕西师范大学出版社, 2018年3月, 73页。



болсонд оршино”⁷². Аюурзанын үргэлжилсэн үгийн зохиолын сэдэв нь чөлөөт, шинэ зуун, шинэ цаг үед монголчууд ямар болоод байгаа, ямар байх ёстой, юуг сурч мэдэх хэрэгтэй гэх зэрэг агуулгыг домог үнэн хоёрын уусалцлын дунд илэрхийлэн гаргажээ.

“Цагаан хар улаан” романд зохиолын баатар Рэнцэнраа ямар нэгэн далдын хүчинд хөтлөгдөн дээдийн нутагтаа хүрч уул зурахаар алс хол Алтай нутагт хүрэх явцад буй болсон үлгэр/*түүх, жишээ*/ үйл явдал, “би”-д тохиолдсон учрал ба бодогдож төрөгдсөн зүйлийг домог үнэнд уусалцуулан илтгэн гаргажээ. “Бөөгийн домог” хэмээх романд зохиолын гол баатар Тэнгисийн Туулайт аралд амьдарч байхдаа Хагдай хэмээх нэгэн бөөтэй таарч, тэр бөөгийн нэг насны хачин сонирхолт амьдралынх нь тухай үзэж сонссон зүйлийг Тэнгисийн бодол сэтгэгдэлтэй уялдуулан бичиж, монголчууд бөө мөргөлийн далд хүчинд итгэн, хүнд үзэгдэшгүй далдын хүчээр оршин тогтнож байдгийн учир сүсэг бишрэлтэй амьдрах ёстой, түүх соёл уламжлалаа хадгалан хөгжүүлэх хэрэгтэй гэх мэт санааг илэрхийлжээ. Энэ нь хүний амьдрал, нийгмийн хувирал өөрчлөлт нь хүний санаагаар болдог биш, ертөнцийн жам, амьдралын ёс хүний амьдралд чухал нөлөө үзүүлж байхыг дам байдлаар харуулсан байдаг.

Мөн тус хоёр романд бодит амьдрал болон домог туульд гарсан үлгэрийг харилцан солбицуулан оруулахдаа соёлын хувирал, нийгэм түүхийн хувирлын явц дунд монголчууд өөрийн язгуур соёл, тууль хайлах ёс заншил, язгуур мөргөл болох бөө мөргөлийн ёс заншлыг уламжлан, бөөгийн ил байдаг чадалд итгэх, хүний далд чадавхийг өргөнөөр нээхийг хүссэн хүслээ илтгэн гаргажээ. “Бөөгийн домог” романд бичигдсэн зарим агуулгаар жишээлэн өгүүлбэл, “Туниг бол хүний хамгийн эрхэм чанар. Бид өөрсдөөсөө болоод ч гуныдаг юм биш. Бид бол хаа нэгтээ хэрээ, дорго, нохойн, хүний биеийн хэвд цутгагдсан дүрс төдий амьтад. Бидэнд хэрээ мэт, нохой мэт харагдаж буй эд бол ихэнх тохиолдолд далд ертөнцийн элч байдаг юм. ... Хүн бол ертөнцийн төв бус, ертөнцийн төвд ургаж буй модны ердийн нэг залтас/*модны хагадас*/ нь. Үүнийгээ далдхан мэдрэхэд бидний сэтгэлд гуниг төрдөг”⁷³. Тус жишээнд хүн гэж хэчнээн өчүүхэн байдгийг, мөн байгаль дэлхий,

⁷² Э.Батжавхлан нар. “XX зууны монголын уран зохиол”, УБ., 2017 т 484

⁷³ “Бөөгийн домог”, ӨМШУТМХХ, (Г.Аюурзана зохиов, Б.Очирбань буулгав) т 123



нийгмийн том хувьсгалын өмнө хэчнээн арчаагүй байдгийг, өөрөө өөртөө эзэн болж чадахгүй “хүн”-ий амьдралыг дэлгэн харуулж байна. Энэ нь нэг талаараа хүний биеч/*объект*/ чадамгай чанарыг омтгойлж байгаа ч нөгөө талаар нийгмийн хувирал өөрчлөлтийн өмнө хүн ямар ч эсэргүүцэх чадал байдаггүй учир өөрийн хийх ёстой зүйлээ хийх нь чухал гэдгийг дам байдлаар илтгэн гаргаж байгаа нь өнгөрсөн зууны 90-ээд онд монголын уран зохиол нь сэдэв чөлөөтэй болсонтой шууд холбоотой юм.

Зах зээлийн эдийн засагт суурилсан монголын нийгэм, эдийн засаг нь хүний хөгжил, соёлын хувиралд сайн муу үр нөлөөг авч ирсэн гэдгийг бид “Бөөгийн домог” романаас харж болно. Зах зээлийн аж ахуйд суурилсан нийгмийн амьдрал, хүний хөгжил нь ямар нэгэн тогтсон үзэл санааны удирдлагаар биш, харин чөлөөт үзэл санаа, чөлөөт сэтгэлгээнд тулгуурлан хөгжих болов. “Дэлхий дээрх анхны бөө Бухули Хар – зайран монгол хүн байсан тухай ч мэднэ. Хаа нэг газраас залсан ч юм уу, өөрөө бичсэн ч юм уу, Бухули Хар бөөгийн судартай байсан гэдэг. Онгод тэнгэрүүд өөрсдийг нь ном журамд хашиж чадах нь гэж унтууцаад Эсгий Малган тэнгэрийн илгээсэн хонь өнөөх судрыг нь идэж хорлосон юм гэнэ. Бас тэнгэр судрыг ниргэж шатаасан, хонь үнсийг нь л идсэн ч гэх нь буй. Бөөгийн судрыг идсэн учраас хонины дал мэргэн байдаг гэж эцэг минь ярьсан сан. Одоо ч энэ бүгд үлгэр домог төдийхнөөр дурсагдаад л элэрч баларч дуусах нь дээ”⁷⁴.

Зах зээлийн эдийн засгийн хөгжил соёлын хөгжилд шууд нөлөөлөн, бөөгийн судар мэтийн зүйлийг үлгэр домог мэтээр ойлгох болж, хүмүүс цаг төр, нийгмийн их хувирлын дунд уламжилж залгамжлах ёстой зүйлээ алгуур умартах болсон хандлагыг тус жишээ тод харуулж байна. “Онгодын хэл бол ихэнхдээ дохио тэмдэг, бэлгэдлийн дом байдаг гэж би чамд ярьсан даа. Буриад аялгуу тэдгээр дохиог хөрвүүлж яг таг дамжуулах чадамжаа өдөр ирэх тутам л алдсаар байна”⁷⁵ хэмээн Аюурзана шинэ зуунд орсны дараах нийгэм түүхийн хөгжилд монголчууд язгуурын соёлоо хэрхэн алдах тийш хандаж байгааг илэрхийлэн гаргажээ. “Зуны адаг сүүн сар гарахын өмнөх битүүний

⁷⁴ “Бөөгийн домог”, ӨМШУТМХХ, (Г.Аюурзана зохиов, Б.Очирбань буулгав) т 122

⁷⁵ “Бөөгийн домог”, ӨМШУТМХХ, (Г.Аюурзана зохиов, Б.Очирбань буулгав) т 235



шөнө Хагдай бөө дарх тахих ёслол үйлдэн багахан шиг нүүрс зэхэж, жаахан төмөр улайтган давтаж суугаад төлөг үзжээ. Энэ бол Чингис хааны дээд язгуурынхан эрт цагт хашигдмал газраас уул хөөрөгдөн хайлуулж гарсныг тэмдэглэж буй, эдүгээ зөвхөн дархан угтай бөө нар л авч үлдсэн ёстой юм. Төлөг үзэхийн өмнө далны яснаа төөрөг зурж суугаа онгодуудыг баясган үлгэр домог ярьдаг номтой”⁷⁶.

“ – Танаас хойш буриад бөө таны бодсон шиг хэмжээнд үлдэх болов уу? та яг юу гэж төсөөлдөг вэ? – бөөгүй цаг үе гэж хүн төрөлхтөнд байгаагүй юм, хэзээд тийм чигээрээ л үлдэнэ. Ирээдүйн бөө нар хэнгэрэг барихгүй, тамлага/бөөгийн онгодын магтаал, дуудлага/ хэлэхгүй, мөөгний дэрсээр утгахгүй байж болно л доо. Гэхдээ ч тэд шидэт үг амилуулах, тэнгэрт нисэх, бусад ертөнцөд нэвтрэх, хүн төрөлхтнийг юухан хээхнээс аврах чадвараа онгодоос л олж авах болно”.⁷⁷ Дээрх хоёр жишээнд зохиогчоос онгод шүтээн хэмээх байдаг мөртөө аль ч цаг үед байдаг хэмээн бөө мөргөл, онгодын хүч чадлыг ихэсгэн үзжээ. Сэдвийн чөлөөллөөс соёлын хувирал хөгжил зүг шилжсэн монголын уран зохиолын хөгжлийн эхний шат ийнхүү шинэ зууны 20 жилд буй болжээ. Үзэл санааны түшиг байхгүй, өрнийн үзэл санааны нөлөөнд бодит байдал, аж ахуй сууриндаа үндэслэсэн үзэл санаа, соёлын хандлагыг буй болгож чадаагүй байсан цаг үед монголчуудын үзэл санаа аж ахуйн хөгжилтэй зохицож чадаагүй.

Шинэ зууны 20-оод жилийн үзэл ухамсрын их өөрчлөлтөд уугал соёлын ойлголт аажмаар багасаж, өрнийн үзэл санаа, соёл аажим газар аван монголчуудын дотоод сэтгэлийн тогтуун байдал эвдэгдсэн нь мэдээжийн хэрэг юм. Яг ийм байдлыг Аюурзанын “Арван зүүдний өр” роман тусган харуулжээ. “Хүн жаргах албагүй ч байж магадгүй шүү дээ. Жаргана, зовно гэдэг хэтэрхий хялбархан ойлголт. Дур зоргоороо байх боломжгүй, зугаацах цаг завгүй, үрж цацах мөнгөгүй хүн цэнгэлийг амсдаггүй. Үүнээс зовлон үүсдэг. Гэвч цэнгэлийг амслаа гээд аз жаргалд хүрэхгүй. Хамгийн гол зүйл бол амар амгалан юм”⁷⁸ хэмээн жаргал

⁷⁶ “Бөөгийн домог”, ӨМШУТМХХ, (Г.Аюурзана зохиов, Б.Очирбань буулгав) т 181

⁷⁷ “Бөөгийн домог”, ӨМШУТМХХ, (Г.Аюурзана зохиов, Б.Очирбань буулгав) т 235

⁷⁸ Г.Аюурзана. “Гурамсан цадиг”, УБ., 2010 т 279



цэнгэл гэж ямар байх, жаргал зовлон хоёр ямар үед буй болдгийг ээдрээт будлиант сэтгэлгээнд хандуулан тайлбарлан өгч байна.

Мөн жаргал зовлон хэмээх эсрэг тэсрэг хоёр зүйлийн дунд оршигч хүний амьдралын хэвийн зүйл болох амар амгалан хамгаас чухал байдгийг, амар амгаланг хөөцөлдөж, тайван тогтуун амьдрахыг чухалчлан ярьж буй. Энэ нь нийгэм, үзэл ухамсрын хувирал ихтэй шинэ зууны монголчуудын дотоод сэтгэлгээнд тохируулан ярьсан зүйл хэмээн ойлгож болно. “ – Яагаад х-х-х абугай шиг хүмүүсийн хувьд бүх зүйл хялбархан болж бүтээд байдаг юм бол? – Яагаад гэвэл амьдрал гэж зүүдний бие юм. – Яагаад Ингаа ор сураггүй алга болчихов? – Яагаад гэвэл, амьдрал гэдэг зүүдний мэт хоосон бүхний эх бие юм. – Яагаад би түүнийг мартчихав? – Яагаад гэвэл, амьдрал гэдэг ердөө л зүүдний эх бие юм. Яагаад Бурмаа ...? Амьдрал гэдэг ердөө л зүүдний биежсэн зүүд болоод тэр гэж үү? Яагаад би ийм л замаар явах ёстой юм бэ? Яагаад гэвэл, амьдрал гэдэг угтаа зүүдний л эх бие юм. Өөр ямар ч хариулт үүнд тэнцэнэ. ...Амьдрал угаасаа л үргэлжийн мөнхөд сайн сайхнаараа байгаа болоод тэр. Жинхэнэ жам ёсоороо байгаа болоод тэр”⁷⁹. Амьдрал дундах хэцүү бүхэн, сэтгэл санааны даралт дарамт бүхэн зүүдтэй холбоотой. Амьдрал зүүдний бие, амьдралыг зүүдэлсэн ч тэр үгүй ч тэр, тэр л ёсоороо үргэлжлэн оршино. Үүнийг мөн амьдрал гэж үргэлжлэлийн чанартай байдгийн учир санаа сэтгэлээ тайван тогтуун байлгахыг хичээн амьдрах нь хамгийн эрхэм хэмээн ойлгож болохоор байна.

Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараах 20-оод жилийн монголын соёлын хувирал нь үзэл ухамсартайгаа нягт харьцаатай байж, шинэ зуунд соёлын хувиралд суурилсан уламжлалт соёл сэтгэлгээг чухалчилсан зохиол бүтээл олон илэрсний нэг нь Аюурзанын романууд байв. Эдгээр роман шинэ зуунд монголчууд язгуур соёлоо уламжлан залгамжилж, нийгэм түүхийн хувирлаас болсон ээдрээт будлиант үзэл бодлоо өөрчлөн, бодит ахуйдаа суурилж, оюуны далд чадавхаа гүйцэд бадруулахыг уриалжээ. Зохиолч Аюурзана шинэ зуун, шинэ үед монголчуудын үзэл санаа, ухамсар, соёлд оршиж байх асуудлыг гүйцэд танин зоригтойгоор уран зохиолдоо тусган, монголчуудаа шинэ зуунд омог бардам хөгжихийг хүссэн санаа тод харагдана. Аюурзанын

⁷⁹ Г.Аюурзана. “Гурамсан цадиг”, УБ., 2010 т 282



романууд нь мөн домог бодит ахуй хоёрын уялдаанаас хүний үзэл ухамсрын хувирлыг тусган харуулсан байна.

Хоёр. Домог, бодит ахуй хоёрын солбицлоос үзэл ухамсрын хувирлыг шинжих нь

“Уран зохиол нь эртний домгоос үүсэлтэй, домог нь мөн шашны ёслолтой харилцан нөхцөлдөж оршдог. Иймээс домог болон ёслол нь уран зохиолын бүтцийн хэлбэрийг буй болгох үндэс суурь нь байж, домог зүй болон харьцуулсан шашны ухаан уг төрхийн хэлбэрийг нотлон, уран зохиол хүн зүйн системийн суурь давхаргыг бүрэлдүүлнэ”⁸⁰. Домгийн системийн чухал үүргийг гүнзгийрүүлэн шинжилбэл “ямар нэгэн тогтсон нийгэмд үндэслэсэн домгийн систем нь тухайн нийгмийн гишүүдэд нийтэд нь байдаг хүсэл бодол болон хэл ярианы туршлагын хөрөнгийг тэр даруй хадгалан үлдээдгээс домгийн систем нэг зүйлийн соёлын түүхийг бүтээхэд хавсрамж болно”⁸¹. Домгийн систем нь соёлын түүхийг бүтээхэд хавсрамж болохын хамт “домгийн систем нь эрт үеийн шидэт чанараасаа болж нийгмийн ухамсарт хадгалагдаж байдаг.

Домог нь цаг үе болгоны уран зохиолд тусгагдаж байдгаас уг төрхөд судалгааны хандлагаа тавьсан хүн зүйн ухааны шүүмжлэл нь цагийн хүрээг давсан үнэ цэнэтэй болж, уран зохиолыг ажиглаж тайлбарлах нэг зүйлийн урт хугацааны арга хэлбэр болсон байна⁸². Уран зохиолыг домог зүйн үүднээс тайлбарлан шинжлэх нь соёлын үнэ цэнэ, нийгэм ахуй, хүний амьдрал зэрэг уран зохиолд хамрагдсан олон зүйлийг нийгмийн ухамсартай холбон задлах боломжийг буй болгодог. Домогт хадгалагдсан соёлын түүхийг уран зохиолоос олж хардаг нь домгийн чухал шинж, мөн зохиолчийн гярхай харц, гарамгай оюун ухаан чухал нөлөө үзүүлж болно.

Аюурзанын “Бөөгийн домог”, “Цагаан хар улаан” гэх хоёр роман нь домог, бодит ахуй хоёрын харилцан уялдаа, бөө мөргөл, шашны ёслол хийгээд бодит ахуй, бодит амьдралын солбицол дунд бичигджээ хэмээн дээр өгүүлсэн билээ. Зохиолын гол баатар Рэнцэнраагийн хар багадаа сонсож байсан элэнцийнх нь тухай домог яриа, Алтайн арван гурван

⁸⁰叶舒宪, 探索非理性的世界: 原型批评的理论与方法[M], 四川人民出版社, 1988年, 第124页。

⁸¹叶舒宪编选, 《神话 原型批评》, 陕西师范大学出版社, 1987年, 第391页。

⁸²叶舒宪, 文学与人类学[M], 陕西师范大学出版社, 2018年3月, 73页。



овооны үүслийн домог, Дарь эхийн домог, Тэнгисийн бөөгийн шидэт орчинд хүрч, ид шидийн хүчний аугаа ихийг биеэрээ мэдэрсэн түүх зэргийг ажиглавал зохиолын өнгө аясыг домоглог шинжтэй болгосон боловч үнэндээ эдгээр домог нь нүүдэлчин монголчуудын соёлыг хадгалж, харахад энгийн домог шиг байгаа ч цаанаа Алтайн арван гурван овооны босгогдсон түүхэн ахуй, Дарь эхийн Рэнцэнраад үзэгдэх дүр зургаас эрдэм ухаан, амьдралын сайн сайхныг ажигч мэргэн билгийг дам илтгэн хүний амьдрал шүтээн хэмээх оюун санааны далдын зүйлийг дээдлэн үзэх хэрэгтэй байдаг ёсыг сэтгэл мэдрэмжээрээ домогтой холбон илэрхийлэн үзүүлжээ.

Тус хоёр романы домогт хадгалагдан байх соёл, соёлын уламжлал түүхийг бодит амьдралд уусалцуулан оруулсан нь алдагдаж байгаа соёлоо ойлгож, хамгаалан хөгжүүлэхийг хүссэн санаа ил тод харагдаж байна. Алтайн арван гурван овооны домгоор жишээлбэл, овоо босгох үйл явц, овооны ерөөл тахилга зэрэг зүйлээс эхлээд овооны тухай цээр ёсыг бичжээ. Энэ нь зохиолд овоонд холбогдох зүйлийг шууд бичихээс зайлсхийн, домгийн өнгө аястай болгож, зохиолоо шидлэг шинж чанартай болгон, уншигчдад соёл түүхээ ойлгон мэдэхийн чухал чанарыг ойлгуулж чаджээ.

Зах зээлийн эдийн засгийн том орчинд амьдрахын төлөө, онгод булш ухаж, музейд байх ховор үнэт эдлэлээ арилжаалж байх хүмүүс “Цагаан хар улаан” романд ч гардаг. “Рэнцэнраа минь дээ, хүн болгон л ямар нэг зүйл тонож цааш нь арилжиж байгаа шүү дээ, өнөөдөр. Чам шиг зотонгоо татаад л дээр нь будаг түрхээд л сайхан амьдрах аргаа олчихсон хүн тийм ч олон биш. ...Барагдахгүй зүйл гэж байхгүй ээ. Чи одоо Орхоны хөндийн булш хиргисүүр, Хархорин руу очоод нарийн ажиглаад үзээрэй. Миний багажийг бариад явсан ч болно. Тэнд бол ямар ч сайн багаж амьгүй шиг байх буй. Нэгжээд дуусгасан болоод тэр. ...”⁸³. Зах зээлийн эдийн засагт шилжсэн он жилүүдэд элдвийн аргаар ашиг хонжоо олох гэж зүтгэх хүн олон болсон байна. Эдгээр завшигч хүмүүст өөрийн уламжлалт соёл, язгуур ёс заншил ард нь хаягдсан гэдгийг бид энэ жишээнээс тодхон харна. “Магадгүй, чухам тийм л өөрийн гэсэн орчинтой болохын төлөө амьд яваа мэт, нэг их хүч хөлс дуслуулаагүй

⁸³ Г.Аюурзана. “Цагаан хар улаан”, УБ., 2014 т 67



зурсан зургууд нь санаанаас ч илүү үнээр энд тэнд зарагдаж, нэг л мэдэхнээ чимээгүй хөрөнгө цуглуулчихсан нь ердөө хязгааргүй их далайн дундаас ийм нэг арал олж эзэмших боломж бүрэлдүүлэхийн тулд л байсан юм шиг гэнэт санагдаад явчихжээ”⁸⁴. Рэнцэнраагийн уул зурахаар явж байгааг зохиолд дүрслэн тоочихдоо түүний зургаа худалдаж их мөнгө олж, америкт арал авах гэж байгаа тухай ургуулан бичиж, Рэнцэнраагаар нэг их хүч хөлс урсгасангүйгээр нэлээд мөнгө төгрөг олсныг яриулсан нь зах зээлийн эдийн засагт шилжсэн жилүүдэд хүмүүсийн их мөнгийг хялбар олж, тэр хол арал авахын мөрөөдөлтэй болсон, боломжгүй “мөрөөдөл”-ийг илтгэж байна.

“Жороо адууны тухай яриан дунд ч хэзээний ам нь халчихсан, үхэр жороолбол муу ёр гээд даруй хүнсэнд хэрэглэдэг ёс байсан тухай хуучилж эхэлсэн өвгөн хөтөлж яваа морьд руугаа дахин нэг удаа хөөрүү ширтсэнээ, - намайг хил гаргаад өг гэсэн юм. Ачааны тэргээр Баянголд аваачих юм гэнэ. ...”⁸⁵ “Тэр урлаг гэдэг чинь юу юм бэ? цаана чинь тэр урлагийн өвийг хадгалж хамгаалах үүрэгтэй хүмүүс нь өөрсдөө музейнхээ үзмэрийг хулгайлаад зарж байхад чинь ...”⁸⁶ монгол соёлоо тээж байгаа жороо морио худалдаж байгаа дүр зураг, түүх соёлын төлөөлөл болсон музейд байгаа эд агуурсаа мөнгө зоосны төлөө худалдаж байгаа дүр зураг нь соёлоороо мөнгө сольж байгаа шинэ цаг үеийн хүмүүсийн муухай бодлыг харуулж байна. Иймэрхүү түүх соёлоо умартаж байгаа байдалд чиглүүлэн зохиогч соёлоо хамгаалан хөгжүүлэхийг уриалах санаагаа илтгэн гаргажээ.

Хүн төрөлхтний оюун сэтгэлгээ нь уламжлал, шинэчлэл, хувьсан өөрчлөгдөх жам ёсны дагуу ерөнхийдөө домгийн, шашны, шинжлэх ухаанч сэтгэлгээ гэсэн үе шатыг дамжин хөгждөг байна. Ингэхдээ домгийн сэтгэлгээ нь хүн төрөлхтний мөн чанар, үнэт зүйл болон шашны ба шинжлэх ухаанч сэтгэлгээнд тодорхой байр сууриа илтгэдэг байна.

“Домгийн сэтгэлгээ нь орчлон ертөнцийн аливаа юмс үзэгдлийн үүсэл гарвал, учир зүй, мөн чанарыг танин мэдэж тодорхой хүрээнд тайлбарлах гэснээрээ шинжлэх ухаанч сэтгэлгээний шинж чанартай,

⁸⁴ Г.Аюурзана. “Цагаан хар улаан”, УБ., 2014 т 41

⁸⁵ Г.Аюурзана. “Цагаан хар улаан”, УБ., 2014 т 120

⁸⁶ Г.Аюурзана. “Цагаан хар улаан”, УБ., 2014 т 67



түүнийгээ уран сэтгэмжээр ургуулан бодож хийсвэр ойлголтыг тодорхой уран дүрээр илэрхийлснээрээ урлагийн шинжтэй, овгийн байгууллын үеийн хамт олны нийтлэг ухамсар, ертөнцийг үзэх үзлийг тусган илэрхийлж байснаараа онцлог байдаг”⁸⁷. Овгийн байгууллын үеийн хамт олны нийтлэг ухамсар, ертөнцийг үзэх үзлийг тусган илэрхийлдэг домгийн сэтгэлгээ нь Аюурзанын хэдэн романд онцлогдож, домог бодит ертөнцийн харилцан уусалцал нь зохиолын шинэ сэвүүн/*сонин*/ чанарыг нэмэгдүүлжээ. “2000-аад оны уран зохиолын ерөнхий чиг хандлага нь бичгийн ба аман зохиолын уламжлалаас бүтээлчээр суралцан дорнын уламжлалт гүн ухааны үндэс ба өрнө дахины орчин цагийн сэтгэлгээг хослуулан реалист ба реалист бус аргаар илэрхийлж байна”⁸⁸. Аюурзанын дээрх хэдэн роман нь яг ийм чиг хандлагын төлөөлөл болж байдаг.

Ид шидийн байдаг тууль Жангар нь туульч хүнд далдын хүч ухааныг хайрладаг. Тууль хайлагч өвгөн “тууль гэдэг угаасаа л онго тэнгэрийн үг. Яг юу хайлж байгаагаа жангарч хүн чихээрээ сонсдоггүй ч байж болно. Цаанаасаа ундраад гарч буй үгсийг л дамжуулж суугаа нь тэр. Жангар бол зүгээр үлгэр огт биш. Заавал онгод хавсарч байж л сая жангар болно. Онгод орох гэдэг нь эчнээ хий ертөнцийг энэ бодит ертөнц рүү авч ирэх сүнсний шат л юм даа”⁸⁹ хэмээн туулийн чанад ёсыг туульч өвгөн онгод сахиустай холбон Рэнцэнраад тайлбарлан өгч байгаа нь туулийн агуулж буй соёлыг дам байдлаар уншигч бидэнд дамжуулан өгч байгаа санаа болно.

“Уулын оройд сэвэлзсэн сайхан салхи үүсэж, салхины аясаар тэр модон дотроос сонсогдож агсан тууль хайлах аяс сэтгэлд нь амилаад, Рэнцэнраагийн бүрзгэр дотор агшин төдийд цэлсхийн онгойжээ. Эргэн тойрон нам гүм болоод, тэртээ өмнө зүгт хязгааргүй их говь цэлийгээд нулимс мэт мэлтгэнэсэн зэрэглээнд умбана. Зэрэглээн дотроос тэнгэрт торойх уулсын нэгийнх нь оройд бас нэг ийм уран зөнч нааш ширтэн буй нь мэдрэгдэх ч шиг, тийм ээ, жинхэнэ гайхамшиг”⁹⁰ байгалийн гайхамшиг болон хүний бүтээсэн соёлын гайхамшиг тууль хоёр

⁸⁷ Э.Батжавхлан нар. “XX зууны монголын уран зохиол”, УБ., 2017 т 529

⁸⁸ Э.Батжавхлан нар. “XX зууны монголын уран зохиол”, УБ., 2017 т 530

⁸⁹ Г.Аюурзана. “Цагаан хар улаан”, УБ., 2014 т 99

⁹⁰ Г.Аюурзана. “Цагаан хар улаан”, УБ., 2014 т 65



Рэнцэнраагийн бүрзгэр ээдрээт дотоод сэтгэлийг нь тайван болгож, эх байгаль, хүний нийгэм хоёрын хамтын уялдаанд хүний аливаа бохир, муу сэтгэл санаа аяндаа цэлмэн тунгалаг болохыг Рэнцэнраагийн бодит амьдралаас төрөгдсөн бодлоор дүрслэн гаргажээ. Домог туулийн соёл түүх тээгч үйлдэл нь хүний үзэл санаа, оюун ухаанд шууд нөлөө үзүүлж, хамтлагийн ухамсаргүйгээр бүрэлдсэн домгийн үзэл санаа нь Аюурзанын зохиол бүтээлийн нэгэн чухал онцлог нь болж байна.

Гурав. Хамтлагийн ухамсаргүйгээс бүрэлдсэн шинэ үзэл санааг илэрхийлэх нь

“Уран зохиолын бүтээлийн буй болох нь ганц хувь хүний үүдэн бүтээлт биш, нэг шинэ шүлгийн буй болох нь аль эрт байсан үгсийн жагсаалтын шинэ хэлбэрийн дахин дэлгэлт болно. Шүлэг нь зөвхөн бусад шүлгийн дундаас буй болж, өгүүллэг нь бусад өгүүллэгийн дундаас буй болно. Уран зохиол өөрийн биеэсээ буй болохоос биш гадаад байдлаас буй болохгүй. Уран зохиолын хэлбэр нь уран зохиолын гадна оршиж байгаа явдал биш”⁹¹ гэж ярьж байгаа нь нэг талаар зохиол бүтээл нь ганц нэг хүний бүтээл биш, харин тухайн үеийн адил бүтээл, нийгэм ахуй зэрэг элдэв олон элементэд суурилан бүтсэн байдгийг илэрхийлж, нөгөө талаар уламжлал шинэчлэлийн асуудлыг уран зохиолын дотоод харьцаа холбооны нөхцөл байдалтай уялдуулан тайлбарлаж байна. Үүнийг харахад цаг үе буюу үзэл урсгал адил бүтээлийг буй болгоно хэмээн үзэж болох боловч зохиолчийн талаас авч үзвэл зохиолч бүрт байдаг хамтлагийн ухамсаргүй нь бусад бүтээлийн дундаас өөр нэг шинэ бүтээлийг буй болгож байна хэмээн ойлгож болох юм.

“Хүний оюуны ертөнцөд домгийн зохион бүтээх давхарга байж, тэр нь мэдрэлийн өвчтөнд байдаг мөртөө бас энгийн хүнд ч байдаг. Адил бус соёл, адил бус цаг үеийн хүнд байх оюуны энэ давхаргыг чухам хамтлагийн ухамсаргүй гэж нэрлэсэн байна. Хамтлагийн ухамсаргүй нь хүн төрөлхтний туршлагын хадгалагдаж байгаа газар үүний хамт энэ туршлагын төрөлх нөхцөл нь аливаа хэрэг үзэгдлийн санаа ахуй болж байдаг. Иймээс хамтлагийн ухамсаргүй нь бусдач оршиж байгаа бодит зүйл, тийм мөртөө үзэл ухамсрыг амьжирлын хүч бялхам болгодог. Тэр

⁹¹ [加拿大] 弗莱著, 陈慧, 袁宪军, 吴伟仁译, 《批评的解剖》, 百花文艺出版社, 2006年1月97页。



бол үзэл ухамсрын хамгийн сүүлийн илрэл, хүн төрөлхтний оюун ухаанд идэвхтэй нөлөө үзүүлж байгаа өвөг дээдсийн туршлага болно”⁹². Хүмүүст хамтад нь байдаг үзэл ухамсрын хэлбэр нь хамтлагийн ухамсаргүйг бүрэлдүүлэн, хамтлагийн ухамсаргүй нь оюун ухаан, бодол сэтгэлийг нөлөөлж домог мэт зүйлийг зохион бүтээдэг. Аюурзанын “Цагаан хар улаан”, “Бөөгийн домог”, “Арван зүүдний өр” гэх гурван романы домог туулийн өнгө үзэмж, бөө мөргөлийн ид шидлэг санаа ахуйг хамтлагийн ухамсаргүйд буй болж бүрэлдсэн зүйлээр тайлбарлан ярихад нийцнэ хэмээн үзэж буй. Хамтлагийн ухамсаргүйгээс болж бүрэлдсэн домог нь үнэндээ оюун санааны түүхийн нэг хэсэг нь байж таарна. Оюун ухааны түүхийн үндэслэл зорилго нь нэг цаг үеийн адил бус бусдач ахуйн дунд цаг үеийн зориг санааг онцлон үзэхэд оршино.

Энэ цаг үеийн шашнаас эхлээд хувцас засал хүртэлхийг багтааж болдог. Бид бусдач хэрэг бодисын далд зүйлээс бүхэл цогц зүйлийг хайн, ийм цаг үеийн зориг санаагаар бүх бодит хэрэг явдлыг тайлбарлаж болно⁹³. Цаг үеийн зориг санааг бусдач хэрэг бодисын далд зүйлээс бүхэл цогцын зүйлийг хайхаар дамжин илэрч болно. Аюурзанын “Цагаан хар улаан”, “Бөөгийн домог”, “Арван зүүдний өр” гэсэн гурван романд ардчилсан үзэл санаа голлосон XX зууны сүүлийн 10 жилийг багтаасан шинэ зууны 10-аад жилийн монголын нийгэм, хүний үзэл ухамсрын хувирал хандлагыг тусган гаргасан байна. Язгуур шашны ухамсар сул болж, бөө мөргөлийн хүч эрдмийг онцолдоггүй, нэгдмэл оюун санааны удирдлага байхгүй “олон туйлт” үзэл санаа ихэд дэлгэрсэн, “мөнгө шүтэх” үзэл ихэд газар авах болсон гэх зэрэг байдал нь зах зээлийн эдийн засагт шилжсэний дараах 20-оод жилийн монголчуудын үзэл ухамсар, цаг үеийн зориг санааны бүрэлдэлд сөрөг нөлөө үзүүлэх болов.

Шинэ зүйлийг зоригтой хүлээн авах, хүн төрөлхтний хамтлагийн ухамсаргүйд бүрэлдсэн домгийн үзэл санаа, домог туулийн хүн төрөлхтөн, нэн ялангуяа монголчуудын амьдрал соёлд үзүүлэх идэвхтэй үр нөлөөг ашиглах нь шинэ зууны монголчуудын уймраа мартамхай

⁹² [瑞士] 荣格著, 李德荣编译, 《荣格性格哲学》, 九州出版社, 2003年8月, 15页。

⁹³ (美) 勒内韦勒克, 奥斯汀沃伦著, 刘象愚, 邢培明, 陈圣生, 李哲明译 文学理论[M], 浙江人民出版社, 2017年2月, 85页, 111页(载《文学于精神史德文季刊》, 第2期, 1193年, 497页)。



сэтгэлгээг засан, ээдрээт будлиант орчинд зохицоход үзэл санааны тус дэм болохыг Аюурзанын дээрх гурван роман бидэнд хэлж өгч байна.

“1990-ээд онд 60, 70, 80-аад оны үеийн уран зохиолын төлөөлөгчид ид бүтээлээ туурвиж байсан ба тухай үеийнхэн ч гэсэн шинэ үе болон гарч ирснээр монголын орчин үеийн утга зохиолын 4 үе зэрэгцэн оршиж, ардчилсан үзэл санаа, нийгмийн чиг баримжааны үр дүнд буй болсон бүтээхүйн болон сэтгэлгээний эрх чөлөөт сэдэв, туурвил зүй, үзэл санааны хувьд эрх чөлөөтэйгээр бүтээн туурвиж байсан”⁹⁴. Цаг үе нь нийгмийн үзэл ухамсар болон уран зохиолын зохицонгуй хөгжлийг буй болгож, шинэ зуунд хуучин уламжлалт соёлоороо шинэ зүйлийг баялагжуулж хөгжүүлэхийг эрхэмлэх болсон байна.

“1990-ээд оны үеийн нийгмийн сэтгэлгээний эрх чөлөө, түүний сөрөг нөлөө болох эмх замбараагүй байдал харьцангуй тогтворжсон, өрнийн утга зохиолын шинэ чиг хандлагыг таг сохроор даган дуурайх байдлаас харьцангуй ангижирсан, өөрөөр хэлбэл уламжлал ба шинэчлэлийн залгамж халааг зүй зохистойгоор хадгалахыг хичээсэн, өрнийн утга зохиолын шинэчлэлийг дорнын уламжлалтай хослуулахыг зорьсон, утга зохиолын онолын сэтгэлгээг ямар нэгэн хэмжээгээр бүтээхээ үндэс сууриа болгон хадгалахад чиглэсэн нь 2000-аад оны үеийн утга зохиолын төлөөлөгчдийн гол ололт байлаа”⁹⁵. Шинэ зууны уран зохиолын ийм амжилтыг Аюурзана шиг хэсэг бүлэг зохиолч буй болгосныг зохиол бүтээлээс нь тод олж харна. Зохиолд тусгагдаж байх үзэл ухамсар, цаг үеийн зориг санааны хувирал хөгжил зэргийг зохиогч Аюурзана өрнийн утга зохиолын онол болон дорнын уламжлалт домгийн сэтгэлгээг уялдуулж, домог бодит ахуй, шидэт орчин болон энгийн орчны харилцан солбицлоор зохион бүтээжээ.

Өрнийн утга зохиолын онолоос суралцах нь монголын уран зохиолын онолыг баялагжуулах нэг талтай ч бодит байдалд тохиромжгүй тал хаяа буй болдог байдал ч гарах нь өрнө дорнын утга зохиол, урлаг соёл, үзэл ухамсрын зөрөөнөөс болсон байна. Аюурзанын дээр өгүүлсэн гурван роман, ялангуяа “Арван зүүдний өр”, “Цагаан хар

⁹⁴ Э.Батжавхлан нар. “XX зууны монголын уран зохиол”, УБ., 2017 т 485

⁹⁵ Э.Батжавхлан нар. “XX зууны монголын уран зохиол”, УБ., 2017 т 521



улаан” гэх хоёр романд зохиогч, Зигмунд Фрейдийн онолыг ашиглахын үүднээс хаяа “зүүд гэж юу болох”, “зүүдийг хэрхэн тайлах” гэх мэтийн агуулгыг зориуд бичиж оруулсан байна. Үргэлжилсэн үгийн зохиолд иймэрхүү онолын асуудлыг шууд бичиж оруулах нь зохиолын логикт харш ба уншуургүй болох байдалд хүргэж мэднэ. Өрнө дорнын утга зохиолын онолыг харилцан уялдуулах гэж зохиогч маань хичээл зүтгэл гаргасан нь илтэд харагдана. Гэвч зарим агуулгыг уншихад логик чанар сул болж, агуулгын залгамж хүчтэй биш гэх бодлыг хаяа өгөх шиг болдог.

ДҮГНЭЛТ

Монгол улсын залуу зохиолч, орчуулагч Гүн овогт Г.Аюурзана “Цагаан хар улаан”, “Бөөгийн домог”, “Арван зүүдний өр” зэрэг гурван роман нь монгол улсын зах зээлийн эдийн засагт шилжсэний дараах хүмүүсийн үзэл санааны хийрхэл, олон туйлт үзэл санаа газар авсан бодит байдлыг өгүүлэлд соёлын хувирал, домог бодит ахуй хоёрын солбицол болон хамтлагийн эзгүй ухамсраас буй болсон үзэл санаа хэмээх гурван талаас нь задлан шинжлэв. Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараах монгол улсын нийгмийн байдал, хүмүүсийн оюуны санааны хувирлыг өгүүлэлд мөн бодит жишээн хамт дэлгэрэнгүй тайлбарлав.

Эдийн засагт суурилсан нийгмийн соёл нь зах зээлийн эдийн засгийн хувирлаас болж хуучин уламжлалаа орхин, шинэ зүйл, шинэ соёлыг хайх болсон нь шинэ зууны монголын нийгэм соёлын бодит байдал болно. Аюурзана дээрх гурван романдаа өрнийн уран зохиолын онол болон дорнын шидлэг уламжлалыг харилцан уялдуулж, нийгэм соёлын хурдан өөрчлөлттэй орчинд уламжлалт соёлоо залгамжлан, бөө мөргөлийн шидэт шинжийг онцгойлон, нийгмийн хувирлын дунд хувь хүн өөрийн зөв хөгжлөө олохыг чухалчилжээ. Аюурзанын домог бодит ахуй хоёрыг уусалцуулан бичих нь зөн шидлэг уран зохиол буюу зохиолын зөн шидлэг шинжийг нэмэгдүүлэн монгол улсын шинэ зууны уран зохиолын реалист бус бичиглэлийн аргыг улам баялагжуулсан байна.



НОМ ЗҮЙ

1. Г.Аюурзана зохиов, Б.Очирбань буулгав. “Бөөгийн домог”, Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо
2. Г.Аюурзана. “Турамсан цадиг”, УБ., 2010
3. Г.Аюурзана. “Цагаан хар улаан”, УБ., 2014
4. Э.Батжавхлан нар. “XX зууны монголын уран зохиол”, УБ., 2017
5. [美] 勒内韦勒克, 奥斯汀沃伦著, 刘象愚, 邢培明, 陈圣生, 李哲明译 文学理论[M], 浙江人民出版社, 2017年, (载《文学于精神史德文季刊》, 第2期, 1933年)
6. 叶舒宪编选, 《神话 原型批评》, 陕西师范大学出版社, 1987年
7. 叶舒宪, 探索非理性的世界: 原型批评的理论与方法[M], 四川人民出版社, 1988年
8. [瑞士] 荣格著, 李德荣编译, 《荣格性格哲学》, 九州出版社, 2003年
9. [加拿大] 弗莱著, 陈慧, 袁宪军, 吴伟仁译, 《批评的解剖》, 百花文艺出版社, 2006年
10. 叶舒宪, 文学与人类学[M], 陕西师范大学出版社, 2018年
11. 叶舒宪, 文学与人类学[M], 陕西师范大学出版社, 2018年

ABSTRACT

Since the 1990s, new changes have taken place in Mongolia's political, economic, and social life, and literature, which has become an important expression of ideology, has been affected by this change, and innovative works have been on the rise. Gun Ayurzan's continuous writings reflect the transformation of people's minds and attitudes as a result of social and political changes, revealing the hidden nature of the trinity of social, cultural, and human relationships. This article will break down this hidden feature into three parts.

Keywords: *Potential power, collective unconscious, G.Ayurzana*

**ДУНДАД УЛСЫН ОДОО ҮЕИЙН УТГА ЗОХИОЛЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН
СУДАЛГААНЫ ТОЙМ §****Тэргэл *, Кань Хай Ин*****ХУРААНГУЙ**

Дундад улсын одоо үеийн утга зохиолын монгол орчуулга хэмээх судлагдахууны тойрон дахь өмнөх судлаачдын судалгаа нь голдуу монгол утга зохиолын орчуулгын онол судалгаа, монгол орчуулгын утга зохиолын түүх судалгаа жич одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа зэрэг гурван адил бус байдалд төвлөрч байгаа тухай өгүүлжээ.

Түлхүүр үгс: Орчуулгын утга зохиол, БНХАУ-ын өнөөгийн утга зохиол, монгол орчуулга, түүхчилсэн судалгаа

Орчуулгын утга зохиол тус биеийн улс, үндэстэн, хэл, соёл алсалсан шинж чанар нь түүний тухай судалгааны байдлын будлиант шинжийг буй болгосон байна. Доор бид дундад улсын одоо үеийн утга зохиолын монгол орчуулга хэмээх судлагдахууны эргэн тойрон дахь урьдах хүмүүсийн судалгааг монгол утга зохиолын орчуулгын онол судалгаа, монгол орчуулгын утга зохиолын орчуулгын онол судалгаа, монгол орчуулгын утга зохиолын түүхийн судалгаа жич одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа зэрэг талаар шинжилж үзье.

Нэг. Монгол утга зохиолын орчуулгын онол судалгаа

Утга зохиолын орчуулгын онол нь нэг зүйлийн онцгой орчуулгын онолд харьяалагдана. Нэг талаар тэр нь орчуулгын ухааны нэгэн салбар, нөгөө талаар тэр нь утга зохиолын онолын нэг салбар буюу утга зохиолын онолын нэг зүйлийн үргэлжлэл, нэг зүйлийн нөхвөрлөл

§ Тус өгүүлэл бол Улын гүн ухаан нийгмийн шинжлэх ухааны судалгааны төсөл “Дундад улсын одоо үеийн утга зохиолын монгол орчуулгын түүх судлал”-ын суурь чанартай бүтээл болно. **Зөвшөөрсөн дугаар (21XZW036).**

* 2019 оны магистрант (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль).

* Доктор, профессор (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургуулийн багш).



болно⁹⁶. Өнгөрсөнд монгол утга зохиолын орчуулгын онолын тухай судалгаа нь орчуулга судлалын ерөнхий онолын бүрэлдэхүүн хэсгийн хувиар орчуулгын ухааны тусгай бүтээлд хамрагдах буюу эрдэм шинжилгээний сэтгүүлүүдээр судалгааны өгүүлэл зохиол нийтлэгдэж байжээ.

1. Орчуулгын ухааны тусгай бүтээлд хамрагдсан байдал

М.Баясгалан, Ринчиний “Орчуулгын ухааны суурь” (ӨМАХХ, 1989 он) гэх бүтээлийн олон төрлийн зохиолын орчуулга хэмээх зургадугаар бүлэгт, уран зохиолын орчуулгын тухай уран зохиолын энгийн онцлог, уран зохиолын орчуулгын баримжаа, уран зохиолын орчуулагчид тавих шаардлага, үлгэрийн зохиолын орчуулга жич шүлэг дууллын орчуулга зэрэг талаар өгүүлжээ. Пэрэнлэйн “Монгол орчуулгын найруулга” (ӨМАХХ, 1992 он) гэх бүтээл дэх “Улаан асарын зүүдний орчуулгын тухай” хэмээх өгүүлэлд зохиогчоос хувь хүний орчуулгын үйлдэл ба онолжуулан хураангуйлжээ. С.Хичээлтийн “Орчуулгын ухааны үндсэн онол” (ӨМАХХ, 2002 он) гэх бүтээлийн хоёрдугаар бүлэгт монгол хэлний орчуулгын онол судалгааны түүхэн уламжлалын тухай өгүүлэхдээ утга зохиолын орчуулгад холбогдох агуулгыг хамарчээ. Жинхуарын “Орчуулга зүй” (ӨМИСХХ, 2004 он) гэх бүтээлийн олон төрлийн орчуулга хэмээх 4 дүгээр бүлэгт, уран зохиолын орчуулгын тухай уран зохиолын онцлог, уран зохиолын орчуулагчид тавих шаардлага жич шүлгийн орчуулга зэрэг талаар өгүүлсэн нь М.Баясгалан, Ринчиний “Орчуулгын ухааны суурь”-тай адилаар бүтэцтэй болжээ. Вү Юэ-ийн “Орчуулгын ухааны суурь мэдлэг” (Үндэстний хэвлэлийн хороо, 2000 он) гэх бүтээлийн олон төрлийн зохиолын орчуулга гэх хэсэгт, туужсын зохиол хийгээд шүлгийн орчуулгын тухай өгүүлж, бас “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах тэнхим”-ийн хятад орчуулгын тухай, уран зохиолын орчуулгад уг үндэстний онцлогийг хадгалвал зохино зэрэг хоёр өгүүлийг хураангуйлсан байна. Ерөнхийлбөл, дээрхийн ихэнх бүтээл нь их дээд сургуулийн орчуулгын ухааны тусгай мэргэжлийн заах материалын шинжтэй байж, утга зохиолын орчуулгын үндсэн онолыг шинжилсэн байна. Гэвч монгол утга зохиолын орчуулгын онолыг тусгайлан

⁹⁶ 王向远:《翻译文学导论》,北京师范大学出版社,2015年7月第一版,224页。



судалсан бүтээл байхгүй. Орчуулгын зохиол бүтээлийн судалгааны хувьд, “Улаан асарын зүүд” мэтийн ойрх үеийн хятад сонгодог бүтээлийн монгол орчуулгын тухай судалгааны чиглэл биш, одоо үеийн орчуулгын зохиол бүтээлийн тухай судалгааны бүтээл байхгүй байна.

2. Судалгааны өгүүлэл

Монгол утга зохиолын орчуулгын онолд холбогдсон судалгааны өгүүлэл 30 гаруй нийтлэгджээ. Судалгааны агуулгыг нь үндэслэн, утга зохиолын орчуулгын шинж чанар, орчуулгын баримжаа жич орчуулах арга зэрэгт холбогдсон онтологи судлал ба орчуулагч, орчуулгын бичвэр жич орчуулгын шүүмж зэрэгт холбогдсон гадаад судалгаа хэмээн хоёр төрөлд хуваан шинжилж болно.

а, Онтологи судлал

Гончигийн “Уран зохиолын орчуулгын тухай товч өгүүлэх нь” (ӨМИСЭШС, 1980.1) гэх өгүүлэлд, уран зохиолын бусад төрөл хэлбэрийн зохиолоос ялгагдах онцлог шинжийг өгүүлэхийн сацуу, уран зохиолын орчуулгын баримжаа, арга зүйг эзэмших жич хэл хэллэгийг чанартай болгохыг санаачилжээ. “Жүжгийн зохиолын орчуулгын тухай товч өгүүлэх нь” (ӨМИСЭШС, 1987.2) гэх өгүүлэлд, жүжгийн зохиолын орчуулгад хүний зан чанарт нийцүүлэх, тоглолтын шаардлагад нийцүүлэх асуудлыг өгүүлжээ. Сайшаалтын “Орчуулгад хэв маягийг илтгэх тухай” (Монгол хэл утга зохиол, 1988.1) гэх өгүүлэлд, уран зохиолын хэв маягийг орчуулах тухай агуулга хэлбэрийн зохиол, хэл хэллэгийн орчуулга жич орчуулагчийн хэв маяг зэрэг асуудлыг өгүүлжээ.

Вү Юэ-ийн “Монголжуу орчуулга гэх дурдалтын тухай” (Монгол хэл бичиг, 1991.4) гэх өгүүлэлд, орчуулгын бүтээлч чанар ба орчуулагчийн эрх чөлөө зэргийг хэрхэн таних тухай сүвэгчилж, монголжуу орчуулга гэх дурдалт нь орчуулгын хязгаарт шинжийг үл анзаарч, бүтээлч чанарыг өрөөсгөлөөр онцлосноос болж шинжлэх ухаанч томьёолол биш гэж үзсэн байна. С.Өлзийбатын “Уран зохиолын орчуулга дахь хоёр чиглэл” (Монгол хэл бичиг, 1996.8), “Яруу найргийн орчуулгын зарим асуудалд” (Монгол хэл бичиг, 1999.4) гэх өгүүлэлд, уран зохиолын орчуулга дахь шууд орчуулах ба утгачилж орчуулах хоёр чиглэлийн тухай нэрт орчуулагчдын үзэл баримтлалыг өгүүлж, орчуулгын үйлдэлд энэ хоёр чиглэлийг зохицуулж, уялдуулж, уусгаж



хэрэглэх хэрэгтэй гэж үзсэн байна. “Яруу найргийн орчуулгын зарим асуудалд” (Монгол хэл бичиг, 1999.4) гэх өгүүлэлд, яруу найргийн орчуулгад уг шүлгийн утга санаа ба үндэстний соёлын мэдээ мэдээллийг хадгалсан хэлбэрийг ч орчуулах хэрэгтэй гэсэн байна. Уранцэцэгийн “Монгол орчуулгын уламжлалаас суралцах асуудалд” (Монгол хэл утга зохиол, 2002.3) гэх өгүүлэлд, харь хэлнээс монгол хэлэнд орчуулсан сонгодог бүтээлийг шинжлэхээр дамжин утгын чиглэлээр орчуулах ба эх хэлний заншлыг журамлан амьдлаг уран найруулгатай орчуулах бол монгол орчуулгын түүхэн уламжлал гэж үзжээ. Мэргэнгуагийн “Утга зохиолын орчуулгын хэв маягийн тухай” (Монгол хэл бичиг, 2003.9) гэх өгүүлэлд, орчуулагч чадахын хэрээр өөрийн биечлэх, уг зохиолын хэв маягийг гажуудуулах ажиллагааг тэвчих хэрэгтэй гэжээ. Ариуны “Уран зохиолын орчуулгын шинж чанарын тухай” (Алтан түлхүүр, 2013.5) гэх өгүүлэлд, уран зохиолын орчуулгын шинж чанарыг бүтээлч чанар, захирагдах чанар жич гол цогцот чанар зэрэг талаар өгүүлжээ. Хураангуйлбал, дээрх өгүүллүүдэд голдуу уран зохиолын орчуулгын уран зохиолын бус орчуулгаас ялгагдах өвөрмөц онцлог шинж, орчуулгын баримжаа, орчуулах арга жич орчуулгын хэв маяг зэрэг агуулгыг шинжилсэн байна. Үүнд судлаачдаас уран зохиолын орчуулгын бүтээлч чанарын тухай ойлголт нэгдмэл боловч, хэрхэн орчуулах вэ? гэх дэлхийн чанартай маргаант асуудлын хувьд, шууд орчуулах “шууд орчуулах” (直译 zhi yi үгчилсэн, махчилсан), “утгачилан орчуулах” (意译 yi yi), “ижилсүүлэн орчуулах” (归化 gui hua), “ондоошуулан орчуулах” (异化 yi hua) талаарх үзэл баримтлалд зөрөөтэй оршиж буй.

Эрдэмтийн “Уран зохиолын орчуулга дахь бүтээлч чанартай сөргөөчилтийг таних учир – Translation study-ийн талаас монгол хятад орчуулгад шинэ агуулга нэмэрлэх нь” (ӨМҮНИСЭШС, 2015.3) гэх өгүүлэлд, уран зохиолын орчуулга дахь бүтээлч чанартай сөргөөчилтийн үзэгдлийн тухай орчуулагч, хүлээн авагч жич хүлээн авах хэлний орчин зэрэг гурван талаар өгүүлж, уран зохиолын орчуулга нь нэгэнт уг зохиогч, орчуулагч, уншигчид жич хүлээн авах орчин тойрон зэрэг олон элементэд холбогдсон будлиантай үйл ажиллагаа болсон байна гэж үзжээ. Хань Тана-ын “Уран зохиолын орчуулга дахь бүтээлч сөргөөчлөлийн илрэх хэлбэрийн тухай” (Монгол хэл бичиг, 2015.10) гэх



өгүүлэлд, уран зохиолын орчуулга дахь бүтээлч сөргөөчлөл нь өвөрмөц орчуулах, буруу орчуулах ба гэж орхигдуулах, сонгож орчуулах, найруулж орчуулах, дам орчуулах, өөрчилж орчуулах зэрэг бодит илрэлтэй байгааг өгүүлсэн байна. Ойрын жилд нийтлэгдсэн энэ хоёр өгүүлэл бол 1999 онд манай улсын харьцуулсан утга зохиол судлалын эрдэмтэн, орчуулгын онолч Ше Тяньжэнь-ээс “Орчуулга зүй” хэмээх бүтээлдээ анх дурдсан *бүтээлч чанартай сөргөөчлөл (创造性叛逆)*-ийн онолын тухай хүлээлт болно. Энэ нь монгол утга зохиолын орчуулгын онол судалгааны талыг дэлгэрүүлж, хэлний давхаргын шинжлэлээс соёл, гоо зүйн давхаргын шинжлэлд гүнзгийрэхийг ахиулсан байна.

б, Гадаад судалгаа

Орчуулагчийн судалгаанд, М.Эрдэнэсангийн “Орчуулгын үйл хэрэгт ихийг бүтээгч оргил” (Монгол хэл бичиг, 1987.10), Тогтохын “Манай улсын соёлын гарамгай зүтгэлтэн алдарт орчуулагч Анчинхүүгийн тухай тэмдэглэх нь” (Монгол хэл бичиг, 1991.3), Сарангуагийн “Монгол орчуулгын үйлсийг нээлцсэн хүн – хянан орчуулагч Ринчинкаваг тэмдэглэв” (Монгол хэл бичиг, 1991.5), С.Эрхэмийн “Үйлсийн замдаа цовоо төгөлдөр яваа хүн – хянан орчуулагч Дүйнхоржавыг тэмдэглэв” (Монгол хэл бичиг, 1994.1) зэрэг зохиол нийтлэгдэж, нэр хүндтэй орчуулагчийн намтар, орчуулгын зохиол бүтээл, монгол орчуулгын үйлсэд үзүүлсэн гавьяа зүтгэл зэргийг нь дурдан өгүүлсэн байна. 2002 онд ӨМАХХ –оос хэвлүүлсэн “Монгол судлалын нэвтэрхий толь, утга зохиолын боть”-д одоо үеийн зохиолч хийгээд орчуулагчийг хамтруулан 131 нэрс жагсаажээ. Энэ нь орчуулагчийн чухал чанар, нийгмийн байр суурь жич үнэ цэнийн тухай нэг хэмжээний нотлол болох боловч тусгай судалгааны өгүүлэл биш аж.

Одоо үеийн утга зохиолын орчуулагчийн судалгаа нь Лю Шисань-ий “Содбилэгийн орчуулгын судлал” (БХҮНИС, 2005 он) гэх магистр цол хамгаалсан өгүүллээс эхэлсэн байна. Тус өгүүлэлд, Содбилэгийн орчуулгын үйлсийг бүх талаар тоочин өгүүлж, шүлэг ба үлгэрийн зохиолын орчуулгынх нь хэв маяг жич түүний орчуулгын үзэл зэргийг шинжилсэн байна. С.Бүрэнбаярын “Монгол орчуулгын үйлсэд үзүүлсэн Дугарсүрэнгийн гавьяа зүтгэл” (Алтан түлхүүр, 2011.4) гэх өгүүлэлд, Дугарсүрэнгийн хятад шүлгийг монголчлох үзлийн тухай



өгүүлжээ. Ү.Начины “Орчуулгын тухай Н.Сайнцогтын үзэл баримтлалыг шинжлэх нь” (Хэл ба орчуулга, 2017.3) гэх өгүүлэлд, орчуулга ба хэлни орчин, орчуулга ба соёлын заншил, орчуулга ба шинэ үгсийн бүрэлдэхүүн, орчуулагчдын эгнээ, монгол зохиолыг хятадчилах асуудал, орчуулгын ажиллагаа дахь харьцуулал зэрэг 6 талаас Н.Сайнцогтын орчуулгын үзэл баримтлалыг өгүүлсэн байна. Ма Шужэнь-ий “Б.Осорын орчуулгын онцлогийг товч шинжлэх нь” (Монгол хэл бичиг, 2018.7) гэх өгүүлэлд, Цэцэгт тал өгүүллэгийн орчуулгаар жишээлж Б.Осорын орчуулгын үг сонгох талаар чанга хянамгай, монгол хэлний баялаг үгсийн санд суурилж урсам ойлгомжтой илтгэх жич монголын сонгодог зохиолын хэл хэллэгийг элбэг сайхан хэрэглэх зэрэг онцлогийг өгүүлжээ. С.Урсгалын “Чэнь Найшюн-ий хятадчилсан Б.Бүрэнбэхийн задгай шүлэг” (Монгол хэл бичиг, 2019.12) гэх өгүүлэлд, Чэнь Найшюн-ий Б.Бүрэнбэхийн задгай шүлэг (Алтан уул, Өвлийн дотор хавар, Толь, Хавар эрт)-ийн хятад орчуулгын оновчтой, амьдлаг, уянгалаг хэв маягийн тухай өгүүлсэн байна.

Орчуулгын бичвэр судалгаанд, Досонамын “Ойлгох, илтгэх, хянар бол орчуулгын үйлдлийн гурван явц мөн – Эцэс төгсгөлийн монгол орчуулгын үг өгүүлбэрийн буруу орчуулгын жишээн дээр” (Монгол хэл бичиг, 2006.2) гэх өгүүлэлд, Эцэс төгсгөл романы монгол орчуулга дахь үг өгүүлбэрийн буруу орчуулгыг өгүүлэхээр дамжуулан, орчуулгын үйлдэл дэх ойлгох, илтгэх, хянах гурван явц жич хоорондох харьцаа холбоог шинжилжээ.

Болорын “Улаан хад”-н орчуулгыг товч шинжлэх нь (Хэл ба орчуулга, 2013.3) гэх өгүүлэлд, Улаан хад романы монгол орчуулга нь уг зохиолд үнэнч байхыг баримталсан суурин дээр, монгол хэлний илтгэх заншлыг эрхэмлэн, зөв ойлгосон суурин дээр оновчтой илтгэх аргыг чухалчилсан тухай өгүүлэв. Сүрэнгийн “Чоно тотем романы монгол орчуулгын тухай товч шинжлэл – нэгдүгээр бүлгийн жишээн дээр” (Монгол хэл бичиг, 2015.4) гэх өгүүлэлд, тус романы Ван Шю Ин нарын орчуулга хийгээд монгол улсын Д.Болдбаатарын орчуулгыг харьцуулан шинжилж, үг хэрэглэлтийн талаарх ялгаа зөрөөнөөс болсон шалтгааныг дэлгэн үзүүлжээ. Төмөрбатын “Шүлэг найрууллын орчуулга дээр орон нутгийн соёлын элементийг хэрхэн улируулан зохицуулах тухай – Лю Лянчэн-ий Шиньжян-д гэх найрууллын түүврийг монголчилсон жишээн



дээр” (Хэл ба орчуулга, 2017.3) гэх өгүүлэлд, шүлэг найрууллын орчуулгад орон нутгийн соёлын элементийг улируулан зохицуулах тухай үгсийн утга, үг өгүүлбэрийн санаа, өгүүлбэр зүй жич хөг айзам зэрэг талаар өгүүлэв. Ургамалын “Эцэс төгсгөл романы хоёр монгол орчуулгын харьцуулсан судлал” (БХҮНИС, 2018 он) гэх магистр цол хамгаалсан өгүүлэлд, тус романы хоёр зүйлийн монгол орчуулгын бичвэрийг үндэстний хэл соёл, шүлэглэг хэл жич хийсвэр нууцгай орон зай зэрэг талаар харьцуулан шинжилжээ.

Орчуулгын шүүмж судалгаанд, Ринчиний “Монгол орчуулгын шүүмжийн тухай бодолхийлэл” (Монгол хэл бичиг, 1993.5) гэх өгүүлэлд, монгол орчуулгад тусгай шүүмжлэгчийн эгнээ буй болгохыг санаачилжээ. Эрдэмтийн “Уран зохиолын орчуулгын шүүмжийн төрөл хэлбэрийн тухай” (Монгол хэл бичиг, 2015.12) гэх өгүүлэлд, сонирхлоор голлосон (номын шүүмж, захидал, сул тэмдэглэл) ба судалгаагаар голлосон (эрдэм шинжилгээний өгүүлэл, тусгай бүтээл) хэмээн уран зохиолын орчуулгын шүүмжийг хоёр төрөлд хуваан шинжилж, өмнөх нь хойнохдоо үйлчилвэл зохино гэх үзлээ дэвшүүлжээ.

“Уран зохиолын шүүмжийн шинж чанар төрөл хэлбэр ба үйлдэл чадамжийн тухай” (ӨМНШУ, 2016.1) гэх өгүүлэлд, уран зохиолын орчуулгын шүүмжийн шинж чанар, төрөл хэлбэр жич үйлдэл чадамжийн тухай өгүүлж, орчуулгын шүүмжид шинжлэх ухаанч чанарыг буй болгож, судалгааны агуулга ба үр бүтээлийг дүрэмжүүлэх зэргийг санаачилсан байна. Ерөнхийлөн үзвэл, монгол утга зохиолын орчуулгын онол судалгаа нь онтологи судалгаагаар голлож, гадаад судалгаанд хэдийгээр олон зүйлийн туршиц илэрч байгаа боловч зөвхөн хөврөл буюу эхлэлтийн шатандаа байсаар байна. Одоо үеийн монгол орчуулагч хийгээд монгол утга зохиолын орчуулгын үйлдлийн үр бүтээл (орчуулгын бичвэр)-ийн тоо хэмжээнээс үзвэл, судалгааны бүтээл нэлээд хомс байгаа юм.

Хоёр. Монгол орчуулгын утга зохиолын түүх судалгаа

Монгол орчуулгын үйлдлийг анх ухамсарлан ажиглаж, утга зохиолын түүхийн үүднээс өгүүлсэн хүмүүст Б.Содном, Ц.Дамдинсүрэн нарыг дурдаж болно. Тэд “Монголын утга зохиолын түүхчилсэн төлөв, Монгол уран зохиолын тоймдоо Орчуулгын утга зохиол хэмээх нэрийг



анх дурдан гаргасан байна⁹⁷. Үндэстний утга зохиолын системд, “орчуулгын утга зохиолыг хүлээн зөвшөөрөх нь эцэстээ хоёр талаар онцгойрно. Нэгд, улс (үндэстэн)-ын ялгалын уран зохиолын түүх бичлэгт орчуулгын утга зохиол нь олвоос зохих орон байраа олох, Хоёрт, харьцангуй тусгаар орчуулгын утга зохиолын түүх найруулж бичих болно”⁹⁸.

Доор монгол уран зохиолын түүх бичлэг хийгээд монгол орчуулгын утга зохиолын түүх судалгааны байдлаас шинжилбэл:

1. Монгол уран зохиолын түүх бичлэг дэх орчуулгын утга зохиол

Монгол уран зохиолын түүх бичлэг дэх орчуулгын уран зохиолын тухай тэмдэглэлийг монгол улс хийгээд өвөр монгол дахь уран зохиолын түүхийн бүтээлээс шинжилж болно. Монгол улсын Б.Содномын “Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв” (Шинжлэх ухаан, 1946.12.13, УБ), Ц.Дамдинсүрэнгийн “Монгол уран зохиолын түүх” (ӨМАХХ, 1957 он), Ц.Дамдинсүрэн, Д.Цэндийн “Монголын уран зохиолын тойм” (дээд, доод-ӨМАХХ, 1983 он), Д.Цэрэнсодномын “Монгол уран зохиол” (ҮнХХ, 1989 он) зэрэг бүтээлд орчуулгын уран зохиолын тухай эрт, ойрх үеийн энэтхэг төвөд, хятад уран зохиолын монгол орчуулгыг тусгай хэсэг бүлгээр өгүүлсэн байна.

Энэ нь монгол эрдэмтдийн орчуулгын уран зохиолын чухал чанарыг мэдэрч байсны илрэл болохоор үл барам нэн ч орчуулгын уран зохиолыг монгол уран зохиолын бүрэлдэхүүн хэсгээр үзэж байсан давшингуй үзэл болно. Өвөр монгол оронд Мансангийн “Монголын уран зохиолын түүх” (ӨМСХХХ, 1980 он), Т.Сайнбаярын “Дундад улсын монгол үндэстний одоо үеийн утга зохиолын түүх” (ӨМСХХ, 1988 он), Б.Сүх, Буянтогтохын “Монгол уран зохиолын хөгжлийн товчоо” (ЛяоҮнХХ, 1996 он), Б.Сүхийн “Монгол уран зохиолын хөгжлийн түүхийн удиртгал” (ӨМСХХ, 2000 он), Рүн Сүх нарын “Монгол уран зохиолын түүх” (хятад, ӨМАХХ, 2000 он), “Монгол судлалын нэвтэрхий толь, утга зохиолын боть” (ӨМАХХ, 2002 он) зэрэг бүтээлд монгол уран зохиолын түүхэн дэх энэтхэг төвөд уран зохиол, хятад уран зохиолын

⁹⁷ Кань Хай Ин. “Монгол үндэстний дундад улсын орчин үеийн орчуулгын утга зохиолын түүх судлал”, ӨМАХХ 2014, т 2

⁹⁸ 谢天振主编:《当代国外翻译理论》,南开大学出版社,2018年11月第2版,第169页。



монгол орчуулгын тухай адил бус хэмжээний тэмдэглэл буй. Дээрхээс Монгол уран зохиолын түүх (Мансан, 1980 он), Монгол уран зохиолын хөгжлийн товчоо (Б.Сүх, Буянтогтох, 1996 он), Монгол уран зохиолын түүх (Рүн Сүх нар, 2000 он) зэрэг гурван бүтээлд орчуулгын утга зохиолын тухай адил бус талаас шинжилсэн байна. Нэгдүгээр бүтээлд, дундад улсын монгол уран зохиолын түүх судлалын хүрээ хэмжээнд анх удаа энэтхэг төвөд уран зохиолын орчуулгын хөгжлийг уран зохиолын түүхийн нэг хэсгээр үзжээ. Хоёрдугаар бүтээлд, энэтхэг, төвөд, хятад орчуулгын уран зохиолд адил байр суурийг олгож, онолын өндөрцөөс хөгжлийн жам хуулинд тулгуурлахаар оролджээ. Гуравдугаар бүтээлд, орчуулгын уран зохиол бол монгол уран зохиолын түүхийн органик бүтэц дэх чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж, чухал бүхий зохиол бүтээлийг нарийн, гүнзгий судалж, монгол уран зохиолын түүх судлалыг шинэ өндөрлөгт түлхэн ахиулсан байна⁹⁹. Эдгээр бүтээл бол монгол орчуулгын уран зохиолын түүх туурвилын түүхэн уламжлал байж, хойшдын монгол орчуулгын утга зохиолын түүх судалгаанд суурь нөхцөл бүрэлдүүлж өгсөн байна.

2. Монгол орчуулгын утга зохиолын түүх судалгаа

1986 онд ӨМАХХ –оос хэвлүүлсэн Ринчинкавагийн “Монгол орчуулгын түүхэн хураангуй тойм” бол монгол үндэстний орчуулгын түүхийг ерөнхийлөн судалсан анхны бүтээл болно. Тус бүтээлд хятад уран зохиолын монгол орчуулгыг хамран өгүүлсэн боловч, монгол орчуулгын утга зохиолын түүхийг тусгайлан судалсан бүтээл биш билээ. С.Урсгалын “Монгол орчуулгын утга зохиолын түүх жич ач холбогдол” (ӨМИСЭШС, 1994.4) гэх өгүүлэлд, анх орчуулгын утга зохиолын ухагдахуун, байр суурь жич хөгжлийн хандлагыг өгүүлж, монгол орчуулгын утга зохиолын түүхийг шинжлэх нь, монгол утга зохиолын түүх зүйг цогцлоох чухал явц мөн гэх үзлээ дурджээ. Тус өгүүлэл нь хойшид монгол орчуулгын утга зохиолын түүхийг системтэй судлахад сүвэгч үлдээсэн байна.

Кань Хай Ин-ий “Лү Шюнь-ий зохиол бүтээлийн монгол орчуулга жич нөлөө тусгал” (ӨМИС, 2005 он) гэх магистр цол хамгаалсан өгүүлэл нь элбэг баялаг материал цуглуулгад суурилан,

⁹⁹ 乌日斯嘎拉: 《蒙古族翻译文学史研究述评》, 《内蒙古师范大学学报》(哲社版), 2003年第3期, 第9页。



дундад улсын орчин үеийн том зохиолч Лү Шюнь-ий зохиолын бүтээлийн монгол хэлэнд орчуулагдсан байдлыг бүх талаар тоочин өгүүлж, түүний зохиол бүтээлийн монгол орчуулгын монгол уран зохиол дахь нөлөө тусгалыг шинжилсэн байна. “Монгол үндэстний дундад улсын орчин үеийн орчуулгын утга зохиолын түүх судлал 1947-1976” (ӨМИС, 2008 он) бол зохиогчийн доктор цол хамгаалсан өгүүлж байж, 2014 онд ӨМАХХ –оос хэвлүүлжээ. Тус бүтээл бол тусгай сэдэвт үечилсэн түүх байж, 1947-1976 оны хоорондох дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгыг түүхчилэн судалсан байна. “Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын түүх судлал 1976-2013” гэх бүтээл (кирилл үсэг, УБ., 2021 он) бол зохиогчийн 2020 онд биелүүлсэн улсын гүн ухаан нийгмийн шинжлэх ухааны төсөл байж, дээрх бүтээлийнх нь цагийн талаарх үргэлжлэл хийгээд агуулгын талаарх гүнзгийрэл болно. Энэ хоёр бүтээл нь одоо үеийн монгол орчуулгын утга зохиолын түүх туурвилын анхны туршиц болсны хувьд, хойшдын судалгаанд нэг зүйлийн хэв загвар хангаж өгсөн байна. Зохиогчоос монгол орчуулгын утга зохиолын хөгжлийн түүхэн төрхийг сэргээхээр мэрийж, орчуулгын утга зохиолын монгол уран зохиол дахь нөлөө тусгалыг харьцуулсан утга зохиолын онол аргаар судалсан нь маш бүтээлч ородлого болжээ.

Линь Чуньянь-ий “Шинэ дундад улс байгуулагдсаны сүүлээрх 17 жилийн турш дундад гадаадын уран зохиолын монгол орчуулгын судлал” (БХҮНИС, 2016 он), Саруулын “Соёлын хувьсгалын үеийн монгол орчуулгын ажлын судалгаа” (БХҮНИС, 2015 он), Бао Линлин-ий “Дундад гадаадын уран зохиолын шинэ цаг үе дэх монгол орчуулгын судалгаа” (БХҮНИС, 2016 он) зэрэг магистр цол хамгаалсан цуврал өгүүлэлд, 1949-1997 оны хоорондох хятад уран зохиолын монгол хэлэнд орчуулагдсан байдлыг ерөнхийлөн тоочиж, орчуулгын онцлог шинжийг дүгнэсэн байна. 2020 онд ҮнХХ –оос хэвлүүлсэн Тэнгисийн “Монгол үндэстний орчуулгын түүх судлал” (хятад) гэх бүтээлийн доод найрал – “БНМАУ байгуулагдсаны сүүлээрх монгол орчуулга”-ын өмнөх гурван бүлгийн агуулга нь дээрх гурван өгүүлэл лүгээ давхацсан хэсэг байдаг.

Хашчулуугийн “Монгол уран зохиолын түүх бичлэг дэх орчуулгын уран зохиолын байр суурийн тухай” (ӨМНШУ, 2019.5) гэх өгүүлэлд, монгол орчуулгын уран зохиолыг монгол уран зохиолын түүх



бичлэгт багтаан оруулж, монгол орчуулгын уран зохиолын түүх туурвин бичвэл зохино гэх үзлээ дэвшүүлжээ. Дорнохүүгийн “Дундад улсын хятад уран зохиолын монгол орчуулгын номын бүртгэл ба судлал (1947-1956)” (ӨМИСЭШС, 2021.4) гэх өгүүлэлд, 1947-1965 оны хоорондох хятад уран зохиолын монгол орчуулгын ном хэвлэлээр тархсан байдлыг шат үе хуваан шинжилж, орчуулгын онцлог жич монгол утга зохиол дахь нөлөө тусгалыг шинжилжээ. Үүнээс гадна, Наран, Саянямбуугийн эрхлэн найруулсан “Дундад улсын орчин үеийн уран зохиол” гэх бүх улсын тусгай мэргэжлийн дээд сургуулийн заах материалыг ӨМСХХХ – оос 2001 онд хэвлүүлжээ. Тус бүтээлийн доод найралд, 1949-1997 оны хоорондох дундад улсын одоо үеийн уран зохиолын түүхийг өгүүлсэн байдаг.

Ерөнхийлбөл, монгол уран зохиолын түүх бичлэгт орчуулгын уран зохиолыг багтаан оруулж байсан уламжлалтай. Гэвч энэхүү уламжлал нь түүхэн хөгжлийн явцад тасалдсан байна. Одоогоор эрдэмтдээс орчуулгын уран зохиолын монгол уран зохиолын түүх бичлэг дэх байр суурийг сэргээхийг санаачлах буюу тусгай судалгаа өрнүүлэхээр хичээж байна. Монгол уран зохиолын түүхэнд адил бус үндэстний орчуулгын уран зохиол нь адил бус байр суурьтай юм. Одоо үеийн хятад уран зохиолын монгол орчуулгын судалгааны байдлаас шинжилбэл, судлагдахууны хувьд дундад улсад орчин (одоо) үеийн утга зохиолын монгол орчуулга буюу хятад уран зохиолын монгол орчуулга хэмээх хоёр зүйлийн хязгаарлал (界定 jìe dìng) оршиж буй. Орчуулгын зохиол бүтээлийн тархалтын зуучийн хувьд, уламжлалт ном хэвлэлээр дамжин орчуулагдсан байдлын тухай судалгаагаар голлож, сонин, сэтгүүл, сүлжээ интернет зэргээр дамжсан байдлын тухай судалгаа гүйцэд хийгдээгүй байна. Орчуулгын утга зохиолын монгол уран зохиол дахь нөлөө тусгалын тухай шинжлэл гүнзгийрэх шаардлагатай байна.

Гурав. Одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа

Одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгааны өрнөлт нь монгол утга зохиолынхны харьцуулсан утга зохиол судлалын онол аргыг хүлээн авсан лугаа шууд холбоотой. Чэнь Ганлүн профессорын 2009 онд нийтэлсэн “Өөрчлөлт нээлтийн гучин жилийн монгол харьцуулсан утга зохиолын судлалын эргэцүүлэл хийгээд



барлал-改革开放三十年蒙古比较文学研究回顾与展望” (ӨМБИСЭШС, хятад, 2009.1) гэх өгүүллээс бид монгол харьцуулсан утга зохиол судлалын түүхэнд, өрнө дорнын харьцуулал, эртний уран зохиол, ардын аман зохиолын харьцууллаар голлож байсныг мэдэж болно. Ойрх орчин үеийн харьцуулсан судалгаанд, Лү Шюнь-ий зохиол бүтээл хийгээд монгол уран зохиолын харьцуулал шинжлэлээс бусад судалгаа тийм сайн хөгжлөө олж чадаагүй байжээ. Гэвч 2009 оны наана цаана, одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа хөвөрч эхэлсэн байна.

1. Судалгааны бүтээл

Ян Баярын найруулсан “Харьцуулсан утга зохиолын өгүүлэмж” (ӨМАХХ, 1993 он) бол хамгийн анхны харьцуулсан утга зохиол судлалын тусгай бүтээл болно. Тус бүтээлийн дээд дэвтэрт харьцуулсан утга зохиолын үндсэн ухагдахуун (Хэтцахиур), судлалын агуулга (Ян Баяр) жич үүсэл хөгжил (Ч.Баатар) зэргийг өгүүлж, доод дэвтэрт Баяр, Хэт, Баатар, Ринчиндорж нарын монгол уран зохиол ба дэлхийн уран зохиолыг харьцуулан шинжилсэн 6 өгүүллийг хураангуйлсан байна. Үүнд Хэтцахиурын “Монгол орчуулгын уран зохиол – нөлөө судлалын чухал сэдэв” гэх өгүүлэлд, харьцуулсан утга зохиолын нөлөө судлалын талаас орчуулгын уран зохиолын шинж чанарыг өгүүлж, монгол орчуулгын уран зохиол нь монгол ураан зохиолыг төрөл хэлбэрийн талаар нөлөөлсөн байдлыг маш нарийн шинжилжээ.

Баатарын “Харьцуулсан утга зохиол ба монгол утга зохиол” (ӨМАХХ, 2002 он) гэх бүтээлд, харьцуулсан утга зохиол ба монгол утга зохиолын хамтын хөгжлийн хандлага, харьцуулсан утга зохиолын судалгааны хүрээ хэмжээ, арга, онолын тэлэлт хийгээд монгол утга зохиол дахь үйлдэл туршиц, монгол шүлэг зүй ба харьцуулсан шүлэг зүй, соёл алсалсан судалгаа ба монгол уран зохиол зэрэг агуулгыг хамарчээ. Энэ хоёр бүтээл нь монгол утга зохиолынхонд харьцуулсан утга зохиол судлалын онол аргыг авч ирсэн боловч одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгааны тусгай бүтээл биш юм.

Намиягийн “Одоо үеийн монгол туужсын тайлал 1949-1966” (ӨМИСХХ, 2005 он) хэмээх бүтээл нь арга зүйн шинжлэлийг зорих үүднээс харьцуулсан утга зохиолын аргыг туршин хэрэглэж, “17 жил”-



ийн монгол туужис хийгээд хятад уран зохиолын харьцаа холбоог шинжилсэн байна. Хайрханы “Одоо үеийн монгол шүлгийн ерөнхийлсөн судлал” (ӨМИС, 2005 он, ӨМСХХХ, 2010 он) гэх бүтээлийн хөндлөнгийн нөлөөлөл хийгээд шинжлэлийн асуудал хэмээх тавдугаар бүлэгт, монгол шинэ шүлгийг эрт эдүгээ гадаад дотоодын утга зохиолын системд байршуулан шинжилж, одоо үеийн монгол хятад шинэ шүлгийн хоорондох нөлөөллийн харьцааг шинжилсэн байна.

Дээрх хоёр бүтээл нь хэдийгээр монгол уран зохиолоор гол судлагдахуун болгосон боловч харь үндэстний уран зохиолын тольдол доор өөрийн үндэстний уран зохиолоо шинжилж, одоо үеийн монгол уран зохиол судлалд дэлхийч хараа хийгээд харьцууллын ухамсрыг авч иржээ. Энэ нь хойшдын одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгааны өрнөл хөгжилд суурийг тавьж өгсөн байна.

2. Судалгааны өгүүлэл

Одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан утга зохиол судлалд, магистр цол хамгаалсан өгүүлэл гол цогц болж буй. Хуарын “Шинэ эриний монгол туужсын орчуулгад холбогдсон соёл зүйн асуудал” (ӨМИС, 2007 он) гэх өгүүлэлд, шинэ эриний монгол туужсын хятад хэл дэх орчуулга танилцуулгын байдлыг өгүүлсэн суурин дээр, орчуулгын бичвэрийн судалгааны байдал, шүүмж өгүүлэлд илэрч байгаа хандлага чиглэл зэрэг асуудлыг өгүүлжээ. Бао Хөгжилтийн “Хятад үндэстний роман бичлэг дэх монгол дүрийн судлал – Жинь Юн хийгээд Жян Рүн-ий зохиол бүтээлээр жишээлэх нь” (ӨМИС, 2010 он) гэх өгүүлэлд, харьцуулсан утга зохиолын дүр зүйн аргаар хятад зохиолчийн Юн ба Жян Рүн хоёрын бүтээлд илэрсэн монгол дүрийг шинжлэхээр дамжин хятад уран зохиол дахь монгол соёлын тухай халуун уншлагын үзэгдлийг өгүүлжээ.

Ван Сараанын “Чоно тотемын адил бус соёлын тойрог дундах хүлээлт” (ӨМИС, 2012 он) гэх өгүүлэлд, Жян Рүн-ий “Чоно тотем” романы хятад, монгол, англи зэрэг гурван зүйлийн адил бус соёлын тойрог дахь адил бус хүлээлтийн байдлыг харьцуулан шинжилжээ. Яруугийн “Жан Чөнжы-ийн туужис хүүрнэл дэх тал нутаг” (ӨМИС, 2013 он) гэх өгүүлэлд, харьцуулсан утга зохиолын дүр зүйн аргаар хотон үндэстний зохиолч Жан Чөнжы-ийн туужис хүүрнэлд илэрсэн “тал



нутаг”-ын дүрийг шинжлэхээр дамжин, зохиогчийн зохиол бүтээлтийн явц, уншигчийн хүрэлтийн явц дахь халуун уншлагын үзэгдлийг өгүүлснээс гадна бас Жан Чөнжы ба Батмөнхийн туужис дахь “тал нутаг”-ийг утга сэдэв, дүр, хүүрнэгчийн байдал жич халамжлалын цэг зэрэг талаар харьцуулан шинжилжээ. Улаантуяагийн “Сэхээтэн залуучуудын туужис хүүрнэл дэх тал нутаг – Лао Гүй-ийн Цуст өнгөтэй гар бүрий роман хийгээд Жян Рүн-ий Чоно тотем романаар жишээлэх нь” (ӨМИС, 2013 он) гэх өгүүлэлд, 20 дугаар зууны 60, 70-аад оноор шилийн голын тал нутагт хөдөө буусан өнгөрөлттэй хятад сэхээтэн зохиолч Лао Гүй ба Жян Рүн-ий хагас намтарчилсан роман “Цусан өнгөтэй шар бүрий” хийгээд “Чоно тотем” дэх тал нутгийн дүрийг харьцуулан шинжилжээ. Зохиогчоос “Цусан өнгөтэй шар бүрий” роман дахь тал нутаг нь ар үзэгдэл төдий болж байхад, Чоно тотем роман дахь тал нутаг нь харин хараан төвлөрөл болж байгаа хэмээн үзэж, үүний гүн давхаргын үндэс шалтгааныг сэхээтний амьдралын бодит туршлага, хожуу соёлын их хувьсгалын үзэл ухамсар, онцгой зохион бүтээх хөдөлгөх хүч, 20 дугаар зууны 80, 90-ээд оны соёлын нөлөө жич зохиогчийн байдал зэрэг талаар задалжээ.

Үзэсгэлэнгийн “Соёлын хувьсгалын сэдэвт монгол хятад туужсын харьцуулал – зохиогчийн үзэл ойлголтыг туурвих нь” (ӨМИС, 2013 он) гэх өгүүлэлд, монгол хятад зохиолчдын зохиол бүтээл дэх соёлын их хувьсгалын шарх сорвийн тухай ойлголтыг харьцуулан шинжилжээ. Ли Соргогийн “Цагаан бугатын шил монгол уран зохиолд” (ӨМИС, 2014 он) гэх өгүүлэлд, Чэнь Жүнши-ийн Цагаан бугатын шил романы монгол хэл дэх орчуулгын байдлыг танилцуулан, уг зохиол хийгээд орчуулгын бичвэрийг харьцуулан шинжилсэн суурин дээр орчуулгын бичвэрийн хүлээлтийн байдлыг улам нэг алхам шинжилжээ. Чөн Рэнь-ий “Монгол хятад уран зохиолын харьцаан дахь А.Одсэр” (ӨМИС, 2014 он) гэх өгүүлэлд, Мао Дүнх ба А.Одсэрийн захидал харилцаа, уулзалт, Мао Дүнх-ий А.Одсэрийн зохиол бүтээлийн тухай шүүмж өгүүлэл, А.Одсэрийн бийр доорх Мао Дүнх-ий дүр зэрэг бодит харьцааг үндэслэн А.Одсэр ба Мао Дүнх-ий харилцаа холбоог өгүүлсэн бөгөөд А.Одсэрийн “Сувд цацсан тал” хийгээд Лю Чин-ий “Үйлс босгосон түүх” хоёр бүтээлийн хоорондох харгалзлын харьцааг шинжилжээ.



Хасчимэгийн “Нөлөө судлалын хараан дахь Б.Бүрэнбэхийн шүлэг туурвил” (ӨМИС, 2015 он) гэх өгүүлэлд, Б.Бүрэнбэхийн шүлэг туурвил дахь тиг стиллийн талаарх задгай шүлгийн үүдэлт, хүүрнэл шүлгийн шинэчлэл, уянгын шүлгийн хөгжүүлэл, арга хэлбэрийн талаарх чөлөөт уянгалал ба санаа ахуй бүтээх зэрэг нь хэрхэн харь гадаадын зохиолч, зохиол бүтээлээс нөлөө хүртсэний зэргээр өөрийн үндэстний уран зохиолын уламжлалаа хөгжүүлж шинэчилсэн тухай өгүүлжээ. Амилангийн “Харьцууллын хараан дахь монгол үндэстний соёл мөрдлөгийн туужис” (ӨМИС, 2017 он) гэх өгүүлэлд, монгол соёл мөрдлөгийн туужсын хөгжлийг услан үүсгэсэн 1981-1984, өрнөл бадрал 1985-2000, үргэлжлэл 2000-2016 хэмээн шат үе хуваан шинжилж, монгол соёл мөрдлөгө ба хятад язгуур мөрдлөгийн уран зохиолын бичвэр ба үзэл урсгалын нөлөөллийн харьцаа жич гадаадын соёллог туужсын монгол уран зохиол дахь бичвэрийн нөлөөллийн харьцааг шинжилжээ. Учралсайханы “Монгол үндэстний 17 жилийн утга зохиолын хятад үндэстний утга зохиолын хүрэн дэх тархалт ба хүлээлт” (ӨМИС, 2018 он) гэх өгүүлэлд, 17 жилийн монгол уран зохиолын хятад уран зохиол дахь хүлээлтийн байдлыг үг хэл, танин мэдэхүй, гоо зүйн давхаргаас шинжилсэн байна.

Энэ мэтээр дээрх өгүүллүүд нь голдуу харьцуулсан утга зохиолын дүр зүйн аргаар хятад уран зохиол дахь монгол дүр буюу монгол уран зохиол дахь хятад дүрийг шинжлэх, харьцуулсан утга зохиолын утга сэдэв судлалын аргаар адилхан нэг утга сэдвийн монгол хятад уран зохиол дахь адил бус илрэлийг шинжлэх, “Орчуулга – тархаалт – хүлээлт – нөлөө тусгал” хэмээх логикоор монгол хятад уран зохиолын солилцоог шинжлэх, харьцуулсан утга зохиолын үзэл урсгал судлал зэрэг агуулгыг хамарсан байна.

Үүнээс гадна, Чимэгийн “Дундад улсын эмэгтэйчүүдийн уран зохиол ба монгол үндэстний эмэгтэйчүүдийн уран зохиолын судалгааг харьцуулан ажиглах нь” (Дундад улсын монгол судлал, 2005.3), Оюунцэцэгийн “20 дугаар зууны 50, 60-аад оны хятад монгол найрууллыг харьцуулан шинжлэх нь” (ӨМНШУ, 2011.4), Сацрангуйн “Хар шороон газар ба дапугийн харьцуулал” (ӨМҮНИСЭШС, 2021.3), Аясын “Өлзийбүрэнгийн Наргуй 20 өдөр ба Янь Лянькө-ийн Амьдрахуйн харьцуулал” (Алтан гарди, 2021.3) зэрэг өгүүлэл



нийтлэгдэж, монгол хятад эмэгтэйчүүдийн судалгааны харьцуулал, ямар нэгэн уран зохиолын төрлийн хувьд одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулал жич дан бичвэрийн харьцуулал зэрэг агуулгад холбогдсон байна.

Онц дурдах чухалтай нь 2020 оны “Тайлал хийгээд залгамжлал: өвөр монголын хувьсгалт утга зохиолын сонгодог бүтээлийн эрдэм шинжилгээний судлан ярилцах хурал” (Хөх хот) дахь Хайрханы 17 жилийн монгол хятад уран зохиолын адилсах харьцааны ажиглалт гэх өгүүлэлд болно. Тус өгүүлэлд, 17 жилийн монгол хятад уран зохиол нь Мао Зэдун-ий “Хэлсэн үг”-ээр хөтөлбөр болгосон дүрэмжүүллийн тогтолцоонд адилсах харьцаатай болсон хэмээн үзэж, өргөн талын ойлгогдохуун, зохион бүтээх арга, хөгжих чиглэл жич гоо сайхны дээд баримжаа зэргийн нэгтгэл, бичил талын агуулга – урлагийн загварын адилсал, хүүрнэлийн талт бүтцийн адилсал зэрэг харьцуулсан утга зохиолын нөлөөллийн үзэгдлийг анх дурдсан байна. Энэ нь одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаанд маш үнэ цэнэтэй үзэл болно.

Ерөнхийлбөл, одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа нь зөвхөн арваад жилийн түүхтэй боловч, урьдах судалгаанд олон зүйлийн туршиц илэрсэн бөгөөд зарим маш үнэ цэнэтэй үзэл дурдагджээ. Гэвч нэн өргөн дэлгэр судалгааны орон зай нээгдээгүй байсаар байна.

ДҮГНЭЛТ

Дундад улсын одоо үеийн утга зохиолын монгол орчуулга нь нэгэнт 70 гаруй жилийн түүхтэй болсон мөртөө мөн үргэлжлэн хөгжиж буй. Урьдах хүмүүсийн судалгааны байдлаас үзвэл, тус судлагдахууны эргэн тойрон дахь монгол орчуулгын утга зохиолын түүхийн байдал дахь системтэй судалгаа хоосон байх юм. Энэхүү судалгаа нь орчуулгын утга зохиол ба монгол уран зохиолын харьцаа холбооны шинжлэл, одоо үеийн монгол хятад уран зохиолын харьцаа холбооны шинжлэл жич монгол уран зохиолын түүх зүйн системийн цогцлол зэрэгт цөм дутагдаж болшгүй чухал агуулга байж, монгол үндэстний орчуулгын уран зохиолын дараагийн судалгаанд тулгам шаардагдаж байна.

THE CULTURAL WAY



ABSTRACT

As a research object of Mongolian translation of contemporary Chinese literature, previous researches mainly focus on three points: first, theoretical studies on Mongolian literary translation, second, studies on the history of Mongolian translated literature, and third, comparative studies on contemporary Mongolian and Chinese literature.

Keywords: *translated literature, contemporary Chinese literature, Mongolian translation, historical research*



ШИНЭ ЦАГ ҮЕИЙН ШАШИН ШҮТЛЭГ ИТГЭЛ БИШРЭЛИЙН ТУХАЙ ШИНЖИХ НЬ

Сүмэн *

ХУРААНГУЙ

Хүн төрөлхтний шашин шүтлэг итгэл бишрэл нь хөгжлийн явцдаа тахигдал учран, самуурал үүсгэн, ухралтаас төөрөлтийн байдалд орж, хүн чанарын доройтлыг үүсгэн, нийгмийн амар тогтуун бус байдлыг үүсгэдэг.

Түлхүүр үгс: Шүтлэг, чанар, доройтол

Шашин шүтлэг итгэл бишрэл нь орчлон ертөнцийн танилт ба өөөрийн танилт жич нийгмийн хөгжлийг дагалдан аяндаа хувирч, нэг улс үндэстний нягтрал бүлгэмдлийн суурь болдог. Монголчууд эрт дээдсээсээ тотем шүтээн болсон араатан амьтан, онгод шүтээн болсон өвөг дээдсийн сүнс, бөөгийн шүтлэг болсон тэнгэр сахиус, үхэж төрөхийн орчлоос мултрах бурхны шүтлэг зэрэг хэд хэдэн шат үеийг өнгөрөөхдөө маш хэцүү бэрхшээлийг амжилттай туулсан ч өнөө харин төөрөлтөд учирсан нь харамсалтай болжээ.

Нэг. Шашин шүтлэг итгэл бишрэлийн тахигдал

Бурхны шашин нь их бага таван ухаанаас бүрэлдэн хүн төрөлхтний аливаа соёл мэдлэгийн цар хүрээг хамарч чадсанаар дэлхийн аливаа шашны дунд тэргүүлж байдаг. Бурхын шашны томоохон сүм хийд нь таван дацантай байж, одоогийнхоор таван их сургууль, маш олон дээд сургууль ба олон тусгай мэргэжлийн салбараар бүрэлдсэн том сургууль гэхэд буруудахгүй. Бурхны шашныг сүм хийд, лам хувраг, бурхны хөрөг зураг, ном судар гэж гадаад байдалд үнэлгээ өгвөл, түүний дотоод агуулж байгаа аугаа их соёлын өвийг хөнгөвчилсөнд тооцогдоно. Бурхны шашин буй болсон цагаас эхлээд маш олон салхи шуурган дундуур, ээдрээ нугачаатай таарчээ. Жишээлбэл, дундад улсын түүхэнд

* Шашин судлалын докторант (Монгол Улсын Их Сургууль).



“Гурван Вү-ийн зовлон” гэж умард Вэй, умард Жоу, Тан зэрэг гурван төрийн түүхэнд бурхны шашны тахигдал үүссэн байна. Төвөд үндэстний түүхэнд “Ландрамын дарангуйлал” гэх шашин төрийн их тэмцэл гарч байсан юм.

XX зуунд монгол нутагт бурхны шашин нь сүйрлийн шинжтэй тахигдалд учирсныг дэлхий нийтээр бүгд мэднэ. 1937-38 онд халх монголд 700 гаруй сүм хийд шатаагдан, хэдэн түмэн лам нар алагдсан харуусалт хэрэг гарч байв. Өвөр монголд ч соёлын хувьсгал өрнөн маш олон сүм хийд, хөрөг шуумлыг эвдэн сүйтгэж, ном судрыг галдан сүйтгэж, лам нарыг тарчлаан зовоож, хар буюу энгийн хүн болгосон зэрэг зүрх шимшрэм гунигт явдал гарч, монгол оронд тоотой хэдхэн сүм хийд, өндөр настай зэмдэг цөөн тооны лам үлдэж, шашин шүтлэг нь утсан дөрөөн дээр тогтож байв. Энэхүү тахигдал нь сүм хийд, ном судар, лам хувраг зэрэг шашин шүтлэгийн тахигдал төдий биш, үнэндээ үндэстний соёлын их тахигдал юм. Түүхэнд үүссэн хэдэн удаагийн талхигдлыг харьцуулбал, XX зуунд үүсгэсэнэ тахигдал нь хамгийн хор уршигтай мөртөө сүйрлийн шинжтэй тахигдал болсноос монголчуудын шашин шүтлэг нь самуурал, ухралт доройтолд чиглэсэн нь ил тод харагдана.

Хоёр. Шашин шүтэлгийн итгэл бишрэлийн самуурал

Бурхны шашин 2500 жилийн өмнөх хүн төрөлхтний эртний цаг үед буй болсон боловч цаг үеэс давсан дээд хэмжээний боловсон онцлогтой тул амьжирлал маш хатуу байж, дэлхий ертөнцөд мэдрэгдэн, нийгмийн хөгжлийн шаардлагад зохицож чадсан байна. Гэтэл аж ахуйн хөгжил, дэлхий дахин даяарчлалыг дагалдан, хэдэн мянган жилийн байгаллаг борогжуу амьдралаасаа уйдаж, зоос мөнгө, ашиг орлого, эд, эрх зэрэгт горьлон, ертөнцийн жаргал цэнгэлд ташууран, шашин шүтлэг итгэл бишрэл нь самуурлын байдалд орсон байна. Шашин шүтлэг нь хүн төрөлхтний идэх өмсөх, явах суух зэрэг богино нэг насны сайн сайхан амьдралын үйл ажиллагаа биш, ямар янзын амьдралаар амьдарч, ямар янзын шашин шүтлэгийг сонгох нь хүн бологчдын эрх чөлөө гэх боловч, дээд зэргийн оюун ухаантай хүн бологчид эрхбиш доод зэргийн мэдрэмжтэй адгууснаас онцгойрсон хүн чанарын боловсноо бадруулж, нэн дээд зэргээр сэхээрч ухаарагсдын боловсонд хүрэхээр хичээх нь зүй ёсны учир билээ.



Ялангуяа XXI зуунд болоход, мөнгө зоос, эрх чөлөөний хөөцөлдөл, харь гүрний таашаал, хүн чанараас тэрслэсэн, бодит ахуйгаас холдсон элдэв янзын хий хоосон суртал агуулга нь өнөөгийн хүмүүсийн уламжлалт шашин шүтлэгийг самуурлын байдалд оруулсан байна. Бурхны шашныг шүтсэнээр монголчууд эрэлхэг зоригоо алдаж, оюун санаа нь мунхарч, хүн ам хорогдож, хаан төрөө алдаж, улсын хүч буурч, дэлхий ертөнцөөс хөгжлөөр хоцорсон гэж бөө мөргөлөө дурсан, зарим нь европын шашин шүтлэгийг ихээр таашаан, амьдралын хэв маягийг нь дууриан, христос шашин буюу исламын шашныг шүтэн, “сүүтэй бол ээж” гэж сэтгэн, “өөх биш булчирхай ч биш” болж саармагжсан шүтлэгтэн олширчээ.

Жишээлбэл, 2009 онд монгол улсын Улаанбаатар хотод шашны үйл ажиллагааны газар 350 байж, үүний дотор христос шашны сүм 197 буюу бүх сүм хийдийн 69%, христос шашныг шүтэгчид 40 мянгыг давж, 90% нь залуучууд эзэлж байв. 2018 онд болоход монгол улсын хүн амын 62%-д хүрсэн, бурхны шашны сүм хийд зөвхөн 63 байна гэсэн мэдээлэл гарч байсан билээ. Монголчууд түүхэндээ Ази Европыг сундалсан аугаа эзэнт гүрнийг байгуулахад бөөгийн хүчинд бус харин эзэн Чингис ба эрэлхэг дайчдын авьяас билиг хүч чадалд түшиглэжээ.

Төрөө алдаж, Мулташ хаалгаар ар газартаа буцсан нь бурхны муугаар ч бус билээ. Монголчууд ч хувьсгал хийж бурхны шашнаа үнсэн товрог болтол сүйтгэж орхилоо. Эргэцүүлэн бодвол ялагдлын үндэс суурь нь шашин шүтлэг итгэл бишрэлд байгаа бус гэдэг нь илэрхий харагдана. Зөвхөн ялагдал доройтлын шалтгаанаа бусдад түлхдэг өчүүхэн хүмүүсийн ярьдаг үзэл төдий юм.

Гурав. Шашин шүтлэг итгэл бишрэлийн ухралт

Хүн төрөлхтний шашин шүтлэг итгэл бишрэлийн хөгжил хувирлын явц бол хүн ба байгаль ертөнц, тэрчлэн орчлонгийн нууцыг нээн судалсан явц тул шашин шүтлэгийн хувирал, итгэл бишрэлий солигдол бол хамгийн эцэстээ хүмүүсийн ойлголтоор тогтоогддог. Иймээс хүмүүсийн ойлголтын хэр хэмжээ адил бус болж, адил бусын шашин шүтлэг буй болох нь дамжиггүй. Бурхны шашин нь хэдэн мянган жилийн турш хүн төрөлхтний сонгодог соёлыг шингээсээр их бага арван ухаан болон хөгжин дэвжиж, дэлхийн гурван том шашны нэг болсон



мөртөө онолын систем нь агуулгын гүн ба өргөнөөр христос шашин хийгээд исламын шашнаас давсан гэдгийг тэнгэрийн хөвгүүн, ертөнцийн эзэн нь бурхны шашны номлодог “зургаан орон”-ы нэг нь байжээ.

Хүн төрөлхтний шашин шүтлэг итгэл бишрэл нь доод шатнаас дээд шат зүг, дотоод ертөнцөөс гадаад ертөнц зүг гүнзгийрсэн нь тодорхой билээ. Мөн бага хүчтэнээс их хүчтэн зүг, урт наснаас мөнхийн насны зүг дэвшсэн гэдгийг шүтлэгийн эзний орших орон зай ба хүч чадлаар нь гадарлаж болно. Бурхны шашин хэдийгээр энэтхэгээс үүсэлтэй гэх боловч гагц энэтхэг хүний шашин бус, бүх хүн төрөлхтний шашин байж, түүний маш олон ёс номлол нь хүн төрөлхтөн буй болохын зэрэгцээ оршин байсан үнэн ёс юм.

Жишээлбэл, “бодь сэтгэл”, “үйлийн үрийн харьцаа” зэрэг нь хүн төрөлхтний сонгодог соёлын өв хөрөнгө мөртөө бурхны шашнаас ч өмнө байжээ. Бурхны шашны монгол оронд уламжлагдахыг дагалдан монголчууд бодь сэтгэл ба үйлийн үрийн харьцаатай болсон гэж үзвэл тун инээдтэй явдал болно. Иймээс бурхны шашны соёл нь монголчуудын удамшилт соёл болох нь гарцаагүй үнэн юм. Монголчуудын өвөг дээдэс мунхагтаа бурхны шашныг шүтсэн бус, харин хүн төрөлхтний хөгжлийн жас ёс, итгэл бишрэлийн их хандлагыг зөв оновчтой танин мэдсэний суурин дээр хүлээн авч, хойч үедээ өв хөрөнгө болгосон юм.

Монголчууд амьтны ертөнцөөс дээдсийн онгод, дээд тэнгэрээс бурхны орон, мөнх бус ертөнцөөс мөнхийн ертөнц хүртэл шүтэхдээ ер нь харанхуй сохроор дагаж дэрэвсэнгүй, төрөө алдсан ч шүтээнээ орхисонгүй, амиа алдсан нь чанараа гутаасангүй билээ. Одоо бид амьдралын гачигдалд атга цай чимх давсанд бусдын шүтээнийг дулдуйдан, уран үг усан балинд шүтлэгээ сольж, хүн чанараа гээвэл шүтээнээ гомдоохоор барахгүй өвөг дээдэстээ ч зэмлүүлэх болно.

Дөрөв. Шашин шүтлэг итгэл бишрэлийн тоонолжин зам

Монголчууд мянган он шүтсэн бурхны шашин, өвөг дээдсээс өвлөж үлдээсэн уламжлалт соёлоо сэжиглэж гадуурхах, тэрчлэн гээж орхих нь нийтлэг үзэгдэл болж байна. Ардын үгэнд “дээл нь муу боловч дээдэс нь сайн” гэгчээр монголчуудын аж амьдралын хэр түвшин нь хөгжсөн улсын хэмжээнээс хоцорч байсан ч монголчуудын хүн чанарын соёл нь дэлхийн эгнээнд жагсаж байдаг.



Шүтээнээ сэжиглэж, соёлоо гээх нь үндэстний мөхөлд хүргэдэг. Учир нь соёлоо гээвэл суурьгүй болж, итгэлээ алдвал ирээдүйгүй болох нь ойлгомжтой юм. Талхигдал, самуурал, ухалтаас шалтгаалж маш олон хүмүүс өнөө чухам юуг итгэл бишрэлийн орон болгохоо олж ядан, итгэл бишрэлийн тонолжин зам дээр зүг чигээ олохгүй төөрөлдөж, христос шүтэгчдийн баян тансаг амьдрал, ислам шүтэгчдийн эрх зэрэг ямба ларжаа, бөө онгодын мэдэмхий мэргэлэгчдийн таргалан цатгалан амьдралын нь бахархаж, уугал шүтээндээ гоморхож тонолжин зам дээр мэдэмхийрч сууна.

Монголчуудын баян чинээлэг сайн сайхан амьдралыг зорьж, урт наслан удаан жаргахыг хүсэн мөрөөдөх нь зүй зохистой, гэтэл тансаг баян амьдралыг шүтээнээс өгдөг бус, харин өөрийн хичээл зүтгэлээр олдог гэдгийг мэдэх хэрэгтэй. Шашин шүтлэг итгэл бишрэл бол хүн төрөлхтний оюун санааны цамхаг, итгэл бишрэлийн төөрөгдөл бол итгэл бишрэл шүтээний төөрөгдөл бус, харин итгэн бишрэгчдийн оюун санааных нь мунхрал, хүн чанарынх нь доройтол мөн.

Итгэл бишрэлгүй хүмүүс бол хүн цогцод гинжлэгдсэн араатан буюу цаашилбал шулмасын гэж хэлэхэд илүүдэхгүй юм. Бурхны шашин нь энэтхэгээс үүссэн, төвөдөөр дамжин монгол оронд уламжлагдсан ч энэтхэгийн бурхны шашин бус, төвөдийн бурхны шашин ч бус, монголчуудын бурхны шашин болох нь дамжиггүй. Бурхны шашны ёс нь монголчуудын уламжлалт ёсонд уусаад, бурхны ёсонд монголчуудын ёсон агуулагдаж, монголчуудын ёсонд бурхны ёс уусан шимэгдэж, цул цэвэр бурхны ёсон, холимоггүй ертөнцийн ёсон гэж ялгахад бэрх юм. Учир нь бурхны шашин бол хүн төрөлхтний сонгодог соёлын өв дээр суурилсан хүний соёлын ухаан мөн.

Тав. Хүн чанарын доройтол

Хүн төрөлхтний дэвшил нь хүн цогцын гоо сайхан, аж амьдралын баян тансаг төдий л биш, нэн чухал нь хүн чанарын цэвэр дэвшил болох юм. Шашин шүтлэг итгэл бишрэлийн доройтол нь үнэндээ хүн чанарын бохирдол мөн. Монголчууд хэдэн мянган жилийн гэрэл цацарсан соёл түүхийн явцдаа, адгуус амьтнаас эхлэн эцэг дээдэс, хувилгаан сахиус, тэнгэр бурхынг хүртэл итгэлийн орон болгон шүтэн бишрээд, өнөө үед итгэл бишрэлд маш их өөрчлөлт үүсэн, цаашлаад ямар ч итгэл



бишрэлгүй болж, өөрийн хүн чанараа ч гээгээд, хүн гэхэд адгуусны чанартай, адгуус гэхэд хүн цогцтой үнэхээр этгээд сонин болж байна.

Бурхны шашны “хамаг амьтан зургаан зүйлийг бурхан болгох” гэдэг нь үнэндээ хамаг амьтны чанарыг бурхны чанар болгох гэсэн явдал болно. Хүн чанарын доройтол нь хүн төрөлхтний амар амгаланг эвдэн, доройтол мөхлийн замаар замнуулж, хүн чанарын дэвшил нь хүн төрөлхтний энх мэнд хөгжил дэвшлийг авч ирэн, цаашилбал мөнхрөлийн замд хөтөлдөг гэдгийг Зонхова номлосон гурван төрөлхтний мөрийн онолоос мэдэх боломжтой. Бурхны шашны үхэж төрөхийн учралын онолоор үзвэл, хүн чанарын дэвшил ба доройтлоор цогцын хэр хэмжээ тогтоогдож, бие цогцын үйлээр чанарын хувирлыг буй болгоно.

Хүн төрөлхтний хөгжлийн явц дахь амьдралын баян тансаг, боловсон сайхан ёс мораль, нийгмийн амар түвшин жич соёл зэрэг маш олон талын илрэл нь “хүн чанар”-ын сууриас салж чадахгүй юм. Хүн төрөлхтний ёс бус үйл ажиллагааг хялбар дөт ёс моралийн асуудал болгон үздэг ч үнэндээ ёс моралийн асуудлаар илэрсэн хүн чанарын асуудал мөн. Хүнээс хүний чанар илэрч, адгууснаас адгуусны чанар илрэх нь жам ёс боловч хүнээс адгуусны үйлдэл илрэх, адгууснаас хүний үйлдэл илрэх нь ч нийтлэг үзэгдэл болжээ. Хүн чанарын хувирлын жам ёсоор авч үзвэл, адгуусны чанар ч хүн чанар болон хувирч, хүн чанар ч адгуусны чанар болж хувирах нь бүр л тэдний ухаарал сэхээрэл ба мунхагийн шалтгаанаас буй болох билээ.

ДҮГНЭЛТ

Шашин шүтлэг итгэл бишрэл үүсэн буй болсон цагаас эхлээд маш олон салхи шуурган дундуур, нугачаа бүдрээг туулан, хүмүүсийн сэтгэлд гүн суугдсан ч тахигдал самууралд учирвал, ухралт төөрөгдөл үүсээд, цаашилбал доройтолд хүргэдэг байна. Шашин шүтлэг бол манай уламжлалт соёлын чухал бүрэлдэхүүн болохын хувьд судлан шинжилж, хоосон биширч мунхагаар шүтэхээс зайлсхийн, өвлөн залгамжилж, уламжлан бадруулах нь шинэ цаг үеийн үүрэг гарцаагүй мөн.



НОМ ЗҮЙ

1. “Сэцлэшгүй Зонхова бээр зохиосон Их бага бодь мөрийн зэрэг оршвой”, эртний модон барын судар
2. Ёнсог. “Монгол шашин суртахууны тойм”, ӨМАХХ 1991
3. Дорж Банзаров. “Харийн шашин буюу монголчуудын бөө мөргөл”, ӨМАХХ 2013
4. Буянбат. “Монголчуудын модны шүтлэг”, ӨМСХХ 2016
5. 释印顺：戒律学论集 中华书局 2010
6. 印度佛教汉文资料选编 北京大学出版社 2010
7. 释印顺：印度佛教思想史 中华书局 2011

ABSTRACT

From the time of the emergence of religion, many winds have blown through the storms, stumbled, and sank deep into the hearts of the people, but when worship is confused, it leads to backwardness, confusion, and even degradation. As an important component of our traditional culture, it is the duty of the new age to study, to avoid idolatry, and to inherit and perpetuate it.

Keywords: Religion, quality, degenerate

**ТОРГУУДЫН ИХ НҮҮДЭЛД ОРОЛЦСОН ХОШУУД АЙМАГ****Ү.Мөнхдагва*****ХУРААНГУЙ**

XIII жарны цагаан бар жилийн өвлийн адаг сард Торгууд тэргүүтэй Ойрад монгол аймгууд Ижил мөрний хөвөөнөөс Или буюу уугуул Зүүнгарын нутаг руугаа нүүв. Уг нүүдлийг “Нүүдэлчдийн сүүлчийн тив дамнасан их нүүдэл” хэмээн үздэг. Уг нүүдэл 6 сар үргэлжилсэн хүнд хүчир нүүдэл болжээ. Тус өгүүлэлд их нүүдэлд оролцсон Хошууд аймаг Ижил мөрөнд хэзээ очсон асуудал, Хошуудын зарим ноёдын хувь заяа, өрх амын тоо, Манжаас тэднийг нутаг зааж суулгасан зэрэг асуудлыг өөрт олдсон баримтын хүрээнд өмнөх судалгаануудад тулгуурлан тодруулахыг зорив. Ойрмогхон түүхч На.Сүхбаатар “1771 оны Торгуудаар тэргүүлсэн нүүдлийн төгсгөл, Манж чин улсаас захирсан бодлого”¹⁰⁰ хэмээх нэгэн бүтээл хэвлүүлж, шинэ баримт материалд үндэслэн өмнөх судалгаанд явж ирсэн зарим эндүү ташаа ойлголтыг залруулж, шинээр нүүдэлд холбогдох зарим асуудлыг авч үзсэн сонирхолтой судалгааг хийжээ.

Түлхүүр үгс: Торгууд, Хошууд, Манж, Их нүүдэл, Ижил мөрөн, Или гол

Нэг. Хошууд аймаг хийгээд Ижил мөрөнд очсон тухай

Урьдаар Хошууд аймгийн үүсэл, хөгжлийг товчхон байдлаар өгүүлэх нь зүйтэй болов уу. Хошууд нь Чингис хааны дүү Хавт Хасарын хойчисын албат харьяат бөгөөд XV зууны эхээр Ойрадын холбоонд орж, XVI-XVII зууны үед Ойрадын дотор хүчирхэгжиж, Ойрадын чуулганыг тэргүүлэх болов. Дөрвөн ойрадын холбоо түүхэндээ гурван удаа зохион байгуулагдаж байжээ. 1437-1502 оны хоорондох анхан Дөрвөн ойрадын холбоог Тогоон тайш анхлан байгуулсан гэж судлаачид үздэг. Дунд дөрвөн ойрадын холбоо нь Хошууд, Торгууд, Цорос болон Дөрвөд, Хойд аймгуудаас бүрэлдэж, 1630-аад оныг хүртэл оршиж байжээ. Сүүлийн

* Түүхийн ухааны докторант, АШУУИС-ийн багш.

¹⁰⁰ “Acta Historica Mongolica”. Tomus . XXII.УБ., 2021. Тал 80-107



дөрвөн ойрадын чуулган дотроо зүүн, баруун хоёр гар болж байв. Зүүн гарт Цорос, Дөрвөд аймаг, Баруун гарт Хошууд, Хойд аймаг багтаж байсан нь Зая бандидын намтар “Сарны гэрэл”¹⁰¹ -ийн агуулгаас мэдэгддэг. Энэ дунд болон сүүлийн Дөрвөн ойрадын холбоог “хан” цолтон удирдах болж, чуулган хийж хүчирхэг овог аймгийн ноёдоос нэгийг сонгодог байв.

XVI зууны дунд үед Эсэн хаан нас барж, Цорос аймаг доройтон, Хошууд аймаг хүчирхэгжиж, тэдний ноёд Ойрадын чуулганыг “хан” цолтойгоор захирах болжээ. Хошуудууд Бүүвэй Мирзээс эхлэн Дөрвөн Ойрадын чуулганы ахалж, Хан ноён Хонгор, Байбагас, Гүүш хан, Очирт цэцэн хан зэрэг таван хүн хан цолтойгоор захирч, Ойрадын түүхэнд чухал нөлөө үзүүлжээ. XVI зууны сүүл XVII зууны эхээр Ойрад монголчууд газар нутгаа өргөтгөх хийгээд өөр бусад шалтгаанаас болж гадагш нүүдэллэх болов.

Урьдаар Ижил мөрөнд хүрсэн Хошуудууд хэзээ нүүдэллэж очсон тухай асуудлыг авч үзье. “Хо өрлөгийн түүх”-д *“Хо өрлөг Баатар хунтайжид Эмээл, Ховогсайраас өөрийн харьяат нэг түмэн таван мянган өрхийг дагуулан Орын ганц модон гэх газар очиж, тариа тарьж амар тайван амьдрах тухайгаа хэлж нүүсэн ба аажмаар хүн мал нь өсч, Ижил Зайд очиж нутаглав”*¹⁰² гэжээ. Хо өрлөгийн хамт Хошууд ноён Хөндлөн увшийн гуравдугаар хөвүүн Дорж тайж, дөрөвдүгээр хөвүүн Эрх дайчин Зодов нар өөрсдийн харьяат Хошуудыг дагуулан Ижилд хүрчээ¹⁰³. Үүнээс үзвэл анх 1630 оны орчим Хо өрлөгийн тэргүүлсэн Торгуудууд баруун тийш нүүдэллэх үед нэг хэсэг Хошуудууд тэднийг дагаж Ижилд хүрсэн ба хүний амын тоо цөөн байжээ.

Зүүнгарын Баатар хунтайж нь арван хөвүүнтэй бөгөөд Буруд хатнаас Цэцэн, Зодов баатар нарын найман хөвүүн төрж, Торгуудын Хо өрлөгийн охин Юм Ахай хатнаас Сэнгэ, Галдан хоёр төрсөн билээ. Тэрээр Сэнгэ, Галдан хоёрыг бусад хөвүүдээсээ илүүд үзэж байсан бололтой. Тухайлбал, Галданг Энса хутагтын хувилгаан хэмээн Төвдөд явуулж, Далай лам, Банчин богд нараас ном эрдэмд суралцуулж, Сэнгэд Дөрвөн ойрадын чуулганы захирагч Очирт цэцэн ханы ач охиныг хатан болгон авч өгч түүний байр суурийг бататгаж байв. Мөн тэрээр нас

¹⁰¹ На.Сүхбаатар. Зая бандида Намхайжамцын намтрын судалгаа. //Bibliotheca oiratica-SI. УБ., 2018

¹⁰² Хо өрлөгийн түүх. Ойрад монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд-II. Эмхэтгэж, тайлбарласан На.Сүхбаатар. УБ., 2001. т 157

¹⁰³ Хошуудын түүх, соёлын судлал”. Эмхэтгэсэн На.Басан, Бу. Мөнхөө, Г.Лижээ. Шинжааны ардын хэвлэлийн хороо. 1999. т 111



барахаасаа өмнө өмч хуваахдаа бүх албатын хагасыг тавдугаар хөвүүн Сэнгэд, бусад олон хөвүүддээ тэн хагасыг нь хувааж өгчээ. Энэ тухай сурвалжид *“Баатар хунтайж улсаа хоёр хийгээд, нэгийг нь нэг хөвүүндээ өгөв, нэгийг нь найман хөвүүндээ өгөв”*¹⁰⁴ гэжээ. Энэ нь мөн чанар дээрээ байр сууриа Сэнгэд өгөх гэсэн санаа байжээ. Тус явдал нь Цэцэн, Зодов баатар нарын дургүйцлыг хүргэсэн бололтой.

Баатар хунтайж нас барсны дараа Сэнгэ нь Очирт цэцэн ханы дэмжлэгээр суурийг залгамжлан бүхий л Зүүнгарыг захирах болсон боловч өмчөөс болсон зөрчил тэмцэл улам ширүүсэв. Эцэстээ Зүүнгар аймаг зүүн, баруун хоёр ангид хуваагдаж, Сэнгэ, Цөхүр увш тэргүүтэн баруун анги, Цэцэн, Зодов баатар тэргүүтэн зүүн анги болов. Энэхүү тэмцэлд Хошууд аймаг ч татагдан орж, угаасаа хоорондоо зөрчилтэй байсан Очирт цэцэн, Авлай тайж нар тус тус баруун зүүн ангийг дэмжиж, зөрчил тэмцэл нь бүх Ойрадыг хамарсан дайн болон хувирчээ.

1659 онд хоёр тал Эмээл орчим байлдаж, Сэнгээр удирдуулсан баруун анги нь Очирт цэцэн ханы дэмжлэгээр ялалт олов. 1660 онд чуулган дарга байсан Очирт цэцэн хан *“Тархай хар хужир”* гэдэг газарт бүх Ойрадын чуулган чуулж, зөрчлийг түр намдаасан ч, Очирт цэцэн болон Авлай тайж хоёрын хоорондох зөрчил улам ширүүсч, 1661 онд хоорондоо байлдаж, дайнд Авлай ялагджээ. Энэ дайнд Хөндлөн увш хөвүүнтэйгээ Авлайг дэмжиж байсан ч, Авлай ялагдахдаа зэрэгцэн харьяат албатаа дагуулж баруун тийш нүүдэллэж Зай мөрний сав газар очиж суух болжээ. Энэ тухай *“Торгууд хаадын тууж”* сурвалжид *“Торгуудын Пунцаг хааны үед Хошууд ноён Хөндлөн увш 3000 өрх албатаа дагуулан Ижилд хүрчээ”*¹⁰⁵ гэсэн тэмдэглэл бий.

Зүүнгарын ноёдын өмчийн асуудлаас болсон үймээнд Сэнгэ алагдаж, Төвдөд лам болж байсан Галдан буцаж ирж Хошуудын Очирт цэцэн ханы дэмжлэгтэй Зүүнгарыг захирах болов. Түүний сүр хүч өсч Зүүнгарын олон аймгийг нэгтгэсний дараа, бүх Ойрадыг нэгтгэхээр зорьж, Очирт цэцэн хан харьяат Хошууд аймгийг дайлжээ. Энэ тухай сурвалжид *“Бошогт хаан луу жил(1676) цагаан сарын хорин дөрвөнд Зайрын Тэмээн хүзүүг даван довтолж Цэцэн хаан үргэн дутаав. ...Тэндээс Доржравдан Аюукийн элчтэй дутааж Боомтын эхэнд хүрч ирж Ижилийн Торгууд тал явъя хэмээж, Ачит цоржийн*

¹⁰⁴ Гаваншарав. Дөрвөн ойрадын түүх. Эрхлэн хэвлүүлсэн На.Сүхбаатар //Bibliotheca orientalis-СН. УБ., 2021.т 44

¹⁰⁵ Торгууд хаадын тууж. Ойрад монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд-I. Эмхэтгэж, тайлбарласан На.Сүхбаатар. УБ., 2001. т 157



хамт одов. Тус жилийн өвлийн дунд сард Шар бэлээс Цэцэн хааныг оруулж авав”¹⁰⁶ гэжээ. Дайны үр дүнд Очирт цэцэн хан ялагдаж, түүний харьяат ард нь бутран сарниж, нэг бүлэг албат нь Очирт сэцэний хатан Доржравданы хамтаар Ижил рүү нүүдэллэж явжээ.

Манж-Зүүнгар улсын дайны хөлөөс зугатан Хошууд, Хойд болон бусад аймгуудаас цөөн тоогоор Ижил мөрөн рүү хүрчээ. Сурвалжид “Манж Чин улс Зүүнгарын хаант улсыг дайлан төвшитгөх явцад, дайнаас зугатааж харьяат албатаа дагуулан Ижил рүү очсон Торгуудын Шээрэн, Хойдын Дэжид, нэг хэсэг Хошууд”¹⁰⁷ гэсэн тэмдэглэл бий. Мөн “Тэнгэрийн тэтгэсний 22 (1757) оны 8 сард Амарсанаагийн бослогын дараахан Хошуудын хан болсон Бархөлөөр нутаглаж байсан Шагдарманжийн зуу илүү албат оргон гарч, Борталын голыг гаталж, баруун зүг одов”¹⁰⁸ гэжээ.

Энэ бүхнээс үзвэл Хошууд нар Ижил мөрөн рүү нүүдэллэсэн үндсэн шалтгаан нь дотоодын зөрчил тэмцэл хийгээд харь улсын түрэмгийлэлтэй холбож үзэж болохоор байна. Дөрвөн удаагийн нүүдлээр Ижил мөрөнд хүрсэн болох нь тодорхой мэдэгдэж байна.

Хоёр. Манжийн төрөөс нүүдлээс ирсэн Хошууд нарт явуулсан бодлого

Түүхч На.Сүхбаатар Их нүүдлийн зорилго, нүүдэлсэн эхэлсэн цаг хугацаа, зам мөр, оролцогчдын тоо, орос манжийн бодлого зэргийг олон хэлний сурвалжийн мэдээнд тулгуурлан нэгэнт тодруулжээ. Тэрээр “... уг нүүдлийг 1763 оны үед хэлэлцэж тогтсон. 1771 оны 1 сарын 17-нд нүүдэл эхлэж, 7 сарын 8 нд Илийд ирсэн. Тэдний зорилго нь “Илийн нутгийг эзлэн авах” байсан учраас цагийн байдалд тохирсон бодлогыг Манжууд баримталсан ба ивээгч асран хамгаалагчийн дүрээр нүүдэлчидтэй харилцаж, тэднийг доройтуулан сөхрүүлж, эрэмгий дайчдаас эгэл тариачин болгоход бодлогоо чиглүүлж байсан”¹⁰⁹ гэх зэргээр маш олон шинэ асуудлыг нөхвөрлөсөн судалгааг хийжээ. Бид нүүдэлд оролцсон Хошууд аймгийн өрх амын тоо, зарим ноёдын хувь

¹⁰⁶ На.Сүхбаатар. Зая бандида Намхайжамцын намтрын судалгаа. //Bibliotheca oiratica-SI. УБ., 2018. т 119-121

¹⁰⁷ Тод үсгийн сурвалж бичиг. “Халимаг хаадын тууж”- д. Бадай, Эрдэнэ, Алтан-Оргил эмхтгэн тайлбарласан “Ойрадын түүхэн сурвалж бичиг”. ӨМСХХ. 1985. т 353.

¹⁰⁸ О.Оюунжаргал. Шинэ хошууд хошуу байгуулагдсан тухай. //Bibliotheca oiratica-LXXXVIII. УБ., 2018

¹⁰⁹ “Acta Historica Mongolici”. Tomus . XXII. УБ., 2021. т 102



заяа, Манжаас тэднийг нутаг зааж суулгасан зэрэг асуудлыг тодруулахыг зорино.

- Хошуудын өрх амын тухай

Анх Хошуудууд Ижил мөрний хөвөөнөөс хөдлөх үед 2000 гаруй өрхийн 10000 гаруй хүн байсан бололтой. “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772) бүтээлд багтсан айлтгалаас үзвэл *“Бас байцаавал, эдүгээ ирсэн эдний албат ард үлэмж, Илийн тойрон газарт түр суулгахад мөн багтаж чадахгүй бөгөөд хүнсгүй, эдүгээ өлсгөлөнд нэрвэгдсэн нь нэлээд буй. Эхлээд хүнс залгамжлуулж бид авч, заасан газарт илгээж суулгавал сая тус. Тэдний хүний тоог асуувал, угаас ирэхэд торгуудын ард их төлөв 30 хэдэн мянган өрх 150 мянга гаруй ам билээ. Хошуудын ард 2000 гаруй өрх 10 мянга гаруй ам билээ. ...”*¹¹⁰ гэж Ижилд байх үеийн өрх амын тоог мэдүүлжээ. Үүнээс нүүдлийн явцад үрэгдэж Илид хүрч ирэхэд Хошуудын өрх ам 1500 гаруй өрхийн 6000 гаруй хүн буцаж иржээ. Энэ тухай *“... Тайж Гүнгэгийн албат 762 өрх 3158 ам, Яримпилын 244 өрх 1161 ам, Ноохайн албат 104 өрх 460 ам, Багбан (bakban)-ы албат 67 өрх 286 ам, Мөнгөний албат 74 өрх 276 ам, Баярлахын албат 60 өрх 274 ам, Занашир (janasiri)-ийн албат 41 өрх 149 ам, Жавзаны албат 40 өрх 125 ам, Бадам (batma)-ын албат 34 өрх 156 ам, Номхоны албат 21 өрх 73 ам, Бабулдаг (babuldak)-ийн албат 26 өрх 58 ам, Түгүл (tugul)-ийн албат 14 өрх 38 ам, Ноён гэлэний албат 10 өрх 48 ам, Баатарын албат есөн өрх 41 ам, Лувсаны албат долоон өрх 35 ам, Чурум (cigum)-ын албат таван өрх 17 ам. Үүнээс дээш бүгд 1518 өрх 6350 ам”*¹¹¹ хэмээн мэдүүлжээ.

**- Их нүүдлийн дараа Хошуудын зарим ноёдын хувь заяа
Тайж Яримпил**

Их нүүдэлд оролцогч Хошууд нарыг ахалсан ноёдын нэг бол тайж Яримпил юм. Түүний гарал угсааг “Илтгэл шастир”-т *“... Засаг төрийн Түшээт бэйл Гүнгэ-ийн төрлийн өвөг. Үүний элэнц өвөг Эрх дайчин Огцотбу. Хөндлөн убашийн дөрөвдүгээр хөвгүүн мөн. Түүнээс хоёр хөвгүүн төрөв. Ахмад хөвгүүн Цагаан. Хоёрдугаар хөвгүүн Тарва.*

¹¹⁰ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca oiratica-CIX.УБ., 2021. Тал 70. Айлтгах нь, Илт, Шүхэдэ нарын айлтгал. 1771.07.01

¹¹¹ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca oiratica-CIX.УБ., 2021. т 121



Цагааны хөвгүүн /6b/ Санжрааш (三济拉什)-аас хоёр хөвгүүн төрөв. Ахмад хөвгүүн даруй Ярампил мөн”¹¹² гэжээ.

Тэрээр Нүүдэлд оролцогч ноёдоос хамгийн ахмад настай нэгэн байжээ. Түүний нас бусад ноёдоос ахимаг байсныг дараах баримтаас мэдэж болно. Айлтгалд “... Хуучин Торгуудын тайж Увш 28 нас, Цэвэгдорж 38 нас, Эмгэн увш 34 нас, тайж Бамбарын хөвүүн Дамбайжалцан 21 нас, тайж Момонт 40 нас, лам Лувсанжалцан 43 нас. Шинэ Торгуудын Шэрэн 43 нас, Луузанжав 36 нас, Шархүүхэн 18 нас, Дэлдэс 36 нас. Хошуудын тайж Яримил 61 нас, Гэндэнноров 25 нас. Цоросын тайж Сандагийн хөвүүн Кэнээ 27 нас. Үүнээс дээш тайж 12, лам нэг”¹¹³ гэжээ. Мөн тэрээр увшийн сахил хүртэн Жанжаа хутагтыг дагалдан лам болжээ. Энэ тухай “... Сайд Фүлүнга, зарлигийг даган Яримпилын дуртайяа лам болсугай хэмээх явдлыг Жанжаа хутагтад хэлж, Увш нарыг дуудан аваачиж, тэдний өмнө Яримпил дуртайяа Жанжаа хутагтыг даган лам болсугай хэмээх явдлыг бидний биес уламжлан айлтгасанд, эзний зарлиг Яримпил чин биширэн үнэнч санаагаар лам болсугай хэмээхийг даган хишиг хүртээн түүний бэйсийн зэргийг түүний хөвүүнд залгамжлуулж Яримпилыг засаг лам болгож Жанжаа хутагтыг дагалдан суутугай хэмээснийг хичээнгүйлэн даган Яримпилд ухуулан буулгасанд, Яримпилын үг, энэ их эзний хишиг, би машид дуртай хэмээн сүслэн баярлах бөгөөд Увшийн зэрэг ард мөн цөм баярлалцах төлөв үзүүлжээ. Үүнд хутагтад хэлж Яримпилыг сахил авахад, хутагтын үг, гэлэн гэцэлийн сахил авбаас сайн өдөр сонгоогүй бөгөөд хамаг бүрдэл үгүй, завдахгүй. Түр увшийн сахил өгсүгэй хэмээж даруй Яримпилыг гэрийн дотор оруулж ном дуудан увшийн сахил өгчээ”¹¹⁴. Тэрээр Ирид ирсний дараа Манжийн хаанд бараалхахаар одож “Амирлангуй бэйс”-ээр өргөмжлөгджээ. Засан тогтоосон өргөмжилвөөс зохих Торгууд, Хошуудын зэрэг тайж нарын аймгийн нэр, хан, ван, бэйл, бэйс, гүн, тайж нарын хуудас дотор “Хошуудын тайж Яримпил, бие ирэв, үүний албат угаас 300 гаруй өрх 1000 гаруй ам билээ, эдүгээ Или голыг

¹¹² Зарлигаар тогтоосон Гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир, 107 дэвтэр Засаг хошууны Амирлангуй бэйс Яримпилийн олдворын шастир. //Bibliotheca oiratica-ХСІХ.УБ., 2020. т 214

¹¹³ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca oiratica-СІХ.УБ., 2021. т 78. Айлтгах нь, Илт, Шүхэдэ нарын айлтгал. 1771.07.14

¹¹⁴ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca oiratica-СІХ.УБ., 2021. Тал 127. “Хошуудын тайж Яримпилд увшийн сахил хүртээж Жанжаа хутагтыг дагалдуулан суулгасан тухай айлтгал 1771.10



гаталсан нь 244 өрх 1161 ам, зарлигаар Амирлангуй бэйс өргөмжлөв”¹¹⁵. Түүний хэргэмийг хөвүүн нь залгамжилжээ. “Илтгэл шастир”-т түүний залгамжийг дараах байдлаар харуулжээ. Хошуудын засаг төрийн Амирлангуй бэйс Доржнамжилын хошуу¹¹⁶-ны хүснэгтэд Яримпилээс Доржнамжилыг хүртлэх үе сүлжлийг харуулжээ.

№	Засаг ноён	Залгамжилсан он	Тайлбар
1	Ярампил	1771-1771	Язгуурын байгуулсан
2	Буянцог	1773-1790	Ярампилын ахмад хөвгүүн
3	Очир	1790-1812	Буянцогийн дүү
4	Бадамцэрэн	1812-1814	Очирын ахмад хөвгүүн
5	Пурпу	1814-1814	Батмацэрэнгийн ахмад хөвгүүн
6	Цэдэндорж	1814-1841	Пурпугийн хөвгүүн
7	Доржнамжил	1841-	Цэдэндоржийн хөвгүүн

Тайж Гэндэнноров. Их нүүдэлд оролцогч Хошууд нарыг ахалж ирсэн ноёдын нэг бол тайж Гэндэнноров юм. Түүний гарал угсааг “Илтгэл шастир”-т дараах байдлаар тэмдэглэжээ. “Хавт Хасарын хорин дөрөвдүгээр үеийн ач. Түүний хуланц өвөг Дорж. Хөндлөн убашийн гуравдугаар хөвгүүн мөн. Түүнээс дөрвөн хөвгүүн төрөв. Нэг нэр Тороших (托罗什瑚), нэг нэр Цагун (察衮), нэг нэр Өвгөн, нэг нэр Ахай. Аль ахмад ба хоёрдугаар агсаныг байцаах тэмдэггүй. Торошихоос дөрвөн хөвгүүн төрөв. Ахмад хөвгүүн Чүгүй (楚贵). Хоёрдугаар хөвгүүн Дондог. Гуравдугаар хөвгүүн Маргас (玛尔噶斯) /2а/ дөрөвдүгээр хөвгүүн Тарвацэрэн. Чүгүйгээс хоёр хөвгүүн төрөв. Ахмад хөвгүүн Тэх (特克), хоёрдугаар хөвгүүн Тугч (图克齐). Тэхээс нэг хөвгүүн төрөв, нэр

¹¹⁵ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca oiratica-С.УБ., 2021. т 129. Засан тогтоосон өргөмжилвөөс зохих Торгууд, Хошуудын зэрэг тайж нарын аймгийн нэр, хан, ван, бэйл, бэйс, гүн, тайж нарын хуудас. 1771.10

¹¹⁶ Зарлигаар тогтоосон Гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир //Bibliotheca oiratica-С.УБ., 2020. т 185



Сархаг (薩尔哈克). Тугчаас хоёр хөвгүүн төрөв. Ахмад хөвгүүн Гэндэнноров”¹¹⁷ гэжээ.

Түүний албат өрхийн тоо бусад ноёдоос хамгийн их байжээ. Тэрээр Ирид ирээд халуун хижиг өвчин тусч хүндээр өвдөн улмаар нас барсан бололтой. Тэрээр харьцангуй залуу хүн бөгөөд 25 настай байжээ. Энэ тухай *“Боол бидний заан гаргасан Хошуудын тайж Гэндэнноров халуун хижиг өвчин олж хэвтээд явж чадахгүй учир түүний дүү Гүнгээг түүний оронд эзний гэгээнийг бараалхан илгээсүгэй хэмээн гуйн хэлмүй. Боол бид үзвэл, Гэндэнноров өвдсөн нь үнэн. Иймд гуйсан ёсоор түүний дүү Гүнгээг авч аваачих явдлыг хичээнгүйлэн сонсон айлтгав”*¹¹⁸ гэжээ. Нас барсан Гэндэнноровыг түүний дүү Гүнгээ залгамжилжээ. Гэндэнноровт нэг хөвүүн байсан бөгөөд нас бага учир дүүд нь залгамжлуулжээ. Засан тогтоосон өргөмжилвөөс зохих Торгууд, Хошуудын зэрэг тайж нарын аймгийн нэр, хан, ван, бэйл, бэйс, гүн, тайж нарын хуудаст *“Гүнгээг бэйл өргөмжилмүй, Хошуудын тайж Гэндэнноров өвдөн үгүй болов, оронд түүний дүү Гүнгээ ирэв, үүний албат угаас 1000 гаруй өрх 5000 гаруй ам билээ, эдүгээ Или голыг гаталсан нь 762 өрх 3158 ам, зарлигаар Бат сэтгэлт Хошууд аймгийн Түшээт бэйл өргөмжлөв. Өмнөн сайд бидний газраас Гэндэнноров өвдөн үгүй болов, түүнд нэг хөвүүн буй боловч нэрийг мэдэхгүй, түүний дүү Гүнгээ ирж тодорхойлон асууж, эсвэл түүний хөвүүнд залгамжлуулах, түүний дүүд залгамжлуулах явдлыг зарлигийг хүлээсүгэй хэмээн айлтгасан билээ. Эдүгээ Шүхэдэгийн айлтгасан хуудсанд Гэндэнноров, Гүнгээгийн нэрийн доор албат огт ялгасангүй хэмээн бичсэн бөгөөд эфү Сэвдэнбалжир бас Гэндэнноровын хөвүүн сая хоёр нас, Гүнгээ даруй тэдний аймгийн ихээхэн тайж хэмээснийг даган Гэндэнноровын бэйлийн зэргийг даруй Гүнгээд залгамжлуулсугай”*¹¹⁹ хэмээжээ.

¹¹⁷ Зарлигаар тогтоосон Гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир, 107 дэвтэр Засаг төрийн түшээт бэйл Гүнгээгийн олдворын шастир. //Bibliotheca oiratica-XCIX.УБ., 2020. т 213

¹¹⁸ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca oiratica-CIX.УБ., 2021. т 78 Шүхэдэ нарын айлтгал. 1771.07.11

¹¹⁹ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca oiratica-CIX.УБ., 2021. т 128. Засан тогтоосон өргөмжилвөөс зохих Торгууд, Хошуудын зэрэг тайж нарын аймгийн нэр, хан, ван, бэйл, бэйс, гүн, тайж нарын хуудас. 1771.10



Тайж Мөнгөн

Их нүүдэлд оролцогч Хошууд ноёдын нэг тайж бол Мөнгөн юм. Зүүнгарын Хошууд ангийн ноён Шагдарманжийн төрлийн хүн бөгөөд Шагдарманж Манжаас урвах үед түүний зайсан нар Торгуудын Шээрэнд хүргэж, тэдний хамт Ижил рүү одсон ажээ. Энэ тухай айлтгалд “Байцаавал, хошуудын ардын дотор хошуудын тайж Мөнгөн, түүний дүү Хайрт (*hairtu*) хэмээх хүн буй. Эднийг байцаалган зарсан Асха, Саршан нарын мэдүүлэн ирсэн бичигт, байцаан асуувал Мөнгөн хошуудын тайж Шагдарманж (*šakdur manji*)-ийн ойр төрлийн хоёрдугаар хөвүүн, түүний эцэг Бархөлийн газарт өвдөн үгүй болов, Шагдарманжийн хэрэгт түүний зайсангууд түүнийг дүүгийн хамт аваачин оргож, замд Шэрэнтэй учирч дагалдан Торгуудад орсон тэр үед Мөнгөн 4, 5 нас, түүний дүү Хайрт 2, 3 нас билээ хэмээн мэдүүлэн иржээ. Мөнгөн ирж асуувал, Мөнгөн энэ жил 18 нас, дүү Хайрт 16 нас, угаас нааш ирэхэд доорх албат 100 гаруй өрх билээ, эдүгээ ирсэн түүний албат 110 шахам өрх 450 гаруй ам буй. Мөнгөн ах дүү хэдий Шагдарманжийн ойр төрөл боловч, Шагдарманж нарын хэрэгт цөм бага хүүхэд, эдүгээ эзний өршөөл соёлыг хүсэн түүний албатыг авч гуйн даган ирснийг даган мөн Шэрэн, Луузанжавын адил газар зааж суулгавал зохимуй. Мөнгөний ах дүү хошуудын хүн учир басхүү боол бид сая айлтгасан ёсоор хошуудын ардын хамт Эрээн хавиргын Гурван жаргалангийн газарт суулгах тоонд оруулж илгээх явдлыг хичээнгүйлэн сонсгон айлтгав”¹²⁰ гэжээ. Түүний уг гаралын талаар Баатар увшийн “Дөрвөн Ойрадын түүх” сурвалжид “Ханай ноён Хонгор →Дүүргэч убаш →Хэлэв Далай Убаш →Луузан →Мөнгөн, Хайрт”¹²¹ хэмээн тэмдэглэжээ.

Манжаас Мөнгөнийг Торгуудын бэйс Шархүүхэний хошуунд оруулан захируулжээ. Удалгүй Мөнгөн нас барав. Түүний хөвүүн Буянхишиг түүний хэргэмийг залгамжилж, засаг тэргүүн зэргийн тайж болжээ. 1796 онд бие даасан хошуу болов. Энэ тухай “Илтгэл шастир”-т “Хошууд засаг тэргүүн тайж Буянхишиг. Хошууд хүн. Эцэг тэргүүн зэрэг тайж Мөнгөн. Тэнгэрийн тэтгэсэний гучин долоодугаар (1772) онд харьяат ардаа удирдан дагаж ирсэнд, Торгуудын бэйс Шархүүхэний хошуунд хавсаргав. Гаозун бүрдэлт хуанди сумын занги шагнаж,

¹²⁰ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca orientalis-CIX.УБ., 2021. т 76. Илт, Шүхэдэ нарын айлтгал. 1771.07.11

¹²¹ Баатар увш. “Дөрвөн Ойрадын түүх”. Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд III, УБ., 2002, т 176-177.



зарлигаар түүнд хавсарган суулган, Мөнгөн удалгүй үгүй болов. Тавин долоодугаар он (1792), Шархүүхэний харьяат ардыг харгислан хорлосон хэргийг сонсгон айлтгасанд, хишиг хүртээж зарлиг буулгаад, Дөрвөдийн ойролцоо газарт нүүлгэн малжуулав. Сайшаалт ерөөлтийн анхдугаар он, Мөнгөний эхнэр Чаян (察彦) Буянхишигийг дагуулан Ховдын хувийн сайд Гончигжавд, түүний харьяат ард төрсөн нь өдөр удаж зуун тавин хүнд хүрэв. Гуйх нь засгийн тамга, мөнгө өгч захируулах ажааму хэмээснийг Гончигжав сонсгон айлтгасанд, Гадаад монголын төрийг засаг явдлын яамнаас хэлэлцэж, “харьяат ардыг нэг сумын болгон найруулж, сумын занги нэг, орлон хөөгч нэг тавиад, Буянхишигт Дөрвөдийн ёсоор засгийн тамга өг, хоол цалингүй” хэмээсэнд, зарлиг “хэлэлцсэн ёсоор болго” хэмээв. Долоодугаар он, хааныг дагаж мураны авд очсонд, отго шагнан хадуулав”¹²² гэжээ.

- **Манжийн хаанд бараалхан очсон, очоогүй Хошуудын бусад ноёдод цол хэргэм шагнасан тухай**

Хэвээр туслагч гүн өргөмжилмүй, Хошуудын тайж Ноохай, ирсэнгүй, үүний албат угаас 256 гаруй өрх 1400 гаруй ам билээ, эдүгээ Или голыг гаталсан нь 104 өрх 460 ам, зарлигаар туслагч гүн өргөмжлөв.

Хэвээр засаг тайж өргөмжилмүй. Хошуудын тайж Багбан, ирсэнгүй, үүний албат угаас 140 өрх 700 гаруй ам билээ, эдүгээ Или голыг гаталсан нь 150 гаруй өрх 450 гаруй ам, эдүгээ Или голыг гаталсан нь 77 өрх 286 ам, засаг тэргүүн зэрэг тайж болгомуй.

Хэвээр засаг тайж өргөмжилмүй. Хошуудын тайж Мөнгөн, ирсэнгүй, үүний албат угаас 140 өрх 700 гаруй ам билээ, эдүгээ Или голыг гаталсан нь 100 гаруй өрх 500 гаруй ам, эдүгээ Или голыг гаталсан нь 74 өрх 266 ам, засаг тэргүүн зэрэг тайж болгов.

Хэвээр засаг тайж өргөмжилмүй. Хошуудын тайж Баярлах, ирсэнгүй, үүний албат угаас 140 өрх 700 гаруй ам билээ, эдүгээ Или голыг гаталсан нь 100 гаруй өрх 500 гаруй ам, эдүгээ Или голыг гаталсан нь 60 өрх 274 ам, засаг тэргүүн зэрэг тайж болгов.

Өмнөн тогтоосноос дордуулж сул тэргүүн зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Занашир, ирсэнгүй, үүний албат угаас 100 гаруй өрх 500 гаруй ам байсан учирт засаг тэргүүн зэрэг тайж болгосон билээ. Эдүгээ түүний Или голыг гаталсан албат 41 өрх 149 ам, амын тоо 200-д

¹²² Зарлигаар тогтоосон залган зохиосон Гадаад мужийн Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн шастир, Дэвтэр арав, Шастирын аравдугаар//Bibliotheca oiratica-С.УБ., 2020. т 52



хүрсэнгүй, засаг тайж болговоос хэтрэхийг даган сул тэргүүн зэрэг тайж болгосугай.

Угаас нэр үгүй, сул тэргүүн зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Жавзан, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат 40 өрх 125 ам, амын тоо Занашир нарт адилшаахыг даган мөн сул тэргүүн зэрэг тайж болгосугай.

Угаас нэр үгүй, сул тэргүүн зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Бадам, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат 34 өрх 156 ам, амын тоо Занашир нарт адилшаахыг даган мөн сул тэргүүн зэрэг тайж болгосугай.

Хошуудын тайж Галданноров, өвдөн үгүй болов. Үүний албат угаас 41 өрх 150 ам байсан учир түүнийг сул тэргүүн зэрэг тайж болгосон билээ.

Угаас нэр үгүй, дэд зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Номхон, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат 21 өрх 73 ам, амын тоо Ерины тоонд адилшаахыг даган дэд зэрэг тайж болгосугай.

Угаас нэр үгүй, гуравдугаар зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Бабулдаг, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат 16 өрх 58 ам, амын тоо цөөн болсныг даган гуравдугаар зэрэг тайж болгосугай.

Угаас нэр үгүй, гуравдугаар зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Ноён гэлэн, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат 10 өрх 48 ам, амын тоо цөөн болсныг даган гуравдугаар зэрэг тайж болгосугай.

Угаас нэр үгүй, гуравдугаар зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Баатар, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат есөн өрх 41 ам, амын тоо Сандагийн албатын тоонд адилшаахыг даган гуравдугаар зэрэг тайж болгосугай.

Угаас нэр үгүй, дөрөвдүгээр зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Төгөл, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат дөрвөн өрх 38 ам, амын тоо нэн цөөн болсныг даган дөрөвдүгээр зэрэг тайж болгосугай.

Угаас нэр үгүй, дөрөвдүгээр зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Лувсан, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат долоон өрх 30 ам, амын



Занамын албатын тоонд адилшаахыг даган дөрөвдүгээр зэрэг тайж болгосугай.

Угаас нэр үгүй, дөрөвдүгээр зэрэг тайж болгомуй. Хошуудын тайж Чурум, ирсэнгүй, Шүхэдэгийн уг айлтгасан хуудсанд үүний нэр үгүй, шинэ айлтгасан хуудсанд үүний албат 17 ам, амын тоо нэн цөөн болсон боловч дөрөвдүгээр зэрэг тайжаас доош, жич дордуулваас зохих зэрэг үгүй, дөрөвдүгээр зэрэг тайж болгосугай¹²³ хэмээн дагаар ирсэн Хошуудын олон ноёдод хэргэм зэрэг шагнажээ.

- **Хошуудын ардыг нутаг заан суулгасан тухай**

Манж нар Торгууд тэргүүтэй Монголчуудыг нутаг заан суулгахдаа хооронд нь холбоо бариулахгүйн тулд тархааж, тусгайлан цагдах сайд томилж байсан баримтууд бий. Манж нар Торгууд нарыг 1771 оны өвөл Или-ээс Зайр, Эрчисийн чиглэлд нүүлгэж, 1772 оноос эхлэн жинхэнээр тархаан суулгасан билээ. Манжууд энэ бодлогоо “Салган тохируулж, хүчийг нь бууруулах гэж томъёолжээ”¹²⁴.

Хошуудын 6000 гаруй хүн ардыг хаана суулгах болсон асуудлыг Шүхэдэгийн айлтгалд үндэслэн авч үзье. Айлтгалд “... Хошуудад хүнс залгамжлуулах хямдыг бодож энэ өвөл Гурван жаргаланд түр суулгаж хойт жил ногоо гарсны хойно боолын санаанд Гурван Жаргалангаас ойр ташрамыг үзэн эдүгээ хүн суусангүй Жултас¹²⁵т суулгасугай. Гагцхүү Жултасын газар зуншваас болмуй, өвөлжсөөс болохгүй. Өмнөн Дашдаваагийн ард цөм Харшаарын уулны дотор өвөлжих билээ. Эдүгээ Харшаарт хэдэн хотон суусан боловч маш цөөн бөгөөд Харшаарын цаана Борлон (borlen), Бубур (bibur)-т суужээ. Харшаар уул мөн уудам гүн, хотонгуудад хамаагүй хэмээн санамуй”¹²⁶ гэжээ. Мөн тэрээр “Байцаавал өмнөн Дашдаваагийн ард 10 мянга гаруй өрх энэ зэрэг газраас Харшаарт хүртэл өвөлжсөн билээ. Эдүгээ хошуудын ард сая 6000 гаруй ам 1000 гаруй өрх буй. ... Гагцхүү Харшаарын харьяат говьд

¹²³ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca orientalis-CIX.УБ., 2021. т 129-132. Засан тогтоосон өргөмжилвөөс зохих Торгууд, Хошуудын зэрэг тайж нарын аймгийн нэр, хан, ван, бэйл, бэйс, гүн, тайж нарын хуудас. 1771.10

¹²⁴ На.Сүхбаатар “1771 оны Торгуудаар тэргүүлсэн нүүдлийн төгсгөл, Манж чин улсаас захирсан бодлого” “Acta Historica Mongolica”. Tomus . XXII.УБ., 2021. т 101

¹²⁵ Жултас: Тэнгэр уулын дунд биеийн тэгш өндөрлөг. Елдос буюу од гэсэн утгатай уйгур үгийг ойрадууд жултас гэж нэрлэжээ. Тэнгэрийн од нуурын усанд тод тусдаг учир ийнхүү нэрлэсэн гэдэг. Шинжааны Баянгол жуугийн Хэжин сианы нутаг.

¹²⁶ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca orientalis-CIX.УБ., 2021. т 99. Торгууд Хошуудын ардад нутаг заан суулгах тухай Шүхэдэгийн айлтгал. 1771.08.14



тавьсан хэдэн өртөөний морь адуулах газарт алслагдсан нь бага ойр боловч тэднийг суулган одох цагт холхон газар зааж, заасан газраас давуулахгүй болгон суулгаж шийтгэвэл даруй хэрэг үгүй болмуй. Тэнгэрийн тэтгэсэний гучин зургаадугаар он 9-р сарын шинийн 5-нд, улаан бэхээр цохсон зарлиг, мэдэв хэмээв”¹²⁷. Үүнээс үзвэл, Тэнгэрийн тэтгэсэн хаанаас тэдний нутаглах газрыг зуны улиралд Жултас, өвөл нь Харшаарт нутаглахыг нь зөвшөөрсөн бөгөөд одоо БНХАУ-ын ШУӨЗО-ны Баянгол жуугийн Бостнуур сиан, Хошууд сианд сууж буй Монголчууд бол эдгээр Хошуудууд юм. Тэднийг заншил ёсоор Харшаарын Хошуудууд гэж нэрлэдэг.

ДҮГНЭЛТ

XVII зууны эхэн үеэс эхлэн Дөрвөн ойрадыг бүрдүүлэгч гол аймаг Хошууд нь олон газар нүүн суурьших болов. Тэдний нэг хэсэг нь Ижил мөрөн зүг нүүдэлсэн бөгөөд үндсэн шалтгаан нь дотоодын зөрчил тэмцэл хийгээд харь улсын түрэмгийлэлтэй холбож үзэхээр байна. Дөрвөн удаагийн нүүдлээр Ижил мөрөнд хүрсэн нь судалгааны явцад тодорхой боллоо. 1771 оны 1 сард Торгуудаар голлосон их нүүдэлд Хошуудын 2000 гаруй өрхийн 10000 гаруй хүн хамт нүүж, нүүдлийн төгсгөлд 1500 гаруй өрхийн 6000 гаруй хүн зорьсон газартаа иржээ. Тэднийг Манжийн төрөөс Гурван жаргаланд түр суулгаж, Жултас болон Харшаарт нутаг заан суулгахаар тогтжээ.

ABSTRACT

From the beginning of the 17th century, the Khoshuud, the main aimag that made up the Four Oirats, moved to many places. Some of them moved to the Volga, mainly due to internal conflicts and foreign aggression. During the study, it became clear that the Volga was reached by four migrations. In January 1771, more than 10,000 people from more than 2,000 households in the Khoshuud migrated with the Torguud, and by the end of the migration, more than 6,000 people from more than 1,500 households had reached their destination. The Manchu government decided to temporarily place them in Gurvan Jargal and to settle in Jultas and Kharshaar.

Keyword: *Torguud, Khoshuud, Manchu, Great migration, Volga, Ili river*

¹²⁷ “Торгуудын түүхэнд холбогдох манж баримтын орчуулгын эмхэтгэл (1731-1772). //Bibliotheca oiratica-CIX.УБ., 2021. т 108



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИУДЫН ҮГИЙН САНГИЙН
ДАВТАМЖИЙГ ХАРЬЦУУЛСАН НЬ***

Т.Батбямба *

Г.Ариун-Онон *

С.Мөнхсайхан §

ХУРААНГУЙ

Монгол улсын үндсэн хуульд улсын бүрэн эрхт байдлын тухай “Монгол улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт, бүгд найрамдах улс мөн”¹²⁸ гэж заажээ. Монгол улс анхны үндсэн хуулиа 1924 оны 11 сарын 25-нд баталснаас хойш улс төр, эдийн засгийн өөр өөр нөхцөл байдалд буюу 1940, 1960, 1992 онд тус тус дахин гурван удаа өөрчлөн засжээ. Бид эдгээр дөрвөн үндсэн хуулийн үгийн санг бүртгэн цахим сан үүсгэж, уг сандаа тулгуурлан үндсэн хуулиудын үгийн сангийн нийт тоо, үгийн давтамжийг харьцуулсан судалгааны үр дүнгээ уг өгүүллээр танилцуулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Хуулийн хэл найруулга, үндсэн хууль, цахим хэл шинжлэл, үгийн сан, давтамж

Удиртгал

Албан харилцаанд хэрэглэж буй бүхий л бичиг баримтын хэл найруулгыг ерөнхийд нь албан бичгийн хэл гэдэг. Энэ нь тухайн хэлнийхээ утга зохиолын хэлний хэм хэмжээг чанд баримталсан, харьцангуй тогтсон журам болон загвартай, найруулгын нарийн ур чадвар шаарддаг хэл юм. Албан бичгийн хэлийг албан баримтын найруулга, ердийн ажил хэргийн найруулга гэж хоёр хуваах бөгөөд албан баримтын найруулгаа дотор нь

-дипломат хэл найруулга

-хуулийн хэл найруулга

* ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын нэр томъёоны судалгаа” сэдэвт ажлын хүрээнд бичив.

* ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын ЭША, ӨМИС-ийн МСДС-ийн докторант

* Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөлийн Ажлын Албаны ЭША, доктор (Ph.D)

§ ШУА-ийн ХЗХ-ийн Хэл шинжлэлийн салбарын ЭШТА, доктор (Ph.D), дэд профессор

¹²⁸ <https://legalinfo.mn/mn/detail/367>



гэж, ердийн ажил хэргийн найруулгаа

-албан захидал

-албан бичиг

гэж тус тус хуваадаг¹²⁹ байна.

Хууль нь нийгмийн албан харилцааг зохицуулж байдаг баримт бичиг бөгөөд хэл шинжлэлийн үүднээс үзвэл төр ард түмэнтэйгээ харилцаж буй албан ёсны хэл юм. Энэ хэл хэдий чинээ ойлгомжтой, зөв шударга, цэвэр тунгалаг байна төдий чинээ төр ард түмний итгэлцэл гүнзгий, харилцаа сэвгүй байна гэсэн үг. Хуулийн хэл найруулга нь албан бичгийн бусад төрлүүдтэйгээ ерөнхийдөө адил боловч бас өөрийн гэсэн бичгийн өвөрмөц онцлогтой. Үүнд:

1. Хууль нь товч бөгөөд тодорхой байх ёстой.
2. Бусад хэл найруулгыг бодвол ерөнхийлөн дүгнэсэн шинжтэй байдаг.
3. Тогтсон загвартай байдаг.
4. Олон нийтэд ойлгомжтой байх ёстой ажээ.

Үгийн сангийн онцлогоос нь товч дурдвал,

- Нийт олны ярилцдаг хамгийн энгийн бөгөөд салаа утгагүй үгийг сонгож хэрэглэдэг. Жишээ нь, “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэх мэт.
- Хуулийг нийт олноороо заавал дагаж мөрдөх, дээдлэн хүндэтгэх ёстой байдаг учир түүний хэл найруулгад хүндэтгэлийн үг хэллэгийг өргөнөөр ашиглах нь бий. Жишээ нь, соёрхон батлах, цог хийморь, ариун цагаан өнгө, өргөн мэдүүлэх гэх мэт.
- Найруулгад нэг үгийг олон дахин давтаж хэрэглэвэл найруулга сулруулах муу нөлөөтэй боловч хуульд тухайн салбартай холбоотой үг хэллэгийг олон дахин давтаж бичиж болдог. Жишээ нь, Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль¹³⁰-д ажил олгогч, ажилтан, аж ахуйн нэгж байгууллага гэх мэт үгс олон дахин давтагдаж байна.
- Хуулийн хэл найруулгад нутгийн аялгууны үг, хар ярианы үг, гадаад хэлний үгийг хэрэглэдэггүй. Хэрэглэвэл голдуу утга зохиолын хэм хэмжээнд тохирсон тухайн салбарт түгээмэл хэрэглэдэг нэр томъёог ашигладаг. Жишээ нь, прокурор, контракт, арбитра, машин механизм, техник, паспорт гэх мэт.

¹²⁹ С.Мөнхсайхан, *Хуулийн хэл найруулга*, Хэл соёлын тулгамдсан асуудлууд цуврал №4, алтан бичгийн хэл найруулга, 100-110 тал

¹³⁰ Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, УБ., 2003



- Олон нийтэд ойлгомжтой байх шаардлага тавьдаг тул хуучин үг, түүхэн үгийг бараг хэрэглэдэггүй, шинэ үгийг хэрэглэх шаардлагатай бол нэмэлт тайлбартайгаар хэрэглэдэг байна.¹³¹
- Хуулийн хэл найруулгад салаа утгатай болон ижил утгатай үгийг хэрэглэдэггүй. Учир нь эдгээр нь найруулгыг бүрхэгдүүлэх юм уу хоёрдмол санаатай болгодог.
- Хуулийн хэл найруулгад, бусдад итгэл үнэмшил төрүүлэх, уриалан дагуулах зорилгоор ойролцоо утгатай үгийг хоршин хэрэглэх нь цөөнгүй. Жишээ нь, “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ”¹³² гэх мэт.

Сүүлийн 100 гаран жилийн хугацаанд Монгол оронд нийгмийн эрс өөрчлөлт бүхий гурван том хувьсгал (үндэсний хувьсгал, ардын хувьсгал, ардчилсан хувьсгал) гарч, нөхцөл байдалтайгаа уялдуулан үндсэн хуулиа дөрвөн ч удаа өөрчлөн баталжээ. Эдгээрийг дурдвал,

1924 оны 11 сарын 8 өдөр эхэлсэн Улсын анхдугаар их хуралд оролцсон халх дөрвөн аймаг, дөрвөд хоёр аймаг, их шавь, Алтай ба Хөвсгөлийн урианхайн хошууд, ардын цэргийн ангиудаас сонгогдсон нийт 77 төлөөлөгч 20 гаруй хоног хэлэлцсэний эцэст Бүгд Найрамдах Монгол Ард Улсын анхдугаар үндсэн хуулийг 1924 оны 11 сарын 25-ны өдрийн 16 цаг 17 минутад батлан гаргасан¹³³ түүхтэй.

Хоёрдугаар Үндсэн хуулийг 1940 оны зургаадугаар сарын 30-ны өдөр Улсын 8 дугаар Их Хурлаар баталсан байна. Хоёрдугаар Үндсэн хууль нь 12 бүлэг, 95 зүйлтэй. 1940 оны БНМАУ-ын Үндсэн хуульд 1960 он хүртэл нийт 16 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.¹³⁴

Монгол Улсын гуравдугаар Үндсэн хуулийг 1960 оны 7 сарын 6-ны өдөр 10 бүлэг, 94 зүйлтэйгээр баталж, 16 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан¹³⁵ ажээ.

1980-аад оны сүүлчээс Монгол оронд өөрчлөлт, шинэчлэлтийн уур амьсгал эхэлж, улмаар 1990 онд үндсэн хуулийг шинэчлэн боловсруулах ажил эхэлжээ. БНМАУ-ын Ардын Их Хурлаас сонгогдсон депутатуудын хоёрдугаар хуралдаан 76 хоног хуралдаж, Монгол Улсын дөрөвдүгээр Үндсэн хуулийг 1992 оны нэгдүгээр сарын 13-нд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаар баталсан бөгөөд тухайн оныхоо хоёрдугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрджээ. Энэхүү Үндсэн хууль нь оршил, 6 бүлэг, 70 зүйлтэй бөгөөд Монгол Улсад нэг шаттай парламент, Ерөнхийлөгчийн институт бүхий бүгд

¹³¹ Ц.Сүхбаатар, Монгол хэлний найруулга зүй, Уб., 2009, 399 тал

¹³² Монгол улсын үндсэн хууль, Уб., 2004, 367 тал

¹³³ <https://www.conscourt.gov.mn/?p=4300>

¹³⁴ <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1940.html>

¹³⁵ <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1960.html>



найрамдах засаглалын ардчилсан хэлбэрийг хуульчлан баталгаажуулсан¹³⁶ байна.

Хуулийг боловсруулан батлах, мөн нэмэн өөрчлөх зэрэг бүхий л үйл ажиллагаанд шинжлэх ухааны ул суурьтай судалгаа хэрэгтэй болдог. Иймээс бид Монгол улсад мөрдөгдөж буй бүхий л хуулийн эх тулгуур болсон Үндсэн хуулийн үгийн санд давтамжийн судалгаа хийж, хуулийн үгийн санг цахим хэл шинжлэлийн үүднээс судлах ажилд өөрсдийн саналыг нэмэрлэхийг зорив. Ийм судалгаа нь хуулийн хэл найруулгад ашиглаж буй үгийн хэрэглээний байдал, үгийн утгын хувирал, үгийн сангийн баяжилт, найруулгын орчны ялгаа зэргийг тодруулахад ач холбогдолтой юм.

Судалгааны үндсэн хэсэг

Монгол хэлний үгийн сангийн цахим сан байгуулах ажлыг өнгөрсөн зууны наяд оноос эхлэн Өвөр Монголын Их Сургуулийн Монгол хэл судлах газар “Монгол хэлний мэдээлэл боловсруулалт (mongolian information processing)-ын ажлаар эхлүүлсэн”¹³⁷ бөгөөд энэ нь монгол хэлний үгийн сангийн материалыг цуглуулан хадгалах, боловсруулах хялбар боломжийг олгосон төдийгүй цахим хэл шинжлэлийн шинэ чиг хандлагыг хөгжүүлэх эхлэл болжээ. Түүнээс хойш МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль, МУИС-ийн Компьютер хэл шинжлэлийн судалгааны төв, одоогийн Хэрэглээний шинжлэх ухааны инженерчлэлийн сургуулийн харьяа Машин оюуны лаборатори, ШУТИС-ийн Холбоо, мэдээлэл технологийн сургууль, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Болорсофт ХХК зэрэг төрийн болон хувийн хэвшлийн судалгааны байгууллагын багш, судлаачид цахим хэл шинжлэлийн онол, практикийн арга зарчмыг боловсруулж, хэл шинжлэлийн толь бичиг, дижитал хөмрөг, орчуулгын программ, хөрвүүлгийн программ, алдаа шалгах, засах программ зэрэг хэлний бүхий л нэгжийн хэрэглээ, давтамж, хэл шинжлэлийн бүх үзүүлэлтийг тусгасан задаргаа хийх зэрэг өргөн хүрээнд ажилладаг программуудыг бүтээж, зохих үр дүнд хүрсээр байна.¹³⁸

Цахим хэл шинжлэл нь хүн ба машин хоорондын харилцан үйлчлэлийг өөртөө нэгтгэсэн цогц системийг бий болгохыг зорьдог шинжлэх ухаан бөгөөд өдгөө дэлхийн улс орон бүр өөр өөрийн хэлний,

¹³⁶ <https://legalinfo.mn/api/front/index.html>

¹³⁷ С.Насан-Урт, Монгол хэл бичгийн сураг занги боловсруулах онол практикийн зарим асуудал. Уб., 2004, 3 тал.

¹³⁸ Т.Багбямба, С.Алтантуяа, Ч.Алтангэрэл, Ч. “ЕБС-ийн I ангийн монгол хэлний сурах бичгийн үгийн сан, үгийн хувиллыг цахим хэл шинжлэлийн үүднээс бүртгэн судалсан нь”, Хэрэглээний хэл шинжлэл, VI(21), Уб., 2021, 90 тал.



уран зохиолын, толь бичгийн, нэр томъёоны, хуулийн гэх мэт цахим санг байгуулан хөгжүүлсээр байна.

Бид судалгааныхаа зорилгын хүрээнд Үндсэн хуулийн бүрэн цахим санг бүрдүүлснээс гадна, үндсэн хууль тус бүрийн цахим санг хэл зүйн нөхцөлөөр хувилаагүй үгсийн хүрээнд гаргасан бөгөөд үүнд AntConc программыг¹³⁹ ашиглаж, давтамжийг тооцоолсон болно. Уг тооцооллоо хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт № 1. Цахим сангийн үгийн сангийн байдал

№	Анги	Нийт үгийн тоо	Хэл зүйн хувилал аваагүй үг
1	1924 оны үндсэн хууль	2414	515
2	1940 оны үндсэн хууль	4452	704
3	1960 оны үндсэн хууль	4486	802
4	1992 оны үндсэн хууль	6502	900
Нийт		17852	2921

Дээрх тоон үзүүлэлтийг ажиглавал, 1924 оны үндсэн хууль нийт 2414 үгтэйгээс 515 нь, 1940 оных нийт 4452 үгтэйгээс 704 нь, 1960 оных нийт 4486 үгтэйгээс 802 нь, 1992 оных нийт 6502 үгтэйгээс 900 нь хэл зүйн нөхцөлгүй буюу нэгж үг байна. Бүрэн санд давтагдсан тоогоор нийт 17852 үг бүртгэгдсэнээс, 2921 олон давтамжтай үг, 1418 нь зөвхөн нэг удаа бүртгэгдсэн нэгж үг байна. Өөрөөр хэлбэл, дурдсан 1418 үгийн утгыг мэдэж байхад дээрх дөрвөн үндсэн хуулийг чөлөөтэй ойлгох боломжтой гэсэн үг юм.

Үндсэн хуулийн бүрэн сангийн үгийн давтамжийг хууль тус бүрээр тооцоолсноо дараах хүснэгтээр үзүүлье. Үүнд:

Хүснэгт № 2. 1924 оны үндсэн хуулийн үгийн сангийн давтамж

¹³⁹ <https://www.laurenceanthony.net/software/antconc/>. Тус программын салангид бичигдсэн хэлний нэгж бүрийг тус тусад нь таньдаг чанарыг харгалзан, цахим сан дахь салангид бичлэгтэй нөхцөлүүдийг өмнөх үгтэй нь хамт тоолохоор тэмдэг хадав.



О давтамжийн тоо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
Давтагдсан нэгж үг	249	74	42	30	20	16	8	6	9	6	7	8	2	8	1	1	6	2	1
Нийт	249	148	126	120	100	96	56	48	81	60	77	96	26	112	15	16	102	36	19

О давтамжийн тоо	20	23	26	28	29	31	33	34	37	38	41	51	54	63	72	74	117	Нийт
Давтагдсан нэгж үг	4	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	515
Нийт	80	23	26	28	29	31	33	34	37	38	41	51	54	63	72	74	117	2414

Хүснэгтээс үзвэл, 1-10 удаа давтагдсан үг (1084) нийт үгийн сангийн 44,9%, 11-20 удаа давтагдсан үг (579) нийт үгийн сангийн 23,98%, 21-30 удаа давтагдсан үг (106) нийт үгийн сангийн 4,39%, 31-40 удаа давтагдсан үг (173) нийт үгийн сангийн 7,08%-ийг тус тус эзэлж байна. Харин үлдсэн 41–ээс дээш давтамжтай үг (472) нийт үгийн сангийн 19,55% -ийг эзэлжээ.

Хүснэгт № 3. 1940 оны үндсэн хуулийн үгийн сангийн давтамж

О давтамжийн тоо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
Давтагдсан нэгж үг	301	101	60	45	27	21	15	10	6	18	7	9	7	8	5	6	5	3	2	3
Нийт	301	202	180	180	135	126	105	80	54	180	77	108	91	112	75	96	85	54	38	60

О давтамжийн тоо	21	22	23	24	25	26	27	28	29	31	32	33	37	38	40	42
Давтагдсан нэгж үг	3	3	3	3	5	2	1	3	3	1	1	1	1	1	1	1
Нийт	63	66	69	72	125	52	27	84	87	31	32	33	37	38	40	42

О давтамжийн тоо	57	59	66	75	90	91	94	98	106	130	155	200	Нийт
Давтагдсан нэгж үг	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	704
Нийт	57	59	66	75	90	91	94	98	106	130	155	200	4452

Хүснэгтээс үзвэл, 1-10 удаа давтагдсан үг (1543) нийт үгийн сангийн 34,65%, 11-20 удаа давтагдсан үг (796) нийт үгийн сангийн



17,87%, 21-30 удаа давтагдсан үг (645) нийт үгийн сангийн 14,48%, 31-40 удаа давтагдсан үг (211) нийт үгийн сангийн 4,73%-ийг, 41–ээс дээш давтамжтай үг (1115) нийт үгийн сангийн 25% -ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт № 4. 1960 оны үндсэн хуулийн үгийн сангийн давтамж

Давтамжийн тоо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
Давтагдсан нэгж үг	330	140	78	45	29	24	14	15	8	20	13	11	5	8	1	3	6	2	4	3
Нийт	330	280	234	180	145	144	98	120	72	200	143	132	65	112	15	48	102	36	76	60

Давтамжийн тоо	21	22	23	24	25	26	28	29	32	33	35	36	37	38	39	40	41	42	43	48
Давтагдсан нэгж үг	4	2	2	1	2	1	1	2	3	1	1	2	2	3	1	1	1	2	1	1
Нийт	84	44	46	24	30	26	28	58	96	33	35	72	74	114	39	40	41	84	43	48

Давтамжийн тоо	54	59	70	75	78	97	105	108	169	Нийт
Давтагдсан нэгж үг	1	1	1	1	1	1	1	1	1	802
Нийт	54	59	70	75	78	97	105	108	169	4486

Давтамжийн дүнгээс үзвэл, 1-10 удаа давтагдсан үг (1803) нийт үгийн сангийн 40,19%, 11-20 удаа давтагдсан үг (789) нийт үгийн сангийн 17,58%, 21-30 удаа давтагдсан үг (360) нийт үгийн сангийн 8,08%, 31-40 удаа давтагдсан үг (463) нийт үгийн сангийн 10,32%-ийг, 41–ээс дээш давтамжтай үг (953) нийт үгийн сангийн 21,24% -ийг тус тус эзэлж байна.



Хүснэгт № 5. 1992 оны үндсэн хуулийн үгийн сангийн давтамж

Одавтамжийн тоо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
Давтагдсан нэгж үг	335	140	81	54	37	35	25	24	16	11	10	14	6	12	5	5	5	8	6	10	5
Нийт	335	280	243	216	185	210	175	192	144	110	110	168	78	168	75	80	85	144	114	200	105

Одавтамжийн тоо	22	24	25	26	27	28	29	30	32	33	34	35	36	37	39	40	41	42	43	44	45
Давтагдсан нэгж үг	7	3	1	3	1	2	1	3	1	1	1	2	1	2	1	1	1	1	1	1	1
Нийт	154	72	25	78	27	56	29	90	32	33	34	70	36	74	39	40	41	42	43	44	45

Одавтамжийн тоо	46	48	49	54	55	61	64	65	68	84	85	87	99	125	126	138	156	181	291	Нийт
Давтагдсан нэгж үг	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	900
Нийт	46	48	49	54	55	61	64	65	68	84	85	87	198	125	126	138	156	181	291	6502

1992 оны үндсэн хуулийн цахим сангийн давтамжийн үр дүн 1-10 удаа давтагдсан үг (2090) нийт үгийн сангийн 32,14%, 11-20 удаа давтагдсан үг (1222) 18,79%, 21-30 удаа давтагдсан үг (636) 9,78%, 31-40 удаа давтагдсан үг (358) 5,50%-ийг тус тус эзэлж байна. Харин үлдсэн 41–ээс дээш давтамжтай үг (1957) нийт үгийн сангийн 30,09% -ийг эзэлж байгааг харуулж болно.


Хүснэгт № 6. Хамгийн их давтамжтай үгс

№	1924 оны үндсэн хууль	Давтал т	1940 оны үндсэн хууль	Давтал т	1960 оны үндсэн хууль	Давтал т	1992 оны үндсэн хууль	Давтал т
1	Улс	117	улс	200	ард	169	улс	291
2	Хурал	74	ард	155	улс	108	хууль	181
3	Зүйл	72	ба	130	хурал	105	эрх	156
4	Зохь	63	хурал	106	зүйл	97	хурал	138
5	Газар	54	зүйл	98	БНМАУ	78	бол	126
6	Ба	51	Монгол	94	эрх	75	их	125
7	Ард	41	найрамд	91	их	70	Монгол	99
8	Засаг	38	бүгд	90	бай	59	үндэс	99
9	Арав	37	нь	75	бол	54	зүйл	87
10	Эрх	34	бол	66	төр	48	засаг	85



Үндсэн хуулийн цахим сан тус бүрийн давтамжийн тооцооллыг гаргахад “улс” гэсэн үг 1924 оны цахим санд 117 удаа, 1924 оны цахим санд 200 удаа, 1992 оны цахим санд 291 удаа, 1960 оны цахим санд “ард” гэсэн үг 169 удаа буюу хамгийн олон давтагджээ.

Бүрэн цахим сангийн хувьд хамгийн олон давтамжтай үгийг тооцоолсноо графикаар үзүүлбэл:



Графикад үзүүлсэн хамгийн олон давтамжтай “улс”, “хурал”, “ард”, “зүйл”, “эрх”, “хууль”, “Монгол”, “их”, “ба”, “бол” гэсэн үгс нийт сангийн 3368 буюу 18,86%-ийг бүрдүүлж байгаа бол, “агуу”, “бадамлянхуа”, “гудамж”, “дугариг”, “Жавзундамба”, “интернационалист”, “ленинизм”, “рашаан”, “ясли” зэрэг 626 үг цахим санд зөвхөн нэг удаа тохиолдож байна.

ДҮГНЭЛТ

Бид 1924, 1940, 1960, 1992 оны Монгол улсын үндсэн хуулийн үгийн сангаар бүрэн цахим сан бүрдүүлж, үгийн давтамжийн судалгааг хийж дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд,

1. 1924 оны үндсэн хуулийн нийт үгийн сан 2414, 1940 оных 4452, 1960 оных 4486, 1992 оных 6502 болон бөгөөд нийт 17852 үгтэй үндсэн хуулийн цахим сан байгуулав. Үүнээс 1418 нь хэл зүйн нөхцөлөөр хувилаагүй нэгж үг байна. 1924 оны анхдугаар Үндсэн хуулийн үгийн сангийн тоо 2414 байсан бол үүнээс хойш 1940 оных 4452, 1960 оных 4486, 1992 оных 6502 болж өссөн нь харагдаж байна. Харин хуулийн бүлэг, заалт эсрэгээрээ улам хураангуйлсан буюу тоо нь цөөрчээ. Энэ нь нийгмийн хийгээд хүмүүсийн харилцаан дахь олон талт хэрэгцээ шаардлага нөлөөлсөн байж болно.
2. Бүрэн цахим сан дахь “шуудан”, “чандмань”, “цөцгий” гэх мэт 626 үг хамгийн цөөн буюу зөвхөн нэг удаа давтагдаж, 3,5%-ийг эзэлж байхад, “улс” хэмээх үг хамгийн олон буюу 776 удаа давтагдаж,



- 4,34%-ийг эзэлж байна. Энэ нь үндсэн хууль бол бүхий л хуулийн тулгуур болж улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн олон асуудлыг зохицуулдагтай холбоотой.
3. Цахим санд хамгийн олон давтагдаж байгаа эхний арван үгсийг ажиглахад, “улс”, “хурал”, “зүйл” гэсэн гурван үг нь дөрвөн хуулийн санд, “ард”, “бол” гэсэн хоёр үг нь гурван хуулийн сан (1924, 1940, 1960)-д, “Монгол”, “засаг”, “эрх”, “ба” гэсэн үгс нь хоёр хуулийн сан (1924, 1940, 1992)-д тус тус тохиолдож, бусад нь тус бүр нэг хуулийн санд давтагдаж байгаа нь хуулийн зорилго, хэл найруулгатай холбоотой ажээ.
 4. Хэлний үгийн сан нь нийгмийн хувирал өөрчлөлтийг соргогоор мэдэрдэг, хэлний хамгийн хөдлөнгө бөгөөд идэвхтэй салбар учир хууль бүрийн цахим санд тухайн нийгмийнхээ онцлогийг харуулсан түүхэн үг цөөнгүй бүртгэгдэв. Тухайлбал,
 - 1924 оны хуульд “ван”, “хошууд”, “Жавзундамба” зэрэг үгс гарч байгаа нь 1924 онд Богд хаан таалал төгсөж, Богд Хаант Монгол Улс буюу хэмжээт эрхт хаант засаглалаас Бүгд найрамдах засаглалд шилжсэн түүхэн үйл явдалтай холбоотой.
 - 1940 оны хуульд “дайн”, “Өмнөговь”, “Архангай” зэрэг үгс бүртгэгдсэн нь тус хуулийн 1-р зүйлд *“Бүгд Найрамдах Монгол Ард Улс болбоос эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм журамд дэвшин орохын учир улс орон юугаа хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин (малчин, ажилчин, сэхээтэн) ардын тусгаар тогтносон улс мөн болно”*¹⁴⁰ хэмээн зааж, засаг захиргааны шинэ хуваарилалт хийсэн болон болон Халх голын дайн зэрэг түүхэн үйл явдалтай холбоотой ажээ.
 - 1960 оны хуульд “ясли”, “тариаланч”, “тэтгэвэр” зэрэг үгс олонтоо гарч байгаа нь тус хуульд *“БНМАУ бол ажилчид, хоршоолсон ардууд (малчин тариачид), хөдөлмөрч сэхээтний социалист улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн”*¹⁴¹ хэмээн заасантай холбож ойлгож болно.
 - 1992 оны хуульд “ерөнхийлөгч”, “стратег”, “өмгөөлөгч” гэх мэт үгс байгаа нь Монгол Улсад нэг шаттай парламент, Ерөнхийлөгчийн институт бүхий бүгд найрамдах засаглалын ардчилсан хэлбэрийг хуульчлан баталгаажуулсантай ¹⁴² холбогдож байна.

¹⁴⁰ Ч.Батдорж, <https://mongoltoli.mn/history/h/701>

¹⁴¹ Мөн тэнд

¹⁴² Мөн тэнд



5. Аливаа хуулийг нийт олонд ойлгомжтой өргөн хэрэглээний үгээр найруулан бичих шаардлага тавьдаг учир цаашид бидний судалгааг монгол хэлний үгийн давтамжийн судалгаатай харьцуулан үзэж өргөн хэрэглээний үгийг ашигласан эсэхэд дүгнэлт хийх боломжтой юм.

НОМ ЗҮЙ

Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Лхагважав, Монгол улсын үндсэн хуулийн үгсийн чуулган, УБ., 2011, 385 тал.

Г.Ариун-Онон, Монгол улсын хуулийн цахим хөмрөгийн байгуулалт, жич үгийн сангийн судалгаа, докторын зэрэг хамгаалах диссертаци, БНХАУ, ӨМӨЗО-ы ӨМИС-ийн МСДС, 2019 он.

Т.Батбямба, С.Алтангуяа, Ч.Алтангэрэл, “ЕБС-ийн I ангийн монгол хэлний сурах бичгийн үгийн сан, үгийн хувиллыг цахим хэл шинжлэлийн үүднээс бүртгэн судалсан нь”, Хэрэглээний хэл шинжлэл, VI(21), УБ., 2021, 90 тал.

Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа, Хэлшинжлэлийн нэр томъёоны тайлбар толь, УБ., 2014, 14 тал

С.Мөнхсайхан, *Хуулийн хэл найруулга*, Албан бичгийн хэл найруулга /Хэлний соёлын тулгамдсан асуудлууд цуврал/ УБ., 2011, 100-110 тал

С.Насан-Урт, Монгол хэл бичгийн сураг занги боловсруулах онол практикийн зарим асуудал, УБ., 186 тал.

Ц.Өлзийхутаг, Монгол хэлний үгийн сан судлал. УБ., 1979, 4 тал

Вэб хуудас:

<https://legalinfo.mn/api/front/cons-detail-1992.html>

<https://legalinfo.mn/api/front/cons-detail-1940.html>

<https://legalinfo.mn/api/front/cons-detail-1960.html>

<https://legalinfo.mn/api/front/cons-detail-1992.html>

<http://www.parliament.mn/n/1cbon>

<https://www.conscourt.gov.mn/?p=4300>

<https://legalinfo.mn/api/front/index.html>

<https://legalinfo.mn/mn/detail/10932>

<https://www.laurenceanthony.net/software/antconc/>

<http://toli.gov.mn/>

<https://mongoltoli.mn/history/h/701>



ABSTRACT

There is a statement in the Constitution of Mongolia “Mongolia is an independent sovereign republic.” Mongolia has amended its constitution four times as a result of the historic changes of the time since the adoption of its first constitution on November 25, 1924. We aimed to create an electronic database of lexicon in four constitution approved in different environments in terms of time and social organization, we present the results of a study comparing the number of words and word frequencies in the constitutions.

Keywords: *law language, constitution, computational linguistics, lexicon, frequency*



**ХАРА ХҮЛЭГҮ БА ХАРА ОГУЛ ХЭМЭЭХ НЭРИЙН ТУХАЙ ТОВЧ
ӨГҮҮҮЛЭХ НЬ**

Жян Юань*, И Вэйчи *

ХУРААНГУЙ

Хара Хүлэгү бол Цагаадайн хант улсын хууль ёсны залгамжлагч бөгөөд түүнийг Персийн түүхч Жувейнийн “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” бүтээлд “Хара Огул” гэх нэрээр тэмдэглэжээ. Гэтэл өөр нэгэн Персийн түүхч Ил хант улсын зайсан Рашид-Ад-Дин эрхлэн найруулсан “Түүхсийн чуулган”-д мөн л Хара Хүлэгү гэсэн уг зохиолын нэрийг хэрэглэсэн байна.

Хара Хүлэгү хэмээх нэр нь Жувенийн бүтээлд Хара Хүлэгү-ээр тэмдэглэгдээгүй төдийгүй энэ нь монголын түүхийг судлаач эрдэмтдийн чухалчилж үздэггүй асуудал болно. Хэрэв Жувейнийн бүтээлийг нарийн ажиглавал уг асуудлыг олж мэдэх билээ. Энэ нь хүмүүсийг өөрийн эрхгүй төөрөлдүүлнэ. Рашид-Ад-Диний бүтээлд “Хара Огул” гэсэн нэр харагдахгүй байгааг олж мэдэх юм. Юуны учир Жувейний “Хара Хүлэгү” гэдгийг Хара Огул гэх нэрээр орлуулсан бэ? Рашид-Ад-Дин яагаад Хара Огул гэж тэмдэглээгүй бэ? гэх зэргээр тал талаас нь нарийн шинжлэн өгүүлэх юм.

* Доктор (Ph.D), Шаогуань Их Сургууль, Марксизмын Сургууль

* Магистр, Шаогуань Их Сургууль, Марксизмын Сургууль

Тус өгүүлэл бол 2017 оны Нийгмийн Шинжлэх Ухааны Үндэсний Сангийн томоохон төсөл “13-14 дүгээр зууны Перс Монголын түүхийн мэдээлэл цуглуулах, судлах” (17ZDA191), 2020 оны Нийгмийн Шинжлэх Ухааны Үндэсний Сангийн залуучуудын төсөл “Юань гүрний үеийн хаадын хаан ширээ өв залгамжлалыг нэгтгэх үүднээс судлах нь” (20CZS026), 2021 оны Шаогуань Их Сургуулийн “Монгол, Юань гүрний эхэн үеийн улс төрийн зүтгэлтнүүд, үйл явдлуудыг нэгтгэх үүднээс судлах нь” (416-9900064502) профессор, докторын судалгааны санхүүжилтийн төслийн хүрээнд бичигдсэн болно.



Өгүүллийн бүтэц:

1. Агуулгын товч
2. Түлхүүр үг
3. Удиртгал
4. Хара Хүлэгү-ийн нэг насны амьдрал, үйл ажиллагаа
5. Хара Огул нэрийн утга
6. Түүхсийн чуулган дахь Хара Хүлэгү-ийн тэмдэглэлийн задлан шинжлэл
7. Дүгнэлт

Хар Хүлэгү болбоос эрхэм дээд монголын алтан урагтан бөгөөд өвөг Цагаадай түүнийг хаант улсынхаа хууль ёсны залгамжлагчаар тодруулж, Цагаадайг нас нөгчисний дараа улсын хан болсон байна. Гэвч Гүюг Их монгол улсын хаан сууринд суусны дараа түүний хаан орыг авга болон Гүюг хаантай харьцаа сайтай Мөнх булаан авсан юм.

Хэдийгээр хоёр жилийн дараа Гүюг хаан нас барж, Мөнх хаан Цагаадайн хант улсын хан суурийг Хара Хүлэгү-д буцаан өгсөн боловч, тэрээр харьяат газартаа харьж чадалгүй нас нөгчсөн байна. Персийн түүхч Жувейнийн үзэхээр Хара Хүлэгү бол танихад бэрх нэр байсан байж мэднэ. Тэрчлэн Жувейни улс төрийн талаар Мөнх хааны зүг хэлбийж, иймээс тэрээр “Огул” хэмээх Цагаадайн хант улсын хууль ёсны залгамжлагчийн перс зэрэг хэргэмийг Хара Хүлэгү ханы бие дээр тохоон тавьжээ. Түүнийг “Хара Огул” гэж тэмдэглэсэн боловч, Түүхсийн чуулганыг Рашид-Ад-Дин эрхлэн найруулсан ч үүнд маш олон монголчууд оролцсон тул нэрийн хувьд маш сайн тогтоосон ба ялгааг гаргасан байна.

Түлхүүр үгс: Хара Хүлэгү, Хара Огул, Перс, Жувейни, Рашид-Ад-Дин



浅谈合刺·旭烈兀与合刺·斡兀立

摘要：合刺·旭烈兀是察合台的合法继承人，他在波斯历史学家志费尼的《世界征服者史》中以“合刺·斡兀立”的名字出现。然而，在另一位波斯史学家伊利汗国宰相拉施特主编的《史集》中，仍然采用了合刺·旭烈兀这一原本的名字。

关键词：合刺·旭烈兀；合刺·斡兀立；波斯；志费尼；拉施特

引言

“合刺·旭烈兀”这一名字在波斯历史学家志费尼的《世界征服者史》中以“合刺·斡兀立”的形式出现，这是许多蒙古史学者所忽视的问题，如果仔细阅读《世界征服者史》便会发现这一现象，这不禁使人感到困惑。在查找之后由伊利汗国宰相拉施特主编的《史集》会发现，并未有“合刺·斡兀立”这一名字的“身影”。为何志费尼要在他的《世界征服者史》中用“合刺·斡兀立”来代替“合刺·旭烈兀”？而同为波斯历史学家的拉施特却未这样做？这种种疑团需要一一解开。

一、合刺·旭烈兀的生平事迹

合刺·旭烈兀出身于蒙古的黄金家族，身份十分高贵。他的曾祖父是成吉思汗，祖父是成吉思汗的嫡二子察合台，父亲是察合台的儿子木秃坚。木秃坚在世时深受成吉思汗的喜爱。据《史集》记载：

“察合台的第一个儿子木秃坚，是也速仑哈敦生下的，父亲爱他胜于其他几个儿子。由于成吉思汗[也非常爱]他，[木秃坚]大部分时间便跟在他[成吉思汗]身边。当成吉思汗派遣他的父亲察合台和术赤、窝阔台[一起]去围攻花刺子模，而自己围攻范延堡时，木秃坚被堡中射来的一支箭击中而死。成吉思汗为此心情大乱，当他攻下该堡时，就把它完全毁掉，并把该堡的居民全部杀光；他称该堡为恶[堡]。”^①

当成吉思汗西征花刺子模之时，经常将木秃坚带在身边。不幸的是在蒙古西征大军攻打范延堡时，木秃坚被箭射死，成吉思汗为了给这个孙子报仇，攻下了范延堡，并屠城。可见成吉思汗对木秃坚的喜爱程度如此之深。

察合台曾经将木秃坚作为他的继承人，当木秃坚死后，察合台又选定他

[基金项目]2017 年国家社会科学基金重大项目“13-14 世纪波斯文蒙古史史料搜集与研究 (17ZDA191)；2020 年国家社科基金青年项目“大一统视野下的元朝汗位继承问题研究” (20CZS026)；

2021 年韶关学院引进教授、博士科研经费项目“大一统视野下的蒙元初期回回政治人物及事件研究”(416-9900064502)。

[作者简介]姜源(1988-)，男，吉林松原人，韶关学院马克思主义学院助教，博士，北乔治亚大学(University of North Georgia)访问学者，主要从事蒙古帝国史研究。

易伟奇(1987-)，男，陕西渭南人，韶关学院马克思主义学院助教，硕士，主要从事中国古代史、世界史研究。

①[波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》，第二卷[M]。北京：商务印书馆，2014，p.163。



的另一个儿子别勒格失作为继承人，但是别勒格失十三岁的时候便死去了^①。察合台又将选定继承人的目光转向了孙子辈，即木秃坚之子合刺·旭烈兀^②。

当成吉思汗的继承人窝阔台可汗驾崩后，察合台支持窝阔台的六皇后脱列哥那摄政^③，最后在脱列哥那的操纵下，她的儿子贵由登上了汗位，成为大蒙古国的下一任可汗^④。可见，察合台及其家族的支持对于脱列哥那、贵由母子能够夺取汗位至关重要。继窝阔台可汗驾崩不久，察合台也相继离世了^⑤。合刺·旭烈兀成为了察合台兀鲁思的君主。但是当贵由成为大蒙古国的可汗后，事情发生了变化。据《世界征服者史》记载：

“但当贵由汗登上汗位时，因为跟察合台之子也速相好，他说：‘有子为何孙子应继承？’因此之故，他以也速承袭其父的国土，委他执掌国政。”^⑥

这里的也速即察合台的儿子也速·蒙哥，也速·蒙哥与贵由汗之间关系很好，因此在贵由汗登上汗位时，帮助也速·蒙哥取代了合刺·旭烈兀成为了察合台兀鲁思的君主。可见，此时合刺·旭烈兀失去了察合台兀鲁思君主的地位。

也速·蒙哥是察合台的嫡子，但是为何察合台在世之时没有将君主之位传给他的儿子也速·蒙哥？而是传给了他的孙子合刺·旭烈兀？据《史集》记载：

“也速·蒙哥是一个大酒鬼，据说，他未酒醉、清醒的时间很少，连把猎鹰交给养猎鹰者的时间也没有。他有个妻子名叫乃失。乃失威信很高，握有大权。他的丈夫经常喝酒，她就代行他的职权。”^⑦

从这段史料的记载可知，虽然也速·蒙哥也是察合台的嫡子，但是他非常喜欢喝酒，经常醉酒，根据蒙古人选定继承人的原则，这样的人是不可能成为下一任兀鲁思的君主，所以由于也速·蒙哥酗酒，他已经失去了察合台兀鲁思君主继承者的资格。但是由于贵由汗的干涉，察合台生前指定的继承人合刺·旭烈兀被他的叔叔也速·蒙哥所取代。

贵由汗在位仅仅两年的时间便离世了^⑧，之后成吉思汗幼子托雷的嫡长子蒙哥夺得了汗位。而也速·蒙哥反对蒙哥登上汗位^⑨，因此蒙哥汗将原本属于合刺·旭烈兀的君主地位还给了他，并且下令处死也速·蒙哥，但是合刺·旭

①[波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》，第二卷[M]. p.173.

②[波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》，第二卷[M]. p.171.

③[伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册[M].呼和浩特：内蒙古人民出版社，1981，p.282.

④[伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册[M]. p.292.

⑤[伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册[M]. p.299.

⑥[伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册[M]. p.322.

⑦[波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》，第二卷[M]. p.174.

⑧[明]宋濂等撰：《元史》卷二《定宗纪》[Z].北京：中华书局，2011，p.39.

⑨[伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册[M]. p.323.



烈兀死在了归国的途中^①。

二、合刺·斡兀立的含义

合刺·旭烈兀是以“合刺·斡兀立”的名字出现在波斯历史学家志费尼的《世界征服者史》中的。“斡兀立”为突厥语词汇“Oghul”，其含义为“儿子”^②。这个词不禁使我们联想到了贵由汗的长妻斡兀立·海迷失，她的名字即“Oghul Qaimish”。可见，当时蒙古人也有用“斡兀立”这个突厥语词起名字的。但是“合刺·斡兀立”却不是真正的名字，因为他的真正的名字是合刺·旭烈兀。

那么志费尼为何要将合刺·旭烈兀称为“合刺·斡兀立”呢？我们需要从《世界征服者史》的记载中寻找答案。据《世界征服者史》记载：

“继合罕之后不久，察合台也去世了。他的孙子合刺斡兀立继承他，而他的嗣子也速没有干预。但因贵由汗对后者极为友好亲密，他说：‘有子怎能让孙子当继承人？’在他们生时，合罕和察合台都指定合刺作为察合台国土的继承人，但贵由把它交给也速，在所有事情上助他一臂之力。”^③

根据这段史料的记载可以得知，志费尼在首次记载合刺·旭烈兀时，称呼他为“合刺·斡兀立”，而第二次再称呼他时，便简称为“合刺”。其中出现了合刺·旭烈兀的叔叔也速·蒙哥，志费尼在记载他时，仍然将他的名字简称为“也速”。为何志费尼在记载这两个蒙古人的名字时用了简称？笔者认为，这是有一定原因的。志费尼出生在波斯的志费因省^④，因此波斯语为他的母语，而蒙古语对于他来说便是一门不同于波斯语的外语，而波斯语与蒙古语属于不同语系^⑤，差别较大，因此志费尼在记载蒙古人的名字时应该较为困难，特别是较长的人名，因此才会将合刺·旭烈兀与也速·蒙哥分别简称为“合刺”与“也速”。再者，蒙哥与旭烈兀同志费尼是同一时期的人物，蒙哥是当时的蒙古可汗，而旭烈兀是蒙哥的弟弟，笔者对此认为，志费尼很有可能不希望将合刺·旭烈兀与也速·蒙哥同旭烈兀与蒙哥相混淆，因此才会将他们简称为“合刺”与“也速”。那么志费尼为何将简称的“合刺”后面又加上“斡兀立”呢？对于“斡兀立”一词，刘迎胜教授认为，“可汗”相当于汉文中的“皇帝”，有别于汗（汉文史料中的“亲王”、“诸王”、“大王”）和波斯文史料中的“斡兀立”^⑥。从这里可以看出，“斡兀立”这一称呼相对于蒙古文中的“汗”及汉文史料中的“亲王”，而合刺·旭烈兀是察合台兀鲁思的君主，因此志费尼才在《世界征服者史》的记载中将“斡兀立”的“头衔”给了

^①[波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》，第二卷[M]. p.174。

^②刘迎胜：《西北民族史与察合台汗国史研究》[M].北京：中国国际广播出版社，2012，p.80。

^③[伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册[M]. p.299。

^④[伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册[M]. p.1。

^⑤波斯语属于印欧语系，而蒙古语属于阿尔泰语系。

^⑥刘迎胜：《西北民族史与察合台汗国史研究》[M].p.80。



他。虽然也速·蒙哥也当过察合台兀鲁思的君主，但是这是在贵由汗的支持下才得以实现的。志费尼在政治倾向上是支持蒙哥汗的，因此对于贵由汗支持下的也速·蒙哥不予以承认。

三、《史集》中关于合刺·旭烈兀的记载状况分析

同是作为用波斯文书写的《史集》，关于合刺·旭烈兀这一名字的记载如何呢？据《史集》记载：

“木秃坚的第四个儿子哈刺-旭烈兀。……察合台让哈刺-旭烈兀代替他的父亲木秃坚当了汗位继承者。他的妻子是兀鲁忽乃哈敦，她生了木八刺-沙。当哈刺-旭烈兀去世时，他的堂兄弟，拜答儿的儿子阿鲁忽，按照阿里-不哥的命令，当了察合台兀鲁思的君主，并娶了兀鲁忽乃哈敦。不久之后，他去世了，木八刺-沙登上了父位。”^①

在这段史料的记载中，“哈刺·旭烈兀”即“合刺·旭烈兀”，其中“合刺”即蒙古文“Qara”义为“黑色”^②。这里既未将合刺·旭烈兀简称为“合刺”，又未给他加上“斡兀立”的头衔，虽然《史集》与《世界征服者史》同为波斯文撰写的史料，但是在这里《史集》却能够按照蒙古人的较长的原名记录他的名字。其原因何在？这就需要从《史集》的编撰过程中查找原因。根据日本京都大学的杉山正明教授的《蒙古帝国的兴亡》一书可知，拉施特在主编《史集》的过程中，参照了蒙古皇室共有的《金册》(Altan Tebder)；蒙古派往伊利汗国的孛罗丞相等许多人也参与了编纂；蒙古各部代代相传的“旧辞”和族谱等口头和书面史料都用到了编纂中^③。由此可见，在《史集》的编纂过程中，有许多人参加了编纂，其中有不少蒙古人，他们不但能够读懂回鹘式蒙古文撰写的《金册》，而且对于蒙古人的人名更是了如指掌，因此与志费尼这个波斯人撰写的《世界征服者史》相比，《史集》在编纂过程中，能够准确地记录较长的蒙古人的名字，并且能够更好的区分重名及名字相近的蒙古人物。

结语

合刺·旭烈兀的一生是比较坎坷的，他出身在高贵的蒙古黄金家族，又被他的祖父察合台确定为察合台兀鲁思的合法继承人，在察合台亡故后，他成为了察合台兀鲁思的君主。但是在贵由当上蒙古可汗后，合刺·旭烈兀的君主地位被他的叔叔，与贵由汗关系要好的也速·蒙哥夺去。虽然两年后贵由汗便撒手人寰，蒙哥汗将察合台兀鲁思君主的地位还给了合刺·旭烈兀，但是他未能

^①[波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》，第二卷[M]. p.171-172。

^②内蒙古大学蒙古学研究院蒙古语文研究所.《蒙汉词典》[Z].呼和浩特：内蒙古大学出版社，1999，p.583。

^③[日]杉山正明著，孙越译，邵建国校.《蒙古帝国的兴亡（上）军事扩张时代》[M].北京：社会科学文献出版社，2018，p.3。



回到他的领地便故去了。合刺·旭烈兀在波斯史学家志费尼的眼中或许是一个很难识记的名字，并且志费尼在政治上倾向于蒙哥可汗，因此他才将“斡兀立”这一带有察合台合法继承人的波斯头衔加在了合刺·旭烈兀的身上，称呼他为“合刺·斡兀立”，而另一部波斯文史书《史集》虽然是拉施特主编的，但是在编纂过程中有许多蒙古人参与，因此在蒙古人物的名字上便能作出很好的识记与区分。

ABSTRACT

Qara Hülegü was Čayatai's lawful heir, who appeared in the name of "Qara Oghul" in the History of the World Conqueror of Juvani who was a Persian historian. However, in the historical source of another Persian historian Rashid al-Din of Yili Khanate's minister who edited Jāmi' al-tawārikh, who still used the original name Qara Hülegü.

Keywords: *Qara Hülegü, Qara Oghul, Persia, Juvaini, Rashid al-Din*

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Жян Юань JIANG Yuan 姜源.

1988 онд төрсөн, эрэгтэй. Жилинь Сунюань-ий харьяат, Шаогуань Их Сургууль Марксизмын Сургуулийн туслах багш, Доктор (Ph.D), University of North Georgia –д зочин судлаач, судалгааны гол чиглэл Монголын эзэнт гүрний үе.

И Вэйчи YI Weiqi 易伟奇.

1987 онд төрсөн, эрэгтэй. Шаньши Вэйнань-ий харьяат, Шаогуань Их Сургууль Марксизмын Сургуулийн туслах багш, Магистр, судалгааны гол чиглэл Эртний хятад болоод Дэлхийн түүх.



МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ОНЦЛОГТ ЭМТ ХООЛЫГ НЭЭН АШИГЛАХ
ТУЛГАМ ЧАНАРЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ[§]

Номин*, Хай Ли*

ХУРААНГУЙ

Тус өгүүлэл нь дэлхий дахины түгшүүр болж байгаа шинэ титэмлэг уушгины сүрьеэ өвчин (covid-19)-ийг сэргийлэн эмчлэх ахуй байдалд монгол үндэстний онцлогт эмт хоолыг нээн ашиглахын тулгам чанарыг “бие тогтох ур ёсон”, “их ёсон огоот(нэн, ер, энгийн) цулгуй”, “бие сэтгэлийн зөв энерги” гэх гурван хэсэгт багтаан бодитойгоор нарийвчлан шинжлэв.

Түлхүүр үгс: Монгол үндэстний онцлогт эмт хоол, хижгийн(цар тахлын) байдлыг сэргийлэн эмчлэх ахуй байдал, нээн ашиглах ач холбогдол

Одоогоор БНХАУ-ын дотоодод цар тахлын байдлыг сэргийлэн эзэмдэх байнгын ахуй байдал тогтнож, бүх шатны засаг захиргааны хамаа бүхий байгууллага нэгжээс эхлээд хөдөө тосгоны энгийн малчин тариачид, хотын ард хүртэл явж суух, ажил албандаа явах, ялангуяа нийгмийн хөдөлгөөнд оролцохдоо амавч (маск) зүүх, биеийн дулаанаа байцаалгах (хэмжүүлэх), аялалын мэргэн цоохор (QR code)-ыг ширвэх (уншуулах) зэрэгт улмаар хэвшин дадалжиж, хүн төрөлхтний эрүүл энхийн том

§ “Хижгийн байдлыг сэргийлэн хязгаарлах ажлыг тогтмолжуулсан ахуй байдалд монгол үндэстний онцлогт эмт хоол хийгээд бие махбодыг сайжруулах тухай судлал”-ын нэг хэсэг болно. *Зөвшөөрсөн дугаар: 2020TYZJJDZ05*

* Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн багш.

* Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн 2020 оны магистрант.



түгшүүр болж байгаа цар тахлаас сэргийлэн хязгарлаж буй. Үүнд вакцин тариулах нь хэдийгээр дэлхий даяар мөрдөн журамлаж байгаа хамгийн нийтлэг цар тахлыг сэргийлэх үйл ажиллагаа болж байгаа боловч хүн төрөлхтний эрүүл энхийг батлан хамгаалах үндсэн баталгаа нь угаас хүний биеийн өвчнийг эсэргүүцэх чадварыг дээшлүүлэх явдал болно.

Нэг. Бие тогтох ур ёсон

Хүний биеийг өвчингүй эрүүл байлгах, махбодыг нь төлжүүлэх, тамир нөхөх, дархлааг дэмжих чадал бүхий идээ ундааг бүхэлд нь монгол үндэстний онцлогт эмт хоол гэж үнэлнэ. Монгол үндэстний эмт хоол нь идээ ундаа, тэжээл бодис ба ерөндгийн нэгдмэл цогц байж, ил тодорхой үндэстний онцлог шинж ба орон нутгийн өвөрмөц чанартай байдаг. Түүнийг хэрэглэхдээ “эм ба идээ эх нэгтэй, эмнэх сувилах ёсон хамт” гэх зарчмыг чанга баримтлан, эрүүл энхийг батлах өдөр тутмын идэш уушаар хэрэглэж, тахлаас сэргийлэх зорилгодоо хүрвэл зохино. “Аливаа эрт язгуурын богд эрдэмтэн нь өвчингүй эрүүл үед сэргийлэн асрахыг анхаарахаас бус, өвчлөсний хойнох явдлаар голчлохгүй байх учир нь огоот идээ ундааны жинхэнэ ёсыг хүндэтгэж эм зэргийг дээдлүүлж”¹ байсныг мэдэж болно.

Үргэлж тохиолдох монгол үндэстний онцлогт эмт хоолонд монголчуудын өдөр тутам шүтэж байдаг цагаан, улаан, бор, хөх идээний зүйл ба айраг, цэгээ зэрэг шимжүүлж тамиржуулах чадал бүхий ундааны зүйлийг багтааж байдаг. Тэдгээр нь голдуу хүний биеийн өвчнийг эсэргүүцэх чадлыг нэмэгдүүлж, махбод тамирыг төлжүүлж, өтөлж хөгшрөхийг хойшлуулан, насан хуггийг уртатгаж, өнгө зүсийг сайжруулах зэрэг үйлдэлтэй.

Хүн бол бие сэтгэлийн органик цогц мөн. Амьдралынхаа мөч бүхэнд өөрийгөө зохицуулан сэлбэн засаж оршин амьдарч чаддагаас “хүн төрөлхтөн бол дээргүй (хүнээс

¹Вүчи Шисань. “Монгол эмнэлгийн үргэлжийн тамир тэжээхүй идээ ундаа”, ЛяоҮнХХ 2012, т 1



хэтийдсэн амьтангүй)”², “дэлхий дээрх хамгийн нарийн, хэмжүүрлэг”³ гэгдсэн “амьтан” юм. Хүн анх эхийн хэвлий хүүхэн хэвтэш (сав, умай)-д тогтон бүрэлдэж амь насны анхны гараагаа эцгийн дусал, эхийн цус, сэтгэл гурвын органик нэгдэл болж хөврөн бойжиж эхэлдэг. “Умайд тогтсон дусал, цус, сэтгэл гурав нь тус тус махбодын мөн чанартай байдаг. Энэ гурвын дотроос эцгийн дусал бол умайд оршсон тэр биеийн долоон тамираас яс хийгээд тархи, нугас, гол нурууг үүсгэнэ. Эхийн цус бол долоон тамираас мах, цус хийгээд таван цул, зургаан савыг үүсгэнэ”⁴. Гэхдээ тэрхүү “дусал”, “цус” хоёр заавал эрүүл энх байх шаардлагатай. “Эрийн дусал цагаан хүнд амттай их болбоос гэмгүйн тэмдэг. Эхнэрийн сарын бэлэг нь энгэсэгний шүүс ба туулайн цус мэт угааваас ариун гэмгүй бөгөөс сая умайд тогтож чадах”⁵ юм. Ингэж эцгийн дусал ба эхийн цус анхлан барилдсан тэр мөчөөсөө салшгүй нэгдээд бие сэтгэлийн бүхэл цогцыг бүтээдэг боловч бүхэлдээ өсөн бойжилтын явцдаа бүр хоол хүнсний шим тэжээлт бодисыг түшиглэдэг.

Даруй 8 зүйлийн тэжээлт эд болох уураг, өөх, нүүрс усны нэгдэл, эрдэс бодис, ус зэрэг 6 зүйлийн химийн бодисын дээр нь хүчилтөрөгч ба ширхэглэг эдийг багтаан үздэг. Иймээс хоол хүнсний тэжээлт эд нь хүний бие тогтох хөрс шороо нь болох мөртөө амь насны оршин тогтнох эргэлтийн үйл ажиллааны энергийн баталгаа болж байдаг. “Иймээс хоол хүнс нь амь насны түүхий материал болж мөн бидэнд энерги болон барилгын материал хангаж байдаг”⁶ гэжээ. Энэ нь

²Дармунанрагба, Лувсанчойрог. “Алтан хадмал” (дээд), ӨМХБ, ӨМШУТМХХ 2015, т 13

³Нагунбилэг, Бао Вэнь Фөн. “Монгол эмнэлгийн бие сэтгэл харилцан үйлдэлцэх засал”, ҮнХХ 2018, т 9

⁴Дармунанрагба, Лувсанчойрог. “Алтан хадмал” (дээд), ӨМХБ, ӨМШУТМХХ 2015, т 34

⁵Дармунанрагба, Лувсанчойрог. “Алтан хадмал” (дээд), ӨМХБ, ӨМШУТМХХ 2015, т 27

⁶А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 282



МОНГОЛЧУУДЫН ОВОО ТАХИХДАА ТОВЛОЖ ТОГТСОН ОРОН БАЙРТАА ОЛОН ХЭСЭГ ЧУЛУУГ ОВООЛЖ, ТАСРАЛТГҮЙ НЭМЖ БАЙЖ САЯ “ОВОО” БОЛГОН ДҮНХИЙЛГЭЖ, ТАХИЛ ТАВИГАА ӨРГӨН “ОВООНЫ ТАХИЛГА”-АА ХИЙДЭГТЭЙ ТӨСТЭЙ ЮМ. Яриангүй овоог цас, шороо, мод мэтээр босгож болдог ч монголчуудын овооны соёлд хэзээнээс чулуугаар босгосон овоо ноёрхох байртай уламжлагдаж ирсэн нь, бас нялх хүүхдийг хоолонд орсон үеэс нь эхлүүлж цагаан идээ, улаан идээгээр голлон тордож бусад зүйлийг хавсаргадагтай адилхан юм. “Хэрвээ 1 наснаас доош хүүхдэд урт хугацаагаар шим тэжээл дутагдвал түүний уураг тархины эсийн тоо нь багасаж хэзээд эргэшгүй тархины бойжилт бүрэн бус ба ой билгийн доройтолд нэгмөсөн оруулдаг”⁷ нь эрүүл бие саруул ухаантай хүний биеийг тогтооход шим тэжээлтэй идээ ундааны зүйл нь суурь чулуу мэт нөлөө үзүүлдгийг гэрчилнэ. Өөрөөр хэлбэл, идээ ундааны энерги нь “машин тэрэгний хөдөлгүүр ажиллахад шатахууны шаталтаар энерги буй болж байхтай адил”⁸-аар хүний биеийн мөч тутамд няцашгүй үйлчилгээ үзүүлдэг юм.

Монгол эмт хоолонд үнээний сүү нь шим тэжээлийн эх сурвалж болно. Бүрэлдэхүүний хувьд, кальц, фосфор, төмөр зэргээс гадна магни, кали, натри зэрэг бичил элемент баялаг агуулж, уушги нэвчирсэн, уушгины архаг, хуучирсан хижиг, чихрийн шижин өвчин, хөхний сүү дутагдах зэрэгт тусалж чаддагаас одоогоор 60%-аас дээш тооны хүмүүс “сүү уудаг” болсноос үнээний сүү нь БНХАУ-ын хүн амын эрүүл мэндийн хөөцөлдлийн шинэ давалгааг босгож буй. Ялангуяа үнээний сүү нь тамир тэнхээ муудсан, өнгө зүс, хүч буурсан, шим тэжээл дутагдсаныг нөхвөрлөх чадал үйлдэл нь түүнийг “хамгийн дээд сайн шим тэжээлт идээ”, “хүний биеийн бүх шим тэжээлийг нөхвөрлөж”⁹, “хүний биеийн бүх эрхтний ажиллагааны хэвийн үйл ажиллагааг батлахад идэвхтэй нөлөө үзүүлэх” тэжээл болгон, “иль”, “монгол үхэр” тэргүүтэй сүүн бүтээгдэхүүний аж ахуйлал

⁷А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 282-283

⁸А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 282

⁹Вүчи Шисань. “Монгол эмнэлгийн үргэлжийн тамир тэжээхүй идээ ундаа”, ЛяоҮнХХ 2012, т 8-9



нь өвөр монголын тал нутаг дээр хөл тогтон бүх улс, цаашлаад Ази, Европын нутгаар хөгжих өнгө шимлэг хөрс шороотой болж чадсан юм.

“500г хонины мах нь хүний биед 6427kj энергийг хангаж чадах болохоор өвлийн улиралд идэхэд тохиромжтой шимт идээний нэг болно. Хонины үүлдэр, нас, тарганы хэмжээ адил бусаас түүний шим тэжээлийн ашиг нь адил бус, гэвч ихэнх шим тэжээлийн бүрэлдэхүүн нь бүр хүний биеийг шимжүүлэх”¹⁰ нөлөөтэй байдаг бол үхрийн мах нь “дэлүү ходоодны тамирыг нөхөх, судас шөрмөсийг чийрэгжүүлэх чадалтай. Дэлүү ходоодны тамир дорой, шингээлт муудах, өвчилж тамир доройдсон, мэсийн шарх удаан эдгэрэх”¹¹ зэрэгт онц сайн тул монголчууд язгуураасаа хонь, үхрийн махыг тамир цусыг нөхвөрлөж чадах идээ гэж чухалчлан үзэж монгол эмт хоолныхоо гол эх материлаа болгож ирсэн юм.

Баргийн шимжүүлж төлжүүлэх идээ ундааны заслаас хонины мах шүүсний засал ба улаан тарлан үнээний сүү нь орон нутгийн онцлогоор гойд, эдүгээ ч ач холбогдлоор товойм байдаг. Монголчууд хонины махыг идэж, шөлийг уух нь “таван хөнөөл, долоон гэмтэл ба цул савын хийг засдаг. Үргэлж ууваас савыг сэлбэн тамирыг сайжруулмуй, борвины ясны шөл (голдуу эрэгтэй эмэгтэйн тамир дорой, сав хийн хүйтнээр туранхай болж, бөөрний тамир буурсаныг засаж, цусан судлыг сайжруулан сарын хирийг тэгшитгэмүй), үндсэн гурван шимтийн шөл, бэлчээрийн улаан тарлан үнээний сүү (бэлчээрийн мал, аливаа мал өөрийн төрөлх мэдрэмжээрээ ургамлаас аль хэрэгцээт өвсөө газар дээрээс нь шилж хэлээрээ зулгаан идэх нь байгаллаг чанартай байж, шим чанар нь ч төгс байдаг ажээ. Улаан тарлан зүстэй үнээн сүү, бусад зүсмийн үнээний сүүнээс амьтны амь амьжралыг тэтгэн тэжээх шим нь өндөр, шим тэжээлт бодисын бүрэлдэхүүн нь эхийн сүүтэй ойролцоо байдгаас нүүдэлчин

¹⁰Вүчи Шисань. “Монгол эмнэлгийн үргэлжийн тамир тэжээхүй идээ ундаа”, ЛяоҮнХХ 2012, т 3

¹¹Вүчи Шисань. “Монгол эмнэлгийн үргэлжийн тамир тэжээхүй идээ ундаа”, ЛяоҮнХХ 2012, т 6



монголчууд өргөмөл хүүхдээ тусгайлан улаан тарлан үнээний сүүгээр угждаг уламжлалт заншил буй), өрөм, тос, айраг, бал бурам, чихэр, цагаан зүсмийн гүүний саамны тунгалаг цэгээ, бор дарс зэрэг цагаан өнгийн зөөлөн шимт идээ ундаан”¹² -г онцгойлон дээдлэх нь өнөө үед өргөн түмний сонирхол таашаалд хүрч буй.

“Хүн төрөлхтний оршин тогтнох цорын гагц суурь бол сайн энергийг үүсгэх амьд бодисын хуулийг дээдэлж, харилцан хайрлан хамгаалж бүлгэмдэх”¹³-д оршино. Учир нь нийгэмчлэн амьдрах нь хүн төрөлхтний оршин тогтнохын үндсэн хууль болж олон зуу мянган жилийн туршид уламжлагдсаар ирсэн юм. Үүнд түшилцэн орших, харилцан тус дэмжлэг үзүүлэх, хамт нийтийн эрүүл мэндээ батлан хамгаалах, хянах хязгаарлах зэрэг амьд бодисын өөрийгөө хөхиүн хөгжүүлж шагнаж торгох жам хуультай байх мөртөө эцсийн ашгийг нь хувь хүн хүртэж байдаг юм.

Ингэж хүн төрөлхтний бие тогтох ур ёсны эх сурвалж нь хамтын эрх ашгаа хамгаалан хөгжүүлж уламжлан бэхжүүлэх үйл ажиллагаанаас эхэлж, үе дамжин уламжлагдана. Ялангуяа шинэ титэмлэг уушгины сүрьеэ дэлгэрч байгаа онцгой цаг эринд хамтын эрүүл энх, амар төвшин, сайн сайхнаа бэхжүүлэн хамгаалах нь нэгэнт хүний бие тогтох ур ёсны тухай нийтлэг ойлголт болжээ. “Хайр бол нэг зүйлийн сайн энерги, сайн энергийг үүсгэж чадвал сая багтаан энэрч чадна. Багтаан энэрэх бол сайн энерги, багтаан энэрч чадвал сая бүлгэмдэлтэй, эв найрамдалтай болж, хүн төрөлхтөн урт удаан хугацаагаар оршин тогтнох суурь бүрэлдэнэ. Ингээд цорын гагц оршин тогтнох гэр орон-дэлхийн бөмбөрцгөө хайрлах болно. Энэ бол хүн төрөлхтний дархан үүрэг хариуцлага юм. Мөн ч хүн төрөлхтний цорын гагц гарах зам юм. Хэрэв харилцан дайсагнавал өөрийгөө устган гэр орноо ч үгүй хийнэ”¹⁴. Тухайлбал, өөрийгөө

¹²Вүчи Шисань. “Монгол эмнэлгийн үргэлжийн тамир тэжээхүй идээ ундаа”, ЛяоҮнХХ 2012, т 65

¹³А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 8

¹⁴А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 60



хайрлахын төлөө өрөөлийг хайрлах хэрэгтэй. Учир нь “хүнийг хайрлах нь өөрийгөө хайрласан явдал” юм. Энэ бол даруй нийгэмчлэн амьдардаг шинж бүхий хүн төрөлхтний оршин хөгжих мөнхийн жам хууль мөн.

Хоёр. Их ёсон огоот цулгүй

Ертөнцийн түмэн бодис дөхөм(*хялбар, товч*) дөтөөсөө нарийн будлиантай өнөр ялдам өнгө аястай болж өсөн хөгжих жамтай билээ. Хүн ч адилхан, анх далай тэнгист дан эст амьтан болж бүрэлдээд урт удаан хөгжлийн явцыг өнгөрөөгөөд өнөөдрийн “хоёр хөлтэй, хохимой толгойтой, усан нүдтэй, цусан зүрхтэй” дээд оюунт амьтан болж хөгжсөн юм. Энэ нь “ертөнцийн хэчнээн будлиантай зүйл ч бүр хамгийн дөхөм явцаар бүрэлдсэн буюу хамгийн дөхөм уг ёсонд эзэмдэгдэж байдаг”¹⁵ гэдгийг харуулжээ. Компьютероор жишээлэхэд, “үнэндээ түүний үндсэн уг ёс нь маш дөхөм, даруй 0 буюу 1, өөрөөр хэлбэл нээх буюу хаах”¹⁶ болно. Шинэ титэмлэг уушгины сүрьеэ өвчин нь дэлхий дахинд үхэл зовлонг авчирч лут их аюул гамшиг болж байгаа боловч бид өөрсдийгөө сайтар тордож, өвчнийг үл халдаах чадвараа дээшлүүлчихвэл, тэрхүү аймшигтай өвчний бактерийг лавтай(*бүрэн*) ялж чадна. Хүний бие махбод нь “өөрийгөө шалган байцаах, өөрийгөө зохицуулах, өөрийгөө сэлбэн засах чадавхитай байдаг”¹⁷-ийн дээр бид цагийн байдалд зохицуулан идээ ундаанд суурилсан “эрүүл амьдрах зүй”-д сайтар суралцан хэрэгжүүлбэл өөрсдийнхөө эрүүл энхийн байдалд байнга байлгана. Учир нь “хүний төрөлх чадвар бол өөрийнх нь хамгийн сайн эмч юм, эмч ба эм бол зөвхөн төрөлх чадварыг нь дэмжих төдий”¹⁸ зүйл юм.

¹⁵ Нагунбилэг, Бао Вэнь Фөн. “Монгол эмнэлгийн бие сэтгэл харилцан үйлдэлцэх засал”, ҮнХХ 2018, т 8

¹⁶ Нагунбилэг, Бао Вэнь Фөн. “Монгол эмнэлгийн бие сэтгэл харилцан үйлдэлцэх засал”, ҮнХХ 2018, т 8

¹⁷ Нагунбилэг, Бао Вэнь Фөн. “Монгол эмнэлгийн бие сэтгэл харилцан үйлдэлцэх засал”, ҮнХХ 2018, т 9

¹⁸ Нагунбилэг, Бао Вэнь Фөн. “Монгол эмнэлгийн бие сэтгэл харилцан



Хижиг тахал дэлгэрч байгаа энэ эринд, өөрийгөө эрүүл саруул авч явж чадах эсэх нь үнэндээ нэг ёсны амьдралд тулгарсан бачим(*чухаг, давчуу*) чанга “шалган байцаалт”(үзлэг, *онош*) мөн. Үүнд хижгийг үл халдаах бие цогц нь тэрхүү “шалган байцаалт”-ын давааг давж чадах эсэхийн зангилаа болно. Монгол үндэстний онцлогт эмт идээгээр “биеэ хамгаалах зэвсэг” хийж, амьтан голтонг эрхэмлэн хайрлаж, байгалаагаар шимтэн шингээсэн хижгээс сэргийлэх бат чанга бэхлэлтийн суурийг тавьж чадна. Иймэрхүү дадал нь хүн зоны өөрсдийнхөө дотоод сэтгэлийн энерги ба нуугдмал хүчээ дайчлан бадруулж, идээ ундаанд тулгуурлан, явдал мөр, сэтгэц зүйн санал зөвлөлгөөг уялдуулсан өвөрмөц шинжтэй юм. “Эд хөрөнгөө алдвал багыг алдана, нэр төрөө алдвал ихийг алдана, эрүүл мэндээ алдвал бүгдийг алдана шүү. Эрүүл мэнд ба амь нас бол хамгийн нандин өв хөрөнгө болох юм. Бид үүнийг хүнд найдаж болохгүй, заавал өөрийн гартаа атгах хэрэгтэй. Тиймээс эрүүл энх амьдрах арга ухаанд суралцах бол туйлын чухал”¹⁹ болоод байна. Бүрэн гүйцэд, тэнцвэртэй эмт хоол нь эрүүл мэндийн суурь, эрүүлжихийн баталгаа, хижгийг урьдчилан сэргийлэх ба эмчлэхийн нэгдүгээр алхам болно. Өдөр тутмын амьдралдаа хоол хүнсний бүрэлдэхүүнийг онц анхаарч, ургамлын гаралтай хоол хүнсийг илүүхэн хэрэглэж, амьтны гаралтай хоол хүнсийг бага хэрэглэж, олон төрлийн, олон өнгийн хоол хүнсийг хэрэглэхдээ хүний бие нь уламжлалт цагаан, улаан, бор, хөх зэргийн хоол хүнснээс олон зүйлийн шим тэжээлийг авч, оршин тогтнож байдаг зарчмыг баримтлах хэрэгтэй. “Идэж ууж чадаж байвал эрүүл гэсэн явдал биш, харин зөв идэж, зөв ууж чадвал сая эрүүл мэндийн суурийг тавьж чадна. Амандаа хөтлөгдөн хоолловол ам баярлаж, бие сэтгэл хохирох юм. Хэрэв ухаандаа хөтлөгдөн хоолловол, ам баярлахаар барахгүй бие сэтгэл нэн илүү баярлаж, эрүүл энхийг олж”²⁰ чадах юм.

Цаг үеэ хурц мэдрэн, нийгмийн хөгжилтэй ид

үйлдэлцэх засал”, ҮнХХ 2018, т 9

¹⁹А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 4-5

²⁰А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 10-11



зохицолдон, эрүүл энх амьдрах нь өнөө цагийн хүмүүсийн заяагдмал илэрхийлэл болжээ. Илрээгүй өвчнөө урьдаар эдгэрүүлж, өөрөө өөрийгөө эрүүлжүүлэх арга ухааныг эзэмшиж, хувь заяаныхаа ерөнхий удирдагч болж, аз жаргалтай, сайн сайхан амьдралын хөтлөгч болох хэрэгтэй. Дэлхийн эрүүлийг хамгааллын зохион байгуулалт (WHO-Дэлхийн эрүүл мэндийн байгууллага)-аас дурдсан “зөв хооллох, зохистой хөдөлгөөн хийх, сэтгэл санаагаа тайван байлгах”, эрүүл энхийн “их ёс”-ыг мөрдөн хэрэгжүүлэхэд зөв хооллохоос эхлэх ёстой юм. **“Хүний бие махбод нь уураг, өөх, нүүрс усны нэгдэл, эрдэс бодис, ус зэрэг 6 зүйлийн химийн бодисоор бүрэлдэж, дээр нь хүчилтөрөгч ба ширхэглэг эд зэрэг 8 зүйлийн тэжээлт эдийг түшиглэн оршдог. Дээрх 8 зүйлийг зохистой хэрэглэхийг зөв хооллолт”**²¹ гэнэ. Монголчууд хэзээнээс их иддэг хүнийг “гахай шиг цадахаа мэдэхгүй амьтан” гэж болхи бүдүүлгийн тэргүүнд тооцдог. Харин биеийг тэжээж чаддаг чанар сайтай олон төрөл зүйлийн, олон өнгө загвартай хоол ундыг шим тэжээл сайтай хэмээн эрхэмлэдэг. “Өдөрт 30-40 зүйлийн хоол хүнс хэрэглэхийг хичээж, хоол голохгүйгээр бага багаар олон удаа хооллох зарчмыг биелүүлбэл таны эрүүл мэндийн суурь сайн болно”²² гэж монгол анагаах ухаантнууд номлох болсныг анхааралдаа авбал зохино. Хижиг тахал дэлгэрснээр хүмүүсийн эрүүл мэндийн тухай ойлголт дээшилж, “бие байвал Бээжин” гэх хуучин үгийн утгыг нэн ухамсарлан, эрүүл мэндийг хамгийн эрхэм дээд хүслээ болгон аж төрөх болж байна. “Байгаллаг анагаах арга гэдэг нь бүх зүйлийн байгаллаг аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх буюу эмчлэн засах аргыг хэлдэг. Бодитоор хэлбэл, даруй хүний амьдрал лугаа шууд холбогдох хоол хүнс, хөдөлгөөн, сэтгэц зүй, агаар, ус, нарны гэрэл, эрүүлжүүлэх тамир, сэтгэлд нууц дохио өгөх, эрүүл мэндийн жолоодлого, дуу хөгжим, унтуулах арга, сүсэг бишрэл, бодлоороо удирдах, эрүүл мэндэд ашигтай оюун мэдрэлийн элемент зэрэг зүйлсээр эрүүл мэндийг хамгаалах болон эрүүлжүүлэх нэг зүйлийн шинжлэх

²¹А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 16-17

²²А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 17



ухаан”²³ мөн.

Байгаллаг анагаах арга нь хоол хүнсээр дэвсгэрлэн өсөн хөгжөөд эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх, эмнэн засах, эдгэрүүлэх зорилтод хүрдгээс идээ ундаагаар эмнэх, засаж эдгэрүүлэх бол дэлхий дахинд зөвшөөрөгдсөн “их ёсон” болох нь дамжиггүй болжээ. Сүүлийн үед АНУ-ийн эрдэмтдийн судлан илрүүлснээр нэг хүний эрүүл мэндийн байдал нь гурван үеийн хүмүүсийн эрүүл мэнд амь насанд нөлөөлдөг нь “удамшлын генийн өөрчлөлт биш, харин уургийн хувирлаар дамжин нөлөөлдөг гэснийг мэдсэн байна. Амьдралын зан дадал ба арга хэлбэр нь нэг хүний үр хүүхэд, омбол(ач) хүүхэд цаашилбал олон үеийн хойчсийн эрүүл мэндэд нөлөөлдөг”²⁴ ажээ. Өнөөдрийн хүмүүсийн эрүүл энх байгаа нь бидний өвөг эмэг, элэнц өвөг эмэг, өвөг дээдсийн маань идээ ундааны зан заншлыг багтаасан уламжлалт сайхан ёс моралийн үр ашиг болох юм. Гэвч “хүн төрөлхтний өвчин ч нийгмийн хөгжлийг дагалдан хөгжиж, элдэв хачин өвчин эмгэг буй болж, өвчний төрөл зүйл улам олшрон, улам будлиантай болж, дэд эрүүл хүмүүс улам олшрон, өнөө болоход хүн төрөлхтний 75%-г эзлэх болсон”²⁵-оос дэлхийн эрүүлийг хамгааллын зохион байгуулалтаас “маш олон хүн өвчнөөр биш, харин эрүүл мэндийн тухай мэдлэг мөхсөөс болж, эрүүл мэнд амь насаа алдаж байна”²⁶ гэж зарлан сэрэмжлүүлсэн байдаг.

Хижиг тахал дэлгэрсэн хямралтай энэ үед, эрүүл мэндээ баталж чадах эсэх нь улс үндэстний хөгжлийн түвшний чухал баримжаа болж “ихэнхдээ биднийг авч явж байгаа эрүүл мэндийн тухай мэдлэг нь өөр бусад хүмүүсээс дууриан сурч авсан мэдлэг байдаг. Өөр хүн яаж хийж, яаж идэж, яаж ууж байгааг дууриан сурдаг. Ингээд өөр хүн ямар өвчин олбол бид мөн тийм өвчин олж байдаг”²⁷-аас бид идээ ундааны амьдралын

²³А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 2

²⁴А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 10

²⁵А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 3

²⁶А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 6

²⁷А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 6



хэв заншилдаа заавал цагийг амжин өөрчлөлт оруулах хэрэгтэй болжээ. Монголчуудын “ам бол там” гэсэн гүн ухааны үзлээр “амаа барих”-ыг сайтар хичээж, өдөр шөнөгүй идэж уун, шалин бүрэлгэхийг хатуу цээрлэн, хүн бүхэн хичээн журамлавал зохино.

Гурав. Бие сэтгэлийн зөв энерги

Идээ ундаа бол бие сэтгэлийн зөв энергийн эх сурвалж мөн. Үүнд монгол үндэстний онцлогт эмт хоол нь бие сэтгэлийн органик шүтэлцээ, үйл ажиллагагд хэрэгсэх зөв энергийн хөмрөг болж өгдөг. “Хүний бие бол маш аварга том амьд бодисын химийн үйлдвэр, эмийн үйлдвэр, цахилгаан үйлдвэр, энергийн үйлдвэр”²⁸ юм. Өдөр тутмын идээ ундаагаар бидний бие махбодод сайн энерги дамжигдан ирж, тэрхүү аварга том үйлдвэрийн эерэг эргэлтийг батлан өрнүүлж байдаг.

Хүн бол эрүүл бие тулгуурлаж, саруул ухаан хөтөлсөн амь насны органик бүхэл цогцот систем болно. “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн өвчний шалтгааныг үзүүлсэн бүлэгт “аливаа өвчний үндсэн шалтгаан нь: Ухаангүйгээс ирмүй. Ухаангүйгээс тачаангуй, урин, мунхаг үүсмүй.

Эдгээр бол бодит өвчний шалтгаан болой. Бас тачаангуй, урин, мунхагаас хий, шар, бадган гурван махбод дүр урваад өвчин үүсгэмүй. Иймээс гурван махбод бол өвчин болохын шууд шалтгаан болно”²⁹ хэмээн дүгнэж, эцсийн эцэст аливаа өвчний дотоод шалтгаан нь бүр хүний сэтгэлээс болдог гэж зааж гаргасан байдаг. “Хүний тогтомт, чанар нь угаас сайн”³⁰ гэдэг үзэл санаанд үндэслэж, “өвчнийг засахад урьдаар сэтгэлийг засна, сэтгэлийг засахад урьдаар хүнийг нь засна”³¹ гэсэн

²⁸ А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 19

²⁹ Нагунбилэг, Бао Вэнь Фөн. “Монгол эмнэлгийн бие сэтгэл харилцан үйлдэлцэх засал”, ҮнХХ 2018, т 82

³⁰ Нагунбилэг, Бао Вэнь Фөн. “Монгол эмнэлгийн бие сэтгэл харилцан үйлдэлцэх засал”, ҮнХХ 2018, т 35

³¹ Нагунбилэг, Бао Вэнь Фөн. “Монгол эмнэлгийн бие сэтгэл харилцан үйлдэлцэх засал”, ҮнХХ 2018, т 35



монгол анагаах ухааны сэтгэц заслын жамд нийцүүлэн хэрэглэж, хижиг дэлгэрсэн ахуй байдалд хүмүүсийн бие сэтгэлийн хос эрүүлжлийг биелүүлэх бол цаг үед тулгамдсан нийгмийн нэн чухал үүрэг болно.

Хэрэв та эрүүл мэнддээ анхаарал тавьж, “зохисгүй муу дадлуудаа хаяж, амаа барьж зөв хооллож, хөлөө хөдөлгөж зохистой биеийн тамирын хөдөлгөөн хийх”³²-ийг баримталж чадвал хижиг тахал дэлгэрсэн хямралтай үед ч гэсэн эрүүл мэндээ хамгаалж чадна. Өөрөөр хэлбэл бид “өөрийгөө зөв удирдан сайн энергийг үүсгэж, хөгжүүлж, бадруулж, дамжуулж, хуваалцаж, хүртэж байх ёстой. Ингээд бид сайн энергитэй эрүүл чийрэг хүн болно. Үүнийг биелүүлэхэд маш хялбархан байдаг. Тухайлбал, инээмсэглэхээс л эхлээд сайн үйлүүдийг хийж байгаарай”³³.

Монгол эмт хоол бол уургийн агууламжаар туйлын баялаг байдаг. “Хоол хүнсний доторх уураг нь биеийн дотор шингээлтээр дамжин задраад шивтэрт хүчил болдог. Дараа нь шивтэрт хүчлийн хэлбэрээр биед шингэж уургийг хангадаг. Шивтэрт хүчлийн төрөл бүрэн, тоо хэмжээ нь гүйцэд, харьцаа нь тохиромжтой бол сая охь сайн уураг болдог”³⁴. Гарцаагүй цагаан, улаан, хөх, бор олон зүйлийн идээг хольж идвэл сая уургийн үнэ цэнийг дээшлүүлж чадах мөртөө уургийн харилцан нөхөх үйлдлийг гүйцэд дээшлүүлж чадна. Монгол эмт хоолонд агуулагдан бүхий уураг нь “амь насны суурь” болох мөртөө органик биеийн бүх нэхдэсийн эсийг бүрэлдүүлэх “бодисын суурь” болж өгдөг давхар суурийн бат цогцолборт асар их нөлөө үзүүлж байдаг бөгөөд тэр нь монгол үндэстний уламжлалт цагаан идээ, улаан идээ жич үр тариан төрөл, бурцгийн бүтээгдэхүүнд элбэг баялаг байдаг юм.

Нэг өдрийн уургийн хэрэгцээ нь 1kg биеийн хүндэд 0.8g шаардагдана. Тухайлбал 50kg биеийн жинтэй хүнд 40g уураг

³² А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 24

³³ А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 20

³⁴ А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 286



хэрэгтэй³⁵ байдгаас “ерийн байдалд өдөр тутмын хоол хүнсээс шингээн авах уургийн хэмжээ нь хүмүүсийн бие махбодын хэрэгцээнд хангалттай байдаг³⁶. Монголчуудын хоол цайн уламжлалт дэг журмыг баримтлан хэрэгжүүлэх нь зүйтэй. Учир нь уураг ихтэй хоолыг хэтэрхий хэрэглэх нь үнэндээ бүрэлгэн сүйтгэх үйл ажиллагаа болох тул хоол ундны хэм хэмжээ, цаг хугацааг онцгойлон анхаарах нь хижиг дэлгэрсэн цаг үеийн хүн болгоны үйл ажиллагаа болох мөртөө судлан шинжлэгчдийн өмнө цаг үеэр дэвшигдэн тулгарсан судлагдахуун мөн.

ДҮГНЭЛТ

Монгол үндэстний эмт хоол нь идээ ундаа, тэжээл бодис ба ерөндгийн нэгдмэл цогц бүхий ил тодорхой үндэстний онцлог шинж ба орон нутгийн өвөрмөц чанарыг агуулсан байдаг. Идэж ууж л байвал эрүүл гэсэн үг биш, харин зөв идэж, зөв уувал эрүүл мэндийн сайн суурийг бататгаж чадна. Ходоодондоо захирагдан хоолловол ходоод цадах ч, бие сэтгэл хохирох талтай. Хэрэв ухаандаа хөтлөгдөн хоолловол, ходоод баярлахаар барахгүй бие сэтгэл нэн илүү баярлаж, эрүүл энх амьдрах билээ. Өвчин тахал дэлгэрсэн хүнд цаг үед, монгол эмийн зүйлийг агуулсан хүнс хэрэглэх нь туйлын чухал юм.

ABSTRACT

Under the background of normalization of epidemic prevention and control, this paper gives a unique understanding of the specific cultural phenomenon “the development value of Mongolian characteristic medicinal diet”, such as “embryonic development”, “simplicity of the road” and “positive energy of body and mind”.

Keywords: *Mongolian characteristic medicinal diet, of epidemic prevention and control background, meaning of development and utilization*

³⁵ А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 286-287

³⁶ А.Мөнх. “Эрүүл энхийн шинэ ертөнц”, ҮнХХ 2018, т 287



Тус өгүүлэл бол БНХАУ-ын Биеийн тамирын ерөнхий товчоо, Биеийн тамир соёл хөгжилтийн төв, Биеийн тамирын соёл судлах суурин газрын гол болох судалгааны төслийн хүрээнд бичигдсэн болно.

Товчилсон үг:

ЛяоҮнХХ – *Ляонины үндэстний хэвлэлийн хороо*
ӨМХБ, ӨМШУТМХХ – *Өвөр монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо*
ҮнХХ – *Үндэстний хэвлэлийн хороо*

Зохиогчийн танилцуулга:

Номин.

БНХАУ-ын Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн багшаар. Судалгааны гол чиглэл монгол зан үйл, ардын соёл.

E-mail : 15247526862@163.com

Хай Ли.

БНХАУ-ын Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн 2020 оны магистрант.

“СОЁЛЫН ЖИМЭЭР” эрдэм шинжилгээний сэтгүүлд

ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ

Ерөнхий шаардлага:

- Урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Монгол судлал ба түүх, соёлын чиглэлийн асуудлыг хөндсөн байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг үзэл санаа дэвшүүлсэн байх
- Судалгааны логик уялдаа, дэс дараалал тодорхой байх

Техник шаардлага:

- Кирил үсгээр бичигдсэн байх (үүний хамт гарчиг, товч агуулга, түлхүүр үг зэргийг англи хэл дээр бичих)
- Хэл зүй хийгээд найруулга зүйн ямар нэг алдаагүй байх
- Үг үсгийн алдаагүй байх
- Цаасны хэмжээ В5
- Үсгийн өндөр 12
- Эшлэл зүүлтийг тухайн хуудсанд хийх эсвэл АРА форматаар бичсэн байх (үсгийн өндөр 10)
- Нүүрийн тоо – 8-15

Судалгааны ажлын бүтэц:

Гарчиг

- Гарчиг англи хэл дээр (content)
- Судлаачийн овог нэр, эрдмийн цол зэрэг, эрхэлж буй ажил, и-мэйл хаяг, утасны дугаарыг бичих
- Товч агуулга
- Товч агуулга англи хэл дээр (abstract)
- Түлхүүр үг
- Түлхүүр үг англи хэл дээр (key word)
- Судалгааны үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Ном зүй
- Дагалдуулал (хэрвээ шаардлагатай бол үйлдэх)

Өгүүлэл хэвлэгдэх явц:

- Өгүүлэл хүлээн авна.
- Өгүүллийг редакцийн гишүүд шүүн хэлэлцэнэ.
- Хэвлэх ба үл хэвлэхийг шийднэ.
- Хэвлэгдэх боломжтой засварлах, өөрчлөх зүйлс буйг мэдэгдэнэ (тодорхой хугацаа өгнө).
- Өгүүлэл хэвлэгдэнэ.

- אלקטרוניקה

- אלקטרוניקה ממוחשבת • אלקטרוניקה דיגיטלית • אלקטרוניקה אנלוגית • אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים

אלקטרוניקה של מכשירים :

- אלקטרוניקה של מכשירים (אלקטרוניקה של מכשירים)

- אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים (key word)

- אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים (abstract)

- אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים

- אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים • E-mail

- אלקטרוניקה של מכשירים • אלקטרוניקה של מכשירים (content)

- אלקטרוניקה של מכשירים

אלקטרוניקה של מכשירים :



ISSN: 2791-1446

СОЁЛЫН ЖИМЭЭР

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН

ТАНИЛЦУУЛГА

2022



ДҮГЭРЖАВЫН БАДАМДОРЖ

Төрсөн газар: 1950 онд Завхан аймгийн Эрдэнэхайрхан сум

Нийгмийн байдал: Малчин

Боловсрол: Дээд

Ажилладаг салбар: Боловсрол, Шинжлэх ухаан

Мэргэжил: Монгол хэл, уран зохиолын багш

Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

д/д	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1	Завхан, тэлмэн сум, Бага сургууль	1968-1970 он	Бага ангийн багш
2	Завхан, Төвийн 10 жилийн сургууль	1970-1973 он	Пионерийн ахлах удирдагч
3	ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн	1979-1983	Эрдэм шинжилгээний ажилтан
4	Ховд, УБДС	1983-1986	Монгол хэлний багш
5	Япон, Токио, Гадаад хэлний их сургууль	1986-1989	Зочин профессор
6	МУИС Унгар, Шинжлэх ухааны их сургууль МУИС	1990 оноос 2009-2015 он 2016 оноос	Монгол хэлний багш Зочин профессор Зөвлөх профессор

Эрдмийн зэрэг, цол

Хэл бичгийн шинжлэх ухааны доктор, МУИС-ийн профессор

Судалгааны чиглэл

Монгол хэл шинжлэлийн утга судлал



ЛУВСАНЖАВЫН ЧУЛУУНБААТАР

1952 онд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр суманд төрсөн.

Боловсрол:

1960-1964 Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын бага сургууль,

1964-1968 Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын 8 жилийн дунд сургууль,

1968-1970 Мөрөн хотын 1-р 10 жилийн дунд сургууль

1976-1981 МУИС-ийн ХБФ-ийн Монгол хэлний анги

1982-1983 МУИС-ийн Багш нарын сурганы курс

1984-1986 МУИС-ийн Англи хэлний 2 жилийн оройн курс

1999-2000 ОХУ-ын Улаан-Үүд хотын Монгол,Төвд, Буддын судлалын хүрээлэнгийн докторантур

2005 оны 4-р сараас 2005 оны 12-р сар Токиогийн Гадаад Судлалын Их сургуулийн япон хэлний 9 сарын курс.

Ажилласан байдал:

1970-1971 Хөвсгөл аймгийн Мөрөн хотын Гурилын үйлдвэрт ажилчин

1971-1974 Ардын армийн 013-р ангид байлдагч, бага түрүүч

1974-1976 Хөвсгөл аймгийн Мөрөн хотын Гурилын үйлдвэрт ажилчин

1981-1989 МУИС-ийн ХБФ-ийн Монгол хэлний тэнхимд багш

1989-1991 Англи улсын Лондонгийн Их Сургуульд мэргэжилтэн багш

1991-1992 МУИС-ийн ХБФ-ийн Монгол хэлний тэнхимд багш

1992-1994 МУИС-ийн Аспирантур хариуцсан мэргэжилтэн

1994-1998 МУИС-ийн Гадаад харилцааны хэлтсийн дарга

1998-2003 МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн эрхлэгч

2003-2005 МУИС-ийн МХСС-ийн захирал

2005-2008 Токиогийн Гадаад Судлалын Их сургуулийн зочин профессор

2008 оны 4 сараас МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн профессор багш

2009 оны 9 сараас 2013 МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн эрхлэгч

2013-2014 МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн зөвлөх профессор

2014-2016 БНХАУ-ын ӨМӨЗО-ны ӨМИС-д зочин профессор

2016-2017 МУИС, ШУС, ХУС, ИБАС-ийн тэнхмийн зөвлөх профессор

2017 оны 9 сараас МУИС-ийн ОУХС-ийн Англи хэлний хөтөлбөрийн багт зөвлөх профессор



Холбоо барих хаяг: Л.Чулуунбаатар, 46/386, Улаанбаатар, Монгол улс

Холбоо барих утас: 976-99094006 гар,

Майл: oyunavral@yahoo.com, l.chuluunbaatar@nunm.edu.mn,

Хэлний чадвар: Орос, Англи, бичгийн Төвд хэлтэй, Япон хэлний анхан шатны мэдлэгтэй

Шагнал: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон, Боловсролын тэргүүн, Шинжлэх ухааны тэргүүн, Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч медаль, багшийн алдар медаль болон ойн медалууд



Н.МЯГМАР

ШУА-ИЙН ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭНГИЙН НИЙГЭМ СОЁЛЫН ХҮН СУДЛАЛЫН САЛБАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

НЭГ. ДИССЕРТАЦИ ЗОХИОЛ

1. Төв аймгийн нутаг дахь эртний түүхийн үл хөдлөх дурсгалууд /магистрын ажил/
2. Өвөр Монголын малчдын аж амьдралын стратеги (Хөвөөт шар хошууны жишээн дээр) /докторын ажил/

ХОЁР. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

1. “Цахар Монголчуудын мөргүүлсэн эцэг эх сонгох ёсон” АММСТөв ЭШ-ний сэтгүүл XVII; ISSN 2072-8085, 2018 он
2. “Өвөр Монголын хот айл, түүний тогтолцоо”. УБИС-ийн Түүх, угсаатан зүйн ЭШ-ний сэтгүүл-XIV, ISSN 2310-256X, 2019 он.
3. “Өвөр Монголын нутаг бэлчээр, түүний үйл явцыг шинжлэх нь”. АММСТөв ЭШ-ний сэтгүүл XVIII; ISSN 2072-8085, 2019 он.
4. “Өвөр Монголын малчдын нутаг бэлчээр, аж байдлын тухай”. ШУА-ийн Түүх археологийн хүрээлэнгийн “Угсаатан судлал” ЭШ-ний сэтгүүл XXVI, ISBN 9789919-5550-4-5 2019 он.
5. “Малжих орны нийгмийн шилжилт, малчдын одоох байдал” БНХАУ-ын ӨМӨЗО-ын ӨМИС-ийн “Гүн ухаан, нийгмийн шинжлэх ухаан” ЭШ-ний сэтгүүл №6, ISSN1006-5547. 2020 он.
(гадаад)



ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

1. Цахар хуримын ёсон дахь нэгэн онцлог, түүнийг шинжлэх нь - “Цахар соёл” ЭШХ /БНХАУ, Улаанцав/ 2017.11 сар (гадаад)
2. Малчдын аж ахуйн стратеги - БНХАУ, ӨМИС-ийн Нийгэм зүй, угсаатны зүйн сургуулийн ЭШХ/ 2018 он (гадаад)
3. Эрүүлийг хамгаалах салбарт Монгол улсаас Лаос улсад үзүүлсэн буцалтгүй тусламж ба Найрамдал эмнэлэг - БНМАУ-ын бүтээн байгуулалт: Ололт, амжилт, сургамж ЭШХ /Түүх угсаатны зүйн хүрээлэн/ 2020.09 сар
4. Монгол-Хятад үндэстний харилцаан дахь “Хүүхэд шургуулах” домын тухай шинжлэх нь - “Монголын угсаатан судлал-2020” ЭШХ /Түүх угсаатны зүйн хүрээлэн/ 2020.10 сар
5. Нийгмийн ухамсарын түвшин дэх шашин шүтлэгийн илрэл, түүний эсрэг тэмцсэн нь – “БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал /1944-1990/” ЭШХ /Түүх угсаатны зүйн хүрээлэн/ 2020.11 сар

ХӨРВҮҮЛЭГ

1. Суухан Гэрэлт. “Алунгоо эхийн домгийн асуудалд”. Хятад дахь Монгол судлал III , Эрхэлсэн: Монгол, Хятадын соёлын харилцааг дэмжих нийгэмлэг., УБ, 2014.
2. Вальтер Хайссиг “Түүхээ эрж яваа Монголчууд” 2021 он (монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлсэн) ISBN 978-9919-24-020-2

ТОВЧООН

1. Диссертаци зохиол - 2
2. Эрдэм шинжилгээний өгүүлэл - 5
3. Эрдэм шинжилгээний илтгэл - 5
4. Захиалгат ажил, төсөл -3
5. Хөрвүүлэг - 2



Л.ХУРЦБААТАР

(Solongyod L.Qurčabaatur) Угсаатан зүй хийгээд Төв Ази судлалын эрдэмтэн.

Солонгод Л.Хурцбаатар 1959.09.23-нд Хятад улсын Өвөр монголын Ордос хотын Отог хошууны малчин, бичгийн хүн Лоосал болон Лонтонгийн хоёрдугаар хөвгүүн болж заяагджээ. 1971-1974 онд тухайн үеийн Отог хошууны Булаг сумын Хархадан сүмийн бага сургуульд суралцан төгсөв. 1974 оноос хоёр жил нутагтаа малчин байв. 1976-1978 онд Өвөр монголын Монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн сургуульд монгол хэл бичиг ба орчуулгын мэргэжлээр суралцан төгсөв.

1980 онд Өвөр монголын Их сургуулийн номын сангийн ухаан ба гүн ухааныг суралцан төгсөв. Тэр тус жилээс эхлэн Өвөр монголын Засаг захиргааны дээд сургуульд номын санч ба үндэстний асуудлын тухай сэтгүүлчээр 1989 он болтол ажиллав. 1989 онд Вольтер Хейссиг гуайн урилгаар Германы Бонн их сургуульд зочин судлаачаар ажиллаж, “Монгол бөө мөргөлийн тайлга тахилгын соёл” хэмээх бүтээлээ туурвин хэвлүүлэв.

1996 онд Германы Кёльн Их сургуульд оюутан, магистр сурлагаа угсаатан зүйн салбар ба өрнө дахины судлалаар нэгдүгээр дэд мэргэжил, Бонн их сургуулийн Төв Азийн судлалаар хоёрдугаар дэд мэргэжлээр суралцан төгсөв. 1999 онд Германы Түбинген их сургуулийн соёл гүн ухааны хүрээлэнд харьцуулал шашин судлал ба соёл угсаатан зүйн мэргэжлээр докторын сурлагаа амжилттай суралцан төгсөж гүн ухааны цол хамгаалав. 1999 оны 4-8 дугаар сард Японы Осака хот дахь Улсын угсаатан зүйн музейд зочин судлаачаар уригдаж, энэ хугацаандаа “Чингис хаан тайлга” (докторын өгүүлэл) хэмээх тав дахь номоо герман хэлээр хэвлүүлэв.

Солонгод Л.Хурцбаатарын хэвлүүлсэн гол болох эрдэм судалгааны номууд:

1. “Хатагин арван гурван атаа тэнгэрийн тайлга”, 1987 он, Өвөр монгол, Хайлаар.
2. “Хишигбатын гүн ухаан жич нийгмийн үзэл санааны тухай материал”, 1988 он, Өвөр монгол, Хөх хот.
3. “Монголын бөө мөргөлийн тайлга тахилгын соёл”, (Ч.Үзмээгийн хамт), 1991 он, Өвөр монгол, Хайлаар.
4. “Хишигбатын <Эрт ба эдүгээх эрдэнийн товч>”(бусадтай хамтарсан), 1997 он, Өвөр монгол, Хайлаар.
5. “Чингис хааны тайлга”(докторын өгүүлэл, герман хэл), Senri Ethnological Reports 11, 1999 он, Япон, Осака.
6. “Чингис хааны алтан бичиг” (Огонос Цогтын хамт), 2001 он, Өвөр монгол, Хайлаар.



7. “Ордосын мянгад овогтон Хишигдүүрэнгийн монголын соёл түүхийн тухай гар бичмэлүүд” (бусадтай хамтарсан), QMD Nr.II. 2011 он, Токуо.
8. “Хишигбат” (бусадтай хамтарсан, 6 боть), 2012 он, Өвөр монгол, Хөх хот.
9. “Монголын бөө мөргөлийн тайлга тахилгын судлал” (бусадтай хамтарсан, 4 боть), 2012 он, Герман, Кёльн.
10. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол” (Солонгод Л.Хастбаатарын хамт, 4 боть), 2014 он, Герман, Кёльн.
11. “Монголчуудын уугал бичгийн соёлын үүсэл буюу Хөх Түрэг бичиг” (судлалын цуврал ②, Д.Баатарын хамт), 2018 он, Герман, Кёльн.
12. “1400 жилийн өмнөх Өвөг монгол хэл – Хүйс толгойн бичээсний судлал” (судлалын цуврал ①, монголоор), 2019 он, Герман, Кёльн.
13. “Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтцийн толь” (бусадтай хамтарсан, судлалын цуврал ③, кириллээр), 2020 он, Герман, Кёльн.
14. “1400 жилийн өмнөх Өвөг монгол хэл – Хүйс толгойн бичээсний судлал” (судлалын цуврал ④, кириллээр), 2020 он, Герман, Кёльн.
15. “Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтцийн толь” (бусадтай хамтарсан, судлалын цуврал ⑤, монголоор), 2020 он, Герман, Кёльн.
16. Доктор Солонгод Л.Хасбаатар (Dr. Solongyod L. Khasbaatar)



Л.ХАСБААТАР

1965 оны 1 сарын 25-нд Ордос Отогийн өмнөд хошууны Манхат гацааны Алаг толгойд малчин бичгийн хүн Лоосал хийгээд Лонтоны дөрөвдүгээр хөвгүүн болж заяагджээ. 1972-1983 онд Отогийн өмнөд хошууны Булаг сум, хошууны дунд сургуулийг төгссөн. 1985-1989 онд Тунляо дахь Өвөрмонголын Үндэстний Дээд Сургуулийн Монгол хэл утга зохиолын мэргэжил эзэмшив. 1989-1993 он болтол Ордосын Эзэн хороо хошууны Монгол дунд сургуульд багш, Отогийн өмнөд хошууны намын хороонд ажиллаж байв.

1994-1997 онд Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд “Яруу найрагч Ренчиний Чойномын амьдрал уран бүтээл” сэвдээр докторын зэрэг хамгаалсан. 1999 оноос Монгол улсын Улаанбаатар Их Сургуулийн гадаад хэлний тэнхимд эрхлэгчээр ажиллав. “Монгол ээжийн хүү” (хамтын бүтээл) яруу найргийн ном, “Солгой хөгжим шиг цагийг сөрж явсан найрагч”, “Яруу найргийн урлахуй эрдэм”, “Чойномын амьдрал уран бүтээл”, “Солонгод овогтны гэрийн цадиг”, “Эрт эдүгээгийн Нангиад орон”, “Цагийн жаварт бөхөөгүй зул” зэрэг эрдэм ном, сургалт судалгааны бүтээлүүдээ бичиж хэвлүүлэв. “Монгол бөө мөргөлийн тайлга тахилгын судлал” хэмээх номын 1 дүгээр боть (“Хаадын гэрийн арван гурван атаа тэнгэрийн тайлга хийгээд Хатгинчууд”-ыг Солонгод Л.Хурцбаатар ахын хамт бичив), “Хишигбат” 4 дүгээр боть (Солонгод Л.Хурцбаатарын хамт)-ийг хамтран бичив. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”-ыг Л.Хурцбаатартай хамтран эмхэтгэн нийтлэв. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”-г Д.Дамдинсүрэнтэй хамтран найруулж 5 дугаар ботид судалгааны бүтээл “Цагийн жаварт бөхөөгүй зул” нь бүрэн эхээрээ сонгогдон оров. Одоо Өвөрмонголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуульд Дэлхийн уран зохиол ба харьцуулсан уран зохиолын судалгааны чиглэлээр судлаачдыг удирдаж, шинээр үүсгэн байгуулсан кирилл үсгийн мэргэжлийн ангийн сургалтын ажлыг голлон хариуцаж байна.



БАТ-ОЧИРЫН БОЛД

1963 онд төрсөн. Шилийн гол аймгийн Сөнөд баруун хошууны Сайхан-Өлзий сумын Сайханшил гацааны уугуул хүн юм. Соёл судлаач, орчуулагч, яруу найрагч. Одоо япон улсын Эрүүл мэнд спортын их сургуульд хүн зүй судлал, сэтгүүл зүйн мэргэжлээр доктор, професор багш.

2002 онд японы Чива их сургуулийн судлах хүрээлэнгээс “Монгол бөхийн соёл уламжлал болон түүний шинэчлэлтийн тухай соёл хүн зүйн судалгаа” гэх сэдвээр эрдэм шинжилгээний докторын цол хамгаалжээ. “Чоно болон бөх – монгол бөхийн барилдаан дахь амилгын ёсны тухай” (2005) зэрэг 50 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, “Тулалдааны соёл – тулалдааны тухай хэвлэл мэдээллийн нийгэм зүй” (2010) зэрэг хамтран бичсэн 10-аад ном бүтээлтэй. “Монгол бөхийн бэлгэдэл зүй” өгүүлэл нь Спорт хүн зүйн үндсэн онол” (2004) гэх японы их сургуулийн сурах бичигт сонгогдон оров.

Үүнээс гадна уран зохиолын талаар “Хамар” (2009), “Аймшигт шөнө” (2012) зэрэг японы өгүүллэгүүд, “Элс манхны театр” зэрэг цуврал орчуулгын бүтээл, “Б.Болдын бөхийн яруу найраг” (2016), “Хайрын үзэл” (2017), “Дэлхийн монгол цуврал” (хамтран зохиосон 2019), зэрэг яруу найргийн түүвэр болон “Хорвоо доголдох үнэн тууль” (Б.Билигийн зураг хавсаргав) гэх найраглалын номоо хэвлүүлжээ. 2020 оноос түүний орчуулсан японы хүүхдийн уран зохиолын бүтээлүүдийг Өвөрмонголын радио телевизийн “Гурван цаг” нэвтрүүлгээр олонтоо нэвтрүүлжээ. 2016 онд “Дэлхийн монгол цувралын нийгэмлэг”-ийг үүсгэн байгуулж, монгол цуврал сонирхогчдын бүтээлийг японы сэтгүүл дээр олон хэлээр нийтэлж байгаа бөгөөд 2021 оноос “Дэлхийн монгол цуврал” цахим сэтгүүлийн найруулагчаар ажиллаж байна.



ЗАЛГААБАЯР

1987 онд төрсөн. Доктор, туслах найруулагч.

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Сөнөд зүүн хошууны уугуул. Сөнөд ястай, Тэлэнгүд овогтой. 2009 онд ӨМӨЗО-ы Тариалангийн Их Сургуулийн Аж ахуйн дээд сургуулийг төгсөв. 2014 онд Өвөрмонголын Багшийн Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургууль төгсөж, Хятадын эртний сурвалж бичгийн магистр цол хамгаалжээ. 2021 онд Өвөрмонголын Их Сургуулийн Монгол түүхийн салбарыг төгсөж, түүхийн ухааны доктор цол хамгаалав. Эдүгээ Өвөрмонголын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл найруулах тасагт ажиллаж байна.